СЗХ
2022 .06 р 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

2022 IPO



# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч: MON BEEF

Үндсэн Андеррайтер: APEX CAPITAL

Туслах Андеррайтер: ТАВАН БОГД КАПИТАЛ

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

“Мон Бийф” ХХК /цаашид “Үнэт цаас гаргагч” буюу “Компани” гэх/ нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид “Бирж” гэх/-ийн холбогдох журмуудын дагуу нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгож байна.

Энэхүү үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөнө үү.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**“ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.”**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон үндсэн **андеррайтер “Апекс Капитал ҮЦК” ХХК**, дэд андеррайтер Таван Богд Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

MON BEEF
2022 .06. 22
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



Таван Богд компанийг 1995 онд Монголын хамгийн өндөр оргил уулсаа бэлгэдэн үүсгэн байгуулж байсан. Тухайн үед Японы FUJIFILM корпорацийн гэрэл зураг боловсруулах лабораторийг нээн, 10 хүрэхгүй ажилтантайгаар бизнесийн гараагаа эхлүүлж байлаа. Харин өнөөдөр үйлдвэрлэл, аялал жуулчлал, банк санхүү, нийтийн хоол үйлчилгээ, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаагаа амжилттай эрхлэн, 26 салбар компани, 4 хөрөнгө оруулалттай компанийн 12,000 гаруй ажилтнуудынхаа хамтаар ард түмнийхээ амьдралын чанарыг дээшлүүлэх эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Бид 2020 онд Монгол үндэстний соёл онцлогийн нэгээхэн хэсэг болсон бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал ахуйтай хослуулан, эрдэмтдийн туршилт судалгаан дээр үндэслэн инноваци шингээн МОН БИЙФ брэндийг үүсгэн байгууллаа.

“Мон Бийф” ХХК нь хөдөө аж ахуйн кластерын цогц системийг бүрдүүлж, малчдын хотноос бяруу болон шүдлэн насны үхрийг 30-100 хоногийн турш шим тэжээлийн тусгай жорын дагуу хамгийн чанартай өвс тэжээлээр бордож зах зээлд эрүүл, гарал үүсэл тодорхой, ШИМТЭЙ, ЗӨӨЛӨН, үхрийн махыг бэлтгэн нийлүүлж байна.

Өнөөдөр та бүхэнд хувьцаагаа санал болгож буй МОН БИЙФ брэнд нь эх орны баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үндэсний итгэлтэй брэнд болтлоо хөгжиж буйд талархаж байна.

Таван Богд Группийн бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаанд итгэж найдан сонгож үйлчлүүлдэг эрхэм хэрэглэгч үйлчлүүлэгч, хамтран ажиллагсад болон нийт группийн ажилтнууддаа талархал илэрхийлж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсье.

**Таван Богд Группийн Ерөнхийлөгч - Ц.Баатарсайхан**

Мон Бийф ХХК компани
MonBeefLLC
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

**Үндсэн андеррайтер**

**"Апекс капитал ҮЦК" ХХК**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Нью Хорайзонс оффис, 9 давхар, 901 тоот
Утас: (976) 7510-7500
Э-шуудан: investment@apex.mn
Вэб хуудас: www.apex.mn

**Дэд андеррайтер**

**"Таван богд капитал ҮЦК" ХХК**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Галлериа-Улаанбаатар, 1 давхар
Утас: (976) 7272-7282
Э-шуудан: cr@tavanbogdcapital.com
Вэб хуудас: www.tavanbogdcapital.com

**Аудитын компани**

**"Эс Жи Эм Ди Аудит" ХХК**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-44, 14/2 и байр, 9 тоот
Утас: (976) 7000-6948
Э-шуудан: ekhbayar@sgmd-audit.mn

**Хуулийн фирм**

**"Өмгөөллийн ХаанЛекс Партнерс" ХХН**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Аюуд тауэр, 14 давхар, 1404 тоот
Утас: (976) 7747-1122
Э-шуудан: info@khanlex.mn
Вэб хуудас: www.khanlex.mn

**"Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс" ХХН**
Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Глобал бизнес центр, 503 тоот
Утас: (976) 7012-9665
Э-шуудан: info@mjlattorneys.mn
Вэб хуудас: http://www.mjlattorneys.mn/

**Үнэлгээний компани**

**"Итгэлт эстимэйт" ХХК**
Хаяг: Баянзүрх дүүрэг 26-р хороо, Хүннүгийн гудамж, Олимп плаза оффис, 401 тоот
Утас: (976) 7600-5638
Э-шуудан: itgelt.estimate@gmail.com

СЗХ MON BEEF 2022.06.22 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД .......... 2
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ .......... 3
ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ .......... 4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .......... 7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .......... 8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .......... 9
1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .......... 10
1.1 Үнэт цаасны хураангуй танилцуулга .......... 11
1.2 Компанийн товч танилцуулга .......... 12
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ .......... 14
2.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл .......... 15
2.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл .......... 17
2.3 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт .......... 18
2.4 Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл .......... 26
2.5 Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлүүд .......... 28
2.6 Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл .......... 32
3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ .......... 34
3.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны процесс .......... 35
3.2 Үйлдвэрлэлийн татан авалтын тухай .......... 36
3.3 Тэжээлийн тухай .......... 38
3.4 Үйлдвэрлэлийн гарцын тухай .......... 41
3.5 Нядалгааны процессын тухай .......... 42
3.6 Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн .......... 43
3.7 Үнэт цаас гаргагчийн борлуулалтын сувгийн тухай .......... 45
3.8 Өрсөлдөөний давуу тал .......... 45
3.9 Эрсдэлийн удирдлага .......... 47
3.9 SWOT шинжилгээ .......... 53
4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ .......... 56
4.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал .......... 57
4.2 Үнэт цаасны зах зээлийн төлөв байдал .......... 59
4.3 Мал аж ахуйн салбарын төлөв байдал .......... 61
4.3.1 Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого .......... 63
4.4 Мах, махан бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд .......... 65
5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .......... 66

MON BEEF ССХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03


5.1 Аудитын тайлангийн дүгнэлт ............ 67

5.2 Санхүүгийн нөхцөл байдал ............ 68

6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН СТРАТЕГИ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ............ 76

6.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө ............ 77

6.2 Санхүүгийн нөхцөл байдлын төсөөлөл ............ 84

8. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ............ 90

7.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай ............ 91

7.2 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл ............ 92

7.2.1 Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл ............ 92

7.2.2 Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга ............ 94

7.3 Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ............ 97

7.4 Үнэт цаас эзэмшигчийн эрх үүрэг ............ 101

7.5 Ногдол ашгийн бодлогын төсөл ............ 103

7.6 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр ............ 104

7.7 Анхдагч зах зээлийн процесс ............ 105

8. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ............ 108

8.1 Андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай ............ 109

8.1.1 Андеррайтерийн танилцуулга ............ 109

8.1.2 Андеррайтерийн компанитай байгуулсан гэрээний тухай ............ 110

8.2 Туслах Андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай ............ 111

8.2.2 Туслах Андеррайтерийн танилцуулга ............ 111

8.2.3 Туслах Андеррайтерийн компанитай байгуулсан гэрээний тухай ............ 112

8.3 Аудитын байгууллагын танилцуулга, гэрээний тухай ............ 113

8.3.1 Аудитын компанийн танилцуулга ............ 113

8.3.2 Аудитын компанитай байгуулсан гэрээний тухай ............ 113

8.4 Хуулийн байгууллагын танилцуулга, гэрээний тухай ............ 114

8.4.1 Хуулийн байгууллагуудын танилцуулга ............ 114

8.5.2 Хуулийн компаниудын гэрээний тухай ............ 116

8.5 Үнэлгээний байгууллагын танилцуулга, гэрээний тухай ............ 117

8.5.1 Үнэлгээний компанийн танилцуулга ............ 117

8.5.2 Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний тухай ............ 117

9. ХАВСРАЛТ


Mon Beef LLC Мон Бийф ХХ компани 6648436 УЛААНБААТАР

MON BEEF
СЗХ
2022 .06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1. Олон нийтэд хувьцааг санал болгохоос өмнөх ба дараах бүтэц: .................. 18
Хүснэгт 2. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл .......................................... 19
Хүснэгт 3. Хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн мэдээлэл ................................................ 19
Хүснэгт 4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл-ХХК дүрмээр.................. 19
Хүснэгт 5. Гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл ...................................................... 21
Хүснэгт 6. Хууль зүйн дүгнэлт ........................................................................................ 25
Хүснэгт 7. Сүүлийн 3 жилийн байдлаар Компанийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл ....................................................................................................... 28
Хүснэгт 8. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25%-ын тоон үзүүлэлт ............................................................................................................................ 31
Хүснэгт 9. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээний мэдээлэл ................................................ 32
Хүснэгт 10. Журмын мэдээлэл ........................................................................................ 33
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн үхрийн татан авалт ................................................... 36
Хүснэгт 12. Малын тэжээлийн үйлдвэрлэл, мянган тонн ............................................... 39
Хүснэгт 13. Тэжээлийн үйлдвэрлэгчдийн тоо, хүчин чадал, 2019 оны байдлаар .......... 40
Хүснэгт 14. "Мон Бийф" компанийн тэжээлийн бүтэц, үнийн мэдээлэл ......................... 40
Хүснэгт 15. Малын дундаж жин, махны гарцын хэмжээ ................................................. 41
Хүснэгт 16. Стейкний махны төрөл, онцлог .................................................................... 43
Хүснэгт 17. Стейкнээс бусад бүтээгдэхүүний төрөл, онцлог ........................................... 44
Хүснэгт 18. Өрсөлдөгчдийн харьцуулсан судалгаа ........................................................ 46
Хүснэгт 19. Эрсдэлийн матриц ........................................................................................ 47
Хүснэгт 20. Банкнуудын татан төвлөрүүлэх хөрөнгийн төсөөлөл, тэрбум төгрөг .......... 60
Хүснэгт 21. Санхүүгийн байдлын тайлан ........................................................................ 68
Хүснэгт 22. Бараа материал, мянган төгрөг .................................................................... 68
Хүснэгт 23. Урьдчилж төлсөн зардал тооцоо, мянган төгрөг .......................................... 69
Хүснэгт 24. Үндсэн хөрөнгө, мянган төгрөг ..................................................................... 69
Хүснэгт 25. Худалдааны болон бусад өглөг, мянган төгрөг ............................................ 69
Хүснэгт 26 Мөнгөн гүйлгээний тайлан, мянган төгрөг ..................................................... 70
Хүснэгт 27 Орлогын тайлан, мянган төгрөг ..................................................................... 71
Хүснэгт 28. Борлуулалтын хэмжээ, кг ............................................................................. 72
Хүснэгт 29. Борлуулалтын дундаж үнэ, төгрөг ................................................................ 73
Хүснэгт 30. Худалдан авалтын өртөг, хувиар .................................................................. 74
Хүснэгт 31. Бордолтын өртөг, хувиар ............................................................................. 74
Хүснэгт 32. Үхрийн татан авалтын болон нядалгааны үеийн дундаж жин, килограмм .. 78
Хүснэгт 33. Бордолтын өртөг, 1 килограммыг төгрөгөөр ................................................ 78
Хүснэгт 34. Орлого үр дүнгийн тайлан ............................................................................. 84
Хүснэгт 35. Ашигт ажиллагаа, хувиар ............................................................................. 85
Хүснэгт 36. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл ..................................................... 86
Хүснэгт 37. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, мянган төгрөг ......................... 87
Хүснэгт 38. Инфляцийн түүхэн мэдээлэл ........................................................................ 94
Хүснэгт 39. Хорогдуулалтын хувийн коэффициентууд ..................................................... 94
Хүснэгт 40. Харьцуулсан ХК-ийн мэдээлэл ..................................................................... 95
Хүснэгт 41. Мөнгөн урсгалын хорогдуулах аргаар хийсэн үнэлгээний үр дүн ................ 95
Хүснэгт 42. Цэвэр активын аргаар хийсэн үнэлгээний үр дүн ........................................ 96
Хүснэгт 43. Зах зээлийн аргаар хийсэн үнэлгээний үр дүн ............................................ 96

MON BEEF
СЗХ
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ 03

Хүснэгт 44. Үнэлгээний үр дүн ....... 96
Хүснэгт 45. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт ....... 97
Хүснэгт 46. Үйлдвэрийн барилгын ажлын зардлын задаргаа ....... 98
Хүснэгт 47. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн зардлын задаргаа ....... 98
Хүснэгт 48. "Мон Бийф" ХХК-ийн нядалгаа, ангилан савлах үйлдвэрийн давуу тал ..... 99
Хүснэгт 49. Нийт үйлдвэрийн зардлын задаргаа ....... 100

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт ....... 18
Зураг 2. Таван Богд Трейд ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт ....... 26
Зураг 3. "Мон Бийф" компанийн бизнес загвар ....... 35
Зураг 4. Үхрийн тоо толгой, 2021 оны байдлаар ....... 36
Зураг 5. Тэжээл хувиргалтын харьцаа (Feed conversion ratio) ....... 38
Зураг 6. Уураг хувиргалтын харьцаа / кг (Protein conversion efficiency) ....... 38
Зураг 7. Энергийн хувиргалтын харьцаа / кг (Energy conversion efficiency) ....... 39
Зураг 8. Мал бэлтгэл, хорио цээрийн үе шат ....... 42
Зураг 9. Мал төхөөрөх үе шат ....... 42
Зураг 10. Мал ангилах, шулах үе шат ....... 42
Зураг 11. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын сувгууд (төлөвлөгөө) ....... 45
Зураг 12. Монгол улсын ДНБ болон өсөлтийн хувь ....... 57
Зураг 13. ДНБ ба Хөрөнгийн зах зээлийн хамаарал ....... 59
Зураг 14. Хөрөнгийн зах зээлийн арилжааны бүтэц ....... 59
Зураг 15. Дэлхийн үхрийн махны хэрэглээ ....... 61
Зураг 16. Нийт болон импортын махны хэмжээ, тонн ....... 62
Зураг 17. ДНБ-д эзлэх МАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн хувь ....... 62
Зураг 18. Монгол улсын үхрийн махны хэрэглээ, мянган тонн ....... 64
Зураг 19. Махны дундаж хэрэглээ, 2020 оны байдлаар, нэг хүнд ногдох ....... 64
Зураг 20. Борлуулалтын дүн, мянган төгрөг ....... 73
Зураг 21. Үхрийн татан авалт ба бэлтгэлд оруулах хэмжээ, толгой үхэр ....... 77
Зураг 22. Тэжээх үхрийн хоногт авах жингийн дундаж нэмэгдэл, грамм ....... 78
Зураг 23. Үхрийн махны гарц, хувиар ....... 79
Зураг 24. Махны цэвэр бүтээгдэхүүний гарц, хувиар ....... 80
Зураг 25. Монгол улсын махны нийлүүлэлтийн хэмжээ, мянган тонн ....... 81
Зураг 26. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны задаргаа, 2020 он ....... 82
Зураг 27. "Мон Бийф" зах зээлийн төлөвлөгөө ....... 82
Зураг 28. Борлуулалтын орлого ба цэвэр ашгийн төсөөлөл, сая төгрөг ....... 84
Зураг 29. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба үйл ажиллагааны зардал, хувиар ....... 85
Зураг 30. Нийт хөрөнгийн төсөөлөл, мянган төгрөг ....... 88
Зураг 31. Нийт өр төлбөр ба өмчийн төсөөлөл, мянган төгрөг ....... 88
Зураг 32. Харьцаа үзүүлэлт ....... 89
Зураг 33. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах зохион байгуулалтын дараалал ....... 105
Зураг 34. Үнэт цаасны анхдагч зах зээлд захиалга өгөх заавар ....... 105

MON BEEF
СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Ам.доллар ($) | Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ББӨ | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МАА | Мал аж ахуй |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| Төгрөг (₮) | Монгол Улсын мөнгөн тэмдэгт |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| КТХ | Компанийн тухай хууль |
| ХоРеКа | Зочид буудал, ресторан, кatering |
| ХЭУБГ | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар |
| M&S apart | Орон сууцуудын дэргэдэх жижиг дэлгүүрүүд |

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

# ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 01

СЗХ MON BEEF 2022 .06. 22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -06- 17 БҮРТГЭВ-03

## 1.1 Үнэт цаасны хураангуй танилцуулга

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "Мон Бийф" ХХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт гаргасан хувьцааны тоо | 150,000,000 ширхэг |
| Шинээр гаргаж буй хувьцааны тоо | 64,285,700 ширхэг |
| Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо | 214,285,700 ширхэг |
| Олон нийтэд санал болгож буй хувьцааны хувь | 30 хувь |
| Нэгж хувьцааны үнэ | 45 төгрөг |
| Нийт татан төвлөрүүлэх дүн | 2,892,856,500 төгрөг |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | ▪ Үйлдвэрийн байр<br>▪ Тоног төхөөрөмжийн худалдан авалт |
| Компанийн нийт хувьцааны зах зээлийн үнэ | 9,642,856,500 төгрөг |

**Олон нийтэд санал болгох нөхцөл**

| | |
|---|---|
| Хувьцааг санал болгох арга | Тогтоосон үнийн арга |
| Санал болгох нэгжийн үнэ | 45 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | 2,892,856,500 төгрөг |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК УЛААНБААТАР ХОТ

MON BEEF
СЭХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

## 1.2 Компанийн товч танилцуулга

| АГУУЛГА | ХУРААНГУЙ | |
|---|---|---|
| Үнэт цаас гаргагчийн үүсэл хөгжил | Хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн салбар Монгол Улсын эдийн засагт өндөр ач холбогдолтой. Дотооддоо мал аж ахуйн нөөц ихтэй боловч хэрэглэгчид итгэж, худалдан авч болох үхрийн махыг бий болгож буй хэсэг нь бага байгаа учир эрүүл, чанартай махыг үйлдвэрлэх зорилгоор үнэт цаас гаргагч “Мон Бийф” ХХК нь 2020 оны 12 сард үүсгэн байгуулагдсан. Өдгөө 5 нэр төрлийн стейкний мах болон 6 нэр төрлийн үхрийн ангилсан махыг хэрэглэгчдэд нийлүүлж зах зээлд танигдсан брэнд болсон байна. | 2.1<br>3.5 |
| Бизнесийн тухай | “Мон Бийф” ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах эрчимжсэн үхрийн фермдээ Монгол үүлдрийн залуу үхрийг 30-100 хоногийн турш өөрсдийн боловсруулсан арга аргачлалаар тэжээн бордож хэрэглэгчдэд чанартай үхрийн махыг хүргэж байна. Монгол үүлдрийн үхрийг тодорхой аймгуудаас татан авч эрүүл ахуйн хяналт шалгалтаар оруулан, 100 хувь фермийн аж ахуйд тэжээснээр эрүүл чийрэг байдлыг алдагдуулалгүйгээр зөөлөн, шүүслэг үхрийн махыг бий болгодог. | 3.1 |
| Хувьцаа эзэмшигчид | Үнэт цаас гаргагчийн толгой компани нь “Таван Богд Трейд” ХХК юм. Толгой компани нь Үнэт цаас гаргагчийн 75 хувийн хувьцааг эзэмшиж байгаа бол хувьцааны бусад хэсгийг 5 хувь хүн эзэмшдэг. Толгой компани нь үнэт цаас гаргагчаас гадна 25 охин компанитай бөгөөд чадварлаг менежментийн үр дүнд салбартаа тэргүүлж байна. | 2.3 |
| Үнэт цаас гаргагчийн удирдлага | Компанийн гүйцэтгэх удирдлагаар худалдаа, борлуулалтын салбарт мэргэшсэн менежментийн баг ажиллаж байгаа ба ферм болон үйлдвэрт туршлагатай баг хамт олон өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулалгүй явуулж байна. | 2.3 |
| Толгой болон түүний охин компаниуд | Толгой компани нь дэлхийн брэнд болсон “Говь” ХК болон үндэсний бүтээн байгуулагч “Улаанбаатар гурил” ХХК, “Улаанбаатар Принт” ХХК зэрэг компаниудыг менежментийн бодлогоор хангаж, бизнесийн ёс зүйг дээдлэн үндэсний хэмжээнд үнэ цэн бүхий бүтээн байгуулалтыг бий болгож байна. | 2.4 |
| Үнэт цаас гаргагчийн зах зээл | Хүний үндсэн хэрэглээний бүтээгдэхүүн болох мах нь хүн амын өсөлт болон хэрэглээний соёлтой холбоотойгоор өсөх хандлагатай байгаа. Энэ хэрээр хүнсний аюулгүй байдал чухлаар яригдаж байна. Нөгөө талдаа хоол хүнсний соёл, хэрэглээ нэмэгдэж үүнд тохирсон үнэ цэн бүхий хүнсний орц шаардагдаж байна. Дэлхий даяар үхрийн | 4.3 |

Мон Бийф ХХ компани УЛААНБААТАР ХОТ Mon Beef LLC

махны үйлдвэрлэл 1961 оноос хойш 2.6 дахин нэмэгдэж, жилд 28 сая тонн байсан бол 2021 оны байдлаар 72 сая тонн болж нэмэгджээ. Манай улсын хувьд жилд 159 мянган тонн үхрийн махыг үйлдвэрлэж байгаа нь 2016 онтой харьцуулахад 72 хувиар өссөн дүн юм.

| | | |
|---|---|---|
| Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа | Төвийн болон бусад аймгуудаас үйлдвэрлэлийн гол түүхий эдийн хангамж болох үхрийн татан авалтыг хийж Монгол орны хөрсөнд ургасан шимтэй өвс, тэжээл, эрдэс бодисоор тусгай жорыг гарган авч бордон өөрийн фермд эрүүл, зөөлөн, хэрэглэхэд хялбар үхрийн махыг зах зээлд нэвтрүүлж байна. Үхрийн махыг MNS 2456:2009 стандартын дагуу бэлтгэж, савладаг. Компанийн төлөвлөж буй борлуулалтын сувгууд, хэрэглэгчдэд өгч буй үнэ цэн, удирдлагын багийн ур чадвар зэрэг хүчин зүйлс нь үнэт цаас гаргагч компанид өрсөлдөөний давуу талыг бий болгож байна. | 3.6 |
| Санхүүгийн байдал | Компани 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгаа ба санхүүгийн эх үүсвэр талд холбоотой талын буюу толгой компанийн 3 тэрбум төгрөгийн зээлтэй байна. Мөн 2022 оны нэгдүгээр улиралд эздийн өмчийг 200 саяас 1.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Үйл ажиллагаа нь эхлэлийн төвшиндөө яваа компанийн хувьд борлуулалт идэвхжээгүй, маркетингийн ажил хийгдээгүй, татан авалт өндөр байснаас үүдсэн борлуулсан бүтээгдэхүүний өртөг өндөр байсан зэрэг томоохон хүчин зүйлсээс үүдэн тайлант жилүүдэд алдагдалтай ажиллав. Гэвч энэ нь богино хугацааны нөлөөлөл юм.<br><br>Нийт хөрөнгийг задлан харвал 50 орчим хувь бараа материал бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл байдлаар, 37 хувь фермийн тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгө , үлдсэн 13 хувь нь бусад эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө байдлаар байршиж байна. | 5.2 |

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

# 02

MonBeefLLC
Мон Бийф
ХХ компани
УЛААНБААТАР ХОТ
6648436

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## 2.1 Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

**Компанийн тухай**

Компани үүсгэн байгуулагдаад удаагүй боловч "Мон Бийф" брэнд бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд хүрэхэд бэлэн болгож, онлайн сувгууд болон томоохон сүлжээ дэлгүүр, ресторануудаар борлуулж байна. Өөрийн фермд тусгай орц найрлага бүхий тэжээлээр үхрийг бордож шимтэй, зөөлөн, шүүслэг бүтээгдэхүүнийг бүтээдэг.

**Алсын хараа**

Хүн бүрийн эхний бас үнэнч сонголт нь байна.

**Эрхэм зорилго**

Үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, олон улсын стандартад нийцсэн эрүүл, чанартай, шимтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар бэлтгэж, хэрэглэгчдэдээ хүргэн, салбартаа тэргүүлнэ.

**Бидний уриа**

Хамтын хүч Амжилтын түлхүүр

**Яагаад энэ бизнест хөл тавих болов?**

Хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуйн салбар нь Монгол Улсын эдийн засгийн өндөр ач холбогдолтой сектор бөгөөд 100 хувь фермийн аж ахуйд бордогдсон үхрийн махыг нийлүүлж буй үндэсний үйлдвэрлэл зах зээлд хараахан тогтвортой хөгжөөгүй байна. Ферм болон ил бэлчээрт гаргах замаар үхрийг тэжээх үед бэлчээрээс өвчин авах, махны чанарт нөлөөлөх эрсдэлүүд байдаг. Иймд үхрийг фермд 100 хувь бордох нь давуу талтай тул Үнэт цаас гаргагч тус аргаар үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагч нь үхрийг малчдаас худалдан авах үедээ эрүүл ахуйн үзлэгт оруулан хянаж, 100 хувь фермийн аж ахуйдаа борддог.

2021 онд Улсын хэмжээнд 5 сая орчим толгой үхэр бүртгэгдсэн байгаа боловч энэ чиглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл дутмаг бөгөөд үйлдвэрийн процессгүй буюу гарал үүсэл зэрэг мэдээлэлгүй махыг гар дээрээс худалдаалах байдал зах зээлд хэвшсэн байна.

**Мал аж ахуйн салбар хөгжих шаардлага**

Хүн төрөлхтөний тэр дундаа Монгол орны хүнсний стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн болох мах нь анхдагч төрлийн хэрэгцээний бүтээгдэхүүн тул нийт хүн амын хэрэглээний төвшин тогтмол өсөлттэй байдаг. Энэ хэрээр хүнсний аюулгүй байдал дэлхий нийтэд чухлаар яригдаж байна. Гарал үүсэл тодорхой, хэрэглэгчдийн итгэж болох стандарт хангасан мах хүнсний хэрэглээнд дутмаг, энэ төрлийн зах зээлд орон зай их байна.

"Мон Бийф" ХХК нь дараах 5 асуудлыг шийдвэрлэхээр хөдөө аж ахуй, тэр дундаа эрчимжсэн мал аж ахуйн салбарт ажиллаж байна. Үүнд:

**Эрүүл, чанартай, гарал үүсэл тодорхой мах, махан бүтээгдэхүүн**

Махны үйлдвэрлэлийн 90 гаруй хувь нь үйлдвэрийн бус аргаар боловсруулагдаж зах зээлийн эргэлтэд орж байгаа ба худалдааны дийлэнхийг ченж буюу өртөг бүтээгч бус дундын зуучлагч нар бүрдүүлдэг. Энэ нь эрүүл ахуй наад захын шаардлагыг хангаж чадахгүй хүнсний аюулгүй байдлын тогтолцоог алдагдахад хүргэж байна. Иймээс Малын эмч мэргэжилтний хяналт дор халдварт болон халдварт бус өвчлөлөөс ангид эрүүл мал, махыг хэрэглэгчдэд хүргэх, Өөрийн орны хөрсөнд ургасан чанартай түүхий эд бүхий бордоог тусгай жорыг дагуу бэлтгэн чанартай, гарал үүсэл тодорхой мах махан бүтээгдэхүүнийг хүргэх эрэлт хэрэгцээ өндөр байна.

**Бэлчээрийн даац**

Малын тоо толгойн өсөлтийг дагаж бэлчээр доройтсоор байна. Ус цаг уур, орчны хүрээлэнгээс 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацын тухай гаргасан мэдээлэлд Монгол Улсын нийт бэлчээр нутгийн 40 гаруй хувьд бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 25 орчим хувьд 3-5 дахин хэтэрсэн, 20 орчим хувьд даац хэтрэлттэй байгааг онцолсон. Иймээс малыг эдийн засгийн эргэлтэд эрт оруулж бэлчээрийн даацын хэтрэлтээс сэргийлэх, МАА-н салбарыг нийгэм, эдийн засгийн эрэлттэй нийцүүлэн хөгжүүлэх шаардлага байна.

**Сум орон нутагт ажлын байрыг бий болгох**

Аймаг, сум орон нутгийн эдийн засгийн хөгжил сул, ажлын байр хомс байна. Үүнээс шалтгаалан нийт хүн амын 60 гаруй хувь нь Улаанбаатар хотод шилжин суурьшиж, түүнийг дагаад үйлдвэрлэл, үйлчилгээнүүд нийслэлд төвлөрсөн. Иймд аймаг, сум орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийг чадавхжуулах шаардлага байна.

**Малчдын хөдөлмөрийг хөнгөвчилж, орлогыг нэмэгдүүлэх**

Малчин өрхүүд нь малыг нас бие гүйцтэл нь маллаад эдийн засгийн эргэлтэд оруулдаг. Ингэж маллахад малчид маш их хүч хөдөлмөр зарцуулдаг хэдий ч хангалттай үр ашиг хүртэж чаддаггүй. Иймээс эр мал буюу үржлийн бус малыг өсвөр насанд нь худалдан борлуулж эдийн засгийн өгөөжтэй байх шаардлагатай байна.

**Мал аж ахуйн салбарын шинэчлэл**

Монгол орон бол мал аж ахуйн орон. ХАА түүний дотроос Мал аж ахуйн салбар нь Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед манай орны эдийн засгийн гол тулгуур багана байсан ба нэгдэлжих хөдөлгөөн өрнөснөөр нүүдлийн мал аж ахуйг хагас эрчимжсэн аж ахуй болох суурийг тавьж, мал аж ахуйн салбарт урьд өмнө байгаагүй техник технологийг нэвтрүүлэн, байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг эрсдэл багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлж, малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, өндөр үр ашигт мал өсгөн үржүүлэхэд анхаарч байсан. Зах зээлийн нийгэмд шилжсэнээр дээрх асуудлууд зогсонги байдалтай байна. Иймээс МАА салбарт шинэ инноваци нэвтрүүлж малын ашиг шим, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## 2.2 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

| | |
|---|---|
| Компанийн оноосон нэр | "Мон Бийф" ХХК |
| Компанийн хэлбэр | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| Байгуулагдсан огноо | 2020.12.23 |
| Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо | 2020.12.31 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011823614 |
| Регистрийн дугаар | 6648436 |
| Компанийн толгой компани | "Таван Богд Трейд" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх<br>Мах боловсруулах, консервлох<br>Малын тэжээл үйлдвэрлэл<br>Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа<br>Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа<br>Барилгын материалын худалдаа |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | Нэг хуулийн этгээд, таван хувь хүн |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1,500,000,000 төгрөг |

**Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил**

| | |
|---|---|
| Хаяг байршил | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 6, Стадион Оргил - 1, Хаан Банк цамхаг, 10 давхар |
| Утас | +976 7533-2222 |
| И-мэйл хаяг | Info.monbeef@tavanbogd.com |
| Вэбсайт | https://www.monbeef.mn/ |

6648436 Mon Beef LLC Улаанбаатар
Мон Бийф ХХ компани
Хот

СЗХ
2022 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



## 2.3 Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

*Зураг 1. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт*




### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 75 дугаар зүйлийн 75.1 болон компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1-т зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ) байна.

**Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл**

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 150,000,000 ширхэг энгийн хувьцааг гаргасан байна. Энэхүү танилцуулгыг бэлтгэх үед, үнэт цаас гаргагч нь нийт 1.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ба дараах хувь хэмжээгээр нэр заасан 1 хуулийн этгээд, 5 хувь хүн эзэмшиж байна.

*Хүснэгт 1. Олон нийтэд хувьцааг санал болгохоос өмнөх ба дараах бүтэц:*

| | **Хувьцаа гаргахаас өмнө** | | **Хувьцаа гаргасны дараа** | |
|---|---|---|---|---|
| Эзэмшигчид | Тоо ширхэг | Хувиар | Тоо ширхэг | Хувиар |
| Таван Богд Трейд | 112,500,000 | 75% | 112,500,000 | 52.5% |
| Ж.Барсболд | 15,000,000 | 10% | 15,000,000 | 7% |
| Ц.Цэцэнхүү | 7,500,000 | 5% | 7,500,000 | 3.5% |
| Э.Пүрэвлхам | 7,500,000 | 5% | 7,500,000 | 3.5% |
| И.Баттуяа | 4,500,000 | 3% | 4,500,000 | 2.1% |
| Ж.Оюунчимэг | 3,000,000 | 2% | 3,000,000 | 1.4% |
| Олон нийт | - | - | 64,285,700 | 30% |
| Нийт | 150,000,000 | 100% | 214,285,700 | 100% |

**Хувьцаа эзэмшигчдийн танилцуулга**

Үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-ийн 75 хувийн хувьцааг "Таван Богд Трейд" ХХК эзэмшиж байгаа.

*Хүснэгт 2. Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл*

| № | Хувьцаа эзэмшигч | Үүсгэн байгуулагдсан огноо | Улсын бүртгэлийн дугаар | Хаяг |
|---|---|---|---|---|
| 1 | "Таван Богд Трейд" ХХК (2543303) | 1997.07.04 | 9011010130 | Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 6, Стадион Оргил-1, Хаан банк цамхаг, 10-р давхар, 1001 тоот |

*Хүснэгт 3. Хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн мэдээлэл*

| № | Хувьцаа эзэмшигч | Мэргэжил | Одоо эрхэлж буй албан тушаал |
|---|---|---|---|
| 1 | Ж.Барсболд | Банкны эдийн засагч | Гүйцэтгэх захирал, "Таван Богд" ХХК |
| 2 | Ц.Цэцэнхүү | Нягтлан бодох бүртгэл Бизнесийн удирдлага | Санхүү бүртгэл хариуцсан захирал, "Таван Богд Трейд" ХХК |
| 3 | Э.Пүрэвлхам | Санхүүгийн менежмент | Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал, "Таван Богд Трейд" ХХК |
| 4 | И.Баттуяа | Бизнесийн удирдлага | Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал, "Таван Богд Трейд" ХХК |
| 5 | Ж.Оюунчимэг | Хэл судлаач, Хэл судлалын магистр, Бизнесийн удирдлага | Маркетинг хариуцсан захирал, "Таван Богд Трейд" ХХК |

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн дүрмийн 8.4-т ХЭХ-н чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байхаар заасан ба компанийн хэлбэр ХК болсноор ТУЗ нь 9 гишүүнтэй болох бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь энэ дүрмийн 7.25-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байхаар тогтоогдсон. Компанийн хэлбэрийг өөрчлөхөөс өмнөх ТУЗ-г гишүүдийн бүтэц дараах байдалтай байна.

*Хүснэгт 4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн талаарх мэдээлэл-ХХК дүрмээр*

| № | Овог нэр | Албан тушаал | Эрхэлж буй албан тушаал | Компанийн засаглалын гэрчилгээ авсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | И.Баттуяа | ТУЗ-ийн дарга | "Таван Богд Трейд" ХХК Үйл ажиллагаа хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал | Авсан |
| 2 | Ж.Барсболд | ТУЗ-ийн гишүүн | "Таван Богд "ХХК Гүйцэтгэх захирал | Авсан |
| 3 | Ц.Оюунцэцэг | ТУЗ-ийн гишүүн | "Таван Богд Трейд" ХХК Дотоод аудит хариуцсан захирал | Авсан |

**ТУЗ-ийн дарга**



| | |
|---|---|
| Овог нэр | И.Баттуяа |
| Боловсрол | Бизнесийн удирдлага бакалавр, Рицүмэйкан ази номхон далайн их сургууль |
| Ажлын туршлага | Баттуяа нь анхны ажлын гараагаа 2009 оноос эхлэн "Таван Богд Интернэйшнл" ХХК-д Гадаад харилцааны мэргэжилтэн, Борлуулалтын супервайзор, Менежмент удирдлага хариуцсан менежер, Борлуулалтын албаны дарга, Борлуулалт маркетинг хариуцсан дэд захирал, Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан; 2019-2020 онд "Таван Богд Саппорт" ХХК хүний нөөц хариуцсан захирал; 2021 оноос одоог хүртэл "Таван Богд Трейд" ХХК-д Үйл ажиллагаа хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирлаар ажиллаж байна. |

**ТУЗ-ийн гишүүн**



| | |
|---|---|
| Овог нэр | Ж.Барсболд |
| Боловсрол | Банкны эдийн засагч бакалавр, Санхүү, эдийн засгийн дээд сургууль |
| Ажлын туршлага | Барсболд нь анхны ажлын гараагаа 2002 онд "Улаанбаатар Принт" ХХК-д Гүйцэтгэх захирлаар эхэлж, 2004-өөс 2008 онд "Финпак" ХХК-д Гүйцэтгэх захирал; 2013-аас 2014 онд "Таван Богд Финанс" ХХК-д мөн Гүйцэтгэх захирал; 2015 оноос одоог хүртэл "Таван Богд" ХХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. |

**ТУЗ-ийн гишүүн**



Овог нэр: Ц.Оюунцэцэг

Боловсрол: Автоматжуулалт ба удирдлага бакалавр, Новосибирскийн электро-техникийн их сургууль

Ажлын туршлага: Оюунцэцэг нь 1995-аас 2001 онд "Таван Богд" ХХК-д Ерөнхий захирлаар, 2001-2011 онд "Таван Богд Трейд" ХХК-д Санхүү бүртгэл хариуцсан захирлаар, 2011-ээс одоог хүртэл Дотоод аудит хариуцсан захирлаар ажиллаж байгаа туршлагатай.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**



Овог нэр: Т.Солонго

Боловсрол: Эрх зүйч бакалавр, МУИС, Хууль зүйн сургууль
Хууль зүйн магистр, МУИС, Хууль зүйн сургууль

Ажлын туршлага: Солонго нь Монгол Улсын Их Сургууль, ХЗС, ОУЭЗТэнхимийн туслах, мэргэжилтэн, "Хьюндай Моторс Монгол" ХХК-д Хуулийн зөвлөх, "Таван Богд Интернэйшнл" ХХК-д Хууль захиргааны менежер, Гоёо ХХК-д Хуулийн зөвлөхөөр ажилласан туршлагатай. Одоо "Таван Богд Трейд" ХХК-д Ахлах хуулийн зөвлөхөөр ажиллаж байна.

## КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТУХАЙ

*Хүснэгт 5. Гүйцэтгэх удирдлагын талаарх мэдээлэл*

| № | Овог нэр | Албан тушаал | Мэргэжил |
|---|---|---|---|
| 1 | Н.Ариунбаатар | Гүйцэтгэх захирал | Бизнесийн удирдлага, Банк санхүү |
| 2 | Г.Оюундэлгэр | Санхүүгийн менежер | Бизнесийн удирдлага, Хэрэглээний статистик |
| 3 | Д.Марал-Эрдэнэ | Ерөнхий нягтлан бодогч | Нягтлан бодогч |
| 4 | Ж.Байгальмаа | Үйлдвэрийн дарга | Хүнс үйлдвэрлэлийн технологи |
| 5 | В.Санчир | Фермийн дарга | Зоо инженер технологич /Малзүйч/ |
| 6 | Г.Дөлгөөн | Хүний нөөцийн менежер | Хүний нөөцийн менежмент |

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

**Гүйцэтгэх захирал**



| | |
|---|---|
| Овог нэр | Н.Ариунбаатар |
| Боловсрол | Бизнесийн удирдлага бакалавр, УБИС |
| Ажилласан туршлага | 2010-аас 2013 онд Бридж Групп-д Нягтлан бодогч, 2013-аас 2015 онд “Эрдэнэдрийлинг” ХХК-д менежер, 2016-аас 2021 онд “Таван Богд Интернэйшнл” ХХК-д Борлуулалтын ажилтан, Худалдааны төлөөлөгч, Орон нутгийн бүс хариуцсан менежер, Жижиглэн суваг хариуцсан супервайзор болон Дэлхийд тэргүүлэгч “Ferrero” брэндийг Монголын зах зээлд төлөөлж, борлуулалт маркетингийн 40 гаруй ажилтантай багийг хариуцсан Ерөнхий менежерээр ажилласан.<br>2022 оны 2 сараас “Мон Бийф” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. |

**Санхүүгийн менежер**



| | |
|---|---|
| Овог нэр | Г.Оюундэлгэр |
| Боловсрол | Хэрэглээний статистикч бакалавр, МУИС-МКС, Бизнесийн удирдлага магистр, МУИС-БС |
| Ажилласан туршлага | 2011 онд Таван Богд группт прогнозтик албан тушаалд ажилд ороод 2018 он хүртэл нийт 8 жилийн хугацаанд прогнозтик, ахлах прогнозтик, санхүүгийн шинжээч, борлуулалтын ахлах менежер, борлуулалт төлөвлөлтийн менежер гэх мэт албан тушаалуудад ажиллаж байсан.<br><br>2020-2021 онд “Грийн Групп”-ийн охин компаниуд болох “Ти Финанс ББСБ”, “Грийн Фактори” ХХК /Талын Монгол махны үйлдвэр/, “Актив Гарден” ХХК-д эдийн засагч, санхүү удирдлагын албаны даргаар тус тус ажилласан ба салбартаа 11 жилийн турш тасралтгүй ажиллаж байна. |

Мон Бийф ХХ компани MonBeefLLC 6648436 Улаанбаатар хот

СЗХ MON BEEF 2022 .06.22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

**Ерөнхий нягтлан бодогч**



Овог нэр Д.Марал-Эрдэнэ

Боловсрол Нягтлан бодогч бакалавр, ИЗОУИС

Ажилласан туршлага 2015-2017 онд "Ноён капитал" ХХК-д тооцооны нягтлан, Ерөнхий нягтлан бодогч 2017- 2018 онд "Тэсо" ХХК Авлагын менежер 2018-2020 онд "Милко" ХХК Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан ба салбартаа 7 жилийн турш тасралтгүй ажиллаж байна.

**Хүний нөөцийн менежер**



Овог нэр Г.Дөлгөөн

Боловсрол Хүний нөөцийн менежмент бакалавр, Рояаль олон улсын их сургууль

Ажилласан туршлага 2015-2018 онд "Хоуп энд Цо" ХХК-д сургалтын мэргэжилтэн 2018-2019 онд "Улаанбаатар Гурил" ХХК-д Хүний нөөцийн мэргэжилтэн 2019-2022 онд "Таван Богд Интернэйшнл" ХХК-д Хүний нөөцийн менежерээр тус тус ажиллаж байсан ба ажиллаж байх хугацаандаа хүний нөөцийн бүхий л функцуудыг хэрэгжүүлэн ажиллаж үйлдвэр борлуулалтын салбарын хүний нөөцийн чиглэлээр 6 жилийн турш тасралтгүй ажиллаж байна. Мөн Таван Богд Группийн дотоод сургагч багшаар ажилладаг.



MonBeefLLC Мон Бийф ХХ компани УЛААНБААТАР 6648436

MON BEEF СЗХ 2022 .06 .22 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

**Фермийн дарга**



Овог нэр В.Санчир
Боловсрол Зоо инженер технологич /Малзүйч/ бакалавр, Хөдөө аж ахуйн, биотехнологийн их сургууль

Ажилласан туршлага 2017 онд Монгол малчин сэтгүүлд менежер, 2017 оны 12 дугаар сараас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Мал эмнэлэг үржлийн газарт Мэргэжилтэн,
2018 оноос ХХААХҮЯ-д Мэргэжилтнээр тус тус ажилласан ба хөдөө аж ахуйн салбарт 6 жилийн турш тасралтгүй ажиллаж байна.

**Үйлдвэрийн дарга**



Овог нэр Ж.Байгальмаа
Боловсрол Хүнс үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуй бакалавр, ШУТИС

Ажилласан туршлага Ж.Байгальмаа нь 2005-2008 онд “Бат Сарай” ХХК-д Ерөнхий технологичоор, 2010 он хүртэлх хугацаанд Werner wurst waren Герман хиамны үйлдвэрт технологич, 2010-2015 онд Солонгос улсад хиамны цех байгуулан чанамал, утлагат хиам, элэгний нухаш үйлдвэрлэдэг байсан.
2018-2021 онд “Хаан хүнс импекс” ХХК-д Үйлдвэрийн менежер, Чанарын менежер
2021-2022 “Модерн номадс” ХХК-н хүнсний үйлдвэрийн Чанарын менежерээр тус тус ажилласан туршлагатай бөгөөд
2022 оны 5 сараас “Мон Бийф” ХХК-д үйлдвэрийн даргаар ажиллаж байна.



6648436 Mon Beef LLC Мон Бийф ХХ КОМПАНИ УЛААНБААТАР ХОТ

СЭХ MON BEEF
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -03- 17

**Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх хууль зүйн дүгнэлт**

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН болон Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нар нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагч анх удаа нийтэд хувьцаа санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан хуулийн дүгнэлтийг бэлтгэсэн.

Хуулийн компани нь Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь дараах шаардлагуудыг хангаж буй эсэх дээр шинжилгээ, дүгнэлт хийсэн байна. Үүнд:

1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй байх
2. Ял шийтгэл эдэлсэн эсэх
3. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх
4. Тохиромжтой этгээдийн шаардлага хангаж байгаа эсэх
5. Татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй байх

*Хүснэгт 6. Хууль зүйн дүгнэлт*

| № | Нэр | Албан тушаал | (1) | (2) | (3) | (4) | (5) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | И.Баттуяа | ТУЗ-ийн дарга | ☑ | ☑ | ☑ | ☑ | ☑ |
| 2 | Ц.Оюунцэцэг | ТУЗ-ийн гишүүн | ☑ | ☑ | ☑ | ☑ | ☑ |
| 3 | Ж.Барсболд | ТУЗ-ийн гишүүн | ☑ | ☑ | ☑ | ☑ | ☑ |
| 4 | Т.Солонго | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | ☑ | ☑ | ☑ | ☑ | ✓ |
| 5 | Н.Ариунбаатар | Гүйцэтгэх захирал | ☑ | ☑ | ☑ | ☑ | ☑ |
| 6 | Г.Оюундэлгэр | Санхүүгийн менежер | ☑ | ☑ | ✓ | ☑ | ✓ |
| 7 | Д.Марал-Эрдэнэ | Ерөнхий нягтлан бодогч | ☑ | ☑ | ✓ | ☑ | ✓ |
| 8 | Г.Дөлгөөн | Хүний нөөцийн менежер | ☑ | ☑ | ✓ | ☑ | ✓ |
| 9 | Ж.Байгальмаа | Үйлдвэрийн дарга | ☑ | ☑ | ✓ | ☑ | ✓ |
| 10 | В.Санчир | Фермийн дарга | ☑ | ☑ | ✓ | ☑ | ✓ |

☑ *Шаардлага хангаж байгаа*

✓ *Энэхүү шаардлагыг хангах албагүй*

**Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт: "эцсийн өмчлөгч" гэдэгт "харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг" ойлгохоор тусгасан.
ХЭУБГ-ын лавлагаанд үндэслэн Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь "Таван Богд Трейд" ХХК, түүний захирал Ц.Баатарсайхан байна гэж дүгнэсэн байна.

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## 2.4 Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох Таван Богд Трейд ХХК-ийн бусад охин компаниуд 2022 оны 05-р сарын 11-ний өдрийн байдлаар дараах бүтэцтэй байна.

*Зураг 2. Таван Богд Трейд ХХК-ийн бүтэц, зохион байгуулалт*




Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Таван Богд Трейд" ХХК-ийн 24 охин компани нь ХХК хэлбэртэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бол "Говь" ХК болон "Жуулчин Дюти Фрий" ХК нь олон нийтэд хувьцаагаа эзэмшүүлсэн байдаг. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд нь банк, санхүү, үйлдвэрлэл, аялал жуулчлал, барилга, уул уурхайн салбаруудад үйл ажиллагаа явуулдаг компаниуд байна.

6648436 Mon Beef LLC Мон Бийф ХХ компани УЛААНБААТАР ХОТ

## “Таван Богд Трейд” ХХК-ийн тухай

“Таван Богд Трейд” ХХК (РД:2543303) нь үнэт цаас гаргагчийн 75 хувийг эзэмшиж байгаа ба Компанийн тухай хуулийн 6.3-т зааснаар “Мон Бийф” ХХК нь “Таван Богд Трейд” ХХК-ийн охин компани байна.




Таван Богд компани нь анх 1995 онд үүсгэн байгуулагдаж, өдгөө 27 дахь жилдээ группийн цар хүрээтэйгээр үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. “Таван Богд Трейд” ХХК нь Таван Богд группийн холдинг компани бөгөөд олон улсын худалдаа, үйлчилгээ, ноолуурын үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл,үйлчилгээ, аялал жуулчлал ба зочлох үйлчилгээ, банк санхүү, барилга угсралт, уул уурхайн хангамжийн үйлчилгээ зэрэг салбаруудад үйл ажиллагаа явуулж буй охин компаниудынхаа бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон охин компаниудад менежментийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий компани юм.

Иймд дээрх зорилгын хүрээнд компани Дэд захирлууд, Дотоод аудит, Санхүү бүртгэл, Санхүү төлөвлөлт, Стратеги удирдлага, Хүний нөөц, Маркетинг, Хууль эрхзүй, Бизнес хөгжүүлэлт, Мэдээлэл технологийн газар, хэлтсийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

“Таван Богд Трейд” ХХК нь үнэт цаас гаргагч “Мон Бийф” ХХК болон бусад 25 охин компани, 4 хөрөнгө оруулалттай компани, тэдгээрийн 12,000 ажилтантайгаар үйл ажиллагааг явуулж байна.

“Таван Богд Трейд” ХХК-ийн Ерөнхий захирлаар Ц.Баатарсайхан ажилладаг бөгөөд тэрээр “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал, болон “Хаан Банк”-ны ТУЗ-ийн гишүүний үүргийг тус тус гүйцэтгэдэг.

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛИАН STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## 2.5 Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлүүд

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл**

Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт: "*Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно*" гэж тодорхой заасан байдаг бөгөөд дээрх хуулийн 91.2 дахь хэсэгт тусгаснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй байхаар заасан байдаг.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах журмын талаар Компанийн тухай хуулийн 92.1 дэх хэсэгт: "*Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргана*", мөн хуулийн 76.1.17 дахь хэсэгт: "*компанийн ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох*"-оор тус тус зохицуулжээ.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн хугацаанаас хуулийн дүгнэлт гаргах өдөр хүртэл хугацаанд нийт 6 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна.

*Хүснэгт 7. Сүүлийн 3 жилийн байдлаар Компанийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл*

| № | Гэрээний нэр | Гэрээ байгуулагч, түүний сонирхлын зөрчлийн хамаарал | Гэрээний агуулга, байгуулсан огноо | Хувьцаа эзэмшигч, ТУЗ баталсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Худалдах худалдан авах гэрээ | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани болох "Таван Богд Сольюшнс" ХХК-тай байгуулсан хэлцэл | Камер, холбогдох хэрэгслийг нийт 4,481,100 төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ /2021.11.12/ | ХЭХ-ын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 40/25-3 тоот шийдвэр |
| 2 | Үйлдвэрийн бүтээгдэхүүн худалдах худалдан авах гэрээ | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани болох "Улаанбаатар гурил" ХХК-тай байгуулсан хэлцэл | Тодорхой хугацаанд зах зээлийн үнээр хивэг худалдах, худалдан авах гэрээ /2021.10.22/ | ХЭХ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-нпа өдрийн 40/05-2 тоот шийдвэр |
| 3 | Автомашин худалдах | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин | Компанийн үйлчилгээнд зориулж 55,000,000 төгрөгийн автомашин | ХЭХ-ын 2021 оны 08 дугаар сарын 2- |

СЭХ MON BEEF
2022 .06 .22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

| | | | | |
|---|---|---|---|---|
| | худалдан авах гэрээ | компани болох “Жуулчин Дюти Фрий” ХХК-тай байгуулсан хэлцэл | худалдах, худалдан авах гэрээ /2021.08.03/ | ны өдрийн 40/04-02 тоот шийдвэр |
| 4 | Түрээсийн гэрээ | “Таван Богд Трейд” ХХК-ийн охин компани болох “Таван Богд Проперти” ХХК-тай байгуулсан хэлцэл | Үйл ажиллагааныхаа зорилгоор эзэмшүүлж, ашиглуулах зорилгоор 40 тн багтаамжтай 3 ширхэг контэйнер нэг сарын 880,000 төгрөгөөр түрээслэх гэрээ /2021.08.25/ | ХЭХ-ийн 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн 40/24-03 тоот шийдвэр |
| 5 | Зээлийн шугамын гэрээ | “Таван Богд Трейд” ХХК | Зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ ( 2,000,000,000 төгрөг, 1,000,000 ам доллар/ 2,849,230,000 төгрөг[1]/ нийт 4,849,230,000 төгрөг)-нд багтаан төгрөгийн жилийн 11.1 хувь, ам долларын жилийн 5.6 хувийн хүүтэйгээр 2023 оны 7-р сарын 05-ны өдрийг дуустал хүртэлх хугацаагаар байгуулсан зээлийн шугамын гэрээ /2021.09.02/ | ХЭХ-ийн 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 40/04-4 тоот шийдвэр |
| 6 | Зээлийн шугамын гэрээ | “Таван Богд Трейд” ХХК-ийн охин компани болох “Таван Богд” ХХК-тай байгуулсан хэлцэл | Зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ (10,000,000,000 төгрөг)-нд багтаан жилийн 11 хувийн хүүтэйгээр, 1жилийн хугацаатай байгуулсан зээлийн шугамын гэрээ /2022.03.25/ | ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 40/ТУЗ-02 тоот тогтоол |

Дээрх хэлцлийн талууд нь Компанийн тухай хуулийн 6.15 дахь хэсгийн дагуу нэг толгой компанийн охин компаниуд буюу зэргэлдээ компаниудын хоорондоо болон толгой компанитай хийгдсэн хэлцэл байх тул Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байна. Түүнчлэн, эдгээр хэлцлүүдээс 5 хэлцэл нь нь Үнэт цаас гаргагчийг 2022 оны 02 дугаар сард ТУЗ-тэй болохоос өмнө батлагдсан хэлцлүүд учир Компанийн тухай хуулийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан хэлцлийн хувьд ТУЗ-өөр батлуулах шаардлага тавигдана.

[1] Гэрээ байгуулах өдрийн байдлаар ам долларын төгрөгтэй харьцах ханш 1 ам доллар=2,849.23 төгрөг.

Үнэт цаас гаргагчийн дээрх хэлцлүүдийг хийх тухай зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүд болон ТУЗ-ийн тогтоолоос үзвэл Компанийн тухай хуулийн 92.1, 91.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар хэлцлийг батлах эсэх талаар зөвшөөрөл олгох шийдвэр гаргах ёстой боловч Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь "Таван Богд Трейд" ХХК-тай нэгдмэл сонирхолтой этгээд буюу тухайн хэлцэлд сонирхлын зөрчилтэй байх тул шийдвэрүүдийг бүх хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтэйгээр гаргаж, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид эсхүл ТУЗ-ийн гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурсан байна.

Түүнчлэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг үзвэл хэлцэл тус бүрийн гэрээний нөхцөл, гэрээ байгуулах үнэ зэргийг урьдчилан танилцуулж, хэлэлцүүлсний дүнд хувьцаа эзэмшигчдийн саналыг авч, хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлаар аливаа эсрэг санал тэмдэглэгдээгүй байна.

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрлийг хуульд заасан журмын дагуу хэлцэл хийх тухай бүрт хувьцаа эзэмшигчдийн хурлаас буюу эрх бүхий этгээдээс олгосны үндсэн дээр буюу зохих журмын дагуу байгуулсан гэж дүгнэжээ.

**Бусадтай байгуулсан их хэмжээний хэлцэл**

Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд 87.1.1 дэх хэсэгт: "*хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/*"; мөн хуулийн 87.1.2 дахь хэсэгт: "*компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг*" гэж тус тус тодорхойлсон байдаг.

Түүнчлэн, тус хуулийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтэйгээр гаргах бөгөөд 88.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэв ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэхээр тусгасан байна.

Үнэт цаас гаргагчаас аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна.

СЗХ MON BEEF он сар 2022.06.22 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

*Хүснэгт 8. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25%-ын тоон үзүүлэлт*

| № | Хугацаа | Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр) | Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны нэгдүгээр улирал | 199,899,010.00 | 49,974,752.50 |
| 2 | 2021 оны хоёрдугаар улирал | 670,412,743.10 | 167,603,185.78 |
| 3 | 2021 оны гуравдугаар улирал | 1,776,718,637.48 | 444,179,659.37 |
| 4 | 2021 оны дөрөвдүгээр улирал | 3,718,709,091.09 | 929,677,272.98 |
| 5 | 2022 оны нэгдүгээр улирал | 3,810,244,226.26 | 952,561,056.57 |

Дээрх тоон үзүүлэлтээр Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их хэмжээний хэлцэлд хамаарах 2 гэрээ байгуулсан байна. Тодруулбал, сонирхлын зөрчилтэй хэлцэлд багтаж байгаа 2021 оны 09 сарын 02-ны өдрийн Зээлийн шугамын гэрээ болон 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн Зээлийн шугамын гэрээ нь мөн их хэмжээний хэлцэлд тооцогдож байгаа бөгөөд хуулийн фирмийн дүгнэлтээр энэхүү гэрээ нь хуульд заасан журмын дагуу байгуулагдсан байна.

## 2.6 Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг байх ба Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 75,000,000 (далан таван сая) төгрөг ба түүнээс дээш мөнгөн дүн байна. Хуулийн дүгнэлт гарсан өдрөөр Үнэт цаас гаргагч нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээ (буюу 75,000,000 төгрөг ба түүнээс дээш хэмжээ)-ний үүрэг хүлээсэн дараах гэрээг байгуулсан байна.

*Хүснэгт 9. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээний мэдээлэл*

| № | Гэрээний нэр | Үнэ | Гэрээ байгуулсан огноо | Хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Sales Contract | 47,350 ам.доллар *(134,936,609 төгрөг[2])* | 2021.05.24 | Үгүй |
| 2 | Ажил гүйцэтгэх ерөнхий гэрээ | 235,000,000 | 2021.05.28 | Үгүй |
| 3 | Үхрийн хашаа угсралтын ажил гүйцэтгэх гэрээ | 157,000,000 | 2021.09.28 | Үгүй |
| 4 | Гражийн барилгын угсралтын ажил гүйцэтгэх гэрээ | 300,000,000 | 2021.09.03 | Үгүй |
| 5 | Ногоон тэжээл худалдах, худалдан авах гэрээ | 108,000,000 | 2021.12.13 | Үгүй |
| 6 | Ногоон тэжээл худалдах, худалдан авах гэрээ | 102,130,100 | 2021.11.23 | Үгүй |
| 7 | Хамтран ажиллах гэрээ | 100,000,000 | 2021.11.02 | Тийм |
| 8 | Худалдах, худалдан авах гэрээ | 85,000,000 | 2021.06.02 | Үгүй |
| 9 | Зээлийн шугамын гэрээ | 4,849,230,000 | 2021.09.02 | Тийм |
| 10 | Зээлийн шугамын гэрээ | 10,000,000,000 | 2022.03.25 | Тийм |

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүнгээр үүрэг хүлээсэн 10 гэрээ байгуулжээ. Үүнээс 3 гэрээ хэрэгжиж байгаа бөгөөд 7 гэрээний хэрэгжилт дууссан байна.

Хуулийн компанийн зүгээс үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй 2021 оны 11 дүгээр 2-ны өдрийн Хамтран ажиллах гэрээ болон Зээлийн шугамын гэрээнүүдийг тус тус дүгнэсэн байна. Дүгнэлтээр дээрх гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй болохыг дурджээ.

**Компанийн засаглалын кодексийг мөрддөг талаар:**

[2] Гэрээ байгуулсан өдрийн байдлаарх Монголбанкны төгрөгийн ам доллартай харьцах ханш 1 ам доллар = 2,849.41 төгрөг.

СЗХ MON BEEF
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 - 06 - 17

Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаа болон компанийн засаглалын кодексийг мөрдөж хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 27 дүрэм журмыг баталж, батлан мөрдүүлэх нэмэлт журмын төслийг гаргасан байна.

*Хүснэгт 10. Журмын мэдээлэл*

| № | Журмын төрөл | Тоо |
|---|---|---|
| 1 | "Мон Бийф" ХХК-ийн дүрэм | 1 |
| 2 | "Мон Бийф"ХК-ийн дүрмийн төсөл | 1 |
| 3 | "Мон Бийф" ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төсөл | 1 |
| 4 | "Мон Бийф" ХК-ийн ТУЗ-ийн хороодын дүрэм | 3 |
| 5 | Ёс зүйн дүрмийн төсөл | 1 |
| 6 | Ногдол ашгийн журмын төсөл | 1 |
| 7 | Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах төсөл | 1 |
| 8 | Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам | 1 |
| 9 | Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам | 1 |
| 10 | Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журмын төсөл | 1 |
| 12 | Хэрэглэгч, харилцагчийн санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам | 1 |
| 13 | Мэдээллийн үйл ажиллагааны журам | 1 |
| 14 | Нууцын тухай журам | 1 |
| 15 | Хөдөлмөрийн дотоод журам | 1 |
| 16 | Гүйцэтгэлийн удирдлагын журам | 1 |
| 17 | ХАБЭА-н мэдлэг ур чадвар олгох журам | 1 |
| 18 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам | 1 |
| 19 | Хөдөлмөрийн эрүүл ахуйн журам | 1 |
| 20 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам | 1 |
| 21 | Компанийн дотоод хяналтын бодлогын баримт бичгийн төсөл | 1 |
| 22 | Мөшгөлтийн журам | 1 |
| 23 | Бордох үйл ажиллагааны журам | 1 |
| 24 | Борлуулалт худалдан авалттай холбоотой журам | 3 |
| Нийт | | 27 |

Дээрх мэдээллээс харвал Үнэт цаас гаргагч нь 21 журмыг баталж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байгаа бол 6 дүрэм, журмын төслийг нэмж гаргасан нь олон нийтэд хувьцаагаа санал болгож, компанийн хэлбэрээ өөрчлөн, нээлттэй компани болсноор хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангаж, хууль болон эрх бүхий байгууллагын дүрэм журмын шаардлага хангуулж ажиллах зорилготой байна.

Хуулийн фирм нь дүгнэлтээрээ 27 журмыг нэг бүрчлэн Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм журам болон Компанийн засаглалын кодексд нийцэж байгаа эсэхийг хянаж, үнэт цаас гаргагчийн дүрэм журмууд нь хуульд нийцсэн хэмээн дүгнэсэн байна.

Мон Бийф ХК MonBeef LLC Улаанбаатар 6648436

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

# 03

MonBeefLLC
МонБийф ХХК
УЛААНБААТАР
6648436

СЗХ MON BEEF 2022 .08. 22 өдөр БҮРТГЭВ № 03

## 3.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны процесс

2022-06-17 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь орон нутгийн малчдаас бяруу болон шүдлэн үхрийг худалдан авч Төв аймагт байршилтай өөрийн үхрийн фермд авчран эрүүл ахуйн шинжилгээнд оруулж, хөдөлгөөнийг хязгаарлан, шаардлагатай нэмэлт тэжээлийг өгч үхрийн жинг нэмэх, үхрийн махыг шимтэй, шүүслэг болгох замаар стандартын шаардлага хангасан, эрүүл, зөөлөн махыг хэрэглэгчдэд хүргэж байна.

Компани фермийн үйл ажиллагааг эхлүүлснээс хойш Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв аймгуудаас үхрийн татан авалтыг хийсэн бөгөөд хол аймгуудаас үхэр авах нь тээвэрлэлтийн явцад үхрийн жин хаялт, тээвэрлэлтийн зардал их гардаг учир төвийн бүсийн аймгуудаас үхрийн татан авалтаа хийж байна. Бярууны дундаж жин 150-180 кг ба 630,000-756,000 төгрөг, шүдлэнгийн дундаж жин 230-250 кг ба 966,000 – 1,050,000 төгрөгийн хооронд худалдан авдаг. Бага насны үхрийн мах амт сайтай, зөөлөн шүүслэг байдаг учир Үнэт цаас гаргагч нь зөвхөн бяруу болон шүдлэн үхрийг одоогоор үйлдвэрлэлдээ ашиглаж байна.

*Зураг 3. "Мон Бийф" компанийн бизнес загвар*




- Малчдаас нас бага үхрийг худалдан авч сорьц, шинжилгээний лабораторид эрүүл ахуйн шаардлага хангаж буй эсэхийг шалгах.

  Шаардлагатай нэмэлт тэжээлийн орцыг тариаланчдаас худалдан авах.

- Үхрийг процессийн дагуу фермд өсгөж "Цалуут Импекс" ХХК-ийн нядалгааны үйлдвэрт стандартын дагуу боловсруулах.

  Энэ хэсэгт 3 үе шаттай үйлдвэрлэлийн процесс явагддаг бөгөөд MNS: 5024 – 2009, MNS 5023:2001 зэрэг стандартыг баримталдаг.

- "Номин", "Сансар" , "Оргил", "Good price", "Наран" зэрэг супер маркетууд, томоохон ресторан, онлайн сувгуудаар борлуулалт хийх.

  "Мон Бийф" брэндийн бүтээгдэхүүнээр үйлчлэх ресторaныг энэ онд нээхээр төлөвлөж байна.

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

## 3.2 Үйлдвэрлэлийн татан авалтын тухай

Монгол улсад 2021 оны байдлаар 5 сая орчим толгой үхэр тоологдсон бөгөөд үүнээс 40 хувь нь хангайн бүсийн аймгуудад, үлдсэн хэсэг нь баруун, зүүн болон төвийн бүсүүдэд ойролцоо тоотой тархсан байдалтай байна. Улсын хэмжээнд шүдлэн үхрийн дундаж үнэ 677,000 мянган төгрөг байгаа бөгөөд Архангай аймаг үхрийн тоо толгой хамгийн их мөн дундаж үхрийн үнэ хамгийн бага буюу 469,000 төгрөг байна.

*Зураг 4. Үхрийн тоо толгой, 2021 оны байдлаар*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2022)*

Төвийн бүсээс алслагдсан аймгуудаас үхрийн татан авалт хийх үед тээвэрлэлтийн явцад буюу 2-оос 3 хоног өвс, тэжээл идээгүй үхрийн жин хаялт их байдаг тул фермд ирсний дараа тээвэрлэлтийн зардлаас гадна тэжээлийн зардал их гарах сул талтай байдаг. Үнэт цаас гаргагч нь Сэлэнгэ, Булган, Архангай, Төв, Хэнтий аймаг зэрэг төвийн бүсийн аймгуудаас үхрийн татан авалтаа хийх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

*Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн үхрийн татан авалт*

| Аймаг | Худалдан авсан үхрийн тоо |
|---|---|
| Төв аймаг | 346 |
| Булган аймаг | 254 |
| Хөвсгөл аймаг | 194 |
| Улаанбаатар хотын ойролцоох бүсүүд | 179 |
| Дорнод аймаг | 166 |
| Архангай аймаг | 134 |
| Хэнтий аймаг | 31 |
| Сэлэнгэ аймаг | 30 |
| **Нийт** | **1,334** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн дотоод мэдээлэл*

Үнэт цаас гаргагч нь 2021-2022 оны эхний улирлын байдлаар нийт 1,334 шүдлэн, бяруу болон 3-4 настай үхрүүдийг 62 малчин нийт 8 ерөнхий бүсээс татан төвлөрүүлсэн байна.

Татан авч буй үхрийн нас, аймаг нутаг, жингийн хэмжээ зэргээс шалтгаалж худалдан авах үнэ нь 1 килограммыг ойролцоогоор **4,000-4,400** төгрөг байна.

MonBeef LLC
Мон Бийф ХХК
Улаанбаатар
6648436

Бүтээгдэхүүн гарахад хамгийн чухал нөөц нь үхэр ба одоогоор үнэт цаас гаргагч нь зорилтот аймаг бүрийн малчдаас өөрсдийн стандарт шаардлагад нийцсэн малыг шилж сонгон цуглуулдаг. Цаашид татан авалтыг тогтмол бөгөөд үйл ажиллагаанд тулгарах эрсдэлүүдийг багасгах үүднээс тухайн аймаг сумын малчидтай гэрээ хийн аль аль талаас үүрэг хариуцлага хүлээн нийлүүлэлтийн сувгийг тогтмолжуулахаар зорьж байна.

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-06-17
БҮРТГЭВ-03

## 3.3 Тэжээлийн тухай

Тэжээлийн орцыг (хүнсний тариалангийн эсвэл бэлчээрийн) хүнсний бүтээгдэхүүний буюу махны гарцтай харьцуулах харьцааг хэмжихэд тэжээл хувиргалтын харьцаа болон үр ашгийн харьцааг ашигладаг.

### Тэжээл хувиргалтын харьцаа

Нэг килограмм мах, өндөг, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардагдах дундаж малын тэжээлийн хэмжээг доорх зурагт үзүүлэв. Эдгээрээс хамгийн их тэжээл зарцуулдаг нь үхрийн мах бөгөөд 1кг үхрийн мах гаргахын тулд 25кг тэжээл зарцуулдаг байна.

*Зураг 5. Тэжээл хувиргалтын харьцаа (Feed conversion ratio)*




*Эх сурвалж: (Our world in Data, 2021)*

### Уураг хувиргалтын харьцаа

Мах, сүүн бүтээгдэхүүний уургийн үр ашгийг тооцохдоо малын гаралтай эцсийн бүтээгдэхүүн доторх тэжээл болгон уургийн орцын хувиар тодорхойлдог.

*Зураг 6. Уураг хувиргалтын харьцаа / кг (Protein conversion efficiency)*




*Эх сурвалж: (Our world in Data, 2021)*

25%-ийн хувиргалтын харьцаа гэдэг нь малын тэжээлийн орц дахь уургийн 25% нь амьтны гаралтай бүтээгдэхүүнд үр дүнтэй хувирсан гэсэн үг юм. Үлдсэн 75% нь хөрвүүлэх явцад алдагдаж үгүй болдог гэж тайлбарлаж болно.



Мон Бийф ХХ компани

СЗХ MON BEEF
2022 .08 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

### Илчлэг хувиргалтын харьцаа

Мах, сүүн бүтээгдэхүүний илчлэгийн үр ашгийг тооцохдоо малын гаралтай эцсийн бүтээгдэхүүн доторх тэжээл болгон илчлэгийн орцын хувиар тодорхойлдог.

*Зураг 7. Энергийн хувиргалтын харьцаа / кг (Energy conversion efficiency)*




*Эх сурвалж: (Our world in Data, 2021)*

Үхрийн махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд малд өгч буй тэжээлийн орц дах нийт илчлэгийн 1.9% нь малын эцсийн бүтээгдэхүүний илчлэгт үр дүнтэй хувирдаг байна. Үлдсэн хэсэг нь хөрвүүлэх явцад алдагдаж үгүй болдог.

### Улсын нийт тэжээл үйлдвэрлэл

Улсын хэмжээгээр 2020 онд тэжээлийн нэгжид шилжүүлснээр 744.4 мянган тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 12.4 хувь буюу 105.3 мянган тонноор өссөн байна. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн нэр төрөл тус бүрээр авч үзвэл буурсан үзүүлэлттэй байгааг дараах хүснэгтээс харж болохоор байна.

*Хүснэгт 12. Малын тэжээлийн үйлдвэрлэл, мянган тонн*

| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| Бэлтгэсэн хадлан | 1'275.4 | 1'008.1 | 1'229.4 | 1'369.2 | 1'186.2 |
| Ашигласан сүрэл | 9.1 | 8.5 | 10.6 | 9.4 | 5.2 |
| Гар тэжээл | 45.8 | 52.3 | 51.7 | 58.4 | 42.2 |
| Бэлтгэсэн дарш | 3.4 | 1.5 | 5.0 | 23.0 | 8.0 |
| Бэлтгэсэн эрдэс тэжээл | 62.8 | 77.9 | 94.5 | 121.3 | 90.5 |
| Үйлдвэрлэсэн тэжээл | 710.3 | 611.5 | 757.4 | 849.7 | 744.4 |

*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2021*

2019 оны байдлаар Монгол улсад нийт 57 гурил, тэжээлийн үйлдвэр, цехүүд байгаагаас цагт 2 тонноос дээш тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай тэжээлийн үйлдвэр 14 (гурилын үйлдвэр ороод), үлдсэн нь жижиг оврын тэжээлийн цех байна.

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 13. Тэжээлийн үйлдвэрлэгчдийн тоо, хүчин чадал, 2019 оны байдлаар*

| Үйлдвэрлэгчийн төрөл | Бүтээгдэхүүн | Тоо | Үйлдвэрлэлийн нийлбэр хүчин чадал, тонн/жил | Ашиглаж буй хүчин чадал, хувиар |
|---|---|---|---|---|
| Гурилын үйлдвэр | Хивэг | 27 | 195,365 тонн | 32% |
| Тэжээлийн үйлдвэр, цехүүд | Багсармал, хивэг, хорголжин, холимог тэжээл, уурагт тэжээл | 30 | 193,600 тонн | 27% |
| Нийт | | | 388,965 тонн | 29% |

*Эх сурвалж: (ХХААХҮЯ, 2019)*

**Үнэт цаас гарагчийн үйлдвэрлэлийн тэжээлийн хэрэглээ**

Үнэт цаас гаргагч нь олон жилийн судалгаа, шинжилгээнд үндэслэн малын тэжээлийн орцыг тодорхойлон, дотоодын зах зээлээс бүрэн хангахуйц түүхий эдүүдээр малын тэжээлийг бэлтгэж байна. Одоогоор Сэлэнгэ, Дархан, Төв аймгууд болон Улаанбаатар гурил компаниас тэжээлийн орцуудыг татан авдаг. Тэжээлийн орцын ихэнх хувийг рулонтой ногоон тэжээл болон пресстэй ногоон тэжээл эзэлж байна. Тэжээлийн бүтцийн дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 14. "Мон Бийф" компанийн тэжээлийн бүтэц, үнийн мэдээлэл*

| № | Түүхий эд | 1тн тэжээлийн үнэ, төг | Тэжээлийн орцын харьцаа хувиар |
|---|---|---|---|
| 1 | Рулонтой ногоон тэжээл | 330,000 | 38% |
| 2 | Пресстэй ногоон тэжээл | 280,000 | 36% |
| 3 | Хивэг | 390,000 | 25% |
| 4 | Шохой чулуу | 150,000 | 0.15% |
| 5 | Рапсын шахдас | 1,430,000 | 0.75% |
| 6 | Ашигт долооц | 1,000,000 | тааваар нь |
| 7 | Хужир | 440,000 | тааваар нь |
| | | | **100%** |

Ашигт долооц болон хужрыг эрдсийн дутагдлыг нөхөх зорилгоор малд тааваар нь өгдөг. Компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд тэжээлийн зарим орцыг өөрсдөө тарьж ургуулахаар төлөвлөж байна. Энэ нь тэжээлийн шимт чанарыг нэмэгдүүлэх боломжтойгоос гадна эцсийн бүтээгдэхүүний өртгийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой төсөл юм.

6648436 MonBeefLLC УЛААНБААТАР ХОТ
Мон Бийф ХХ компани

СЗХ MON BEEF
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-17
БҮРТГЭВ-03

## 3.4 Үйлдвэрлэлийн гарцын тухай

Олон улсын дундаж үхрийн махны гарцтай харьцуулахад манай улсын үхрийн махны гарц 2.5-3 хувиар бага байна.

*Хүснэгт 15. Малын дундаж жин, махны гарцын хэмжээ*

| Малын төрөл | Дундаж амьд жин, кг | Махны гарц, Монгол Улс, % | Махны гарц, дэлхийн дундаж |
|---|---|---|---|
| Үхэр | 250 | 47.5% | 50 - 60% |
| Хонь | 50 | 42.0% | 45 - 55% |
| Ямаа | 45 | 38.0% | 48 - 50% |
| Адуу | 260 | 42.9% | 50 - 57% |
| Тэмээ | 500 | 49.8% | 50 - 55% |

*Эх сурвалж: (ХХААХҮЯ, 2022)*

100 хоног бордсон залуу үхрийн хувьд жин бага ч махны амт чанар сайн тул стейкний шаардлага хангах цэвэр махны хэмжээ нийт гарцын 36 хувь, цул болон ястай мах 45 орчим хувийг, дайвар болон бусад хэсэг 20 орчим хувийг бүрдүүлж байна.

## 3.5 Нядалгааны процессын тухай

Үйлдвэрийн процесс нь хүнсний зориулалттай төхөөрөх малыг сонгохоос эхлээд үзлэг шинжилгээнд оруулж өвчтэй эсэхийг шалгах, ариутгасан сав баглаа, боодолтой эцсийн бүтээгдэхүүн бэлэн болгох бүхий л процессыг авч үзэх юм. Мал нядалгаа, эцсийн бүтээгдэхүүнийг бэлэн болгох процесс нь үндсэн 3 үе шаттай байх бөгөөд тус бүрийн үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн шаардлага, стандарттай байдаг. Үйлдвэрлэлийн процессыг товч байдлаар доор задлан үзүүлэв.

1. **Мал бэлтгэл, хорио цээр -** Эхний үе шатын зорилго нь хүнсний зориулалттай төхөөрөх эрүүл малыг сонгох юм. Малын бүртгэл хийснээс 21-28 хоног карантинд байлгасны дараа тандан шинжилгээ авдаг.

*Зураг 8. Мал бэлтгэл, хорио цээрийн үе шат*




2. **Мал төхөөрөх** - Хүнсний зориулалттай төхөөрөх малыг үйлдвэрт хүлээн авч хэсэг хугацаанд сойн амраадаг. Үүний дараа төхөөрөхийн өмнөх үзлэг хийх бөгөөд хэвийн малыг цахилгаан хүчдэлийн тусламжтай муужруулан цуслах, арьсыг хуулах, гэдэс дотрыг гаргах гэсэн дараалаар төхөөрнө. Дайвар болон махыг ангилан гэдэс, толгой салгасан үеийн жинг тэмдэглэх шаардлагатай.

*Зураг 9. Мал төхөөрөх үе шат*




3. **Мах ангилах, шулах дараалал** - Гулууз тал өрөөл мах бүхий түүхий эдийг хүлээж авна. Орчны эрүүл ахуйн шаардлага чухал бөгөөд өрөөний хэм +10-12'C ба агаарын харьцангуй чийглэг 75-80% байх ёстой. Түүхий эдийг цэвэрлэж, сортлосны дараа хэсэглэн хуваахдаа үйлдвэрийн аргаар болон уламжлалт аргыг ашигладаг. Стандартын дагуу хэсэгчлэн, ангилсны дараа вакум савлагаанд хийж эцсийн бүтээгдэхүүний хяналтын хэсэг рүү явуулна.

*Зураг 10. Мал ангилах, шулах үе шат*



СЗХ MON BEEF
2022 06 22
БҮРТГЭВ
№01



2022-06-17
БҮРТГЭВ-03

## 3.6 Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн

“Мон Бийф” компани нь зөөлөн, шүүслэг, шимтэй үхрийн махыг хэрэглэгчдэдээ хүргэхээр зорьж байгаа бөгөөд бүтээгдэхүүнүүдийг үндсэн болон нэмэлт бүтээгдэхүүн гэж ангилан тус бүрийн онцлог шинж чанарыг танилцуулж байна. Компанийн гол нэрийн бүтээгдэхүүн нь стейкний мах бөгөөд таван өөр төрлийн стейкний махыг ресторанууд болон олон нийтийн сүлжээ дэлгүүрүүдээр худалдаалж байна.

*Хүснэгт 16. Стейкний махны төрөл, онцлог*



**T-bone steak**

Нурууны махан стейк – Маханд дурлагсдын хамгийн дуртай стейкний төрөл бөгөөд хамгийн зөөлөн гол махан ба өөх тостой хоёр стейкийг нэг дороос амталж болох юм.



**Rib-eye steak**

Үхрийн хавирганы толгой хэсгийн стейк – Хамгийн шүүслэг, нарийн ширхэгтэй стейкний төрөл бөгөөд ястай болон ясгүй хэлбэрээр зарагддаг. Бусад стейктэй харьцуулахад илүү амттай боловч бага зэрэг зажлууртай байдаг.




**Sirloin steak**

Нурууны махан стейк – Үхрийн нуруу, хавирганы ардын хэсгээс авсан ураг ихтэй, өөх тос багатай стейкний төрөл юм. Бусад стейктэй харьцуулахад бага зэрэг хатуу учир үнийн хувьд хямд байдаг.



**Flank steak**

Цорой махан стейк – Үхрийн хэвлийн дагуух цоройн хэсгийн махнаас авдаг, бусад хэсэгтэй харьцуулахад өөх тос багатай, эслэг ихтэй стейкний төрөлд ордог бүтээгдэхүүн.



**Tenderloin steak**

Үхрийн гол махан стейк – Үхрийн нурууны дагуух цилиндр хэлбэртэй ачаалал авдаггүй гол махны хэсгээс авдаг, хамгийн зөөлөн, нарийн ширхэгтэй стейкний мах бөгөөд үнийн хувьд хамгийн үнэтэй бүтээгдэхүүн юм.

“Мон Бийф” компани нь гол нэрийн бүтээгдэхүүн болох стейкний зөөлөн махыг гаргахын тулд бэлчээрийн үхрийг 100 хоног бордож, хөдөлгөөнийг хязгаарлан эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэж байна.



Mon Beef LLC
УЛААНБААТАР

*Хүснэгт 17. Стейкнээс бусад бүтээгдэхүүний төрөл, онцлог*

|  |  |  |
| --- | --- | --- |
| **Өвчүүний цул мах** | **Гуяны цул мах** | **Татсан мах** |
| Үхрийн өвчүү – Чанаж хэрэглэхэд илүү тохиромжтой бөгөөд үхрийн махны зөөлөн, амттай хэсгийн мах юм. | Үхрийн гуяны цул мах – Төрөл бүрийн хоолонд өөрийн хүссэнээр бэлдэж хэрэглэх боломжтой, жижиг хэмжээгээр савлагдсан. | Үхрийн өөхтэй татсан мах – Бууз, хуушуур хийхэд ашиглахаас гадна хүүхдийн бантан, зутан хийхэд тохиромжтой эрүүл, шинэ бүтээгдэхүүн юм. |
|  |  |  |
| **Хааны цул мах** | **Хавирга** | **Гуляшны мах** |
| Үхрийн хааны цул мах - Төрөл бүрийн хоолонд өөрийн хүссэнээр бэлдэж хэрэглэх боломжтой, жижиг хэмжээгээр савлагдсан. | Үхрийн хавирга – Усанд чанах, жигнэх мөн тосонд шарж идэхэд тохиромжтой байдлаар бэлтгэгдсэн бүтээгдэхүүн. | Зөөлөн гуляшны мах – Гэрийн нөхцөлд мөн ресторанууд хоолондоо шууд ашиглах боломжтой зөөлөн, дөрвөлжин хэрчиж бэлтгэсэн бүтээгдэхүүн. |

Мөн гол нэрийн бүтээгдэхүүн болох стейкний махнаас гадна өдөр тутмын хэрэглээнд зориулан жижиглэж, татаж бэлтгэсэн үхрийн зөөлөн махны 6 төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ санал болгож байна. Гарал үүсэл нь тодорхой, үйлдвэрийн стандартын дагуу бэлтгэсэн, эрүүл хүнс хэрэглэхийг зорьдог хэрэглэгчдэд эдгээр бүтээгдэхүүнүүд нь хамгийн зөв сонголт болж чадах юм.

СЗХ MON BEEF
2022 08 22
БҮРТГЭВ
№ 01



2022-08-17
БҮРТГЭВ-03

## 3.7 Үнэт цаас гаргагчийн борлуулалтын сувгийн тухай

"Мон Бийф" компани нь бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг үндсэн 5 хэсэгт хуваан, зорилтот бүлгүүдийг тодорхойлон борлуулалтаа хийж байна.

*Зураг 11. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын сувгууд (төлөвлөгөө)*




**Сүлжээ дэлгүүрүүд** – "Номин", "Сансар" "Оргил" "Good price", "Efes", "Fresco" болон "Ханбүргэдэй" зэрэг сүлжээ дэлгүүрүүдийн нийт 120 цэгт хэлдээсэн бүтээгдэхүүнийг байршуулан ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр сүлжээ дэлгүүрийн зарим салбарт бүтээгдэхүүнээ нийлүүлээд байна. Сүлжээ дэлгүүрүүд нь нийт борлуулалтын 30%-ийг бүрдүүлэх буюу томоохон борлуулалтын суваг юм.

**Орон сууцуудын дэргэдэх жижиг дэлгүүрүүд (M&S Apart)** - Борлуулалт өндөртэй хотхон, орон сууцуудын дэлгүүрүүдэд нийтдээ 300 цэг байршуулж худалдаалахаар төлөвлөж байна.

**Ресторан, кетеринг, буудал, кафе болон бусад байгууллагууд (ХоРеКа)** - Одоогийн байдлаар Нагоми, Little sheep сүлжээ ресторануудад стейк болон бусад төрлийн бүтээгдэхүүнүүдийг нийлүүлж байгаа бөгөөд энэ онд Мон Бийф стейкний ресторанparam Улаанбаатар Галлерэй салбарт нээхээр ажиллаж байна.

**Борлуулалтын нэрийн цэгүүд (Борлуулалтын цэг)** - Нэрийн барааны 5 цэгээр дамжуулах шинэ махны худалдаа хийх бөгөөд нийт борлуулалтын 10 хувийг нэрийн цэгүүдээр борлуулах төлөвлөгөөтэй байна.

**Онлайн борлуулалт (Онлайн худалдаа)** - Компанийн веб захиалга, шууд утасны захиалга болон Ток ток зэрэг бусад онлайн захиалгатай хамтран ажиллаж байна.

## 3.8 Өрсөлдөөний давуу тал

Манай улсад 100% фермийн аж ахуйд бордогдож, хэрэглэгчдийн гарт хүрч буй ижил төрлийн бүтээгдэхүүн ховор бөгөөд ихэнх нь орон нутгийн малчдаас авсан бэлчээрийн үхрийн махыг ашиглаж байна. Фермийн үхрийн мах нь үнийн хувьд зах зээлд өрсөлдөхүйц, гарал үүсэл тодорхой, зөөлөн шүүслэг байдаг. Зарим өндөр зэрэглэлийн ресторанууд Япон, Австрали зэрэг улсуудаас хэлдээсэн үхрийн махыг авчран үйлчилгээндээ ашиглаж байна. Үнэт цаас гаргагчийн бизнес загвартай ижил чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй, нэг төрлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудаас өрсөлдөөний давуу тал үүсэж буй зүйлсийг дурдвал:

**Зах зээлд нэвтрэлтийн давуу байдал** - Толгой компани болох Таван Богд Трейд компанийн охин компаниуд болох Нагоми, Little sheep сүлжээ ресторанууд, хамтын ажиллагаатай томоохон сүлжээ дэлгүүрүүдэд бүтээгдэхүүнийг байршуулснаар хэрэглэгчдэд хурдан танигдах давуу талтай. Мөн хэрэглэгчдэд стейкний төрөл, амтыг мэдрүүлэх шинэ ресторанparam төсөл нь хотын төвд байршилтай учир дотоодын

СЭХ 2022 оны 06 сар 22 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

хэрэглэгчдийг татахаас гадна аялал жуулчлалын салбарын хэрэглэгчдийг татах ихээхэн боломжтой юм.

**Үйлдвэрийн хүчин чадлын давуу тал** - Махны чиглэлийн үхрийн фермүүдээс хамгийн ихдээ 5000 үхрийн хүчин чадалтай өрсөлдөгч ферм байгаа болович энэ компани нь дангаараа зах зээлийн эрэлтийг хангах боломжгүй юм. Фермийн чиглэлийн дундаж хүчин чадал бүхий үйлдвэрийг байгуулах нь үйлдвэрлэлийн процессыг хурдасгах, өрсөлдөхүйц үнээр эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх давуу талтай.

*Хүснэгт 18. Өрсөлдөгчдийн харьцуулсан судалгаа*

| | Гацуурт хүнс | Занаду | БиБи батчер | Хөвсгөл лэйк | ХҮЧҮ | Талын монгол | Мон Бийф |
|---|---|---|---|---|---|---|---|
| Ферм / үхрийн даацаар тооцов / | 5000 | 600 | X | X | 1000 | X | 1000 |
| Фермд тэжээх хоног | 210 | 120 | X | X | 90 | X | 100 |
| Махны чиглэлийн Үүлдэр | 3 | 1 | 1 | 3 | 2 | 1 | 1 |
| Үйлдвэр | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Үхрийн махан бүтээгдэхүүний тоо | 25 | 35 | 20 | 4 | 42 | 15 | 10 |
| Групп | Гацуурт групп | X | X | X | X | Грийн групп | Таван Богд групп |
| Нэрийн дэлгүүр | 8 | 1 | 2 | X | X | X | 2 |
| Нэрийн ресторан | 1 | 1 | X | 1 | X | X | X |
| Сүлжээ дэлгүүр | 1 | X | X | X | X | X | 8 |
| Хүргэлт | 50,000 төгрөгөөс дээш худалдан авалтад | 1,2,4,5 дахь өдрүүдэд хүргэдэг | 1-2 хоногт хүргэнэ | Хот дотор үнэгүй | 50,000 төгрөгөөс дээш худалдан авалтад | Хот дотор үнэгүй | Хот дотор үнэгүй |
| Сэврээдэг эсэх /Dry age/ хоногоор | X | 7 | 14 | 28 | 14 | X | X |
| Хагас боловсруулсан бүтээгдэхүүн гаргадаг эсэх | X | X | 1 | X | X | 1 | X |
| Веб хуудас | *Gatsuurt.mn* | *www.xanadurazorback.com* | X | *www.khuvsgullake.mn* | X | *www.taliinmongol.mn* | *www.monbeef.mn* |
| Сошиал хуудас /FB дагагчаар/ | 69511 | 13425 | 18050 | 20970 | 6435 | 131928 | 29121 |
| E-commerce | X | X | X | 1 | X | X | 1 |



Мон Бийф ХХ КОМПАНИ Mon Beef LLC 6648436 УЛААНБААТАР ХОТ

СЗХ MON BEEF 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17

## 3.9 Эрсдэлийн удирдлага

Компанийн дотоод үйл ажиллагааны функцүүд болох үйлдвэрлэл, үйл ажиллагаа, хүний нөөц, борлуулалт болон санхүүгийн үйл ажиллагаанд ямар эрсдэлүүд тулгарах боломжтойг тодорхойлон эдгээрийн компанид үзүүлэх нөлөө болон эрсдэлийн удирдлагын хэлбэрүүдийг тодорхойлов.

*Хүснэгт 19. Эрсдэлийн матриц*

**Эрсдэл тохиох магадлал** (Их → Бага)

**Эрсдэлийн учруулж болохуйц хохирол** (Бага → Их)

| Хохирол \ Магадлал | Их | | | | Бага |
|---|---|---|---|---|---|
| Их | Ханган нийлүүлэгчээ алдах | Бяруу худалдан авалт удаашрах | Тээвэрлэлтийн асуудал үүсэх | Бярууны жингийн өсөлт хангалтгүй байх | ХАБЭА зөрчигдөх |
| | Фермийн үхэр өвчлөх | Оновчгүй шийдвэр гаргах | Үхрийн татан авалтын журам мөрдөлт алдагдах | Бүтээгдэхүүний чанарт өөрчлөлт орох | Бэлэн бүтээгдэхүүний хадгалалт зөрчигдөх |
| | Алдаатай өртгийн тооцоолол хийх | Бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн зардал хэтрэлт | Үйлдвэрийн процесс доголдох | Нядалгааны үеийн горим алдагдах | Борлуулалтын суваг буруу тодорхойлох |
| | Малын хорио цээр | Савлагааны түүхий эд материал хомсдох | Хүний нөөцийн хомсдол | Ажилтнуудын тогтвор суурьшил алдагдах | Тэжээлийн хангамж муудах |
| Бага | Байгалийн давагдашгүй хүчин зүйл | Үйлдвэрийн процесс санхүүжилт дутагдах | Тэжээлийн орц чанар муудах | Уялдаа холбоо муудах | Хил гааль хаагдах |

Мөн компаниас хамааралгүйгээр гадаад орчны нөлөөлөл компанид ямар нөлөө үзүүлэх боломжтойг тодорхойлон тэдгээрийн эсрэг авах арга хэмжээнүүдийг доор тодорхойлов.

СЗХ 2022 06. 22 сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ 03

### Үйлдвэрлэлийн эрсдэл

Компанийн үйлдвэрлэлд үхрийн татан авалтаас эхлээд бордолт, тэжээл, нядалгаа болон эцсийн бүтээгдэхүүн бэлэн болох бүх процесс хамаарагдах юм. Хүнсний чиглэлийн үйлдвэрлэлийн компани учраас өдөр тутмын үйл ажиллагааг тасалдалгүй явуулахад тохиолдох боломжтой эрсдэлүүдийг нарийн тодорхойлон, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авах, шаардлагатай хэсгүүдэд тодорхой санхүүжилт оруулах гэх мэт аргыг ашиглаж байна.

| Эрсдэлийн төрлүүд | Юу тохиолдож болох вэ? | Компани ямар арга хэмжээ авах вэ? |
|---|---|---|
| Мал бэлтгэл | Үхрийн татан авалттай холбоотой журам зөрчих, төлөвлөснөөс өндөр үнээр худалдаж авах | Хямд үед фермийн боломжит хэмжээгээр нөөц бүрдүүлж үйлдвэрийн аргаар боловсруулан нөөц үүсгэх |
| | Ханган нийлүүлэгчээ алдах, үүнтэй холбоотой төлөвлөөгүй аймгуудаас татан авалт хийх, тээврийн зардал нэмэгдэх, бүтээгдэхүүний гарц муудах | Ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулах. Төлөвлөөгүй аймгаас худалдан авах шаардлага үүсвэл тээвэр болон үнийг хамгийн багаар тохиролцон худалдан авна. Фермийн аргаар бордоход илүү өндөр ашиг шим өгөх үхрийг сонгон авах. |
| | Өвөл хаврын улиралд үхрийн олдоц багасах, намар хэт ихээр худалдан авснаас нэг үхрийг тэжээх хугацаа уртсах | Урьдчилсан байдлаар нийлүүлэгчидтэй гэрээ хэлцэл хийх. Тугал худалдан авч хямд үнээр бордох. Фермийн үхрийн нөөцийг хангалттай хэмжээнд барьж ажиллах /үл тасалдуулах/ |
| | Тээвэрлэлтийн явцад осол гарах, тээвэрлэлт удаашрах | Техникийн бүрэн бүтэн байдлыг урьдчилан бэлдэх. Жолоочийн эрүүл мэнд хэвийн ажил үүргээ хийж гүйцэтгэхэд хяналт шаардлага тавих. Зайлшгүй тохиолдолд дараагийн болон шилжүүлэн ачих техник хэрэгсэл хүний нөөцийг бэлэн байлгах. Урьдчилан сануулах. |
| Үхэр бордолт | Фермийн үхэр өвчин, тахал тусах - Тухайн тээвэрлэж ирсэн сум, орон нутагт малын гоц халдварт өвчин, тахал гарсан эсэхээс, эсхүл тус бүс нутагт ойр, залгаа нутагт байрлаж байсан бол урьдчилан сэргийлэх тарилга, эмчилгээ хийгдээгүй бол бордолтод байсан үхэр мөн халдварлаж болзошгүй | Малын гоц халдварт өвчин бүхий бүс нутгаас мал худалдан авахгүй байх, хил залгаа нутаг дэвсгэрт нь өвчин гарсан сум орон нутгаас, мал худалдан авахаар бол вакцин, тарилга туулгалтад хамруулсан баримтыг шалгах ажлыг зохион байгуулна. Аж ахуйд тээвэрлэгдэн ирсэн тохиолдолд мал эмнэлгийн үзлэгт хамруулан халдварт болон халдварт бус өвчний шинж тэмдэгтэй үхэр байвал эмчилгээний хашаанд тусгаарлан эмчилж эдгэсэн үед бордолтын хашаанд оруулах |



MonBeef LLC Мон Бийф ХК УЛААНБААТАР

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
СЗХ
2022 оны 07 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

| | | |
|---|---|---|
| | Жингийн хангалттай нэмэгдэлгүй байх | Жингийн нэмэгдлийг тогтмол хэмжээнд барихын тулд тэжээлийн түүхий эдийг хүлээж авахдаа шинжилгээнд хамруулж уураг, бусад агууламжийг шалгаж тогтмол стандартын дагуу шалгаж хүлээж авах |
| | Тэжээлийн хангамж болон орцын чанар муудах - Хангалттай шим тэжээл авч чадахгүйн улмаас халдварт бус өвчнөөр өвчлөх, жингийн нэмэгдэл хангалттай хэмжээнд хүрэхгүй байх | Тэжээлийн түүхий эд, ногоон тэжээл, буудай зэргийг худалдан авах гэрээ байгуулахдаа тухайн жилийн бяруу худалдан авах төлөвлөгөөнд уялдуулан чанартай түүхий эдийг хүрэлцэхүйц хэмжээнд тариалуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулах |
| Нядалгаа | Нядалгааны үед ариун цэврийн горим алдагдах, бүтээгдэхүүний чанарт муугаар нөлөөлөх - Хэрэглэгчийн санал гомдол нэмэгдэх, сэтгэл ханамж буурах, компанийн нэр хүндэд нөлөөлөх, худалдан авалт буурснаар ашиг буурах | Эрүүл ахуйн журам мөрдөх, технологийн хяналтыг шат бүрд хийж, тогтмол хяналт тавих |
| | Тоног төхөөрөмж эвдрэх, засвар хийх сэлбэг хомс байх. Үйлдвэрлэлийн процесс доголдох | Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, тоног төхөөрөмжийн урсгал засварын хуваарь гаргаж тогтмол үзлэг шалгалт хийх, дашборд хөтлөх, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх |
| Савлагаа | Савлагааны горим, журам зөрчсөнтэй холбоотой бүтээгдэхүүний чанар муудах | Технологийн зааврын дагуу технологийн хяналтыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд хийх, үйлдвэрийн ажилчдад чанар стандартын сургалт тогтмол орох |
| | Савлагааны түүхий эд материал хомстож, нийлүүлэлт хангалтгүй байснаар бүтээгдэхүүний гарц буурах | Үйлдвэрлэлийн төлөвлөгөө болон борлуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан сав баглаа боодлын төлөвлөлт сар бүр хийж нөөц бүрдүүлэлт үүсгэж явах |

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

### Үйл ажиллагааны эрсдэл

Компанийн үйл ажиллагааны эрсдэлд гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалттай холбоотой хэн нэгний эрх ашиг зөрчигдөх мөн ферм болон оффисын ажилчдын ажлын уялдаа холбооноос үүдэлтэй эрсдэлүүдийг авч үзсэн.

| Эрсдэлийн төрлүүд | Юу тохиолдож болох вэ? | Компанид ямар нөлөө үзүүлэх боломжтой вэ? |
|---|---|---|
| Ферм болон оффисын үйл ажиллагаа | Компанийн гүйцэтгэх удирдлагын оновчгүй шийдвэр гаргалттай холбоотой компанийн үйл ажиллагаа доголдох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх | ТУЗ-н даргын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлж томоохон шийдвэр гаргалтад хамтран ажиллах |
| | Ферм болон оффисын ажилчдын ажлын уялдаа холбоо тодорхойгүйгээс бизнесийн процесст доголдол үүсэх, шийдвэр гаргалт удаашрах | Ферм болон үйлдвэрийн удирдлагуудын ажлыг хуваарьт зохицуулалт хийсэн ба 7 хоногийн 2-3 өдөр оффис дээр ажиллах процессыг алдагдуулахгүй ажиллах |
| | Фермд ажиллах хүний нөөцийн хомсдол үүсэх, туршлагатай ажилчдаа алдах | Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрны өдөрлөг хийх, ажилтнуудаа идэвхжүүлэн халамжлах |
| | Ажлын байрны сэтгэл ханамж, цалин урамшууллын систем тодорхойгүй байдлаас үүдэлтэй ажилчид тогтвор суурьшилгүй ажиллах | Ур чадвар, хандлагын сургалтыг тогтмол зохион байгуулах, идэвхжүүлэх, шинэ ажилтнуудаа сургаж хөгжүүлэх урамшуулалт хөтөлбөр гарган сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх |
| | Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал зөрчигдөх, хагас болон бүтэн хөдөлмөрийн чадвар алдах | ХАБЭА-н зааварчилгааг мөрдөж ажиллах, ажлын байрны хяналт шалгалтыг тогтмол хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх |



Мон Бийф ХХК MonBeefLLC УЛААНБААТАР ХОТ 6648436

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

### Борлуулалт, маркетингийн эрсдэл

| Юу тохиолдож болох вэ? | Компанид ямар нөлөө үзүүлэх боломжтой вэ? |
|---|---|
| Борлуулалтын суваг, зорилтот хэрэглэгчид болон эрэлтийг буруу тодорхойлсонтой холбоотой бүтээгдэхүүний борлуулалт хангалтгүй байх | Зах зээлийн нөхцөл байдал болон борлуулалтын суваг зорилтот хэрэглэгчийн судалгаа шинжилгээг сайтар хийн, бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг урьдчилан тодорхойлон борлуулалтыг нэмэгдүүлэх арга замыг судлан зах зээлд бүтээгдэхүүнийг нэвтрүүлнэ. |
| Бэлэн бүтээгдэхүүний хадгалалт болон түгээлтийн журам алдагдаж, бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд хүргэх хугацаа хойшлох | Борлуулалтын багаас агуулах руу урьдчилсан захиалгыг тогтмол өгч ажиллах, агуулах түгээлт хийх өдрийн өмнөх өдөр захиалгыг бэлтгэх зэргээр борлуулалт, агуулах, түгээлтийн хоорондын уялдаа холбоог сайжруулна. |

### Санхүүгийн эрсдэл

| Юу тохиолдож болох вэ? | Компанид ямар нөлөө үзүүлэх боломжтой вэ? |
|---|---|
| Компани өргөжих, үйлдвэрлэлийн процессыг сайжруулахад санхүүжилт дутагдах | Мөнгөн урсгалын төлөвлөлтийг сараар болон жилээр урьдчилж бодитой гаргаж, тасралтгүй шинэчлэх |
| Өртгийн тооцооллыг алдаатай хийх, үүнтэй холбоотой санхүүгийн алдагдалд орох | Өртөг бодолтын үе шатыг зардлын ангилал онцлогоос нь хамааруулж, худалдан авалт, бордолт, нядалгаа, сэврээх, боловсруулах, бэлэн бүтээгдэхүүн болгох гэсэн 6 үе шатанд хувааж, тухайн үе шат тус бүрд хамаарах зардлуудыг нарийн хуваарилан өртөг бодолтыг оновчтой хийнэ. Гарцын стандарт нормуудыг оновчтой тогтоож үйл ажиллагаандаа нягт баримталж ажиллана. |
| Үйлдвэр барих, тоног төхөөрөмж авахтай холбоотой зардлууд нь төлөвлөсөн өртгөөс давах | Аливаа худалдан авалтыг хийхээс өмнө 2-3 газрын үнийн саналыг харьцуулж, нарийн судалсны үндсэн дээр худалдан авалтын шийдвэрийг гаргадаг. Төлөвлөсөн өртгөөс давуулахгүйн тулд тухай бүр нь судалгаагаа шинэчилж ажиллана |

## Гадаад хүчин зүйлийн эрсдэл

| Юу тохиолдож болох вэ? | Компанид ямар нөлөө үзүүлэх боломжтой вэ? |
|---|---|
| Улс орныг хамарсан тахал, өвчлөлтэй холбоотой хорио цээр тогтоох эрсдэл | Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтын ажиллагааны хүрээнд зохих түр журмын дагуу малын хөдөлгөөнийг хийх |
| Олон улсын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор хил хаагдах, шаардлагатай түүхий эд материалын худалдан авалт зогсох | Сав баглаа боодол гэх мэт бараа материалын нөөцийг зохистой бүрдүүлж, урьдчилан төлөвлөж ажиллана. |
| Байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсоноор фермийн үхрүүд хорогдох | Фермийн үхрүүд хорогдсоноор компанийн үйл ажиллагаа доголдох, борлуулалт, үйлдвэр г.м субъектүүдийн зардал ихсэх учир урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авах |
| Толгой компани болон түүний охин компаниудын үйл ажиллагааны сөрөг нөлөө илэрсэн тохиолдолд компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх | Бизнесийн салбар болон үйл ажиллагаа тусдаа явагдах тул шаардлагатай тохиолдолд мэдэгдэл хийх |
| Гадаад валютын эрсдэл | Тоног төхөөрөмж болон сав баглаа боодлоос бусад бүх шаардлагатай түүхий эд материалуудыг дотоодоос худалдаж авдаг тул, гадаад валютын эрсдэл харьцангуй бага. Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг төлөвлөхдөө гадаад валютын ханшийг нөөцтэй төлөвлөж байна. |

СЗХ MON BEEF 2022.06.22 өдөр БҮРТГЭВ №01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## 3.9 SWOT шинжилгээ

### ДАВУУ ТАЛ

**Хямд бөгөөд эрэлтийг хангахуйц гол түүхий эд** - Бүтээгдэхүүний хамгийн том түүхий эд нь үхэр ба Монгол улсын хувьд 2021 оны мал тооллогоор 5 сая орчим үхэр байна. Үнэт цаас гаргагчийн хувьд жилд дунджаар 5,000-8,000 толгой үхэр нядалгаанд оруулахаар төлөвлөөд байгаа нь хамгийн чухал нөөцийн хувьд дотооддоо хангалттай байна гэж үзэж байна. Мөн үхрийг фермд бордон тэжээж байгаа ба энэхүү бордоо, тэжээлийн 90 орчим хувийг дотоодоос бүрэн хангах боломжтой байна.

**Зах зээлд ялгарал үүсэхүйц бүтээгдэхүүн** - Боловсруулсан үхрийн махны тэр дундаа стейкний махны хувьд томоохон ресторан, бусад хоолны үйлчилгээ эрхэлж буй байгууллагууд болон сүлжээ дэлгүүрүүдэд нийлүүлж буй махны ихэнх хувь нь импортынх байгаа ба Үнэт цаас гаргагчийн хувьд Монгол хөрсөнд ургасан шимт тэжээлээр бордон, эрүүл ахуйн стандартыг дээд зэргээр сахин бүтээгдэхүүнээ бэлтгэн хэрэглэгчид хүргэж байна. Үхрийн мах нь эрүүл ахуйн болон нядалгааны стандартын дагуу бэлтгэгдэж хэрэглэгчдэд хүрдэг давуу талтай.

**Борлуулалт, маркетингийн хүчтэй сувгууд** - Борлуулалтын 5 сувгаар бүтээгдэхүүнээ борлуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үүнд толгой компани болох “Таван Богд Трейд” ХХК болон бусад зэргэлдээ компаниуд, хамтын ажиллагаатай ресторан, сүлжээ дэлгүүрүүдээр борлуулалт, маркетинг хийх нь зах зээлд хурдан нэвтрэхэд давуу талыг үүсгэж байна.

**Зах зээлд ойр үйлдвэрийн байршил** - Төв аймгийн Сэргэлэн сумд байрлах үхрийн ферм болон шинээр барих гэж буй үйлдвэр нь зорилтот сегмент буюу Улаанбаатар хотын хэрэглэгчдэд шинэ бүтээгдэхүүнийг хурдан шуурхай хүргэхэд байршлын хувьд хамгийн тохиромжтой гэж үзэж байна.

**Үйлдвэрлэл, худалдааны салбарт туршлагатай баг хамт олон** - Том хувьцаа эзэмшигч болох “Таван Богд Трейд” ХХК-ийн хувьд үйлдвэрлэл, худалдааны салбарт үйл ажиллагаагаа амжилттай явуулж, эцсийн хэрэглэгчдэд хүрч ажиллаж байна.

### СУЛ ТАЛ

**Шинэлэг салбар тул хэрэглэгчдийн ойлголт сул** - Иргэдийн 95 гаруй хувь нь уламжлалт буюу ахуйн аргаар нядалсан хямд өртөгтэй махыг хэрэглэдэг ба фермд тэжээгдсэн, үйлдвэрийн аргаар нядалсан эрүүл махыг хэрэглээнд хоногшуулах нь иргэдийн орлого, хүнсний талаарх боловсролтой шууд холбоотой тул бизнесийн эхний жилүүдэд маркетинг, борлуулалтын зардал өндөр байна.

**Нядалгааны үйлдвэр болон сорьц, шинжилгээний газар байхгүй** - Одоогоор үхрийн нядалгааг Налайх дүүрэгт байрлах “Цалуут Импекс” ХХК-ийн үйлдвэрээр хийлгэж байгаа бөгөөд стандартын дагуу мал төхөөрөх үйлдвэр ховор учир үүнтэй холбоотой зардал өндөр байна. Мөн үхрийн махны тодорхой үзүүлэлтүүд буюу коллаген, ураг, тослог, нян зэргийг “Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори”-оор хийлгэж байна. Компани өөрийн нядалгааны үйлдвэр болон сорьц, шинжилгээний

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

лабораторитой болсноор бүтээгдэхүүний үнэ цэн улам нэмэгдэх, өртгийг бууруулах боломжтой юм.

**Бэлтгэн нийлүүлэгчээс хэт хамааралтай** - Үхрийг бэлтгэн нийлүүлж буй байгууллага байхгүй ба малчдаас үхрийг татан авдаг. Энэ нь бүтээгдэхүүний орц тухайн малчин бүрээс шалтгаалсан хувь хүний харилцаан дээр тогтож байгаа ба цаашлаад үүсэх эрсдэл нь түүхий эдийн дутагдалд үүсэх, үнийн огцом хэлбэлзэл гэх мэт зүйлс байна. Бизнест түүхий эдийн тогтвортой байдал гэдэг маш чухал тул татан авалтыг тогтсон стандартын дагуу гэрээгээр үүрэг, хариуцлага хүлээн нийлүүлж, татан авах нь чухал байна.

**Мэргэжлийн хүний нөөц хомс** - Үхрийн фермүүд болон мал төхөөрөх, ангилах үйлдвэрүүд орон нутгуудад их байгаатай холбоотойгоор мэргэжлийн хүний нөөцийн олдоц бага байна.

**Фермийн болон үйлдвэрийн үйл ажиллагааны стандарт өндөр** - Хүнсний үйлдвэрлэл болон фермийн үйл ажиллагаанд малтай зүй зохистой харьцах, өдөр тутмын үйл ажиллагаандаа цэвэр, аюулгүй байдлыг үргэлж сахих шаардлагатай. Үйл ажиллагааны стандартыг мөрдөөгүйгээс үүдэлтэй чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн зах зээлд гаргах, хэрэглэгчийн итгэлийг алдах аюултай юм.

## БОЛОМЖ

**Өргөн хэрэглээний бараа учир зах зээл илүү томрох боломжтой** - Монгол хүний махны хэрэглээ дэлхийн дундажтай харьцуулахад ойролцоо байдаг ч эрүүл ахуй талаас дутагдалтай байна. Гэвч хэрэглэж заншсан бүтээгдэхүүний хэрэглээний соёл, стандартын шатыг ахиулснаар борлуулах зах зээлийн боломж маш өндөр байна.

**Жижиглэнгээс өндөр зэрэглэлийн ресторан хүртэл борлуулалт хийх боломжтой** - Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь жижиглэнгээр худалдаалагдах боломжтой байхаар шийдэгдсэн бөгөөд стейкний мах 300 гр жинтэй худалдаалагдаж байна. Мөн томоохон ресторанд ханган нийлүүлэлт тогтмол хийх боломжтой.

**Зах зээлийн томоохон тоглогч болох боломжтой** - Одоогоор 100 хувь фермийн аж ахуйд бордогдож хэрэглэгчдийн гарт хүрч буй ижил төрлийн бүтээгдэхүүн байхгүй бөгөөд дотоод төдийгүй гадаад улсын жуулчдын хувьд үнэ цэнтэй брэнд болон хөгжих боломжтой.

**Тогтвортой бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бий болгох боломжтой** - Үхэр худалдан авах орон нутгийн малчид, хоршоод болон тэжээл худалдан авах тариаланчид, байгууллагуудтай урт хугацааны гэрээ хийж орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэх замаар үнийг тогтвортой барих, бэлтгэн нийлүүлэгчдээ илүү олон болгох боломжтой.

## УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ

**Борлуулалтын зорилтдоо хүрч чадахгүй байх** - Худалдан авагчдын дунд хэвшсэн соёл өөрчлөгдөхгүй байх, зах зээлийн багтаамжийг буруу тооцох, үйлдвэрийн хүчин чадал буурах нөхцөл зэрэг нь борлуулалтад сөргөөр нөлөөлөх боломжтой.

Mon Beef LLC
Мон Бийф ХХК
УЛААНБААТАР ХОТ

MON BEEF
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17

**Сүргийн тоо толгой хорогдох** - Улирлын чанартай бизнес тул бяруүны тоо цөөрөх, үнийн хэлбэлзэл ихсэх, эрүүл ахуйг сайн сахиагүйгээс үүдэн фермийн үхрийн тоо толгой хорогдох эрсдэлтэй.

**Бүтээгдэхүүний үнэ цэнийг хэрэглэгчид ойлгохгүй байх** - Монголчуудын мал аж ахуйн соёл нь олон жилийн турш хадгалагдан ирсэнтэй холбоотойгоор хэвшмэл ойлголт ихтэй бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангах, хяналт шалгалтын тогтолцоо нь хангалттай бүрдээгүй юм. Фермийн аж ахуй төдийлөн хөгжөөгүйгээс хэрэглэгчид энэ төрлийн бүтээгдэхүүнийг сонгох, таашаах нь хугацаа авах магадлалтай.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

# 04

MonBeefLLC
Мон Бийф
ХХ КОМПАНИ
УЛААНБААТАР ХОТ
6648436

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17

## 4.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

Макро эдийн засгийн нөхцөл байдал нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны болон санхүүгийн цаашдын гүйцэтгэлд нөлөөлөх том хүчин зүйл.

*Зураг 12. Монгол улсын ДНБ болон өсөлтийн хувь*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2022)*

Монгол Улсын эдийн засгийн байдал экспортын гоплох түүхий эдүүд болох нүүрс болон зэсийн үнэ, хөрш орнуудын хилийн нөхцөл байдал зэргээс ихээхэн хамаардаг ба 2017-2018 оны эдийн засгийн сэргэлт нь түүхий эдийн гадаад зах зээлийн тааламжтай орчин, үнийн өсөлт зэрэгтэй холбоотой байсан.

2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг 3.3 хувиар агшсан ба Монгол Улсын хэмжээнд уг үзүүлэлт 4.6 хувь байсан нь хилийн хориг зэрэгтэй салшгүй холбоотой байв.

Үнэт цаас гаргагч нь хүний анхдагч хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлт уналтаас хүчтэй хамаардаггүй. 2016-2020 онуудад Монгол Улсын хэмжээнд нэг хүн сард дунджаар 8.9 кг махыг хэрэглэж байгаа бөгөөд 5 жилийн хугацаанд уг үзүүлэлт тогтвортойгоор өсөж байна.

**Төсвийн бодлого**

2022 оны 3 сарын байдлаар төсвийн тэнцэл 254 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Цар тахлаас үүдсэн татварын хөнгөлөлт, импортын саадтай холбоотой татварын орлого 2020 онд 14 хувиар буурсан ч 2021 онд 32 хувиар өсөв. Төсөвт эзлэх хөрөнгийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх нь эдийн засгийг урт хугацаанд дэмжих сайн талтай байдаг ч Монгол улсын төсвийн зардлын дийлэнхийг урсгал зардал буюу цалин хөлс, бараа материал, татаас, их засвар гэх мэт зардлууд эзэлж байна.

**Нөлөөлөл:** Төсвийн орлогын өөрчлөлт нь төсвийн тэнцэлд шууд нөлөөтэй байдаг. Төсөв алдагдалтай байх нь нийгмийн чухал дэд бүтэц, зардлуудыг санхүүжүүлэх мөнгөн урсгал дутагдалтай болж засгийн газар зээл авахад хүрдэг. Ингэснээр дунд, хугацааны эдийн засагт ирэх дарамт нэмэгдэх ба цаашлаад иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай томоохон төсөл хөтөлбөрөө, санхүүжүүлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй. Энэ нь иргэдийн бизнес эрхлэх, ажил үйлчилгээгээ явуулах

орчинд шууд нөлөөтэй тул ирээдүйн хүн амын орлогын өсөлт бууралтад нөлөөлөх байдал өндөр байдаг.

**Мөнгөний бодлого**
2020 оноос эхлэн Монгол банк бодлогын хүүг 6 хувьд хадгалсаар байсан нь зээлийн хүүг бууруулах, эдийн засгийг дэмжих зорилготой байсан. 2022 оны 3 дугаар сараас бодлогын хүүг 9 нэгж болгон өсгөсөн. 2021 онд эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөр явагдаж жижиг дунд бизнесийг дэмжих гурван хувийн хүүтэй зээл олгогдсон ба банк бус санхүүгийн байгууллагын зээлийн ангилалд өөрчлөлт оруулсан.

**Нөлөөлөл:** Мөнгөний бодлого нь Төв банкны зохицуулалтаар дамжин төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах процесс бөгөөд төгрөгийн ханш унах нь иргэдийн худалдан авах чадвар буурах сөрөг үр дагаварт хүргэдэг.

2022 он гарсаар зээл олголтыг бууруулж, инфляцийн төвшинг бууруулах зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлээд байна.

## 4.2 Үнэт цаасны зах зээлийн төлөв байдал

2021 онд зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөг, ТОП-20 индекс 44,411 нэгжид хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт болсон. Нийт арилжааны дүн 1.4 их наяд төгрөгт хүрсэн нь мөн л дээд үзүүлэлт болсон ба нэг жилийн хугацаанд 9 бүтээгдэхүүн зах зээлд шинээр гарсан байна.

*Зураг 13. ДНБ ба Хөрөнгийн зах зээлийн хамаарал*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2022)*

Нийт 1.4 их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа явагдсан нь түүхэн дээд үзүүлэлт болж байна. Арилжааны дийлэнх хэсгийг буюу 1 их наяд төгрөгийн арилжааг компанийн бонд бүрдүүлж байгаа бол 300 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн дүнтэй байна. 2021 оны эхэнд байсан үзүүлэлтийг 2022 оны эхний байдалтай харьцуулан үзвэл MSE A индекс 69 хувиар, MSE B индекс 61 хувь, харин ТОП 20 индекс 130 хувь тус тус өссөн байна. Эдгээр нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх ойлголт сайжирч, нөгөө талаас хөрөнгө оруулалтын сонголт нэмэгдэж байгаатай холбоотой байна.

*Зураг 14. Хөрөнгийн зах зээлийн арилжааны бүтэц*




*Эх сурвалж: (Санхүүгийн зохицуулах хороо, 2022)*

**Хөрөнгийн зах зээлийн төлөв**

2020 онд банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн билээ. Банкны тухай хуулийн төсөлд банк нь зөвхөн хувьцаат компани хэлбэртэй байх тухай, аливаа этгээд банкны саналын эрхтэй хувьцааны 20-иос дээш хувийг эзэмшихийг хориглох тухай туссан. 2022 оны хагас жил гэхэд топ 5 банк хувьцаат компани болж хөрөнгийн биржид бүртгэгдэх, нийт хувь эзэмшлийн 10-с дээш хувийг гаргах үүрэг хүлээгээд байгаа. 2022 оны 1-р улирлын тайлан мэдээлэлд тулгуурлан Топ 5 банк дотоодын хөрөнгийн бирж дээр гарвал татах дүн болон хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хэрхэн өөрчлөгдөх талаар дараах тооцооллыг урьдчилан гаргаж байна.

Хүснэгт 20. Банкнуудын татан төвлөрүүлэх хөрөнгийн төсөөлөл, тэрбум төгрөг

| Банк | Эздийн өмч | Шинээр гаргах хувьцаа-10% | Татах дүн |
|---|---|---|---|
| Хаан банк | 1,503.8 | 1,670.9 | 167.1 |
| ХХБ | 1,069.1 | 1,187.9 | 118.8 |
| Голомт банк | 631.6 | 701.8 | 70.2 |
| Төрийн банк | 412.7 | 458.6 | 45.9 |
| Хас банк | 407.3 | 452.6 | 45.3 |
| **Нийт** | **4,024.5** | **4,471.7** | **447.2** |

*Эх сурвалж: Шинжээчийн төсөөлөл*

Стратегийн 5 банкны нийт өөрийн хөрөнгө 2022 оны 1-р улирлын байдлаар 4 их наяд төгрөг байна. PB ratio 1 буюу өөрийн хөрөнгийн дүнг үржүүлэхгүй үнэлж зах зээлд санал болговол 5 банкны нийт үнэлгээ 4.5 их наяд төгрөг болно (төсөөлөл). 2022 оны 6 сараас өмнө 10-с доошгүй хувийг санал болгоно гэж үзвэл 447.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 5 банк татах юм. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 онд 5.9 их наяд байгаа бол топ 5 банкны үнэлгээний төсөөллийг нэмж тооцвол 10.4 их наяд болно. Эдгээр нь зөвхөн топ 5 банкны үзүүлэлтэд тулгуурласан тооцоолол ба илүү олон банкууд нээлттэй болох, түүнээс үүдэн илүү өсөлт үзүүлэх хүлээлттэй байна.

**Нөлөөлөл**: Зөвхөн банкны IPO-той холбоотой хөрөнгийн зах зээлийн үнэлгээ хамгийн багадаа 2 дахин өсөх хүлээлт үүсэж байгаа нь богино хугацаанд Монголын хөрөнгийн зах зээл хурдацтай тэлэх төлөвийг харуулж байна.

2022 оны 3-р сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт 26.4 их наяд төгрөг байгаа нь Монгол банкны зүгээс мөнгөний зөөлөн бодлого баримталж байсаны үр дүн юм. Зах зээлд эргэлдэх мөнгөний хэмжээ өндөр байснаар сул мөнгөн урсгал хөрөнгийн зах зээл рүү шилжиж эхэлсэн нь банкны хугацаат хадгаламжийн хүү буурсантай холбоотой байв. *(2017 оноос хойш 12 сар хүртэлх хугацаат хадгаламжийн дундаж хүү 5 нэгжээр буурч 10.2 хувьд хүрсэн.)*

Төгрөгийн худалдан авах чадварыг тогтворжуулах, үнийн төвшинг барих зорилгоор мөнгөний хатуу бодлогыг 2022 оны 4 сараас баримтлах болсон нь хөрөнгийн зах зээлийн идэвх буурах нөлөөллийг үүсгээд байна.

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

## 4.3 Мал аж ахуйн салбарын төлөв байдал

Дэлхий даяар үхрийн махны үйлдвэрлэл 1961 оноос хойш хоёр дахин нэмэгдэж, жилд 28 сая тонн байсан бол 2021 оны байдлаар 72 сая тонн болж нэмэгджээ. Үхрийн махны үйлдвэрлэлээр АНУ, Бразил, Хятад, Аргентин, Австрали, Энэтхэг гэх мэт улсууд тэргүүлж байгаа бол 2021 оны байдлаар Монгол улс нийт 162 мянган тонн үхрийн мах хэрэглэж, 1 хүнд ногдох үхрийн махны хэрэглээгээрээ олон улсуудтай харьцуулбал дундаж орнуудын тоонд багтаж байна.

*Зураг 15. Дэлхийн үхрийн махны хэрэглээ*




*Эх сурвалж: (Our world in Data, 2021)*

Монгол улсын МАА-н салбар нь ДНБ-ийн 13-15 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд илүү өсөлттэй байна. Мал аж ахуйн эдийн засагт оруулах нөлөөллийг авч үзвэл, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байгаагийн 92 орчим хувийг МАА салбар бүрдүүлдэг. Харин аймаг, орон нутгийн хувьд ДНБ-ий дийлэнх буюу 38.4 хувийг МАА-н салбар эзэлсэн хэвээр байна. Тухайлбал, орон нутгийн эдийн засагт мал аж ахуйн салбарын эзлэх хувь Архангай, Дундговь, Говь-Алтай аймагт хамгийн их байхад уул уурхай, үйлдвэрлэл ихтэй Өмнөговь, Орхон, Дархан-Уул аймагт бага байна.

Нийтийн хоол, аялал жуулчлалын салбарт шаардлагатай тусгай зориулалтын үхрийн махны хэрэгцээг хангах зорилгоор 2016-2020 онуудад жил бүр 500 тонн үхрийн мах импортлох зөвшөөрлийг олгож ирсэн бөгөөд 2016 оноос 2020 он хүртэлх үхрийн махны импортын хэмжээг доорх зурагт харуулав. 2020 онд үхрийн махны импорт 250 хувиар өссөн байна.

СЭХ
2022.06.22
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

*Зураг 16. Нийт болон импортын махны хэмжээ, тонн*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар, 2022)*

**Нөлөөлөл:** Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын хувьд хүнсний өргөн хэрэглээ буюу уламжлалт хэрэглээ болох махны салбар. Үхрийн махны хувьд дотооддоо бүрэн хангаж байгаа ба нэг хүнд ногдох махны хэрэглээ сүүлийн жилүүдэд тогтмол байгаа нь иргэдийн орлогын нөхцөл байдалд тохирон эрэлт нийлүүлэлт тогтсон өнгө аястай байна.

*Зураг 17. ДНБ-д эзлэх МАА-н салбарын нийт үйлдвэрлэлийн хувь*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2022)*

Цаашид ДНБ-нд эзлэх мал аж ахуйн салбарын тэлэлт нь бэлэн байгаа түүхий эд буюу малыг сайн гарц, бүтээгдэхүүн болгосноор хурдтай өсөх боломжтой ба үнэт цаас гаргагчийн хувьд зах зээлийг хүлээх бус тодорхой хэмжээнд тэлэхээр зорин ажиллаж байна.

MON BEEF
СЗХ
он 2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

### 4.3.1 Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэх төрийн бодлого

МАА-н салбарын 2020-2025 оны хөгжлийн хандлага, стратегийн зорилтоор мэдлэгт суурилсан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх, мэргэжлийн үйлчилгээг төгөлдөршүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. Энэ нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарыг төрөөс дэмжиж буй таатай нөхцөл байдал үүссэнийг илтгэж байна. Мал аж ахуйн салбарын хөгжлийн загвар нь уламжлалт өв соёлыг хадгалсан бэлчээрийн аж ахуйг зонхилон, дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн аж ахуйг хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлэх, нөөцийг тогтвортой, зохистой ашиглах, ногоон эдийн засгийн чиг баримжааг дэмжихэд суурилна.

Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ:

- Малын төрөл бүрийн тэжээлийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлж, түүний шимт чанарыг сайжруулах үйл ажиллагааг тогтворжуулах;
- Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, эрүүл тайван байдлыг баталгаажуулах арга хэмжээг бүс нутгийн онцлогтой уялдуулан ялгавартайгаар хэрэгжүүлж, баруун болон төвийн бүс нутаг дахь вакцинжуулалтыг эрс багасгаж, эрүүлжүүлэх шинжилгээ хийх стратегид шилжих ба малын эмийн үлдэгдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамаарч малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бий болгох;
- Малын үржил селекцийн ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор малын ашиг шимийн чиглэлд нийцүүлэн үржлийн ажлын стратеги төлөвлөгөөний дагуу явуулах;
- Шинээр болон дахин сэргэж байгаа малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангах;
- Гоц халдварт зарим өвчнөөр тайван бүсийн статусыг хангах, мал эмнэлгийн ажил, үйлчилгээ, тогтолцоог олон улсын жишигт хүргэх;
- Малын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, малын эм, био бэлдмэлийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын төвшинд хүргэх;
- Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр дамжуулан хяналт тавьж гарал үүсэл, эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах;

Мал аж ахуйн салбарын 2030 он хүртэлх хөгжлийн хандлага нь бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг дэлхий нийтэд таниулсан органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урсгалыг бий болгож үнэ цэний сүлжээг хөгжүүлсэн, тогтвортой үйлдвэрлэлийг явуулахад бодлого чиглэгдэж байгаа нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг үүсгэж байна.

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## Монгол Улсын махны хэрэглээ

Сүүлийн жилүүдэд манай улсын махны хэрэглээ өссөөр байгаа бөгөөд 2020 онд өмнөх онтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт махны хэрэглээний ойролцоогоор 21 хувийг үхрийн махны хэрэглээ тогтмол эзэлж байна.

*Зураг 18. Монгол улсын үхрийн махны хэрэглээ, мянган тонн*




*Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2021)*

Мөн дотоодын үйлдвэрт боловсруулсан малын гаралтай бүтээгдэхүүнээс үхрийн махаар хийсэн бүтээгдэхүүн бусад төрлийн махтай харьцуулахад харьцангуй бага хувийг эзэлж байгаа бөгөөд махны чиглэлийн үйлдвэрүүд малын гаралтай бүтээгдэхүүн хийхдээ ихэвчлэн адуу болон хонины махыг илүү ашиглаж байна.
Монголчуудын нэг хүнд ногдох махны хэрэглээг бусад улсуудтай харьцуулахад хонь, ямааны махны хэрэглээ маш өндөр байгаа бөгөөд харин үхрийн махны хэрэглээ 22 килограмм буюу дундаж үзүүлэлттэй байна.

*Зураг 19. Махны дундаж хэрэглээ, 2020 оны байдлаар, нэг хүнд ногдох*




*Эх сурвалж: (Our world in Data, 2020)*

Мон Бийф ХХ компани

СЗХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ

2022-06-17
БҮРТГЭВ-03

## 4.4 Мах, махан бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд

**MNS 2456:2009** - Мах, махан бүтээгдэхүүн - Үхрийн хэсэглэж, ангилсан мах - Үхрийн махыг үйлдвэрлэх, худалдаалах, нийтийн хоол, экспортын зориулалтаар үйлдвэрийн нөхцөлд хэсэглэх, шулах, ангилах, савлах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

**HACCP** - Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо - хүнсний аюулгүй байдалд онцгой хор хөнөөлтэй аюулыг илрүүлэх, үнэлэх, хянах тогтолцоо. Хүнсний үйлдвэрлэлийг анхан шатнаас нь эхлэн эцсийн бүтээгдэхүүн бэлэн болж, хэрэглэгчдэд хүргэх хүртэлх бүх дамжлагын аюултай байдлын эрсдэлийг үнэлж, хяналт тавин, системтэйгээр судлан шинжилнэ.

**ISO 22000 стандарт** - Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо - Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага.

**ISO 9001 стандарт** - Чанарын удирдлагын тогтолцоо.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

# 05

MonBeef LLC
Мон Бийф ХХК
6648436
УЛААНБААТАР ХОТ

## 5.1 Аудитын тайлангийн дүгнэлт

"Мон Бийф" ХХК-ийн 2021 оны жил эцсийн болон 2022 оны 1-р улирлын санхүүгийн тайлангуудад "ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ" ХХК хараат бус аудитын дүгнэлт хийсэн.
2022 оны 1-р улирлын санхүүгийн мэдээлэлд үндэслэсэн хараат бус аудитын дүгнэлт:

"Мон Бийф" ХХК ("Компани" гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн завсар үеийн хураангуй санхүүгийн мэдээллүүдэд аудит хийлээ:

- 2022 оны 3 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан:
- Энэ өдрөөр тасалбар болсон 2022 оны 1-р улирлын ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан хураангуй санхүүгийн мэдээллүүд нь Компанийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон 2022 оны 1-р улирлын санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, Завсар үеийн санхүүгийн тайлан ("НББОУС 34")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

СЗХ
он сар өдөр
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01
2022-06-17
БҮРТГЭВ-03

## 5.2 Санхүүгийн нөхцөл байдал

### Санхүүгийн байдлын тайлан

*Хүснэгт 21. Санхүүгийн байдлын тайлан*

| *мянган төгрөг* | 2021 * | 2022. I * | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 40,061 | 10,179 | *0.3%* |
| Худалдааны болон бусад авлага | 138,466 | 155,788 | *4.1%* |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 211,838 | 256,670 | *6.7%* |
| Бараа материал | 1,905,617 | 1,907,665 | *50.1%* |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,295,982 | 2,330,302 | *61.2%* |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Өмч барилга, тоног төхөөрөмж | 1,365,990 | 1,418,016 | *37.2%* |
| Биет бус хөрөнгө | 18,566 | 23,755 | *0.6%* |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 38,171 | 38,171 | *1.0%* |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,422,727 | 1,479,942 | *38.8%* |
| **Нийт хөрөнгө** | **3,718,709** | **3,810,244** | ***100.0%*** |
| Өр төлбөр | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 288,929 | 158,919 | *4.2%* |
| Татварын өр | 1,679 | 3,644 | *0.1%* |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 290,608 | 162,563 | *4.3%* |
| Холбоотой талын санхүүжилтийн өр | 3,580,532 | 3,021,000 | *79.3%* |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | 3,580,532 | 3,021,000 | *79.3%* |
| Нийт өр төлбөрийн дүн | 3,871,140 | 3,183,563 | *83.6%* |
| Эздийн өмч | | | |
| Хувьцаат капитал | 200,000 | 1,500,000 | *39.4%* |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (352,431) | (873,319) | *(22.9)%* |
| Нийт өмчийн дүн | (152,431) | 626,681 | *16.4%* |
| **Нийт өр төлбөр ба өмчийн дүн** | **3,718,709** | **3,810,244** | ***100.0%*** |

**- Аудитлагдсан*

2022 оны эхний улирлын байдлаар компани нь нийт 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байна. Нийт хөрөнгийн 60 хувь нь эргэлтийн хөрөнгөөс бүрдэж, үүний бараа материал дийлэнх хэсгийг буюу 82 хувийг эзэлж байна. Үлдсэн эргэлтийн бус хөрөнгийн дүн 1.48 тэрбум төгрөг, үүний 95 хувийг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл эзэлж байна. Голлох томоохон дүнгүүдийг задлан харвал:

*Хүснэгт 22. Бараа материал, мянган төгрөг*

| | **2021** | **2022.I** |
|---|---|---|
| Түүхий эд материал | 1,502,107 | 1,276,190 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 103 | 87 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 308,030 | 539,418 |
| Хангамжийн материал | 95,377 | 91,970 |
| **Нийт** | **1,905,617** | **1,907,665** |

Мон Бийф компани
MonBeef LLC
УЛААНБААТАР

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн түүхий эд материалын үлдэгдэл 841,618 мянган төгрөгийн дансны үнэтэй 360 толгой үхэр (2021 оны 12 дугаар сарын 31-нээр 1,088,475 төгрөгийн дансны үнэтэй 722 толгой үхэр) багтаж байна.

*Хүснэгт 23. Урьдчилж төлсөн зардал тооцоо, мянган төгрөг*

| | 2021 | 2022.I |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 31,782 | 58,204 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа | 180,056 | 198,466 |
| **Нийт** | **211,838** | **256,670** |

*Хүснэгт 24. Үндсэн хөрөнгө, мянган төгрөг*

| | 2021 | 2022.I |
|---|---|---|
| Машин тоног төхөөрөмж | 67,676 | 72,096 |
| Тээврийн хэрэгсэл | 439,436 | 446,941 |
| Тавилга эд хогшил | 838,257 | 902,543 |
| Компьютер, бусад хэрэгсэл | 67,643 | 85,118 |
| Хуримтлагдсан элэгдэл | 47,022 | 88,682 |
| **Нийт** | **1,365,990** | **1,418,016** |

Компанид нийт 8 ширхэг тээврийн хэрэгсэл, 10 ширхэг фермерийн зориулалттай тоног төхөөрөмж, шаардлагатай бусад хашаа, саравч мөн 95 ширхэг компьтер, ширээ, сандал, программ хангамжийн гэх мэт хөрөнгө бүртгэлтэй байна.

Үйл ажиллагаа эрхэлж буй газрын хувьд 2022 оны 3 сарын 31-нээр санхүүгийн тайланд хараахан бүртгэгдээгүй байсан ба “Таван Богд Трейд” ХХК-н холбоотой “Сэргэлэн Ресорт” ХХК дээр бүртгэлтэй байсан газраас 10 га газрыг үхрийн фермерийн зориулалттайгаар 2022 оны 4 сарын 27-ны өдөр өөрийн нэр дээр бүртгэн, шилжүүлэн авсан.

*Хүснэгт 25. Худалдааны болон бусад өглөг, мянган төгрөг*

| | 2021 | 2022.I |
|---|---|---|
| Худалдааны өглөг | 200,947 | 61,488 |
| Цалингийн өглөг | 40,532 | 44,084 |
| НӨАТ-ын өглөг | 188 | 194 |
| ХХОАТ-бн өглөг | 6,486 | 7,005 |
| Бусад өглөг | 40,777 | 46,147 |
| **Нийт** | **288,929** | **158,919** |

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

Урт хугацаат зээлийн мэдээлэл:

Компани нь өөрийн толгой болоод зэргэлдээ компаниас бэлэн мөнгөний нөөцөө богино хугацаанд бүрдүүлэхийн тулд арилжааны банкны шугамын зээлийн нөхцөлтэй ижил төстэй хэлбэрээр санхүүжилт татах боломжтой байдаг. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар өөрийн зэргэлдээ компани болох "Таван Богд" ХХК-иас жилийн 11 хувийн хүүтэй 3,021,000,000 төгрөгийн шугамын зээлийн үлдэгдэлтэй байна.

Эх үүсвэр талд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн дүн 1.5 тэрбум төгрөг байна. Энэ нь нийт хөрөнгийн 39 хувь, өр төлбөрийн дүн нийт 3.1 тэрбум төгрөг үүний 95 хувийг зэргэлдээ компанийн санхүүжилтээс бүрдэж байна.

Эхлэлийн цэг дээрээ яваа компанийн хувьд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, үйлдвэрлэлд шаардагдах хашаа, барилга байгууламж, бэлэн бүтээгдэхүүнд шаардагдах түүхий эд бараа материалууд нь нэн чухал тул орж ирсэн мөнгөн урсгалууд нь үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын тус зардлуудад зарцуулагдсан байна.

*Хүснэгт 26 Мөнгөн гүйлгээний тайлан, мянган төгрөг*

| | 2021 | 2022.I |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн | 107,137 | 449,399 |
| Бараа борлуулсан үйлчилгээ үзүүлсний орлого | 107,027 | 448,580 |
| Бусад мөнгөн орлого | 110 | 819 |
| Мөнгөн зарлагын дүн | 2,635,657 | 1,079,950 |
| Ажиллагчдад төлсөн | (102,792) | (107,119) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (76,485) | (61,451) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (2,176,187) | (673,061) |
| Түлш, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (8,080) | (0) |
| Хүүний төлбөрт төлсөн | (55,329) | (68,944) |
| Татварын байгууллагад төлсөн | (20,547) | (28,613) |
| Даатгалын байгууллагад төлсөн | (578) | (0) |
| Бусад мөнгөн зарлага | (195,659) | (140,762) |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (2,528,520) | (630,551) |

| | | |
|---|---|---|
| **ХО-ын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн | 2,548 | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 2,548 | - |
| Мөнгөн зарлагын дүн | (1,207,963) | (133,701) |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (1,207,963) | (133,701) |
| ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (1,205,415) | (133,701) |



6648436 MonBeefLLC УЛААНБААТАР ХОТ
Мон Бийф ХХК

СЗХ MON BEEF
2022 оны 06 сар 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCH
2022-06-17
БҮРТГЭВ-03

| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
|---|---|---|
| Мөнгөн орлогын дүн | 7,890,382 | 9,352,825 |
| Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,700,382 | 8,042,825 |
| Хувьцаа, өмчийн бусад ҮЦ гаргаснаас хүлээн авсан | 190,000 | 1,310,000 |
| Мөнгөн зарлагын дүн | (4,135,579) | (8,602,494) |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | (4,135,579) | (8,602,494) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **3,754,803** | **750,331** |
| Вальютын ханшийн зөрүү | (806) | (15,962) |
| **Бүх цэвэр мөнгөн цэвэр гүйлгээ** | **20,063** | **(29,883)** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 19,999 | 40,062 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 40,062 | 10,179 |

2021 болон 2022 оны нэгдүгээр улиралд компанийн бэлэн мөнгөөр хийгдэж буй гүйлгээнүүдийг харвал:

Үйл ажиллагаанаас буюу бараа бүтээгдэхүүний борлуулалтаас орж ирсэн мөнгө нь нийт орж ирсэн мөнгөн урсгалын 1- 4.5 хувь байна. Үлдэх 95-99 хувь нь зэргэлдээ компанийн шугамын зээл, өглөг хэлбэрээр богино хугацаанд санхүүжиж, буцаан төлөх замаар бараа бүтээгдэхүүн, үндсэн хөрөнгө болоод зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны зардлуудад зориулагдсан байна.

### Орлого үр дүнгийн тайлан

*Хүснэгт 27 Орлогын тайлан, мянган төгрөг*

| *мянган төгрөг* | **2021 *** | **2022. I *** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 226,697 | 509,165 | 100.0% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (206,540) | (624,232) | 122.6% |
| Нийт ашиг | 20,156 | (115,067) | (22.6)% |
| Хүүгийн орлого | - | - | 0.0% |
| Бусад орлого | 3,032 | 1,146 | 0.2% |
| Борлуулалт, маркетингийн зардал | (95,832) | (109,978) | 21.6% |
| Ерөнхий удирдлагын зардал | (258,626) | (198,604) | 39.0% |
| Санхүүгийн цэвэр зардал | (62,153) | (75,259) | 14.8% |
| Бусад зардал | (6,653) | (7,164) | 1.4% |
| Ханшийн зөрүүгийн ашиг алдагдал | (425) | (15,962) | 3.1% |
| Бусад ашиг(алдагдал) | - | - | 0.0% |
| Татварын өмнөх ашиг | (400,501) | (520,888) | (102.3)% |
| Татварын зардал | 38,171 | - | 0.0% |
| Тайлант жилийн цэвэр ашиг | (362,330) | (520,888) | (102.3)% |

** - Аудитлагдсан*

Компани 2021 онд нэг сар борлуулалт хийсэн ба 2022 оны эхний улирлын байдлаар 509 сая төгрөгийн борлуулалтыг хийв. Малын гоц халдварт өвчнөөс шалтгаалан үхрийн олдоц хомс, бүтээгдэхүүн хангалттай танигдаагүй, борлуулалт төсөөлж байснаас бага

байсан зэрэг шалтгааны улмаас 2021 оны 11 сараас өмнө худалдаж авсан үхрүүдийг 100-аас илүү хоног тэжээх шаардлага гарч, энэ нь үхрийн өртөг нэмэгдэх, улмаар бүтээгдэхүүний өртөг нэмэгдэхэд нөлөөлсөн /*Үхрийн тэжээх зардал гарсаар байсан*/.

Компанийн борлуулалт хараахан идэвхжээгүй буюу борлуулалтын орлого нь өртөг болоод үйл ажиллагааны зардалтай харьцуулахад бага хэмжээнд байсан тул сүүлийн тайлант үеүдэд алдагдалтай гарчээ. Гэвч энэ нь богино хугацааны үр дүн ба үхрийн татан авалт, махны гарц нэмэгдэж байгаа зэрэг суурь хүчин зүйлс хэвийн байгаа мөн зах зээлд таниулах ажиллагаа ихээр хийгдээгүй байгаагийн нэгэн илрэл юм.

*Хүснэгт 28. Борлуулалтын хэмжээ, кг*

| | 2022 | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1-р сар | 2-р сар | 3-р сар | Нийт | Эзлэх хувь |
| **Хорека** | **4,344** | **12,723** | **14,097** | **31,164** | **80%** |
| Стейк | 200 | 103 | 591 | 894 | |
| Цул мах | 1,452 | 11,006 | 6,630 | 19,087 | |
| Ястай мах | - | 1,480 | 3,495 | 4,975 | |
| Бусад | 325 | 61 | 76 | 461 | |
| Дайвар | 2,368 | 74 | 3,305 | 5,747 | |
| **Онлайн** | **2,437** | **1,264** | **491** | **4,191** | **11%** |
| Стейк | 28 | 13 | 79 | 121 | |
| Цул мах | 722 | 110 | 256 | 1,088 | |
| Ястай мах | 11 | - | - | 11 | |
| Бусад | 1,676 | 1,141 | 155 | 2,972 | |
| Дайвар | - | - | - | - | |
| **Нэрийн дэлгүүр** | **332** | **150** | **438** | **920** | **2%** |
| Стейк | 65 | 82 | 280 | 427 | |
| Цул мах | 220 | 63 | 137 | 420 | |
| Ястай мах | 24 | 5 | 10 | 40 | |
| Бусад | - | - | 10 | 10 | |
| Дайвар | 23 | - | - | 23 | |
| **Орон сууцны дэлгүүрүүд** | **203** | **1,103** | **187** | **1,493** | **4%** |
| Стейк | 32 | 34 | 48 | 114 | |
| Цул мах | 159 | 121 | 141 | 421 | |
| Ястай мах | 12 | - | (1) | 11 | |
| Бусад | - | 948 | - | 948 | |
| Дайвар | - | - | - | - | |
| **Супермаркет худалдааны төвүүд** | **-** | **314** | **675** | **988** | **3%** |
| Стейк | - | 60 | 206 | 266 | |
| Цул мах | - | 252 | 469 | 720 | |
| Ястай мах | - | 2 | - | 2 | |
| Бусад | - | - | - | - | |
| Дайвар | - | - | - | - | |
| **Нийт** | **7,316** | **15,554** | **15,887** | **38,756** | **100%** |

Борлуулалтын сувгуудын борлуулалтын хэмжээг харвал Хорека буюу зочид буудал, зоогийн газар, кафены борлуулалтын хэмжээн 80 орчим хувийг, онлайн худалдаа 11 хувь, сүлжээ дэлгүүрүүд болон борлуулалтын цэгүүд, орон сууцны дэлгүүрүүд үлдсэн 9 орчим хувийн борлуулалтыг бүрдүүлсэн байна.

*Хүснэгт 29. Борлуулалтын дундаж үнэ, төгрөг*

| Махны ангилал | Дундаж үнэ |
|---|---|
| Стейк | 48,389 |
| Цул мах | 17,155 |
| Ястай мах | 15,969 |
| Бусад | 3,975 |
| Дайвар | 4,541 |

Бүтээгдэхүүнүүдийн борлуулалтын үнийн хувьд бөөнөөр борлуулалт хийгддэг Хорека болон сүлжээ дэлгүүрүүдэд борлуулсан үнэ харьцангуй бага байгаа ба дээр дурдсан дундаж үнүүдээс борлуулалтын суваг болоод махны ангилал бүрээс хамаарч 1-14 хувиар борлуулсан үнэ хэлбэлзэж байна.

*Зураг 20. Борлуулалтын дүн, мянган төгрөг*



СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

## Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн задаргаа

*Хүснэгт 30. Худалдан авалтын өртөг, хувиар*

| Нэг толгой үхрийн худалдан авалтын нийт өртөг | |
|---|---|
| Шууд материалын зардал | 68% |
| Шууд хөдөлмөрийн зардал | 5% |
| ҮНЗ | 11% |
| ҮНЗ-Тээвэр | 11% |
| Элэгдэл | 5% |

Тухайн борлуулж буй бараа бүтээгдэхүүнийг анх түүхий эдээс эхлээд бэлэн бүтээгдэхүүн болох хүртэлх бүх гарч буй зардал хамгийн том бөгөөд чухал зардал байдаг. "Мон Бийф" ХХК-ийн нийт борлуулсан бүтээгдэхүүний өртгийн 80 орчим хувь нь үхрийн худалдан авалт буюу түүнтэй холбоотой болон хөдөлмөрийн, үйлдвэрийн нэмэгдэл бусад зардлуудаас бүрдэж байна

*Хүснэгт 31. Бордолтын өртөг, хувиар*

| Нийт бордолтын өртөг | |
|---|---|
| **Шууд бус материалын зардал** | |
| Тэжээлийн зардал-100 хоног | 63% |
| **Шууд хөдөлмөр** | |
| Цалин /бордох үйл ажиллагаа/ | 14% |
| Үйлдвэрийн нэмэгдэл зардал | 14% |
| **ҮНЗ-Тээвэр** | 5% |
| Элэгдлийн зардал | 4% |

Дараагийн чухал зардал бол бордолтын зардал ба үүний дийлэнх хэсгийг тэжээлийн зардал эзэлж байна. Мөн ажилчдын цалин, бусад үйлдвэрлэлийн нэмэгдэл болон тээвэрлэлтийн зардлуудаас бүрдэж байна.



MonBeefLLC Мон Бийф ХХ компани 6648436 УЛААНБААТАР

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

СЗХ
2022.06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН СТРАТЕГИ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

06

## 6.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Монгол улс 2020 оны байдлаар жилд 745 мянган тонн махыг дотооддоо хэрэглээнд нийлүүлээд байна. Үүний зөвхөн 4-5 орчим хувь нь л үйлдвэрийн аргаар боловсруулсан мах юм. Үхрийн мах нь нийт үйлдвэрийн аргаар боловсруулсан махны 15 хувь буюу нийт махны зах зээлийн 0.3 хувийг л бүрдүүлж буй хөгжлийн төвшин эхэн үедээ яваа жижиг зах зээл юм. Үнэт цаас гаргагчийн зүгээс нийгэмд үнэ цэн бүхий эрүүл , шимт тэжээл, бордоогоор хангасан, сайн чанарын, үнийн хувьд дотоодын зах зээл дээрх махтай ойролцоо, импортын махнаас илүү хямд бүтээгдэхүүнийг санал болгож байгаагаараа онцлог давуу талтай.

Компани нь салбарын бусад компанитай харьцуулбал харьцангуй эхлэлийн шатан дээрээ яваа ба үйл ажиллагаагаа эхлүүлж, зах зээл дээр өөрсдийн брэндээ таниулж, идэвхжүүлж байна.

### Үйл ажиллагааны төлөвлөгөө

*Зураг 21. Үхрийн татан авалт ба бэлтгэлд оруулах хэмжээ, толгой үхэр*




Ферм нь нийт 6 хашаатай ба 80 үхрийн 6 ширхэг, 130 үхрийн 2 ширхэг нийт 840 үхрийг сард байршуулах боломжтой.

Үнэт цаас гаргагч 2026 он хүртэл сар бүр 300-551 үхрийг тэхээрэн, 330-540 үхрийг татан авах төлөвлөгөөтэй байна.

Татан авалтын хэмжээ өндөр байгаа нэг шалтгаан нь тухайн нэг сард татан авалт дээр нийлүүлэлт, цаг үеийн асуудлаас улбаатай эрсдэл үүссэн үед дахин нэг сарын нөөц байлгах замаар бүтээгдэхүүний орцын хангалт нийлүүлэлтийг зохицуулж байна.

Үхрийн аж ахуйн ферм нь үхрийг дотоодын малчдаас бяруу байхад нь тээвэрлэн авчирч 21-30 хоног тусгаарлан үхрийг эрүүл, аюулгүй гэдгийг баталгаажуулах буюу вакцины үлдэгдэл арилах боломжтой хугацаанд ажигладаг. Энэ үед татан авчирсан үхэрт ямар нэгэн өвчний шинж тэмдэг болоод бэртэл, гэмтэл зэрэг зүйлс илэрч, үүсээгүй тохиолдолд үргэлжлүүлэн цааш 79 хоног нийт 100 хоног фермд сайн чанарын шимт тэжээллэг тэжээлээр бордон төхөөрч мах бэлтгэл хийгддэг.

"Мон Бийф" ХХК-ийн 2022 оны 6 сар хүртэл үйл ажиллагаа нь бүрэн бярууг 100 хоног фермд тэжээн гарцын жин бага ч стейкний шаардлага хангах сайн чанарын махыг бэлтгэнэ. Харин 2022 оны 6 дугаар сараас нийт мах бэлтгэлийн 70 орчим хувийг 3,4

настай үхрийг татан төвлөрүүлж 21-30 хоног вакцин болон бусад эрүүл ахуйн дэглэмийг сахин бордон төхөөрч гарцын эргэлтийг хурдасгах төлөвтэй байна. Эдгээр үхрүүдийг масс борлуулалтад буюу нарийн ангилж, савласан цул болон ястай мах, зорсон, шөлний, гуляшны мах зэргээр төрөлжүүлэн худалдаалахаар төлөвлөөд байна. 100 хоног бордох үхрийн махны хувьд цаашид үйлдвэрлэлийн 30 орчим хувийг эзэлж үндсэн үйл ажиллагааны дараалал алдагдахгүй явагдана.

*Зураг 22. Тэжээх үхрийн хоногт авах жингийн дундаж нэмэгдэл, грамм*




*Хүснэгт 32. Үхрийн татан авалтын болон нядалгааны үеийн дундаж жин, килограмм*

| Хэмжих нэгж, кг | Худалдан авах үеийн жин | Төхөөрөх үеийн жин |
|---|---|---|
| 100 хоногтой үхэр | 210 | 291 |
| 30 хоногтой үхэр | 350 | 359 |

Фермд тухайн сар бүр төхөөрөх үхрээс гадна үйлдвэрлэлийн эргэлтийг алдагдуулахгүй байх зорилгоор татан авалтууд нэмж хийгдэн ирдэг. 100 хоног бордох үхрийн хувьд дунджаар 210 килограмм жинтэй, 30 хоног бордох үхрийг 350 килограмм жинтэйгээр худалдан авч бяруны хувьд/100 хоног тэжээнэ/ хоногт дунджаар 750-902 грамм жингийн нэмэгдэл авснаар 100 хоногийн дараа гэхэд ойролцоогоор 285 - 300 килограмм жинтэй, 4 настай үхрийн хувьд хоногт нэмэх жингийн хэмжээ насжилтаасаа хамаарч харьцангуй залуу үхрээс удаан байдаг ба хоногт ойролцоогоор 400-426 грамм нэмэгдэл авснаар 30 хоногийн дараа ойролцоогоор 360 орчим кг жинтэй болдог. Нядалгаанд орох үеийн жингийн дундаж байдлын таамаглалыг дээрх графикаар харуулав.

Үнэт цаас гаргагчийн зүгээс өдрийн жингийн нэмэгдлийг ахиулах зорилгоор “Баялаг Фийд” ХХК-тай хамтран өөрсдийн ферм дээр судалгаа, шинжилгээнд үндэслэсэн монгол үхрийн биеийн онцлогт тохирсон тэжээлийн туршилтыг 4 сараас эхлүүлээд байгаа ба үр дүн өндөр байна.

*Хүснэгт 33. Бордолтын өртөг, 1 килограммыг төгрөгөөр*

| | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|
| Рулонтой ногоон тэжээл | 330 | 356 | 385 | 416 | 449 |
| Пресстэй ногоон тэжээл | 280 | 302 | 327 | 353 | 381 |
| Хивэг | 390 | 421 | 455 | 491 | 531 |
| Шохой чулуу | 150 | 162 | 175 | 189 | 204 |
| Рапсын шахдас | 1,430 | 1,544 | 1,668 | 1,801 | 1,945 |
| Ашигт долоос | 1,000 | 1,080 | 1,166 | 1,260 | 1,360 |
| Хужир | 440 | 475 | 513 | 554 | 599 |

СЗХ
2022 .06. 22
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17

Үнэт цаас гаргагчийн зүгээс 7 төрлийн тэжээлийн бүтээгдэхүүнээр үхрийг борддог ба түүхий эдийн татан авалтын үнийг 2026 он хүртэл тооцоолохдоо сүүлийн 10 жилийн дундаж инфляцийн дүнгийн нөлөөллийг оруулав.

*Зураг 23. Үхрийн махны гарц, хувиар*




Бод малын гулууз буюу дотор гэдэс, толгой, шийр зэргээс бусад эвдээгүй бүтэн тураг махны гарцын хэмжээ нь монгол үхрийн хувьд ойролцоогоор 47.5-50% байдаг байна. Үүнийг 24 цагийн хугацаанд үйлдвэрийн аргаар хатаан сэврээж цэвэр сэврээхийн гарц гулуузнаас 0.6-0.8 хувийн хорогдолтой гардаг. Үүнээс зарим бэлэн бүтээгдэхүүн болоход ялгах шаардлагатай яс зэргийг салгаснаар сэврээхийн 80 орчим хувь нь цэвэр махны гарц болж бэлэн бүтээгдэхүүн болдог.

"Мон Бийф" үйлдвэрийн 30 хоног бордох үхрийн гулуузны гарцыг 50 хувиар цэвэр махны гарцыг үүнээс 80 орчим хувиар гарахаар цаашид төлөвлөөд байна. Тэгвэл илүү бага жинтэй ч сайн чанарын махны гарц өндөр 100 өдөр бордож буй бярууны махны гарцыг дунджаар 48 хувьтай байгаа ба үүнээс сэврээхийн хорогдлыг 0.6-0.8 хувиар тооцов. Улмаар махны цэвэр гарцын хэмжээ 78 орчим хувьтай байна. Энэ нь харьцангуй залуу мал тул жингийн зөрүү гарч гарцын хэмжээ харьцангуй бага байх ч мах нь илүү зөөлөн, амтлаг байдаг.

Зураг 24. Махны цэвэр бүтээгдэхүүний гарц, хувиар




Үнэт цаас гаргагчийн 30 хоног бордох үхрийн хувьд цэвэр махны гарцаас дийлэнх хэсэг нь бидний өдөр тутамдаа хэрэглэдэг цул болон ястай мах 63 орчим хувь, илүү зөөлөн буюу стейкний зориулалттай мах 17 орчим, бусад дайвар бүтээгдэхүүнүүд 20 орчим хувиар бэлэн бүтээгдэхүүн болж гарахаар байна.

Харин 100 хоног бордсон залуу үхрийн хувьд дээр дурдсанчлан жин бага ч махны амт чанар сайн тул стейкний шаардлага хангах цэвэр махны хэмжээ нийт гарцын 36 хувь, цул болон ястай мах 45 орчим хувийг, дайвар болон бусад хэсэг 20 орчим хувиар бүрдүүлж байна.

Энэ оны 6 сараас эхлэн 100 хоног бордсон үхрийн стейкний нэр төрлийг үе шат, дараалалтайгаар нэмэгдүүлж, 2022 оны эцэс гэхэд стейкний гарцын хувийг 30-35 хувьд хүргэхээр төлөвлөж байна. Ингэснээр бордолтын өртөг бага хэмжээгээр нэмэгдэх ч, стейкний үнэ бусад төрлийн махнаас өндөр үнэтэй байх тул үйл ажиллагааны ашгийн төвшин нэмэгдэнэ гэж харж байна.



*Стейкний махны тухай сонирхолтой баримт*

*Хоолны номонд албан ёсоор хэвлэгдсэн анхны стейкний жор 15-р зуунд Их Британид төрсөн бөгөөд удалгүй Европ гэх мэт олон улс орны хоолны уламжлалаас хамааран төрөл бүрийн аргаар стейкийг шарсан байна. Стейк хийхэд 2.5-4 см зузаантай, хөндлөн зүссэн мах хэрэглэдэг тул махаа зүсэх арга барил маш чухал байдаг. Сайн зүсэх нь махны целлюлозын нүхэнд тос нэвтэрч, стейкийг хурдан чанаж, илүү шүүслэг болгодог. Дунджаар гулуузны зөвхөн 35 хүртэлх хувь нь стейк хийхэд тохиромжтой байдаг тул энэ хоолонд зориулагдсан махыг элит, үнэтэй гэж үздэг.*

СЗХ
2022 06 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONBEEF



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

**Мах ангилан төхөөрөх үйлдвэрийг хөгжүүлэх нь:**

| Өнөөгийн нөхцөл байдал | Сайжруулах төлөвлөгөө |
|---|---|
| 1. "Мон Бийф" ХХК нь "Цалуут Импекс" ХХК-аар үхрээ нядлуулах, нарийн ангилгаа хийлгүүлэх, савлуулах гэх мэт үйлчилгээнүүдийг авдаг. "Цалуут Импекс" ХХК нь ISO 9001:2016, ISO 22000:2018 , HACCP CAC/RCP/ 1:2003, стандартууд болон ариун цэврийн бүрэн шаардлагыг хангадаг. | "Мон Бийф" ХХК нь өөрийн гэсэн нядалгаа болон ангилгаа, савлагааны жишиг үйлдвэрийг 2022 оны 4-р улирлаас бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд одоогоор зураг төслийн ажил хийгдээд байна. Мөн үйлдвэр барих газар инженер геологийн судалгаа хийгдэн явж байна. |
| 2. "Мон Бийф" ХХК нь өөрсдийн нядалгаа болон ангилгаа савлагааны үйлдвэргүй тул үхрийг нядлах, ангилах, савлах явцад бэлэн бүтээгдэхүүний өртөг маш ихээр нэмэгдэж, бохир буюу үйл ажиллагааны ашиг хангалтгүй хэмжээнд очиход нөлөөлж байна. | Нядалгаа болон ангилан савлах жишиг үйлдвэр ашиглалтад оруулах байршлуудыг харьцуулж, байршил сонголтод нөлөөлөх шалгуур үзүүлэлтийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн. Шалгуур үзүүлэлтийн хувьд мал бэлтгэл, дэд бүтэц, анхны хөрөнгө оруулалт, Улаанбаатар хотоос алслагдсан байдал, хүчин чадал, ажиллах хүчин, хөдөлмөрийн насны хүн амын тоо зэргийг авч үзсэн. Үнэлгээ хийхэд хамгийн өндөр буюу 79 оноогоор Төв аймгийн Сэргэлэн сумын байршил тодорсон. |

**Зах зээлд эзлэх хэмжээ**

*Зураг 25. Монгол улсын махны нийлүүлэлтийн хэмжээ, мянган тонн*




Монгол улсын хэмжээнд 2020 онд 745 гаруй мянган тонн мах нядлан бэлтгэж хүн амын хэрэгцээнд зориулан 648 мянган тонн мах нийлүүлжээ. Хүн амын өсөлтийг даган хэрэглээ өсдөг. 2016 оноос хойш нэг хүнд ногдох махны хэрэглээ 6 хувиар өсч жилд нэг хүнд ногдох махны хэрэглээ 106 килограммд хүрээд байна.

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Гэвч бидний хэрэглэж буй мах хэр эрүүл, чанартай вэ? гэдэг баталгаа хомс байгаагийн нэг илрэл нь үйлдвэрийн аргаар боловсруулсан мах нь нийт махны нийлүүлэлтийн 4-5 хувьд байна. Уламжлалт нүүдлийн соёлоос улбаатай махны хэрэглээгээ одоо ч хадгалж ахуйн аргаар дийлэнх махаа нядлан, ангилж боловсруулж, эрүүл ахуйг чанд сахихгүй байгаа зэрэг зүйлсээс үүдэн иргэдийн гол нэрийн хүнсний бараа болох махны чанар үзүүлэлт сул байна.

*Зураг 26. Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны задаргаа, 2020 он*




Жилд дунджаар 26 мянган тонн нийлүүлэгдэж байгаа үйлдвэрийн аргаар боловсруулсан махны бүтцийг авч үзвэл дийлэнх хэсгүүд нь тахиа, гахай, хонь, үхрийн мах байна. Бидний зорилтот зах зээл болох боловсруулсан үхрийн мах нь энэхүү зах зээлийн 15.2 хувийг эзэлж байна.

*Зураг 27. "Мон Бийф" зах зээлийн төлөвлөгөө*



СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01



Үхрийн боловсруулсан махны зах зээл олон хүчин зүйлсээс хамаарч өсөх боломжтой байна. Хүн амын өсөлт жилд дунджаар 2.5 хувиар , амьжиргааны зардал 6.3 хувиар, хүн амын орлогын өсөлт 9.5 хувиар өсч нэг хүнд ногдох махны хэрэглээ сүүлийн 5 жилд тогтмол бөгөөд өссөн дүнгээр 8.9 кг-д хүрээд байна мөн бусад үйлдвэр, фермүүдийн бүтээмж зэргээс хамаарч зах зээл тэлэх боломж өндөр байгаа ч бидний хувьд 2020 оны нийлүүлэлтийг 2022 онд суурь болгон өнөөгийн махны дундаж үнээр тооцоолбол ойролцоогоор үйлдвэрийн аргаар ангилан боловсруулсан махны зах зээл 105 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна.
“Мон Бийф” ХХК-ийн хувьд зах зээлийнхээ өсөлтөөс хамаарч 10-13 хувийг хангахаар зорин ажиллаж байна.

## 6.2 Санхүүгийн нөхцөл байдлын төсөөлөл

*Хүснэгт 34. Орлого үр дүнгийн тайлан*

**Орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл, мянган төгрөг**

| | 2022F | 2023F | 2024F | 2025F | 2026F |
|---|---|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **10,585.4** | **14,510.0** | **16,655.4** | **19,049.2** | **21,653.1** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 7,868.8 | 9,726.7 | 10,960.0 | 12,532.7 | 14,189.5 |
| **Нийт ашиг** | **2,716.6** | **4,783.2** | **5,695.4** | **6,516.5** | **7,463,584** |
| Борлуулалт, маркетингийн зардал | 423.4 | 580.4 | 666.2 | 762.0 | 866.1 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,738.5 | 2,019.5 | 2,242.9 | 2,492.9 | 2,760.1 |
| **Татварын өмнөх ашиг** | **554.7** | **2,183.4** | **2,786.3** | **3,261.7** | **3,837.3** |
| Татварын зардал | 55.5 | 218.3 | 278.6 | 326.2 | 383.7 |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | **499.2** | **1,965.0** | **2,507.7** | **2,935.5** | **3,453.6** |

Компани нь 2022 оны эхний улирлын байдлаар 509 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Энэ оны 5 сараас ферм нь сард дунджаар 40-60 тонн мах зах зээлд нийлүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь нийт хүчин чадлын 50-75 хувь ба тогтмол энэ дүнгээрээ борлуулалтын хэмжээгээ барьж чадвал энэ оны эцэст 10 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байхаар төлөвлөөд байна.

*Зураг 28. Борлуулалтын орлого ба цэвэр ашгийн төсөөлөл, сая төгрөг*



Цаашид үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмж бүрэн хүчин чадалдаа очсоноор сард дунджаар 77 тонн мах бэлтгэн 2026 он гэхэд жилд 20 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олох төлөвлөгөөтэй байна.

*Зураг 29. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба үйл ажиллагааны зардал, хувиар*




Цаашид махны гарцыг сайжруулж, нядалгаа болон ангилан савлах жишиг үйлдвэр ашиглалтад орсноор 1 үхэрт ногдох үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал 50 орчим хувиар буурахаар тооцоолоод байна. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг буурснаар үйл ажиллагааны ашгийн хувь 2 дахин нэмэгдэх боломжтой мөн борлуулалтыг эрчимжүүлснээр борлуулалтын орлогод эзлэх борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурах төлөвтэй байна.

Үнэт цаас гаргагчийн зүгээс нядалгаа, ангилан савлах үйлдвэрийн төслийг яаралтай хэрэгжүүлж, маркетингийн болоод борлуулалтын идэвхийг нэмэгдүүлснээр гарцын хэмжээг өсгөж, бүтээгдэхүүний борлуулалтын орлогод эзлэх өртгийн хэмжээг 2023 он гэхэд 66 хувь руу бууруулах төлөвлөгөөтэй байна.

*Хүснэгт 35. Ашигт ажиллагаа, хувиар*

| | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|
| Нийт ашгийн маржин | 25.7% | 33.0% | 34.2% | 34.2% | 34.5% |
| Ашгийн маржин | 0.9% | 11.3% | 14.1% | 15.4% | 15.9% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 1.2% | 21.0% | 26.7% | 31.1% | 34.5% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 1.2% | 21.0% | 26.7% | 31.1% | 34.5% |

Компани 2021 оны эцэс, 2022 оны эхний улирлуудад алдагдалтай ажилласан ба үйлдвэрлэлийн хурд нэмэгдсэнээр нэгж бүтээгдэхүүнд ногдох өртгийн хэмжээ буурч, борлуулалтын орлого нэмэгдсэнээр ашигт ажиллагааны хувь 2023-2026 онуудад 11-16 хувьтай байхаар төлөвлөөд байна.

СЗХ
2022 .06.22 өдөр
MON BEEF
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 36. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл*

| | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Тайлант хугацааны ашиг (алдагдал) | 93,160 | 1,600,354 | 2,315,343 | 2,935,496 | 3,453,623 |
| **Тохируулгууд:** | | | | | |
| Элэгдэл, хорогдлын зардлын өөрчлөл | 387,230 | 516,726 | 563,181 | 588,469 | 613,757 |
| Мөнгөн бус гүйлгээний өөрчлөлт | | | | | |
| Дансны ба бусад авлагын өөрчлөлт | (124,973) | (91,082) | (48,044) | (53,710) | (58,508) |
| УТТооцоо, УГЗардлын өөрчлөлт | | | | | |
| Бараа материалын өөрчлөлт | (349,391) | (145,652) | (64,946) | 346,449 | (215,603) |
| Дансны ба бусад өглөгийн өөрчлөлт | 14,638 | 50,901 | 33,789 | 43,088 | 45,392 |
| Хүүгийн орлого (-) | | | | | |
| Хүүгийн зардал (+) | 451,147 | 405,151 | 213,684 | | |
| Орлогын татварын зардал (+) | 10,351 | 177,817 | 257,260 | 326,166 | 383,736 |
| Хүлээн авсан хүү (+) | | | | | |
| Төлсөн хүү (-) | (451,147) | (405,151) | (213,684) | | |
| Төлсөн орлогын татвар (-) | (10,351) | (177,817) | (257,260) | (326,166) | (383,736) |
| **ҮА-ны цэвэр мөнгөн гүйлгээ** | **20,444** | **1,931,247** | **2,576,906** | **3,882,114** | **3,88,661** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Үндсэн хөрөнгийн өөрчлөлт | (3,868,537) | (331,666) | (465,856) | (331,666) | (331,666) |
| Биет бус хөрөнгийн өөрчлөлт | | | | | |
| Худалдан авсан хөрөнгө оруулалт | 1,300,000 | | | | |
| Хүлээн авсан ногдол ашиг | | | | | |
| Хоорондын тооцооны авлагын өөрчлө | | | | | |
| Холбоотой талын өглөгийн өөрчлөлт(+ | | | | | |
| IPO | 2,892,857 | | | | |
| **ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **324,320** | **(331,666)** | **(465,856)** | **(331,666)** | **(331,666)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Богино хугацаат зээлийн өөрчлөлт (+) | (365,045) | (1,519,581) | (1,695,906) | | |
| Урт хугацаат зээлийн өөрлөлт (+) | | | | | |
| Хоорондын тооцооны авлагын өөрчлө | | | | | |
| Хоорондын тооцооны өглөгийн өөрчлө | | | | | |
| Төлсөн ногдол ашиг (-) | | | | (2,331,801) | (2,935,496) |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн өөрчлөлт (- | | | | | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(365,045)** | **(1,519,581)** | **(1,695,906)** | **(2,331,801)** | **(2,935,496)** |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (20,061) | 80,000 | 415,144 | 1,235,104 | 571,499 |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 40,061 | 20,000 | 100,000 | 515,144 | 1,750,248 |
| **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **20,000** | **100,000** | **515,144** | **1,750,248** | **2,321,746** |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
MON BEEF
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03



Компани 2023 оны хагас хүртэл хамгийн том эх үүсвэр болох зэргэлдээ компанийн санхүүжилтээ холбогдох хүүгийн зардалтай хамт төлөхөөр байна. Бараа бүтээгдэхүүний борлуулалт болон олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө зэрэг орж ирсэн мөнгөн урсгалууд нь үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө, бараа материалд түлхүү зарцуулагдах байдлаар 2026 он хүртэл төлөвлөөд байна.

*Хүснэгт 37. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, мянган төгрөг*

| *мянган төгрөг* | 2022F | 2023F | 2024F | 2025F | 2026F |
|---|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | | | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 20,000 | 100,000 | 515,144 | 1,750,245 | 2,321,748 |
| Худалдааны болон бусад авлага | 263,439 | 354,521 | 402,565 | 456,275 | 514,783 |
| Урьдчилж олсон орлого | 211,838 | 211,838 | 211,838 | 211,838 | 211,838 |
| Бараа материал | 2,255,008 | 2,400,660 | 2,688,024 | 2,319,254 | 2,534,857 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | **2,750,285** | **3,067,019** | **3,817,571** | **4,737,615** | **5,583,225** |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | | | |
| Өмч барилга, тоног төхөөрөмж | 4,847,296 | 4,662,236 | 4,564,910 | 4,308,107 | 4,026,016 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 56,738 | 56,738 | 56,738 | 56,738 | 56,738 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | **4,904,034** | **4,718,973** | **4,621,648** | **4,364,845** | **4,082,754** |
| **Нийт хөрөнгө** | **7,654,319** | **7,785,992** | **8,439,219** | **9,102,460** | **9,665,978** |
| Өр төлбөр | | | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 296,894 | 347,795 | 381,583 | 424,671 | 470,063 |
| Татварын өр | 8,353 | 8,353 | 8,353 | 8,353 | 8,353 |
| Богино хугацаат зээл | 3,215,487 | 1,695,906 | | | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | **3,520,733** | **2,052,053** | **389,936** | **433,024** | **478,416** |
| Холбоотой талын санхүүжилтийн өр | - | - | | - | - |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - | - | - | - |
| Нийт өр төлбөрийн дүн | **3,520,733** | **2,052,053** | **389,936** | **433,024** | **478,416** |
| Өмч | | | | | |
| Хувьцаат капитал | 2,142,857 | 2,142,857 | 2,142,857 | 2,142,857 | 2,142,857 |
| Нэмж төлөгдсөн капитал | 2,250,000 | 2,250,000 | 2,250,000 | 2,250,000 | 2,250,000 |
| Тайлант үеийн ашиг алдагдал | 93,160 | 1,635,184 | 2,354,123 | 2,935,496 | 3,453,623 |
| Хуримтлагдсан ашиг(алдагдал) | (352,430) | (259,270) | 1,375,913 | 1,375,913 | 1,375,913 |
| Нийт өмчийн дүн | **4,133,585** | **5,733,939** | **8,049,283** | **8,669,436** | **9,187,562** |
| **Нийт өр төлбөр ба өмчийн дүн** | **7,654,319** | **7,785,992** | **8,439,219** | **9,102,460** | **9,665,978** |

СЗХ
2022 06 27
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

Зураг 30. Нийт хөрөнгийн төсөөлөл, мянган төгрөг




Компани үүсгэн байгуулагдсан цагаасаа дүрмийн сан болон толгой компанийн зээлээр санхүүжиж үүгээрээ үйл ажиллагаанд шаардагдах эргэлтийн бараа материалыг санхүүжүүлсэн бол цаашид орж ирэх мөнгөн урсгалаар мөн адил ангилгаа, нядалгааны үйлдвэр, шаардлагатай тоног төхөөрөмж, үхрийн татан авалт зэрэгт шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг ихээхэн хийснээр цаашид 2026 он хүртэл жилд дунджаар нийт хөрөнгийн хэмжээ 16 хувиар өсөх төлөвтэй байна.

Зураг 31. Нийт өр төлбөр ба өмчийн төсөөлөл, мянган төгрөг



Компани 2021 оны эцэст 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй 200 сая төгрөгийн эздийн өмчтэй байсан бол дүрмийн сангийн хэмжээгээ 2022 оны 1-р улиралд 1.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн ч хуримтлагдсан алдагдлын нөлөөгөөр нийт хөрөнгийн хэмжээ 3.8 тэрбум төгрөгийн дүнтэй байна. Цаашид компани нь олон нийтээс хөрөнгө татан хувьцаат хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж, хуримтлагдсан ашгийн өгөөжөө эх үүсвэр болгон урт хугацаат зээл өглөг авахгүй байхаар төлөвлөн зорьж байна.

*Зураг 32. Харьцаа үзүүлэлт*




Үнэт цаас гаргагч нь 2021 оны 4-р улиралд зэргэлдээ компаниас 3.5 тэрбумын шугамын зээлээр санхүүжсэн үүнээс өөр томоохон дүнтэй зээл өглөг байхгүй байна. Энэ нь нийт хөрөнгийн 92 орчим байгаа ба цаашид томоохон зээл авахгүйгээр төсөөлж зээлээ төлж, бусад эх үүсвэр, хуримтлагдсан ашгийн нөлөөгөөр 2023 оноос өр төлбөрийн харьцаа огцом буурч санхүүгийн нөхцөл байдал илүү сайжрах төлөвтэй байна.

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

07

## 7.1 Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | “Мон Бийф” ХХК |
| Үнэт цаасны бүртгэл, самбар | МХБ, III ангилал |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт гаргасан хувьцааны тоо | 150,000,000 ширхэг |
| Шинээр гаргаж буй хувьцааны тоо | 64,285,700 ширхэг |
| Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо | 214,285,700 ширхэг |
| Олон нийтэд санал болгож буй хувьцааны хувь | 30 хувь |
| Нэгж хувьцааны үнэ | 45 төгрөг |
| Нийт татан төвлөрүүлэх дүн | 2,892,856,500 төгрөг |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | ▪ Үйлдвэрийн байр<br>▪ Тоног төхөөрөмжийн худалдан авалт |
| Компанийн нийт хувьцааны зах зээлийн үнэ | 9,642,856,500 төгрөг |

**Олон нийтэд санал болгох нөхцөл**

| | |
|---|---|
| Хувьцааг санал болгох арга | Тогтоосон үнийн арга |
| Санал болгох нэгжийн үнэ | 45 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | 2,892,856,500 төгрөг |

| | |
|---|---|
| Үндсэн андеррайтер | “Апекс Капитал ҮЦК” ХХК |
| Туслах андеррайтер | “Таван Богд Капитал ҮЦК” ХХК |

СЗХ
он 2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ
MON BEEF
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03



## 7.2 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

### 7.2.1 Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 40/ТУЗ-08 тоот тогтоолоор анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгох үнийг 45 төгрөг байхаар тогтоосон. Хувьцааны энэхүү үнэлгээг:

- Хөндлөнгийн үнэлгээний "Итгэлт Эстимэйт" ХХК-ийн гүйцэтгэсэн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан;
- Үнэт цаас гаргагч компанийн өөрийн үнэлгээ болон
- Үндсэн андеррайтерийн гүйцэтгэсэн үнэлгээ зэргийг үндэслэн тогтоосон.

2022 оны 02 сарын 16-ны өдөр байгуулсан Хөрөнгийн үнэлгээний ажлын гэрээний дагуу "Итгэлт Эстимэйт" ХХК нь "Мон Бийф" ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ ҮОУК-аас баталсан нийтээр хүлээн зөвшөөрсөн 3-н хандлагын орлогын хандлагын арга, цэвэр активын арга, зах зээлийн аргыг ашиглан үнэлгээг хийсэн бөгөөд Орлогын хандлагын цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар хийсэн үнэлгээнд 100 хувь ач холбогдол өгсөн болно. Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар хийсэн үнэлгээний үр дүнд Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг **12.8 тэрбум төгрөгөөр** тогтоосон.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хөгжлийн шатандаа байгаа, компанийн цаашдын борлуулалтын цар хүрээ нэмэгдэх боломжтой болон эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж компанийн үнэлгээг **25 хувийн хөнгөлөлттэйгөөр** буюу **9.6 тэрбум төгрөг** болгон хямдруулах санал гаргасан. Үүний дагуу Үнэт цаас гаргагч нь олон нийтэд шинээр гаргаж буй 64,285,700 ширхэг хувьцааг нэгж бүрийг 45 төгрөгөөр санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэлгээний компанийн тайлангийн дэлгэрэнгүйг хавсралт дахь Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлангаас харна уу.

| | |
|---|---|
| Үнэлгээний байгууллага | "Итгэлт Эстимэйт" ХХК |
| Үнэлгээний төрөл | Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ |
| Бизнесийн үнэлгээ | Цэвэр активын аргаар – 874,000,000 төгрөг<br>Зах зээлийн аргаар – 2,870,100,000 төгрөг<br>Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргаар – **12,861,800,000 төгрөг**<br>**Нэгж хувьцааны үнэ 60 төгрөг** |
| Олон нийтэд санал болгож буй үнэлгээ | 9,642,856,500 төгрөг (25 хувиар бага)<br>**Нэгж хувьцааны үнэ 45 төгрөг** |

СЗХ
2022 06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
MONBEEF

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 06 17
БҮРТГЭВ-03



Үнэт цаас гаргагчийн хувьд борлуулалтын өсөлт үзүүлэх боломжтой, ХАА-н бизнес нөгөө талаас эхлэлтийн шатандаа байгаа тул компанийн ирээдүйд чухал ач холбогдол өгч цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга ашиглан үнэлгээг хийсэн байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ 1118265142

СЗХ
2022.06.02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 7.2.2 Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга

Цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргаар компанийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийг жигнэсэн дундаж санхүүжилтийн зардлаар(WACC) хорогдуулан өнөөгийн үнэ цэнийг тооцоолох ба нийлбэр нь компанийн нийт үнэлгээ(Enterprise Value) болдог. Компанийн нийт үнэлгээнээс цэвэр өр төлбөрийг (Net debt) хасч тооцсоноор компанийн хувьцааны үнэлгээг (Equity Value) гаргаж авдаг.

Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувийг тогтоохдоо нийлбэрийн аргыг ашиглан дараах томьёогоор тодорхойлсон. Үүнд:

МГХТХ = Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувь

МГХТХ = К1+К2+К3+К4

К1- Эрсдэлгүй хүү
К2- Макро төвшний нөлөөллийн хувь
К3- Салбарын гадаад эрсдэлийн хувь
К4- Компанийн дотоод эрсдэлийн хувь

К1- Эрсдэлгүй хүү- Засгийн газрын бодлогын хүү 9 хувь байгааг үндэслэн тооцов.

К2- Макро төвшний нөлөөллийн хувь- Монгол улсын сүүлийн 5 жилийн инфляцийн дунджаар тооцоолов.

*Хүснэгт 38. Инфляцийн түүхэн мэдээлэл*

| Он | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | Дундаж |
|---|---|---|---|---|---|---|
| Тухайн жилийн инфляц | 6.40% | 8.10% | 5.20% | 2.30% | 13.40% | 7.08% |

К3- Салбарын гадаад эрсдэлийн хувь- Өрсөлдөгч нэмэгдэх, валютын ханшийн хэлбэлзэл, дэлхийн нийтийг хамарсан цар тахал зэргийг харгалзан үзэж 2 хувь байна.

К4- Компанийн дотоод эрсдэлийн хувь:
Байгууллагын санхүүгийн нөөц – 1%
Орлогын таамаглал – 1%

*Хүснэгт 39. Хорогдуулалтын хувийн коэффициентууд*

| Коэффициентийн ангилал | Коэффициентийн агуулга | Хувь |
|---|---|---|
| К1 | Эрсдэлгүй хүү | 9.0% |
| К2 | Макро төвшний нөлөөллийн хувь | 7.08% |
| К3 | Салбарын гадаад эрсдэлийн хувь | 2% |
| К4 | Компанийн дотоод эрсдэлийн хувь | 3% |
| Мөнгөн гүйлгээг хорогдуулан тооцох хувь | | 21.08% |

СЗХ
2022..06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MONBEEF



2022-03-17
БҮРТГЭВ

**Тогтмол өсөлтийн хувь:**

Цаашид жил бүр тогтмол өсөлтийн хувийг 7.5 хувь байна гэж тооцоолов. Тогтмол өсөлт нь бизнест урт хугацаанд тасралтгүй ажиллах боломжийг илтгэх үндсэн үзүүлэлт бөгөөд тогтмол орлогын өсөлт нь цаг ямагт инцляцийн дундаж төвшнөөс өндөр байна. Өөрөөр хэлбэл тогтмол орлогын өсөлт нь инфляцийн дундаж хувиас бага байгаа үед аливаа бизнес цаашид үргэлжлэх боломжгүй гэж үзэх юм.

“Зах зээлийн арга”-аар хийхдээ I ангиллын ХК, ижил үйл ажиллагаа явуулж байгаа ХК-ийн мэдээлэлд үндэслэн хийсэн болно.

Дараах мэдээлэлд үндэслэн хийсэн болно.

*Хүснэгт 40. Харьцуулсан ХК-ийн мэдээлэл*

| № | Үзүүлэлт | Түмэн Шувуут ХК | Сүү ХК |
|---|---|---|---|
| 1 | Нийт орлого /сая.төгрөг/ | 35,912.9 | 100,397.0 |
| 2 | Цэвэр ашиг /сая.төгрөг/ | 6,940.0 | 9,400.8 |
| 3 | Эздийн өмч /сая.төгрөг/ | 30,352.7 | 32,981.2 |
| 4 | Нийт хувьцааны тоо /ширхэг / | 200,000,000 | 343,061,914 |
| 5 | Нэгж хувьцааны өнөөгийн үнэ /төгрөг/ | 501.9 | 559.5 |
| 6 | Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөг/ | 34.7 | 27.4 |
| 7 | Зах зээлийн үнэлгээ /сая.төг/ | 100,380.0 | 191,943.1 |
| 8 | Үнэ ашгийн харьцаа | 14.5 | 20.4 |
| 9 | Үнэ эздийн өмчийн харьцаа | 3.34 | 5.82 |

**Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргаар хийсэн үнэлгээ**

1. Орлогын албан татварын хувь – 10%
2. Дискаунтын хувь – 21.08%
3. Сүүлийн жилийн орлогын өсөлт – 7.5%

*Хүснэгт 41. Мөнгөн урсгалын хорогдуулах аргаар хийсэн үнэлгээний үр дүн*

| *сая төгрөг* | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн гүйлгээний урсгал | 446.8 | 592.4 | 1,704.7 | 2,181.6 | 2,951.8 |
| Өнөөгийн үнэ цэнэ /2026 он хүртэлх/ | 3,883 | | | | |
| Эцсийн жилийн өртөг /2026 оноос хойш/ | 23,366 | | | | |
| **Бизнесийн үнэ цэнэ** | **12,861.8** | | **Арван хоёр тэрбум найман зуун жаран нэгэн сая найман зуун мянган төгрөг** | | |

2022-2026 оны хооронд олох цэвэр мөнгөн урсгал дээр тулгуурлан хорогдуулах аргыг ашиглан тооцоолол хийхэд Үнэт цаас гаргагчийн ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн нийлбэр буюу компанийн нийт үнэлгээ нь 12.8 тэрбум төгрөг болж байна.

Мон Бийф ХХК компани

СЗХ
2022 06 22 өдөр
БҮРТГЭВ
MON BEEF
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 42. Цэвэр активын аргаар хийсэн үнэлгээний үр дүн*

| Үзүүлэлт | | Дүн /мянган төгрөг/ |
|---|---|---|
| 2022-03-31-ний байдлаарх нийт хөрөнгө | | 3,810,244.4 |
| Нэмэгдэх нь | Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 247,946.6 |
| Хасагдах нь | Нийт өр төлбөр | 3,183,563.0 |
| **Хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээний дүн** | | **874,628.0** |

Цэвэр активын аргаа хийсэн үнэлгээний дүн 874,628,000 /**Найман зуун далан дөрвөн сая зургаан зуун хорин найман мянга/**-н төгрөг

*Хүснэгт 43. Зах зээлийн аргаар хийсэн үнэлгээний үр дүн*

| № | Нэр | "Мон Бийф" ХХК |
|---|---|---|
| 1 | Нийт орлого /мян.төг/ | 509,165 |
| 2 | Эздийн өмч /мян.төг/ | 626,681.0 |
| 3 | Үнэ эздийн өмчийн харьцаа | 4.58 |
| | **Үнэ эздийн өмчийн харьцаагаар үнэлсэн дүн /мян.төг/** | **2,870,169.2** |

Компанийг "Түмэн шувуут" ХК болон "Сүү" ХК-уудын үйл ажиллагааны чиглэл нь үнэт цаас гаргагчийн бизнестэй төстэй үйл ажиллагаатай тул энэхүү компаниудын санхүүгийн үзүүлэлтийг үндэслэн компанийн үнэлгээг 2.8 тэрбум төгрөг гэж үнэлэв.

*Хүснэгт 44. Үнэлгээний үр дүн*

| № | Нэр | Дүн сая.төг | Ач холбогдох | Дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргаар хийсэн үнэлгээний үр дүн | 12,861.8 | 100% | 12,861.8 |
| 2 | Цэвэр активын аргаар хийсэн үнэлгээ | 874.6 | 0% | - |
| 3 | Зах зээлийн аргаар хийсэн үнэлгээний үр дүн | 2,870.1 | 0% | - |
| Үнэлгээний нэгдсэн үр дүн | | | | 12,861.8 |

Дээрх үнэлгээний аргууд болон компанийн цаашид авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжсэнээр компанийн үнэлгээ нэмэгдэх боломжийг үндэслэн үнэт цаас гаргагч компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 40/ТУЗ-08 тоот тогтоолоор компанийн нэгж хувьцааны үнэ цэнийг 45 төгрөг, компанийн нийт үнэлгээг 9.6 тэрбум төгрөг байхаар шийдвэрлэсэн.

Үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ"-ний тайлангаас харна уу.

СЗХ
2022 .06. 2.2 өдөр
БҮРТГЭВ
№ 01
MON'BEEF

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03



## 7.3 Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд өөрийн бизнесийн 30 хувиа санал болгон 2.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж тус хөрөнгийг компанийн бизнесийн дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд нядалгаа, ангилан савлах үйлдвэр болон агуулахын төсөлд зарцуулахаар төлөвлөөд байна.

“Мон Бийф” ХХК нь “Цалуут Импекс” ХХК-аар үхрээ нядлуулах, нарийн ангилгаа хийлгүүлэх, савлуулах гэх мэт үйлчилгээнүүдийг авдаг ба тус үйлдвэр нь ISO 9001:2016, ISO 22000:2018 , HACCP CAC/RCP/ 1:2003 стандартууд болон ариун цэврийн бүрэн шаардлагыг хангадаг.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор мах нядалгаа болон ангилан савлах үйлдвэрийг барих бэлтгэл ажлаа хангаж байна.

**Тулгарч буй асуудал:**

Нядалгаа болон ангилан савлах үйлдвэрүүдийн өмнө тулгарч байгаа бэрхшээлүүд нь технологи, стандартын асуудал байна. Хүнсний үйлдвэрлэлийн үе шат бүр хүйтэн гинжин сүлжээнд буюу хөргүүрээс хөргүүрт, хөлдөөгчөөс хөлдөөгчийн хооронд, эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэр орчинд явагдах ёстой ч үйлдвэрлэгч, хэрэглэгчийн мэдлэг хангалтгүйгээс үйлдвэрлэлийн бус аргаар төхөөрсөн, эрүүл ахуйн шаардлага хангаагүй орчинд бэлтгэгдсэн малыг хэрэглэсэн хэвээр байна. Мөн нэг асуудал нь дайвар бүтээгдэхүүн боловсруулах технологи сул байгаагаас дайвар бүтээгдэхүүн хаягдаж байна.

Энэ мэт хүн амын хэрэглээний стандарт, шаардлагад үүсч буй асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдэх, өөрийн брэндийн эрүүл ахуй, чанарыг илүү сайжруулж дээшлүүлэх үүднээс нядалгаа ангилан савлах үйлдвэрийг барьж буй юм.

*Хүснэгт 45. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт*

| Хийгдэх ажлууд | Шаардагдах хөрөнгө /төгрөг/ | Эзлэх хувь |
|---|---|---|
| Үйлдвэрийн тоног төхөөрөмж | 1,903,530,000 | 66% |
| Үйлдвэрийн барилга | 989,326,500 | 34% |
| **Нийт** | 2,892,856,500 | **100%** |

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 66 хувь нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, 34 хувь нь үйлдвэрийн барилгын ажилд зарцуулагдахаар төлөвлөгдөж байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ 1118265142

СЭХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

Хүснэгт 46. Үйлдвэрийн барилгын ажлын зардлын задаргаа

| Хийгдэх ажлууд | Дүн /төгрөг/ | Эзлэх хувь |
|---|---|---|
| Нядалгааны үйлдвэрийн барилга | 864,000,000 | 87% |
| Зуух | 50,000,000.0 | 5% |
| Худаг гаргах, ус цэвэршүүлэх хэсэг | 50,326,500.0 | 5% |
| Цахилгааны өргөтгөл | 25,000,000.0 | 3% |
| **Нийт** | 989,326,500 | **100%** |

Барилгын ажлын явцын хувьд зураг төслийн ажил дуусаад байна. 2022 оны 6 сараас бүтээн байгуулалтын ажил эхлэн 2022 оны дөрөвдүгээр улирал гэхэд бүрэн дуусгах төлөвлөгөөтэй байна. Үйлдвэр нь 1 ээлжиндээ 30 бодыг ангилан нядлах хүчин чадалтай ба ISO 9001:2016, ISO 22000:2018, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо , HACCP CAC/RCP/ 1:2003 зэрэг стандартуудыг хангасан орчин үеийн шинэлэг техник, технологийг ашиглахаараа давуу талтай юм.

Хүснэгт 47. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн зардлын задаргаа

| Шаардлагатай тоног төхөөрөмж | Дүн /төгрөг/ | Эзлэх хувь |
|---|---|---|
| Мал төхөөрөх тоног төхөөрөмж | 603,143,264 | 32% |
| Хөргөлтийн тоног төхөөрөмж | 537,115,099 | 28% |
| Мал төхөөрөх туслах тоног төхөөрөмж | 400,911,445 | 21% |
| Дайвар бүтээгдэхүүн цэвэрлэх төхөөрөмж | 176,031,924 | 9% |
| Шулалгаа, ангилгааны төхөөрөмж | 186,328,268 | 10% |
| **Нийт** | 1,903,530,000 | **100%** |

“Мон Бийф” ХХК нь хамгийн дэвшилтэт нядалгаа болон ангилан савлах жишиг үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Турк улсын томоохон үйлдвэрээс татан авалт хийхээр төлөвлөөд байна.Тоног төхөөрөмжийн зардлын дийлэнх хэсэг нь мал төхөөрөх болон хөргөлтийн тоног төхөөрөмжүүдэд зарцуулагдахаар байна.

Нядалгаа болон ангилан савлах жишиг үйлдвэр ашиглалтад орсноор 1 үхэрт ногдох үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал 50% орчим буурахаар байна. Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг буурснаар үйл ажиллагааны ашгийн хувь 2 дахин нэмэгдэхээр байна.

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

Хүснэгт 48. "Мон Бийф" ХХК-ийн нядалгаа, ангилан савлах үйлдвэрийн давуу тал

| | "Мон бийф" ХХК | "Цалуут импекс" ХХК |
|---|---|---|
| 1 | Агуулахын хүртээмж хангалттай | Агуулахын хүрэлцээ багаас үүдэж эхэнд орсон бүтээгдэхүүнээ эхэнд гаргаж чаддаггүй |
| 2 | Өртөг буурна | Бүх ажиллагаа үнэлгээтэй. Зах зээлийн үнээс өндөр |
| 3 | Технологийн горим зөрчигдөхгүй | Агуулахын дүүргэлтээс хамаарч технологийн горим алдагдах магадлалтай |
| 4 | Технологийн нууцлал хадгалж чадна | Технологийн нууцлалаа хадгалах боломжгүй |
| 5 | Хангалттай хэмжээтэй агуулахтай учраас сул байгаа агуулахаа түрээсэлж бусад орлого олох боломж бүрдэнэ | Одоогийн ашиглаж байгаа 2 агуулах өндөр түрээс төлж байгаа |
| 6 | Эрүүл ахуйн шаардлага хангадаг цэвэрлэгээ ариутгал хийх боломжтой халуун усаар хангагддаг | Усны насосын хүчин чадал муу, орой цэвэрлэгээ хийхэд ус хүрэлцдэггүй цаг алддаг мөн усны шаардлага бүрэн хангадаггүй |
| 7 | ХАБЭА бүрэн хангасан. Тоног төхөөрөмж сууриуулалт стандарт, хуулийн дагуу явагдана. Бүх тоног төхөөрөмж дээр мэргэжлийн хяналтаас зөвшөөрөл авч ажиллуулна. | Тоног төхөөрөмжүүд дээр газардуулга хийгдээгүй ба барилгын газардуулга үйлдвэр рүү орж ирээгүй байгаа |
| 8 | Бүтээгдэхүүний нэр төрөл нэмэх боломжтой зай талбайтай (хагас боловсруулсан бүтээгдэхүүн, түүхий зайдас нэмэх үйлдвэрлэх гэх мэт) | Нэр төрөл нэмэх олон төрлийн тоног төхөөрөмж байхгүй байгаа |
| 9 | Бүх технологи ажиллагаа зөв горимд орж тусдаа хэсгүүдэд хийгддэг болно | Ангилгаа, шулалгаа, савлагаа, хөрөөдөх, зорох, машиндах ажиллагаа нэг өрөөнд явагддаг |
| 10 | Үйлдвэрийн урсгал зөв болно | Урсгал сөрдөг |
| 11 | Хүчин чадал өндөртэй тоног төхөөрөмж суурилуулна | Одоогийн ашиглаж буй тоног төхөөрөмжүүд нь хүчин чадал багатай |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
MON BEEF
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022.06.17
БҮРТГЭВ-03

*Хүснэгт 49. Нийт үйлдвэрийн зардлын задаргаа*

| **Хийгдэх ажлууд** | **Шаардагдах хөрөнгө /төгрөг/** | **Эзлэх хувь** |
|---|---|---|
| Үйлдвэрийн тоног төхөөрөмж | 1,903,530,000 | 66% |
| Үйлдвэрийн барилга | 989,326,500 | 34% |
| **Нийт** | 2,892,856,500 | **100%** |

Нийт үйлдвэрийн бүтээн байгуулалтын зардлыг 3.76 тэрбум төгрөгөөр төлөвлөөд байгаа ба үлдсэн 869 орчим сая төгрөгийг компанийн дотоод эх үүсвэрээр шийдэхээр төлөвлөөд байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ



Мон Бийф ХХК

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
MONBEEF
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03



## 7.4 Үнэт цаас эзэмшигчийн эрх үүрэг

Үнэт цаас гаргагч нь компанийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын компанийн тухай хууль, үнэт цаасны зах зээлийн тухай хууль, компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрэмд зааснаар дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж буй хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дагуу эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу компанийн нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй. Үүнд:
    - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
    - Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
    - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг батлах;
    - Хувьцаа эзэмшигч дангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:
    - Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах;
    - Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;



АЛЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ 1118265142
5453283

- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүд нэр дэвшүүлэх;
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигч нь доорх үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороо болон шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй. Үүнд:
    - Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй тохиолдолд гомдол гаргах;
    - ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг албан тушаалтнаар компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;
    - Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;
    - Компанийн энгийн хувьцааны эзэмшигч нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх

**Компанийн хувьцаа эзэмшигчид дараах үүргийг хүлээнэ. Үүнд:**

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
- Энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх;
- Компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах;
- Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон СЗХ-нд тус тус бичгээр мэдэгдэх;

Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцах;

СЭХ
2022 .06 сар MONBEEF
БҮРТГЭВ
№ 01



2022-06-17
БҮРТГЭЭ-03

## 7.5 Ногдол ашгийн бодлогын төсөл

Компанийн ногдол ашгийн бодлогын төсөл нь холбогдох хууль (Компанийн тухай хууль) болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн боловсруулагдсан.
Уг баримт бичиг нь ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, олгох, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

**Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах**

Тухайн санхүүгийн жилийн эцсийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулан, санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар ТУЗ хуралдан шийдвэр гаргана.
Хэрвээ ТУЗ тухайн жил ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай хувьцаа эзэмшигчдийн хурал дээр танилцуулах бөгөөд шийдвэр гаргасан үндэслэлийг тайлагнана.

**Ногдол ашиг хуваарилах нөхцөл**

Дараах нөхцөл хангагдсан нөхцөлд компани ногдол ашиг хуваарилах боломжтой. Үүнд:

- ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;
- ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх.

**Ногдол ашиг хуваарилах**

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийг гаргах бөгөөд ногдол ашиг тараах шийдвэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- Хувьцааны төрөл тус бүрээр нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- Ногдол ашиг олгож эхлэх, дуусах хугацаа;
- Ногдол ашгийг олгох арга зам, хэлбэр.

**Тайлагнах**

Компани ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан саадгүй танилцах боломжийг бүрдүүлнэ.

Ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнана.

СЗХ
2022 06 22 өдөр
БҮРТГЭВ
MON BEEF
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03



## 7.6 Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 сарын 25 -ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам” мөн МХБ-ийн ТУЗ-ын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу зохион байгуулна.

Үнэт цаас гаргагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-д тусгагдсан “ТОГТООСОН ҮНЭЭР ХУВЬЦААГ САНАЛ БОЛГОХ” аргыг ашиглана.

Тогтоосон үнээр хувьцааг санал болгох арга нь харилцагч худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнэ (өгөөж)-ээр өгнө.

Үнэт цаас гаргагч нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгох үнийг дараах байдлаар тогтоосон байна.

| | Захиалгын арга | Нэмж гаргах хувьцаанаас санал болгох хувь | Хувьцааны тоо ширхэг | Санал болгох үнэ | Нийт татан төвлөрүүлэх дүн |
|---|---|---|---|---|---|
| Олон нийт | Тогтоосон үнээр хувьцааг санал болгох | 100% | 64,285,700 ширхэг | 45 төгрөг | 2,892,856,500 төгрөг |
| Нийт | | | | | 2,892,856,500 төгрөг |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК 5453283 УЛААНБААТАР ХОТ 1118265142

Мон Бийф ХХК

## 7.7 Анхдагч зах зээлийн процесс

Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

*Зураг 33. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах зохион байгуулалтын дараалал*




**Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах**

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

**Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах**

Андеррайтер нь олон нийтэд үнэт цаасыг танилцуулах үйл ажиллагааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлэн тогтоосон хугацааны дотор олон нийтэд үнэт цаасыг танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

**Захиалга хүлээн авах**

Үнэт цаас гаргагч болон Үндсэн андеррайтер нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын гурваас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд гаргаснаар анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно.

Хөрөнгө оруулагчид нь бүртгэлтэй брокерын компаниудад үнэт цаасны захиалгаа өгч болох ба онлайнаар захиалгаа өгөх бүрэн боломжтой.

**Үнэт цаасны анхдагч зах зээлд захиалга өгөх заавар**

*Зураг 34. Үнэт цаасны анхдагч зах зээлд захиалга өгөх заавар*




**Үнэт цаасны хуваарилалт, нийлүүлэлт**

Биржийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ыг баримтлан ажиллах бөгөөд Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцвол Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

Үнэт цаасны анхдагч зах зээлийг арилжааг тогтоосон үнийн аргаар зохион байгуулах бөгөөд олон нийтэд санал болгож буй хувьцаанаас давсан захиалга ирсэн нөхцөлд хувь тэнцүүлэх болно. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

**Төлбөр тооцоо**

Анхдагч зах зээлийн арилжаанд захиалга өгсөн хөрөнгө оруулагч нар нь хувьцааны үнийн дүнг ҮЦТХТ-ийн дансандаа байршуулсан байх бөгөөд арилжааны системийн дагуу Үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч нарын хооронд төлбөр тооцоо хийгдэнэ.

**Үнэ тогтворжуулах хөтөлбөр**

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэхээр андеррайтерийн гэрээгээр харилцан тохиролцсон. Тодруулбал, Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Таван Богд Трейд" ХХК нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд, олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн үнийн дүнгийн 15 хувиар, Үндсэн андеррайтер нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сарын хугацаанд, олон нийтээс татан төвлөрүүлсэн үнийн дүнгийн 2 хувиар үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм.

Олон нийтэд хувьцааг анх удаа санал болгох үйл ажиллагаатай холбоотой гарах аливаа зардлыг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс суутгахгүй.

СЗХ
2022 .06 .22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

# 08

СТ MON BEEF
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 8.1 Андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай

### 8.1.1 Андеррайтерийн танилцуулга

**"Апекс капитал ҮЦК" ХХК**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж, Нью Хорайзонс оффис, 9 давхар, 901 тоот
Утас: (976) 7510-7500
Э-шуудан: investment@apex.mn
Вэб хуудас: www.apex.mn

"Апекс капитал ҮЦК" ХХК анх 2011 онд үүсгэн байгуулагдсан ба 2018 онд удирдлагын бүтцийг шинэчилж, тогтвортой ажиллах хүчийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд үйл ажиллагаагаа өргөжүүлж брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрөл, гадаад арилжааны брокер, мөнгөн хөрөнгийн номиналын зөвшөөрөлтэйгөөр 24,000 гаруй харилцагчид-даа санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлж байна. Бүтээн байгуулалтаараа Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулж буй бизнесүүдийг олон нийтэд таниулах зорилгоор "Үндэсний бүтээн байгуулалтаа хамтдаа санхүүжүүлье" аяныг эхлүүлсэн ба "Апекс капитал ҮЦК" нь энэхүү аяны хүрээнд бүтээн байгуулагч бизнесүүдийг чухалчлан ажиллахаар болсон. Компанийн үйлчилгээний нэг хэсэг болох Андеррайтерийн үйлчилгээг 40 гаруй аж ахуй нэгжид үзүүлсэн бөгөөд дараах ажлуудыг амжилттай гүйцэтгэжээ.

Өнгөрсөн 4 жилийн хугацаанд хүнс үйлдвэрлэл, барилга, банк бус санхүү, электрон бараа худалдаа, мал аж ахуй болон нислэгийн салбарын 40 орчим аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж 130 орчим тэрбум төгрөгийн тогтмол хүүгийн өгөөжтэй бондын бүтээгдэхүүн гаргахад амжилттай ажилласан ба хөрөнгө оруулалт хийсэн байгууллага болон хувь хөрөнгө оруулагч нар хүүгийн өгөөж хүртсээр байна;

- Монголын хамгийн том хамтын хөрөнгө оруулалтын сан болох "Мандал Ирээдүйн өсөлт" ХОС-ийн 50 тэрбум төгрөгийн санхүүжилт татах ажилд андеррайтераар ажилласан;
- Конвиниенс сүлжээ дэлгүүрийн цэгцтэй үйлчилгээг таниулсан "Сентрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн 27 тэрбум төгрөгийн IPO ажилд туслах андеррайтераар ажилласан ба нийт 9665 хөрөнгө оруулагч оролцсон;
- Монгол Улсад гарсан хоёрдох хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох "Омни актив ТЗК" ХХК-ийн үнэт цаас гаргах ажиллагаанд үндсэн андеррайтераар ажилласан.

СЭХ
он сар өдөр
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

### 8.1.2 Андеррайтерийн компанитай байгуулсан гэрээний тухай

“Апекс капитал ҮЦК” ХХК нь “Мон Бийф” ХХК-тай 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр 06/APK/22/21 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус гэрээгээр “Мон Бийф” ХХК-ийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгох ажиллагаанд үндсэн андеррайтераар “Апекс капитал ҮЦК” ХХК оролцож, дараах ажлыг гүйцэтгэхээр харилцан тохиролцсон болно.

- Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгон гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ, тооцоолол хийх, үйлдвэрлэл, компанийн үйл ажиллагаатай танилцах ажлыг гүйцэтгэнэ. Түүний дагуу өөрсдийн боловсруулсан судалгаа шинжилгээнд үндэслэн үнэт цаас гаргахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, үнэт цаасны танилцуулга боловсруулах, хамтран ажиллаж буй мэргэжлийн оролцогч байгууллагууд болох хууль, аудит, үнэлгээний дүгнэлт болон бусад шаардах баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллана.
- Үнэт цаасыг танилцуулах, санхүүжилт татан төвлөрүүлэхэд ажиллагааг хууль болон журамд заасны дагуу олон нийтэд санал болгон танилцуулж, санхүүжилт татан төвлөрүүлэх ажлыг бие даан гүйцэтгэнэ. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаанаас үлдсэн хэсгийг өөрөө хүлээн авах үүрэг хүлээн оролцож байна.

Нөгөө талаас Үнэт цаас гаргагч нь анх удаа өөрийн хувьцаагаа санал болгохтой холбоотой үнэн зөв, бодит мэдээлэл өгөх, баримт бичгийн эх хувийг Үндсэн андеррайтер шаардсаны дагуу гарган өгөх үүрэг хүлээж оролцож байна.

6648436 MonBeefLLC УЛААНБААТАР
Мон Бийф ХХК

СЗХ
MON BEEF
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ

## 8.2 Туслах Андеррайтерийн танилцуулга, гэрээний тухай

### 8.2.2 Туслах Андеррайтерийн танилцуулга

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

**"Таван Богд Капитал ҮЦК" ХХК**
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар худалдааны төв 1 давхар
Утас: (976) 7272-7282
Э-шуудан: cr@tavanbogdcapital.com
Вэб хуудас: www.tavanbogdcapital.com
Банк реформ вэб хуудас:
www.bankformer.tavanbogdcapital.mn

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2011 онд "Зэт Жи Би ҮЦК" ХХК нэртэйгээр брокерийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан. 2021 оны 04 сард бүтцийн өөрчлөлт хийж, Таван Богд Трейд ХХК-ийн 85%-ийн хөрөнгө оруулалттайгаар өөрчлөн байгуулагдсан. 2021 оны 04 сараас үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлтийг хийж Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлтээр Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Мөнгөн хөрөнгийн номинал данс эзэмших, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах худалдан авахад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг авч харилцагч, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн өргөн хүрээнд үйлчилгээг үйлчилгээг үзүүлж эхлээд байна.
Компани нь олон жилийн туршлагатай, санхүү хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдээр баг хамт олноо бүрдүүлэн богино хугацаанд бодитой үр дүн гарган ажиллаж байна.

Стратегийн шинэчлэлийн хүрээнд хүний нөөцийн болоод бүтээгдэхүүн, үйлчилгээний бүрэн шинэчлэлийг богино хугацаанд амжилттай хийж үнэт цаасны компанийн цогц үйлчилгээг үзүүлж байгаагаа онцлох ололт, амжилтыг танилцуулж байна. Үүнд:

1. Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд 2021 оны 12 дугаар сард 10 тэрбум төгрөгийн Говь бонд, 2022 оны 04 дүгээр сард 500 сая төгрөгийн Эко кар бонд, 2021 оны 12 сараас 2022 оны 05 дугаар сар хүртэл хугацаанд гурван удаагийн гаргалтаар нийт 15 тэрбум төгрөгийн Таван Богд Финанс бондыг тус тус амжилттай гаргахад андеррайтерийн үйлчилгээг үзүүлээд байна.
2. Мөн гадаад, дотоодын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслийн зуучлалын, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг 40 гаруй мянган харилцагчдадаа үзүүлэхийн зэрэгцээ өөрийн сошиал хуудас, веб сайтаар дамжуулан дэлхийн болон дотоодын зах зээлийн нөхцөл байдлыг мэдээллэн ажиллаж өдөрт давхардсан тоогоор 10,000 гаруй харилцагч, үйлчлүүлэгчид тогтмол мэдээ, мэдээллийг (Crypto focus, Global stock focus, Domestic stock focus, Full focus г.м) хүргүүлэн ажиллаж байна.
3. Системийн нөлөө бүхий топ 5 арилжааны банкнуудын IPO төслүүдэд зориулан хөрөнгө оруулалтын зөвлөхийн "Банк реформер" цогц үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.
4. Ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор анхлан хеджингийн үйлчилгээг нэвтрүүлэв.

Мон Бийф ХХК
MonBeefLLC
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022 он 06 сар 02 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

5. Олон улсын чиг хандлагын дагуу NFT зах зээлд бүтээгдэхүүнээ гаргаж анхдагч зах зээлд 1 секунд хүрэхгүй хугацаанд амжилттай борлуулалт хийлээ. NFT эзэмшигчид нь хугацаагүйгээр "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах эрхтэй болсноороо давуу талтай байна.

### 8.2.3 Туслах Андеррайтерийн компанитай байгуулсан гэрээний тухай

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК, үндсэн андеррайтер "Апекс капитал ҮЦК" ХХК-тай 06/АРК/22/22 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г 2022 оны 04 сарын 13-нд байгуулсан. Энэхүү гэрээнд Үнэт цаас гаргагчийн IPO төсөлд туслах андеррайтерийн үйлчилгээг үзүүлэх, шаардагдах судалгаа, тооцоолол, холбогдох бэлтгэл ажлуудыг хамтран гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, үнэт цаасны танилцуулгын төсөлтэй танилцаж, санал, зөвлөж өгөх, хөрөнгө оруулагч нарт компанийг танилцуулах, анхдагч зах зээлд арилжаалагдаж буй хувьцааг санал болгох, санхүүжилт татаж өгөх үйлчилгээг тус тус үзүүлэхээр харилцан тохиролцоод байна.

Mon Beef LLC
Мон Бийф ХХ компани
6648436
УЛААНБААТАР

СЭХ MON BEEF
2022 .06 он сар 17 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 8.3 Аудитын байгууллагын танилцуулга, гэрээний тухай

### 8.3.1 Аудитын компанийн танилцуулга

SGMD АУДИТ

**"Эс Жи Эм Ди Аудит" ХХК**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-44, 14/2 и байр, 9 тоот
Утас: (976) 7000-6948
Э-шуудан: ekhbayar@sgmd-audit.mn

"Эс Жи Эм Ди Аудит" ХХК нь компани анх 2006 оны 03 сарын 20-ны өдөр бизнесийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр байгуулагдсан. "Монтгомери Аудит" ХХК нь 1998 оны 12 дугаар сард аудитын үйлчилгээ эрхлэх чиглэлээр байгуулагдсан бөгөөд 2002 оны 1 дүгээр сард "Итгэлт Аудит" ХХК-д нэгдсэн. Улмаар "Эс Жи Эм Ди Аудит" ХХК нь 2009 оны 11 дүгээр сарын 30-нд Сангийн Сайдын 266 тоот тушаалаар аудитын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авч дахин зохион байгуулагдсан. Компани аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

Баталгаажуулалт
- Санхүүгийн тайлангийн аудит
- Санхүүгийн тайланг шалгах ажил
- Бусад баталгаажуулах ажил
- Санхүүгийн тайланг нягтлах ажил
- Санхүүгийн холбогдох үйлчилгээ
- Гүйцэтгэлийн аудит

Зөвлөх үйлчилгээ
- Удирдлагын бүртгэл
- Дотоод хяналтын систем
- Санхүү, Нягтлан бодох бүртгэл
- НББ-ийн бодлогын баримт бичиг
- Татварын зөвлөгөө өгөх

Холбогдох үйлчилгээ
- Зөвшилцсөн горим гүйцэтгэх ажил
- Санхүүгийн түүхэн мэдээлэл эмхтгэх
- Нягтлан бодох бүртгэл хөтлөх
- Татварын тайлан бэлтгэх, бэлтгэхэд туслах, зөвлөгөө өгөх
- НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулах

Сургалт
- НББ-ийн анхан шатны мэдлэг олгох
- НББ-ийн практик дадлага эзэмшүүлэх

Компани нь өнгөрсөн хугацаанд нийт 245 гаруй компанийн санхүүгийн тайланд бүрэн хэмжээний аудит хийж, зохих туршлага хуримтлуулаад байна.

### 8.3.2 Аудитын компанитай байгуулсан гэрээний тухай

"Эс Жи Эм Ди Аудит" ХХК нь үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-тай 2022/2/12 болон 2022/2/19 тоот "Аудитын үйлчилгээний гэрээ"-г байгуулсан. Уг гэрээнүүдэд 2021 оны санхүүгийн жилийн тайлан мөн 2022 оны 1-р улирлын санхүүгийн жилийн тайланд аудит хийж, аудиторын дүгнэлт гаргахаар харилцан тохиролцсон. Гэрээнүүдэд заагдсанаар аудитын шалгалтыг Аудитын олон улсын стандарт, Нийтээр Хүлээн Зөвшөөрөгдсөн

Зарчим, Монгол улсын Аудитын тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын дагуу мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд гүйцэтгэхээр заагдсан.

## 8.4 Хуулийн байгууллагын танилцуулга, гэрээний тухай

### 8.4.1 Хуулийн байгууллагуудын танилцуулга

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгох ажиллагаанд дараах хуулийн фирмүүдтэй "Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан хамтран ажиллаж байна.

**Өмгөөллийн "ХаанЛекс партнерс" ХХН**
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж, Аюуд тауэр, 14 давхар, 1404 тоот
Утас: (976) 7747-1122
Э-шуудан: info@khanlex.mn
Вэб хуудас: www.khanlex.mn

Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН ("ХаанЛекс") нь банк санхүү, үнэт цаас, дэд бүтэц, эрчим хүч, шүүхийн маргаан, бизнесийн болон компанийн эрх зүйн салбарт голчлон хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Монголын тэргүүлэх хуулийн фирмүүдийн нэг юм. Өнгөрсөн арван жилийн хугацаанд өөрсдийн үйлчилгээ, мэдлэг туршлагаа олон улсын зах зээлийн томоохон оролцогч нарт хүргэж ирсэн ба эдгээрт олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагууд, гадаадын төрийн өмчит болон хувийн салбарын тэргүүлэгч компаниуд багтдаг.

Компани Монгол Улсад хийгдсэн олон улсын шинжтэй томоохон гэрээ, хэлцлүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч, амжилттай ажилласан ба тэдгээрийн зарим нь олон улсын хэмжээнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн, хууль зүйн зөвлөгөө өгч ажилладаг үндсэн эрх зүйн салбарууд (банк санхүү, дэд бүтэц, бизнесийн эрх зүй, шүүхийн маргаан зэрэг)-аас гадна хурдтай хөгжиж буй "ногоон санхүүжилт"-ийн эрх зүйн чиглэлээр ажилласан байдал, туршлагаараа Монгол Улсын хуулийн фирмүүдийн дунд тэргүүлэх байр суурь эзэлдэг. Өдгөө "ногоон санхүүжилт" нь байгаль орчны өнөөгийн байдлыг сайжруулахад чиглэгдсэн нэн чухал, цогц санхүүжилт болоод байгаа билээ.

MON BEEF
СЗХ
2022 он .06 сар 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-06-17
БҮРТГЭВ-03

**Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН**
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж, 13/02, Глобал Бизнес Центр, 503 тоот
Утас: (976) 7012-9665
Э-шуудан: info@mjlattorneys.mn
Вэб хуудас: www.mjlattorneys.mn

Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН нь дотоодын болон гадаадын иргэн, хуулийн этгээдэд хууль зүйн иж бүрэн, цогц зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг хязгаарлагдмал хариуцлагатай өмгөөллийн нөхөрлөл юм. Эм Жэй Эл Атторнейс хуулийн фирм нь 2012 онд үүсгэн байгуулагдсан ба дараах чиглэлээр хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг.

- Компанийн ба худалдааны эрх зүй
- Хөрөнгийн зах зээл ба үнэт цаас
- Компани нэгтгэх ба хувьцаа худалдан авах
- Банк, санхүү ба даатгал
- Хөрөнгө оруулалт ба хөрөнгө зуучлах
- Уул уурхай ба эрдэс баялаг
- Газрын тос, байгалийн хий ба эрчим хүч
- Татвар
- Үл хөдлөх хөрөнгө ба барилга
- Лиценз ба зөвшөөрөл
- Засгийн газрын харилцаа ба цагаачлал
- Концесс ба тендер
- Дэд бүтэц ба зам тээвэр
- Арбитр ба шүүхийн маргаан
- Дампуурлын эрх зүй
- Аялал жуулчлал ба зочид буудал
- Хэвлэл мэдээлэл, холбоо харилцаа ба технологи
- Өв залгамжлал ба гэр бүлийн эрх зүй
- Байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа
- Хуулийн магадлан шалгалт ба хянан нийцүүлэх үйл ажиллагаа
- Инженеринг, худалдан авах ажиллагаа ба барилга байгууламж
- Патент, барааны тэмдэг ба оюуны өмч
- Хөдөлмөрийн харьцаа ба ажил эрхлэлт

Хуулийн нөхөрлөлийн тусгай зөвшөөрөл

Өмгөөллийн “Эм Жэй Эл Атторнейс” ХХН нь Монголын Хуульчдын Холбоонд 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдөр бүртгүүлсэн, 047 дугаартай гэрчилгээтэй, “Өмгөөллийн ХаанЛекс Партнерс ХХН” нь 2019 оны 5 дугаар сарын 16-ны өдөр бүртгүүлсэн, 203 дугаартай гэрчилгээтэй.

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

### 8.5.2 Хуулийн компаниудын гэрээний тухай

Өмгөөллийн "ХаанЛекс партнерс" ХХН болон "Эм Жэй Эл Атторнейс" ХХН нар нь "Мон Бийф" ХХК-тай 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 540 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус гэрээгээр "Мон Бийф" ХХК-ийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгох ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх улмаар хууль зүйн дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэхээр харилцан тохиролцсон. Уг ажилтай холбогдуулан Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт бичиг, материалыг шалгаж СЗХ-ны үнэт цаасны бүртгэлийн журам болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 2018/01 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан асуудлуудын хүрээнд хууль зүйн дүгнэлт бэлтгэхээр харилцан тохиролцсон байна.

Нөгөө талаас Үнэт цаас гаргагч нь үнэн бодит мэдээллээр зөвлөхийг хангах, шаардлагатай тодруулгад үнэн зөвөөр хариу илгээх үүрэг хүлээсэн байна.

Мон Бийф ХХ компани

## 8.5 Үнэлгээний байгууллагын танилцуулга, гэрээний тухай

### 8.5.1 Үнэлгээний компанийн танилцуулга

ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ

**"Итгэлт-Эстимэйт" ХХК**
Хаяг: БЗД, 26-р хороо, Хүннүгийн гудамж, Олимп плаза оффис, 401 тоот
Утас: (976) 76005638
Э-шуудан: itgelt.estimate@gmail.com
Факс: info@itgeltgroup.mn

Итгэлт Эстимэйт ХХК нь 1999 оноос Хууль зүйн Яам, Сангийн Яамнаас Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авч үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийж эхэлсэн, олон жилийн туршлагатай, салбартаа тэргүүлэгч компани бөгөөд 20 жилийн туршид тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, өнөөдөр Баянгол I, II салбар, Баянзүрх салбар, Орхон салбар, Хөвсгөл салбар, Сүхбаатар салбар зэрэг нийт 5 салбартай, 9 мэргэшсэн үнэлгээчин, 11 мэргэжилтэн буюу нийт 20 хүнтэй чадварлаг баг бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Анх үүсгэн байгуулагдсан цагаасаа хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний чиглэлээр ажиллаж эхэлсэн бөгөөд 2008 оноос Санхүүгийн Зохицуулах Хорооноос Даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл авснаар даатгалын хохирлын үнэлгээ, 2010 оноос Дэлхийн банкны буцалтгүй тусламж, олон улсын төсөл хөтөлбөрүүдэд гүйцэтгэлийн болон хэрэгжилтийн үнэлгээ хийх болон зөвлөх үйлчилгээ явуулах болсон. 2015 оноос БНСУ-ын хохирол үнэлэгчдийн холбоо, Монголын хохирол үнэлэгчдийн холбоо хамтран зохион байгуулсан.

Компани нь бизнесийн үнэлгээ, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, даатгалын хохирлын үнэлгээ болон хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлын үнэлгээ, зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Бизнесийн үнэлгээний хувьд 2022 оны 1-р улирлын байдлаар хувьчлалын болон олон улсын хөрөнгийн зах зээл болон дотоодын хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгох зорилготой 50 гаруй томоохон аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн үнэлгээг хийгээд байна. Үүнд Монгол улсынхаа үндэсний үйлдвэрлэлийн хөгжил, хүнсний болон хүн ардын эрүүл мэндийн сахин хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулан "Түмэн шувуут" ХХК, "Монос Хүнс" ХХК нарын бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

### 8.5.2 Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний тухай

"Итгэлт-Эстимэйт" ХХК нь үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэх №2022/08 тоот гэрээг 2022 оны 02 сарын 16-нд байгуулсан. Энэхүү гэрээнд Үнэт цаас гаргагчийн IPO төсөлд "Мон Бийф" ХХК-ийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг Монгол улсын хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Үнэлгээний Олон Улсын Стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бие даасан хараат бус байдлаар тогтоох үйлчилгээ үзүүлэхээр харилцан тохиролцсон байна.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

БҮРТГЭВ-03

## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ БАТАЛГААЖУУЛСАН

*Овог, нэр: И..Баттуяа*

*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-ийн ТУЗ-ийн дарга*

*Гарын үсэг:.................................*

*(Тамга/тэмдэг)*

*Овог, нэр:О.Дамжин*

*Албан тушаал: Андеррайтер "Апекс Капитал ҮЦК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга*

*Гарын үсэг:.................................*

*(Тамга/тэмдэг)*

*Овог, нэр: Н.Ариунбаатар*

*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-ийн гүйцэтгэх захирал*

*Гарын үсэг:.................................*

*(Тамга/тэмдэг)*

*Овог, нэр:Б.Лхамдолгор*

*Албан тушаал: Андеррайтер "Апекс Капитал ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал*

*Гарын үсэг:.................................*

*(Тамга/тэмдэг)*

*Овог, нэр:Д.Марал-Эрдэнэ*

*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч*

*Гарын үсэг:.................................*

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

APEX CAPITAL

**"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК**

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж 4, Нью хоризонс, 901 тоот
Утас: 7510-7500, И-мэйл: investment@apex.mn,
Веб: www.apex.mn

2022 / 06 / 21 # 20

танай ____________ # ____________ т

## Андеррайтерийн дүгнэлт

Үндсэн андеррайтер "Апекс капитал ҮЦК" ХХК нь 2022 оны 3-р сарын 28-ны өдөр Үнэт цаас гаргагч "Мон Бийф" ХХК-тай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны өргөжилт, хөрөнгө оруулалтад шаардлагатай 2.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг компанийн хувьцааны тодорхой хэсгийг Монголын хөрөнгийн биржээр дамж
уулан олон нийтэд санал болгох үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэн ажиллахаар харилцан тохиролцсон.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа нь Монгол улсын холбогдох хууль болон зохицуулах байгууллагын дүрэм, журмын дагуу гүйцэтгэгдэж байна. Тухайлбал, Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль, журмууд хамаарна.

Үндсэн андеррайтер нь үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд "Мон Бийф" ХХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгохтой холбоотой судалгаа шинжилгээг хөндлөнгийн зүгээс бие даан гүйцэтгэж, дараах үндэслэл бүхий дүгнэлтийг гаргалаа.

***Компанийн хувьцаа эзэмшигчид***

Компани олон нийтэд хувьцаагаа санал болгохоос өмнө хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй байна.

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Хувь хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд ХХК | 112,500,000 | 75% |
| 2 | Ж.Барсболд | 15,000,000 | 10% |
| 3 | Ц.Цэцэнхүү | 7,500,000 | 5% |
| 4 | Э.Пүрэвлхам | 7,500,000 | 5% |
| 5 | И.Баттуяа | 4,500,000 | 3% |
| 6 | Ж.Оюунчимэг | 3,000,000 | 2% |
| | **Нийт** | **150,000,000** | **100%** |

Харин олон нийтэд хувьцаагаа санал болгосны дараа хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ дараах байдалтай болж өөрчлөгдөнө.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ 1118265142

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Хувь хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд ХХК | 112,500,000 | 52.5% |
| 2 | Ж.Барсболд | 15,000,000 | 7% |
| 3 | Ц.Цэцэнхүү | 7,500,000 | 3.5% |
| 4 | Э.Пүрэвлхам | 7,500,000 | 3.5% |
| 5 | И.Баттуяа | 4,500,000 | 2.1% |
| 6 | Ж.Оюунчимэг | 3,000,000 | 1.4% |
| 7 | Олон нийт | 64,285,700 | 30% |
| | **Нийт** | **214,285,700** | **100%** |

Дээрх мэдээллээс харахад Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт тодорхойлсноор үнэт цаас гаргагч нь олон нийтэд хувьцаагаа санал болгохоос өмнө болон дараа нь компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч "Таван Богд Трейд" ХХК-ийн хэвээр байхаар байна. "Таван Богд Трейд" ХХК нь нийт 5 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хувьцаа эзэмшигч Монгол улсын иргэн Ц.Баатарсайхан 60 хувийн хувьцааг эзэмшиж байгаа нь Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч гэж тодорхойлогдож байна.

Үнэт цаас гаргагчийн бусад 5 хувьцаа эзэмшигчдийн хувьд "Таван богд групп" -т 10 ба түүнээс дээш ажилласан туршлагатай захирлууд байна. "Мон Бийф" ХХК нь "Таван богд групп"- ийн хэмжээнд хамгийн анхны ажилтнуудын хамт үүсгэн байгуулсан компани гэдгийг дурдахын зэрэгцээ туршлагатай олон хувьцаа эзэмшигчидтэй байх нь компанийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй.

Дээрхээс гадна компани нь олон нийтэд нийт хувьцааны 30 хувийг санал болгохоор шийдвэрлэсэн нь одоогийн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэл бүхий хувьцаат компаниудтай харьцуулахад жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмших хувь харьцангуй өндөр байна гэж үзсэн.

***Компанийн засаглал***

Олон нийтэд хувьцаагаа санал болгож буй компанийн хувьд сайн засаглалтай байх нь тухайн компани цаашид тогтвортой өсөн дэвшиж, хөгжихийн суурь бөгөөд энэхүү үзүүлэлтийг зайлшгүй онцолж харах нь зүйтэй. Иймээс андеррайтерийн үйлчилгээний хүрээнд гуравдагч этгээдтэй хамтран засаглалын дараах гол үзүүлэлтүүдэд үнэлгээ хийсэн.

1. Хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалалт;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурал;
3. ТУЗ-ийн үйл ажиллагаа;
4. Гүйцэтгэх удирдлага;
5. Мэдээллийн ил тод нээлттэй байдал;
6. Чухал хэлцлүүд;
7. Хяналтын тогтолцоо.

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдаад удаагүй тул засаглалын тал дээр сайжруулах, анхаарах асуудал байсныг хэлэх нь зүйтэй. Тодруулбал, "Таван Богд трейд" ХХК-ийн охин компани тул шийдвэр гаргалт нь том хувьцаа эзэмшигчээс хамаарал бүхий байх хандлагатай, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа хараахан жигдрээгүй, Гүйцэтгэх удирдлагын хувьд өсөн дэвжиж буй залуу удирдлага байгааг тус тус дурдаж болно.

Иймээс засаглалын дээр дурдсан гол үзүүлэлтийг жигд сайжруулах, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг дүрэм журмаараа сайжруулах тал дээр зөвлөмж хүргүүлэн хамтран ажилласан. Үүний дагуу Үнэт цаас гаргагч нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, Төлөөлөн удирдах зөвлөл болон

СЭХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тодорхой болгон дүрэм журмыг сайжруулж, нэмэлтээр 6 журмыг батлан компанидаа мөрдлөг болгохоор ажиллаж байна.

Хөндлөнгийн хууль зүйн дүгнэлт гаргасан өмгөөллийн “ХаанЛекс” ХХН болон “Эм Жэй Эл Атторнейс” ХХН-ийн 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлтээр “Мон Бийф” ХХК-ийн мөрдөж буй болон шинээр батлах дүрэм, журмын төсөл нь холбогдох хууль болон компанийн засаглалын кодекст нийцсэн гэж үзсэн байна.

***Оролцогч талууд***

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.16-д заасны дагуу *“сүүлийн нэг жилээс дээшгүй хугацааны дотор хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан”* мөн зүйлийн 10.6-д “*Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна*” гэсний дагуу дараах оролцогч талууд ажилласан.

- “Итгэлт эстимэйт” ХХК-ийн 2022 оны 05 сарын 09-ны өдрийн Үнэлгээний тайлан;
- “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн 2022 оны 04 сарын 13-ны өдрийн Санхүүгийн баталгаажуулсан тайлан;
- “ХаанЛекс партнерс” ХХН болон “Эм Жэй Эл Атторнейс” ХХН-ын хамтарсан 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүйн дүгнэлт;;

Хөндлөнгийн дүгнэлт гаргасан мэргэжлийн компаниуд нь үнэт цаас гаргах ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад туслах аудит, үнэлгээ, хуулийн дүгнэлтүүдийг гарган ажилласан.

***Үйл ажиллагаа явуулж буй салбарын нөхцөл байдлын талаар***

*Зах зээлийн багтаамж*

Монгол Улсын хэмжээнд жилд нийт 649 мянган тонн мах махан бүтээгдэхүүн энэ нь үнийн дүнгээр 8.5 их наяд төгрөг нөгөө талаас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох гурил, гурилан бүтээгдэхүүн нь 263 мянган тонн энэ нь үнийн дүнгээр 452 тэрбум төгрөг байна. Мах махан бүтээгдэхүүний зах зээлийн багтаамжийн хэмжээ гурил, гурилан бүтээгдэхүүний зах зээлийн хэмжээтэй харьцуулахад 19 дахин өндөр дүнтэй байна.

Үүнээс үхрийн махны нийлүүлэлт 159 мянган тонн (Зах зээлийн багтаамж 2 их наяд төгрөг) дотооддоо бэлтгэж үйлдвэрийн аргаар боловсруулсан үхрийн мах 0.3 (үнийн дүн 6 тэрбум төгрөг) хувийг л эзэлж байна. Үхрийн махны хэрэглээ нь жилээс жилд өссөн дүнтэй байгаа, үүнд үйлдвэрийн аргаар боловсруулагдсан үхрийн мах маш бага хэмжээг эзэлж байгаа ч үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн багтаамж өсөх боломжтой, өсөх хэрэгцээ байгааг илтгэн харуулдаг.

*Салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл*

Өнөөдөр дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдал, цар тахал, тээвэр ложистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомстол үнийн өсөлт зэргээс шалтгаалан хүнсний хангамж, аюулгүй байдал, улс орон бүрийн нэн тулгамдсан асуудал болон хувирч байна.

СЗХ
он сар өдөр
2022.06.23
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17

Дэлхийн зах зээлд хүнс болон бордооны үнэ сүүлийн 14 жилийн хугацаанд хамгийн өндөр хувиар өслөө. Ялангуяа үр тариа, ургамлын тосны үнэ сүүлийн саруудад огцом өсч бага орлоготой иргэд болон хүнсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байна. Тодруулбал, сүүлийн 15 сарын хугацаанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр 43 хувиар, түүний дотор үр тарианы үнэ 56 хувиар өслөө. Сүүлийн 3 сарын хугацаанд бордооны үнэ 20 хувиар өссөн байгаа нь Монгол улсын хувьд дотоодын хүнсний үйлдвэрүүдээ гадаад улсаас хараат бусаар хөгжүүлэх нэн шаардлагатай байгааг илтгэнэ.

Нөгөө талаас Монгол улс хорт хавдрын нас баралтаар дэлхийд дээгүүрт орж, чанаргүй хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт их байгаа нь хүнсний чанар аюулгүй байдал сул байгааг илтгэж байна. Энэ нь монгол хүний хүнсний гол хэрэглээ болох мах махан бүтээгдэхүүний хэрэглээний соёлд анхаарч өөрчлөх шаардлага байгааг илтгэнэ. Тухайлбал малын идэш тэжээл чанартай байж чанартай мах гарах, их хэмжээгээр нөөцөлж бус өдөр тутамдаа шинэ мах хэрэглэх, малын гарал үүсэл нь тодорхой байж тухайн мал зохистой хугацаандаа зохистой эм тариаг хэрэглэсэн эсэх нь тодорхой болох мөн мах бэлтгэлийн процесс, савалгаа болон хадгалалт нь эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд стандартын дагуу бэлтгэгдсэн байх зэрэг орно.

Орчин үеийн хөдөө аж ахуйн салбар нь олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, аливаа эрсдэлд дархлаатай, өрхийн үйлдвэрлэлээс үндэсний үйлдвэрлэлд шилжсэн, хүртээмжтэй, засаглал сайтай нөгөөтээгүүр санхүүжилтийн оновчтой тогтолцоотой байх шаардлага тулгарч байна. Өөрөөр хэлбэл, манай улсын хөдөө аж ахуйн салбар нь эрүүл малтай, өндөр бүтээмжтэй, байгаль орчинд ээлтэй, суурь дэд бүтэцтэй, санхүүжилтийн оновчтой тогтолцоотой, шинэ техник технологи нэвтрүүлсэн, мэргэшсэн хүний нөөцтэй, хувийн хэвшилд тулгуурласан байх нэн шаардлагатай байна.

*Салбарын хөгжих боломж*

Монгол улс 67.3 сая толгой малтай, жилд 8.5 их наяд төгрөгийн мах махан бүтээгдэхүүн хэрэглэдэг, 2021 оны байдлаар 23.5 сая ам долларын үнийн дүн бүхий мах, махан бүтээгдэхүүн экспортолсон (Адууны мах) нь нийт экспортын 0.23 хувийг бүрдүүлж байна. Харин уул уурхайн гаралтай экспорт нийт экспортын 92 хувийг бүрдүүлсэн байна.

Монгол улстай хүн амын тоо болон мал толгойн тоогоор ойролцоо Шинэ Зеланд улс нь 5.1 сая хүн амтай ба ойролцоогоор 37 сая толгой малтай. Дотоодын нийт бүтээгдэхүүний хувьд Монгол улс 9.2 тэрбум доллар бол Шинэ Зеланд улсынх 212.5 тэрбум ам.доллар буюу манай улсаас 23 дахин их байна. Экспортын гол түүхий эд нь Монгол улсын хувьд нүүрс бол Шинэ Зеланд улсын нүүрсний экспорт махны экспортоос 4 дахин бага, махны гол худалдан авагч орнууд нь Хятад, Австрали, Малайз, Индонез, Япон болон Филиппин, АНУ байна. Гол төлөв Ази тивийн бүсчлэлд багтах улс орнууд байгаа нь манай улсын махны экспортын нөөц боломж өндөр байгааг харуулж байна.

| | MGL | NZD | Тайлбар |
|---|---|---|---|
| Хүн ам (сая) | 3.4 | 5.1 | Монгол улс нь газар нутгийн хувьд 5.8 дахин том байдаг. |
| Мал толгой (сая) | 67.3 | 37 | Монгол улс мал сүргийн тоо толгой 1.8 дахин их. |

АЛЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ



МонБииф ХХК
УЛААНБААТАР

| | | | |
|---|---|---|---|
| Мах экспорт (сая.доллар) | 23.5 | 10,000 | Монгол улсын экспортын гол түүхий эд нь нүүрс бол Шинэ Зеланд улсын гол экспорт нь сүү, сүүн бүтээгдэхүүн, мах байдаг. |
| ДНБ (тэр.доллар) | 9.2 | 212.5 | Шинэ Зеланд улсын ДНБ нь манай улсаас 23 дахин өндөр байна. |

Манай улсын махны чанар нь фермийн аж ахуйгаар бус ил бэлчээрээр малыг өсгөж, эрүүл ахуйн хяналтад оруулдаггүй, шинэ сайн тэжээлээр борддоггүй цаашлаад малыг үйлдвэрийн бус аргаар нядалгаанд оруулж байгаа болон савлагаа, хадгалалт, тээвэрлэлтийн стандарт мөрдөхгүй байгаа нь импортын боломжийг хаах төдийгүй дотоодын хүнсний чанар стандартад сөрөг нөлөө үзүүлж байна.

Энэ нь зөвхөн үнэт цаас гаргагч компаниар хязгаарлагдахгүй тус чиглэлд үйл ажиллагаагаа хөгжүүлэх бүхий л бизнесүүдэд томоохон орон зай байгааг илтгэж байна.

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай**

Үнэт цаас гаргагч нь Монгол улсын уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуйн системтэй хослуулан орон нутгийн малчдаас бяруу болон шүдлэн үхрийг худалдан авч эрүүл ахуйн шинжилгээнд оруулж, 30 – 100 хоног ая тухыг ханган, хөдөлгөөний хязгаарлаж, олон жилийн судалгаанд тулгуурласан шимтэй өвс, тэжээлээр бордох замаар үхрийн жинг нэмэгдүүлэн эрүүл, зөөлөн, стандартын дагуу бэлтгэсэн үхрийн махыг хэрэглэгчдэд санал болгож байна.

Үхрийн худалдан авалтыг Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв аймгуудаас хийсэн ба цаашдаа төвийн бүсийн аймгуудаас татан авалт хийх төлөвлөгөөтэй байгаа. Энэ нь татан авалтын явцад үхрийн жингийн хорогдол, тээвэрлэлтийн зардал харьцангуй бага байх боломжийг олгож байгаа юм.

Монгол улс 2021 оны байдлаар таван сая гаруй толгой үхэртэй байгаа ба үнэт цаас гаргагч нь жилд дунджаар 6 мянган үхэр худалдан авалт хийхээр төлөвлөж байгаа нь үйлдвэрлэлийн орцод хомстол үүсэх, тасалдах аюул байхгүй гэдгийг харуулж байна.

Эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, гарал үүсэл тодорхой, залуу үхрийн махыг иргэдийн өдөр тутмын хэрэглээ болгохоор зорьж буй үнэт цаас гаргагчийн гол нэрийн бүтээгдэхүүн нь стейкны мах бөгөөд бордолтын хоногоос хамааран үхрийн махны гарцын 17-36%-ийн эзэлдэг. Мөн өдөр тутмын хэрэглээнд зориулсан цул болон ястай мах 45 – 63%, дайвар бүтээгдэхүүн 20 орчим хувийг эзэлж байна. Бүтээгдэхүүнийг таван төрлийн сувгаар борлуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үүнд сүлжээ дэлгүүрүүд, орон сууцуудын жижиг дэлгүүр, ХоРеКа, Борлуулалтын цэг болон онлайн худалдаанууд хамаарагдана. Мөн өөрийн нэрийн стейкны ресторaныг нээх зэргээр бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэн хэрэглэгчдэд хэдийнээ танигдаад байна. Бидний дүгнэлтээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан борлуулалтын төлөвлөгөөтэй ажиллаж байгаа нь үнэт цаас гаргагчийн цаашдын үйл ажиллагаа өргөжин дэвшихэд чухал нөлөөтэй юм.

*Эрсдэлийн хүчин зүйл*

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд бий болох боломжтой эрсдэлүүдийг үйлдвэрлэл, үйл ажиллагаа, борлуулалт, санхүүгийн болон гадаад хүчин зүйлсээс хамааралтай эрсдэлүүдийг тодорхойлж, эдгээрийн эрсдэлийн удирдлагын арга, хэлбэрүүдийг дараах байдлаар тодорхойлов.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№

2022 -06- 17

*Үйлдвэрлэлийн эрсдэл:* Үүнд мал бэлтгэлийн үйл ажиллагаа буюу үхрийн татан авалттай холбоотой үйл ажиллагаа, үхрийн бордолт буюу ферм дээрх өдөр тутмын үйл ажиллагаа, нядалгаа буюу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагаанууд эрсдэл үүсэх боломжтой юм. Мал бэлтгэлийн үед фермийн боломжит хэмжээгээр нөөц бүрдүүлэх, нийлүүлэгчидтэй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх гэрээ хэлэлцээр хийх, тээвэрлэлтийн явцад жолоочийн эрүүл мэнд болон хэвийн ажил үүргээ гүйцэтгэхэд хяналт тавих гэх мэтээр эрсдэлүүдийг удирдах шаардлагатай. Үхэр бордолтын үе шатанд жингийн нэмэгдлийг тогтмол хэмжиж, тэжээлийн түүхий эдийг хүлээж авахдаа лабораторид нарийн шинжилгээ хийдэг байх, халдварт болон халдварт бус өвчний шинж тэмдэг илэрвэл яаралтай тусгаарлах хашааг бэлэн байлгах хэрэгтэй юм. Нядалгаа болон савлагааны үед шатанд эрүүл ахуйн горим алдахаас урьдчилан сэргийлэх, ажилчдын ариун цэвэр болон эцсийн бүтээгдэхүүний чанар стандартад хяналт тавих журам болон стандартын горимуудыг өдөрт тутмын үйл ажиллагаанд дасал болгох шаардлагатай.

*Үйл ажиллагааны эрсдэл:* Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь ферм болон оффисын үйл ажиллагаагаар салах бөгөөд эдгээрийн уялдаа холбоог тодорхой байлгах, мэдээллийн солилцох болон шийдвэр гаргалт удаашрах зэргээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн хамгийн чухал нь фермд ажиллах хүний нөөц хомстох, туршлагатай ажилчдаа алдах эрсдэл юм. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилтнуудын цалин урамшуулал, карьер хөгжлийн төлөвлөгөөг тодорхой гаргаж идэвхжүүлэн халамжлах үйл ажиллагааг явуулдаг байх хэрэгтэй. Нөгөө талаас ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх ХАБЭХ-н зааварчилгааг тасралтгүй өгдөг байх шаардлагатай.

*Борлуулалт болон санхүүгийн эрсдэл:* Үнэт цаас гаргагч үйлдвэрлэлийн процессыг сайжруулах, өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилт дутах, үйлдвэр барих болон тоног төхөөрөмж авахтай холбоотой зардлууд төлөвлөснөөс давах гэх мэт эрсдэлүүд үүсэх боломжтой юм. Мөн борлуулалт зорилтот хэрэглэгчид болон эрэлтийг буруу тодорхойлсноос үүдэн алдагдалтай ажиллах эрсдэл бий болох боломжтой. Эдгээрээс урьдчилан сэргийлж зах зээлийн болон борлуулалтын сувгуудын зорилтот хэрэглэгчдийн зан төлөвийг нарийн судалгаа, шинжилгээгээр тогтмол тодорхойлдог байх шаардлагатай.

## Санхүүгийн нөхцөл байдал

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 12-р сард үүсгэн байгуулагдаж 2021 оны 11 сараас олон нийтэд бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн гарааны бизнес учир санхүүгийн тайлангийн шинжилгээнд 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан болон 2022 оны 1-р улирлын аудитлагдсан тайланг ашигласан болно.
2022 оны эхний улирлын байдлаар компанийн нийт хөрөнгө 3.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 60%-ийг эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хамгийн гол орц нь бяруу болон шүдлэн насны үхэр бөгөөд үүнийг бараа материал хэсэгт бүртгэдэг учир эргэлтийн хөрөнгийн 82%-ийг эзэлж байна. Нийт хөрөнгийн эргэлтийн бус хөрөнгөнд 1.48 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, машин техник хэрэгсэл эзэлж байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

*Санхүүгийн байдлын тайлан /товч/*

| *мянган төгрөг* | 2021 * | 2022. I * | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 2,295,982 | 2,330,302 | *61.2%* |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,422,727 | 1,479,942 | *38.8%* |
| **Нийт хөрөнгө** | **3,718,709** | **3,810,244** | ***100.0%*** |
| Нийт өр төлбөрийн дүн | 3,871,140 | 3,183,563 | *83.6%* |
| Нийт өмчийн дүн | (152,431) | 626,681 | *16.4%* |
| **Нийт өр төлбөр ба өмчийн дүн** | **3,718,709** | **3,810,244** | ***100.0%*** |

**- Аудитлагдсан*

Компанийн эх үүсвэр талд хувьцаа эзэмшигчдийн 1.5 тэрбумын хөрөнгө оруулалт болон 3.1 тэрбум төгрөгийн өр төлбөр эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь богино хугацаанд бэлэн мөнгөний нөөцөө бүрдүүлэхийн тулд өөрийн толгой компани болон зэргэлдээ компаниудаас арилжааны банкны шугамын зээлийн нөхцөлтэй ижил нөхцөлөөр санхүүжилт татан ажиллаж байна.

*Орлогын тайлан /товч/*

| *мянган төгрөг* | **2021 *** | **2022. I *** | **Эзлэх хувь** |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 226,697 | 509,165 | 100.0% |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | (206,540) | (624,232) | 122.6% |
| Нийт ашиг | 20,156 | (115,067) | (22.6)% |
| Бусад орлого | 3,032 | 1,146 | 0.2% |
| Борлуулалт, маркетингийн зардал | (95,832) | (109,978) | 21.6% |
| Ерөнхий удирдлагын зардал | (258,626) | (198,604) | 39.0% |
| Санхүүгийн цэвэр зардал | (62,153) | (75,259) | 14.8% |
| Бусад зардал | (6,653) | (7,164) | 1.4% |
| Ханшийн зөрүүгийн ашиг алдагдал | (425) | (15,962) | 3.1% |
| Татварын өмнөх ашиг | (400,501) | (520,888) | (102.3%) |
| Татварын зардал | 38,171 | - | 0.0% |
| Тайлант жилийн цэвэр ашиг | (362,330) | (520,888) | (102.3)% |

** - Аудитлагдсан*

Үнэт цаас гаргагчийн борлуулалт хараахан идэвхжээгүй, бүтээгдэхүүнээ зах зээлд таниулах эхлэлийн үе шатандаа явж байгаа тул сүүлийн тайлант үеүдэд алдагдалтай ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн нь иргэдийн эрэлт хэрэгцээ өндөр, өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бөгөөд тогтвортой, олон сувгуудаар дамжуулан борлуулалт хийгдэж байгаа учир 2022 оны жилийн эцсийн байдлаар ашигтай ажиллана гэсэн төсөөлөлтэй байна.

**Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь одоогоор төвийн бүсийн аймаг, сумдын малчдаас малаа биечлэн очиж сонгон авч байна. Үйлдвэрлэлийн нөөц гэдэг бүтээгдэхүүний хувьд маш чухал тул малын татан авалтыг илүү системтэйгээр албан гэрээний үндсэн дээр, шалгуур, шаардлага тавьж, үүрэг хариуцлага хүлээн нийлүүлэлтээ татан авахаар зорьж байгаа нь зардал болоод, цаг хугацааг ихээр хэмнэх боломж юм гэж харж байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ № 1118265142



6648436 МонБийф ХХК УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

нийлүүлэлтээ татан авахаар зорьж байгаа нь зардал болоод, цаг хугацааг ихээр хэмнэх боломж юм гэж харж байна.

Үнэт цаас гаргагчийн ферм нь нийт 840 үхрийн багтаамжтай ба 2026 он хүртэл сард хийх татан авалт болон нядалгааны тоог шат дараатай нэмэгдүүлэхээр тооцоолоод байгаа. Энэ онд нийт хүчин чадлын 50-80 хувийг ашиглахаар байгаа ба цаашлаад бизнес төлөвлөгөөний дагуу бүтээгдэхүүний гарцын хэмжээгээ нэмэгдүүлж, борлуулалтаа идэвхжүүлж чадвал 2024 он гэхэд бүрэн хүчин чадлаараа ажиллах боломжтой гэж үзэж байна.

Үхрийн жингийн нэмэгдлийн хувьд одоогоор хоногт дунджаар 750-800 гр байна. "Мон Бийф" ХХК-н хувьд "Баялаг Фийд" ХХК компанитай хамтран өөрсдийн судалгаа, шинжилгээнд үндэслэсэн тэжээлийн туршилтыг амжилттай хийж байна. Энэ судалгааны явц сайн байгаа ба үр дүнг үхрийн хоногт нэмэгдэх жингийн хэмжээг 1 килограммаас дээш байх боломжтойгоор таамаглаж байна. Туршилтын сайн үр дүн нь фермийн үйл ажиллагаанд нэвтэрснээр махны гарцын хэмжээ нэмэгдэж компанийн ашигт ажиллагаанд өндөр нөлөөтэй байна гэж дүгнэв.

Үйлдвэрлэлийн хувьд бяруу, шүдлэн үхрийг 100 хоног бордон тэжээж , техөөрөн эргэлтэд оруулж байна. Энэ нь стейкны шаардлага хангах махны гарц өндөр ч бэлэн бүтээгдэхүүн болох хугацаа урт байгаа тул энэ оны хоёрдугаар хагасаас 3-4 настай үхрийг татан авчирч 30 хоног эрүүл ахуйг чанд сахин бордон тэжээж мах бэлтгэлийг хийж бүтээгдэхүүний эргэлтийг хурдасгахаар зорьж байгаа нь борлуулалтын орлогын төсөөллийг бодит гэж үзэх нэг шалтгаан болсон.

Мах бэлтгэлийн процессын хувьд "Цалуут Импекс" ХХК-д хийгдэж буй нядалгаа болон ангилан савлах явцад агуулахын хүрэлцээ бага, технологийн нууц алдагдах, тоног төхөөремжийн нэр төрөл бага, зардал өндөр зэрэг дутагдалтай талууд байгаа тул өөрсдийн болоод олон улсын стандарт шаардлагыг хангах үйлдвэрийг барьж байгуулснаар бүтээгдэхүүний нэгжид ногдох өртгийг бууруулах боломжтой болоод байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл нь үйлдвэрийн аргаар боловсруулж, ангилсан мах нь нийт махны зах зээлийн 4-5 хувь байгаа ба энэ нь өнөөгийн ханшаар 105 орчим тэрбум төгрөгийн зах зээл байна. Үнэт цаас гаргагчийн хувьд дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд энэхүү зах зээлийнхээ 10-13 хувийг хангахаар зорьж байгаа ба энэ нь нийт махны нийлүүлэлтийн 0.5 орчим хувь тул төлөвлөгөөндөө хүрэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

**Олон нийтээс татсан хөрөнгийн зарцуулалт**

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд өөрийн бизнесийн 30 хувиа санал болгон 2.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж тус хөрөнгийг компанийн бизнесийн дунд хугацааны төлөвлөгөөний хүрээнд нядалгаа, ангилгааны үйлдвэрийн төсөлд зарцуулахаар төлөвлөөд байна. "Мон Бийф" ХХК нь "Цалуут Импекс" ХХК-аар үхрээ нядлуулах, нарийн ангилан савлуулах гэх мэт үйлчилгээнүүдийг авдаг ба тус үйлдвэр нь ISO 9001:2016, ISO 22000:2018 , HACCP CAC/RCP/ 1:2003 стандартууд болон ариун цэврийн бүрэн шаардлагыг хангадаг. Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор мах нядалгаа болон ангилгааны үйлдвэрийг барих бэлтгэл ажлаа хангаж байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

6642436
MonGeo LLC

СЭХ
2022 06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт:

| Хийгдэх ажлууд | Шаардагдах хөрөнгө /төгрөг/ | Эзлэх хувь |
|---|---|---|
| Үйлдвэрийн тоног төхөөрөмж | 1,903,530,000 | 66% |
| Үйлдвэрийн барилга | 989,326,500 | 34% |
| Нийт | **2,892,856,500** | 100% |

Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 66 хувь нь үйлдвэрийн тоног төхөөрөмж, 34 хувь нь үйлдвэрийн барилгын ажилд зарцуулагдахаар төлөвлөгдөж байна.

Барилгын ажлын явцын хувьд зураг төслийн ажил дууссан ба одоогоор барилгын түүхий эдийн татан авалтуудаа идэвхтэй хийж байна. 2022 оны 6 сараас бүтээн байгуулалтын ажил эхлэн 2023 оны нэгдүгээр улирал гэхэд бүрэн дуусгах төлөвлөгөөтэй байна.

Үйлдвэр нь 1 ээлжиндээ 30 бодыг ангилан нядлах хүчин чадалтай ба ISO 9001:2016, ISO 22000:2018, ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо , HACCP CAC/RCP/ 1:2003 зэрэг стандартуудыг хангасан орчин үеийн шинэлэг техник, технологийг ашиглахаараа давуу талтай байгаа зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэх, бүтээгдэхүүнд ногдох зардлын бууралт зэрэг зэрэг нөлөөллүүд өндөр байна гэж дүгнэж байна.

**Үнэ тогтоосон үндэслэл**

Үнэт цаас гаргагчийн **"Итгэлт Эстимэйт" ХХК**-тай 2022 оны 02 сарын 16-ны өдөр байгуулсан Хөрөнгийн үнэлгээний ажлын гэрээний дагуу хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний тайлан гүйцэтгүүлсэн. Тус үнэлгээний дагуу "Мон Бийф" ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийхдээ ҮОУК-аас баталсан нийтээр хүлээн зөвшөөрсөн 3-н хандлагын орлогын хандлагын арга, цэвэр активын арга, зах зээлийн аргыг ашиглан үнэлгээг хийсэн. Үнэлгээний эцсийн дүгнэлтээр орлогын хандлагын цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар хийсэн үнэлгээнд 100 хувь ач холбогдол өгч үнэлгээний үр дүнд **Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг 12.8 тэрбум төгрөг буюу нэгж хувьцааны үнийг 60 төгрөгөөр тогтоосон.**

Бид үндсэн андеррайтерийн хүрээнд үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэр бодитойг үнэлэх зорилгоор "Мон Бийф" ХХК-ийн бизнесийн үнэлгээг дотооддоо хийсэн ба уг дүн нь 12.2 тэрбум төгрөг байв.
Улмаар андеррайтеруудын зүгээс зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үзэж Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдүүдэд санал хүргүүлэн, харилцан санал солилцсоны үндсэн дээр "Мон Бийф" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 20-ний өдрийн 40/ТУЗ-08 тоот тогтоолоор **хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлгээний үр дүнг олон нийтэд 25 хувийн хөнгөлөлттэй үнээр буюу бизнесийн үнэлгээг 9.6 тэрбум төгрөг, нэгж хувьцааны үнийг 45 төгрөг болгон хямдруулахаар шийдвэрлэсэн.**

Үнэт цаас гаргагчийн хувьд борлуулалтын өсөлт үзүүлэх боломжтой, дотоодын хөгжих боломж өндөр томоохон зах зээлд үйлдвэрлэлийн бизнес явуулж байгаа тул компанийн ирээдүйд чухал ач холбогдол өгч цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргыг ашиглан үнэлгээг хийсэн.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453... УЛААНБААТАР ХОТ 1118265142

СЗХ
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

## ДҮГНЭЛТ

"Апекс капитал" ҮЦК нь үндсэн андеррайтерын үйлчилгээний хүрээнд "Мон Бийф" ХХК-ийн олон нийтэд анх удаа хувьцаа санал болгох үйл ажиллагаатай холбоотой хийсэн судалгаа шинжилгээнүүд болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагуудын гаргасан тайлан, дүгнэлтэд үндэслэн "Мон Бийф" ХХК-ийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалах боломжтой гэж үзэж байна. **Үнэт цаас гаргагч компани нь компанийн нийт хувьцааны 30 хувийг шинэ хөрөнгө оруулагчдад санал болгон шинээр 64,285,700 ширхэг хувьцааг гарган нэг бүрийг нь 45 төгрөгөөр нийт 2,892,856,500 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэн дүгнэлтийг гаргаж байна.**

Одоогоор Монгол улсад үнэт цаас гаргагчтай ижил үйл ажиллагаа явуулдаг мал аж ахуйн салбарын инновац шингэсэн үйлдвэрлэлтэй компани байхгүй байгаа нь зах зээлд хурдан нэвтрэх, бүтээгдэхүүнээ байршуулан хэрэглэгчдийн итгэлийг хүлээх боломжийг олгож байна. Зах зээлийн энэхүү боломжуудаас гадна үнэт цаас гаргагчийн олон жилийн судалгаа, шинжилгээнд үндэслэсэн тэжээлийн бүтэц, чанарын шаардлагуудыг хангаж байгаа байдал нь бүтээгдэхүүний урт хугацааны оршин тогтнох, зардлын болон чанарын давуу талуудыг бий болгож байна.

Үйлдвэрийн аргаар боловсруулагдсан үхрийн мах нь нийт махны нийлүүлэлтийн ердөө 0.3 хувийг эзэлж байгаа нь стандартын шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мах, махан бүтээгдэхүүний өсөх орон зай асар өндөр байгааг харуулж байна. Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний хүрээнд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр мах нядалгаа болон ангилан савлах тоног төхөөрөмж авах цаашлаад үйлдвэр барих төсөл нь Монголчуудын уламжлагдсан махны хэрэглээг илүү стандартад нийцүүлсэн, хүнсний аюулгүй байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой юм.

Дотоодын зах зээлээс гадна урт хугацаандаа фермийн аж ахуйн үхрийн махны экспортын эрэлт хэрэгцээг хангахын тулд компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд эхний шатны хөрөнгө босгох хэрэгцээ байгааг дээрх судалгаа, шинжилгээний үр дүнгүүдээс харах боломжтой.

Таван Богд Групп нь хүнсний салбарын отгон үйлдвэрлэгч Мон Бийф ХХК-ийг олон нийтэд нээлттэй болгосноор салбартаа тэргүүлэгч, мэргэшсэн хамт олонтой, тогтвортой өсөлттэй компанийн хөрөнгө оруулагч болох боломжийг хүн бүрд олгож байгаа юм. Үүний үр дүнд андеррайтерийн зүгээс цаашид Монгол улсын томоохон групп компаниуд олон нийтэд нээлттэй компани болж хөрөнгийн зах зээлийн идэвхийг нэмэх, иргэдэд хөрөнгө оруулалтын таатай боломжуудыг олгох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

Энэхүү дүгнэлтээр нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ирээдүйн өсөлт, төлөвлөгөөний биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь дээрх судалгаа, шинжилгээ болон гадаад дотоодын эрсдэлүүдийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283
УЛААНБААТАР ХОТ 1118265142



6648436
Мон Би...
ХХ компани

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

Т.ЭНХ-АМГАЛАН ............................................ АНДЕРРАЙТЕРИЙН ХЭСГИЙН АХЛАХ

П.СЭЛЭНГЭ ........................................ ХУУЛЬЧ

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Б.ЛХАМДОЛГОР ............................................ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

СЯХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

# ХАВСРАЛТ 09

СЗХ
2022 .06сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MON BEEF



## ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТ

| № | Материалын жагсаалт | Хуудасны тоо |
|---|---|---|
| 1. | Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ | 1 |
| 2. | Үнэт цаас гаргагч компанийн дүрэм | 10 |
| 3. | Толгой компанийн гэрчилгээ, дүрэм | 6 |
| 4. | Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, хурлын тэмдэглэл | 3 |
| 5. | Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр | 3 |
| 6. | Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, хурлын тэмдэглэл /Нийтэд санал болгох энгийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох тухай/ | 2 |
| 7. | Хувьцаат компанийн дүрмийн төсөл | 12 |
| 8. | ТУЗ-ийн гишүүд, ерөнхий нарийн бичгийн даргын засаглалын гэрчилгээ | 4 |
| 9. | Оролцогч байгууллагуудын гэрчилгээ, тусгай зөвшөөрөл | 26 |
| 10. | Хууль зүйн дүгнэлт | 28 |
| 11. | Аудитын дүгнэлт /2021 оны жилийн, 2022 оны нэгдүгээр улирал/ | 29 |
| 12. | Үнэлгээний тайлан | 71 |
| 13. | Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, гэрээ /Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн тухай/ | 4 |
| 14. | Төлбөр төлсөн баримт | 1 |
| | **Нийт** | **200** |

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000222836

2020.12.31
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011823614
/ Хувийн хэргийн дугаар /

6648436
/ Регистрийн дугаар /

Мон бийф — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2020.12.23 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 70200 | Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 46630 | Барилгын материалын худалдаа |
| 01410 | Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх |
| 10100 | Мах боловсруулах, консервлох |
| 10800 | Малын тэжээл үйлдвэрлэл |
| 01620 | Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа |

| Хугацаагүй | 1 | 10,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, стадион оргил, Хаан банк цамхаг, 10-р давхар, Утас1: 99117880, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тэмдэг/ /гарын үсэг/ Г.САНЖААА

*Гэрчилгээ дахин олгосон 2021 он 04 сар 08 өдөр*

СЗХ 2022.05.22 он сар өдөр БҮРТГЭВ № 01

... он ... сар ... өдөр Бүртгэлийн № 1699 ... Хан-Уул дүүргийн ... тойргийн нотариатч Д.Ундрах би энэ хуулбарын үнэн зөвийг гэрчилэв.

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 91

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Энхтөр овогтой Пүрэвлхам-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.04.08 | Г.Санжаа |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2021.04.08 | Г.Санжаа |
| 3 | Баяраа овогтой Түвшинбаатар-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.05.21 | У.Мандахтуяа |
| 4 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 190000 мян.төг-р нэмэгдэж нийт 200000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2021.06.10 | Н.Энхтуяа |
| 5 | Хувьцаа эзэмшигч 8 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 8 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.06.10 | Н.Энхтуяа |
| 6 | Эцсийн өмчлөгч бүртгэв. | 2021.06.10 | Н.Энхтуяа |
| 7 | Чулуун овогтой Ванчинэрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.11.11 | Э.Баточир |
| 8 | Хувьцаа эзэмшигч эзэмшигчийн тоо нийт 7 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.11.11 | Э.Баточир |
| 9 | Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2022.01.17 | Э.Баточир |
| 10 | Намхайдорж овогтой [illegible]баатар-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-[illegible] [illegible]. | 2022.02.10 | Э.Баточир |
| 11 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 300000 мян.төг-р нэмэгдэж нийт 500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2022.03.18 | Э.Баточир |
| 12 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1000000 мян.төг-р нэмэгдэж нийт 1500000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2022.04.12 | Э.Баточир |
| 13 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2022.05.10 | Э.Баточир |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдэж ашигласан Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээг засварласан бол хүчингүй.

* 0 0 3 2 2 2 8 3 6 *

“Мон Бийф” ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчийн 2022 оны 05 сарын 02-ны өдрийн 4а/12 тоот шийдвэрийн Хавсралт №1

## “МОН БИЙФ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Компанийн оноосон нэр (Монголоор)
   а) Бүрэн нэр “Мон Бийф” ХХК
   б) Англиар “Mon Beef” LLC
1.2 Компанийн оршин байгаа хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө-6, Стадион Оргил-1, Хаан Банк цамхаг, 10 давхарт байна
1.3 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч

| № | Үүсгэн байгуулагчийн нэр | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд | 2543303 | ХУД, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, өөрийн байр. | 75112222 |
| 2 | Ж.Барсболд | СЮ76100216 | СБД, 1-р хороо 220 мянгат, 24 байр 77 тоот | 9911-9957 |
| 3 | Ц.Цэцэнхүү | ЦГ69041622 | ХУД, 3-р хороо, 4-р байр 30 тоот | 99994662 |
| 4 | Э.Пүрэвлхам | ПЮ86082877 | Хан уул дүүрэг 11-р хороо, дүнжингарав гудамж 51-р байр, 1-орц 82 тоот | 99109380 |
| 5 | И.Баттуяа | ХБ86010165 | ХУД, 2-р хороо, 86-р байр, 201 тоот | 99102817 |
| 6 | Ж.Оюунчимэг | ХН73031868 | Хан-Уул дүүрэг, Цэнгэлдэх хотхон, 204 байр, 801 тоот | 99109839 |

1.4 “Мон Бийф” ХХК нь (цаашид “компани” гэнэ) Компанийн тухай Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдах хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123
Хуулийн этгээдийн регистрийн дугаар 9011826614
2022 оны 05 сарын 10 өдөр
Бүртгэсэн улсын (ахлах) бүртгэгчийн

ТЭХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ 03

Mon Beef LLC Мон Бийф ХХ компани 6648436 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

1.5 Тусгай зөвшөөрөл шаардахаас бусад хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.

1.6 Компани нь орлого, ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

- Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
- Барилгын материалын худалдаа
- Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх /0141/
- Мах боловсруулах, консервлох /1010/
- Малын тэжээл үйлдвэрлэл /1080/
- Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа /0162/

1.7 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ

1.8 Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

1.9 Компани нь улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

1.10 Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулна.

## ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1 Компани нь өөрийн нэрийн өмнөөс эрх, эдлэн үүрэг хүлээх, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдана.

2.2 Компани нь өөртөө барааны тэмдэг болон билэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг (тамга) хэрэглэнэ.

2.3 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар болон бусадтай хамтран өөрийн эсвэл салбар эсвэл төлөөлөгчийн газрыг гадаадад болон бусад аймаг, хот, дүүрэг, хороонд ажиллуулна. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ. Компанийн салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд, компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

2.4 Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрт болон гадаадад салбар төлөөлөгчийн газар, охин компанийг байгуулан ажиллуулах эрхтэй.

2.5 Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

2.6 Компани нь төрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллага түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлүүлэх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.

2.7 Компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцална.

2.8 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

## ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ

3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.

3.2. Компани нь Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу нягтлан бодох болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.

3.3. Компани нь дотоод хяналтын /аудит/ албатай байх ба компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэл нь хууль тогтоомж, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт нийцэж байгааг хангаж ажиллана.

3.4. Дотоод хяналтын алба нь үүссэн зөрчил дутагдлыг засаж залруулах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зөвлөмж, шаардлагыг хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагад танилцуулж мэдээлэх үүрэгтэй.

3.5. Компани нь Монгол улсын татварын хуулиудыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлнө.

3.6. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.7. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргийг биелүүлнэ.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

4.1 Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

4.2 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3 Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

4.4 Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон түүний багын гишүүн, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно. \

4.5 Компанийн эрх бүхий албан тушаалтнууд "Компанийн тухай" хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-д заасан үүрэг хүлээж, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

## ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

5.1. Хувьцаа эзэмшигч нь Компанийн дүрэмд заасан журмын дагуу компанийн үйл ажиллагааг удирдахад оролцоно

5.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.

5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах. Ногдол ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.

5.4. Хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах.

СЗХ
2022.06.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

5.5. Компани татан буугдах үед өр төлбөр барагдуулсны дараагаар компанийн үндсэн хөрөнгө худалдан борлуулсан орлогоос эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувь хүртэх.

5.6. Компанийн үйл ажиллагааны байдал, санхүүгийн байдал, бусад бичиг баримт мэдээ тайлантай танилцах.

5.7. Компанийн эрх барих болон захиргааны байгууллагад санал оруулах, хэлэлцүүлэх,

5.8. Компанийн болон түүний шууд харьяа үйлдвэрийн бүтээгдэхүүн, гадаад дотоод зах зээлээс худалдан авч байгаа зүйлс, үзүүлж буй үйлчилгээг тэргүүн ээлжид авах эрхтэй.

5.9. Хувьцаа эзэмшигч нь нас барсан тохиолдолд түүний өв залгамжлагч нь компанийн гишүүнээр элсэх эрхтэй.

5.10. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсны дагуу Ерөнхий захирал, гүйцэтгэх захирлаар ажиллаж болно.

## ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

6.1 Хувьцаа эзэмшигч нь компанийн дүрэм, гэрээний заалтыг чанд сахиж компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх.

6.2 Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлэх

6.3 Компанийн нууцыг чандлан хадгалах.

6.4 Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаанд чин шударгаар хандах.

6.5 Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээгээр биелүүлэх.

6.6 Хувьцаа эзэмшигч нь өөрийн буруугаас компанид учруулсан хохирлыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 12 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.

6.7 Хувьцаа эзэмшигч нь төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ноогдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасаж болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

6.8 Хувьцаа эзэмшигч нь энгийн хувьцаа, ноогдол хувь эзэмших эрхээ бүгдийг буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх саналтай бол энэ тухайгаа бусад хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдэгдэнэ. Бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг давуу эрхийн дагуу тэргүүн ээлжид худалдан авах эсэхээ 30 хоногийн дотор мэдэгдэнэ. Энэ хугацаанд хариу мэдэгдээгүй бол мэдэгдэлд дурдсан хугацаанд шилжүүлэх, худалдахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

6.9 Хувьцаа эзэмшигч нь компанийн гишүүнээс гарах тухай өргөдлөө хувь эзэмшигчдийн хуралд 1 сараас доошгүй хугацааны өмнө гаргана. Хувьцаа эзэмшигчийг компаниас гаргах тухай шийдвэр, дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хувьцаа эзэмшигчийг компаниас гарсанд тооцно.

6.10 Хувьцаа эзэмшигч компаниас гарсан тохиолдолд дор дурдсан хөрөнгө олгоно.

6.10.1 Хувь нийлүүлсэн хөрөнгийнх нь үнэ. /өртөг/

6.10.2 Уг гишүүнд ногдох ноогдол ашиг.

СЗХ
2022 06. 22
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

6.11 Хувьцаа эзэмшигчид дараах зүйлийг хориглоно.
6.11.1 Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолдоо ашиглахыг хориглоно.
6.11.2 Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхийг хориглоно.

## ДОЛОО. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

7.1 Компани нь **1,500,000,000 /Нэг тэрбум таван зуун сая/** төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Энэхүү хөрөнгө хувьцаанд хуваагдсан байх бөгөөд нэг бүр нь **10 /арван/** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **150,000,000** ширхэг хувьцаа байна.

| № | Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр | Эзэмших хувьцаа | | | дүрмийн санд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Үнэ | | |
| | | | Нэгж | Бүгд | |
| 1. | Таван Богд Трейд | 112,500,000 | 10 | 1,125,000,000 | 75% |
| 2. | Ж.Барсболд | 15,000,000 | | 150,000,000 | 10% |
| 3. | Ц.Цэцэнхүү | 7,500,000 | | 75,000,000 | 5% |
| 4. | Э.Пүрэвлхам | 7,500,000 | | 75,000,000 | 5% |
| 5. | И.Баттуяа | 4,500,000 | | 45,000,000 | 3% |
| 6. | Ж.Оюунчимэг | 3,000,000 | | 30,000,000 | 2% |
| | **НИЙТ** | **150,000,000** | **10** | **1,500,000,000** | **100%** |

7.2 Хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, алдагдал хариуцах үүргийн хэмжээ болон компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг гэрчилнэ.
7.3 Компанийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байх бөгөөд энгийн хэлбэртэй байна.
7.4 Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.
7.5 Шаардлагатай тохиолдолд хувь эзэмшигчдийн санаачилга, хамтын шийдвэрээр дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.
7.6 Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан хувь нийлүүлсэн хөрөнгөө тэр хэмжээгээр хорогдуулж болно.
7.7 Компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.
7.8 Энэхүү хөрөнгө нь тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний тайланг хавсаргаж баталгаажуулна.

## НАЙМ. КОМПАНИЙН УДИРДЛАГА ТҮҮНИЙ ЭРХ, ХЭМЖЭЭ

УЛСЫН БҮРТГЭГЧ

Мон Бийф ХХК MonBeefLLC УЛААНБААТАР 6648436

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
8.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн заасан журмын дагуу зарлан хуралдуулна.
8.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "**ТУЗ**" гэх) байна.
8.5. Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид "Гүйцэтгэх захирал" гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
8.6. Гүйцэтгэх захиралтай ТУЗ контрактын гэрээ байгуулах бөгөөд уг гэрээгээр Гүйцэтгэх захирлын эрх хэмжээ, Их хэмжээний болон Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хүрээ хязгаарыг зохицуулна.

## ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 9.1.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 9.1.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар
- 9.1.3. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг сонгох, тэдгээрийн эрх хэмжээ, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
- 9.1.4. ТУЗ-ийн гишүүдийн болон Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг тогтоох;
- 9.1.5. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Гүйцэтгэх захирлаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 9.1.6. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;
- 9.1.7. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон 76-р зүйлд заасан бусад асуудал;
- 9.1.8. Гүйцэтгэх удирдлага болон хувьцаа эзэмшигчдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

9.2. Компанийн ТУЗ нь 3 гишүүнтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Таван Богд Трейд ХХК-аас томилогдох 2 гишүүнийг 3 (гурав) жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд Хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно. ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэг нь хараат бус гишүүдээр бүрдэнэ.
9.3. ТУЗ-ын 3 гишүүний 2 гишүүнийг Таван Богд Трейд ХХК-аас томилох бөгөөд нэг гишүүнийг хувьцаа эзэмшигчдээс жил бүр сонгоно.
9.4. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хэдэн удаа ч хурал зарлан хуралдуулж болно.
9.5. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-аас түүний оронд өөр хүнийг түр томилно.
9.6. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн санал хураалтын дийлэнх олонхын саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн үүрэг гүйцэтгэнэ.
9.7. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих үүрэгтэй.

МОН БИЙФ ХХК / MonBeef LLC, Улаанбаатар хот, 6648436

СЗХ
2022 06 22 өдөр
БҮРТГЭВ
№01

2022-06-17
БҮРТГЭВ-03

9.8. ТУЗ-ийн хурал хуралдуулах хугацааг ТУЗ-ийн дотоод журмаар тогтооно. Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааныхаа журмыг тогтоож батална.
9.9. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
9.10. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг Нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
9.11. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
9.12. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.
9.13. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
9.14. 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд ТУЗ-ийн гишүүнээр сонгох эсэхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.
9.15. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ.Үүнд:
    9.15.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
    9.15.2. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;
    9.15.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;
    9.15.4. Өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;
    9.15.5. ТУЗ-ийн хуралд идэвхтэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.
9.16. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзшигчдийн хуралд оролцоогүй, идэвх хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.

## АРАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН БҮРЭН ЭРХ, ХАРИУЦЛАГА

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид "Гүйцэтгэх захирал" гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
10.2. Компанийн гүйцэтгэх захирлыг ТУЗ-ийн шийдвэрээр томилж, чөлөөлөх ба түүний эрх, үүрэг, хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, урамшуулал зэргийг менежментийн гэрээгээр тохирно. Энэхүү гэрээнд Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн заалтуудыг агуулгын хувьд багтаана. Гүйцэтгэх захирал ажиллах хугацааг хатуу тогтооно.
10.3. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

Mon Beef LLC
Мон Бийф ХХ компани

СЗХ
2022 .08. 22
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

10.4. Гүйцэтгэх удирдлага нь гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн төлөөлөн гэрээ, хэлцэл байгуулахад, гарын үсэг зурах, компанийн эрх бүхий албан тушаалтан (Менежмент багийн ажилтан) ажилчдыг томилох, чөлөөлөх болон итгэмжлэлгүйгээр компанийг төлөөлөх, гэрээгээр тогтоосон эрхийн хүрээнд эрх бүхий асуудлаар тушаал, шийдвэр гаргах, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.5. Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааны үр дүн, гэрээний биелэлтийг жилд нэгээс доошгүй удаа Төлөөлөн удирдах зөвлөлд хуралд тайлагнан дүгнүүлж байна.

10.6. Гүйцэтгэх удирдлага нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг хариуцна.

## АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

11.1. Компани нь санхүүгийн тайлангаа "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.

11.2. Компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах бөгөөд толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.

11.3. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна

- 11.3.1. Баланс
- 11.3.2. Орлого үр дүнгийн тайлан
- 11.3.3. Мөнгө гүйлгээний тайлан
- 11.3.4. Хуримтлагдсан ашгийн тайлан

11.4. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн удирдлагад олгосон цалин урамшуулал, тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас.

11.5. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх удирдлага хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

11.6. Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, ня-бо бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

11.7. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.

- 11.7.1. Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд
- 11.7.2. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- 11.7.3. Компанийн дотоод бичиг, баримт, материалууд
- 11.7.4. Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд
- 11.7.5. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
- 11.7.6. Компанийн гүйцэтгэх удирдлагын тушаал шийдвэр, хурал зөвлөгөөний тэмдэглэл
- 11.7.7. Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд
- 11.7.8. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд

## АРВАН ХОЁР. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ. ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

СЗХ
он сар өдөр
2022 06 22 В
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

12.1. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.
12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг “Компанийн тухай” хуулийн 18-23 дугээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.
12.3. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр, Иргэний хууль болон Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр татан буулгана.
12.4. Шүүх Компанийг дараах үндэслэлээр татан буулгана.
   12.4.1. Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан
   12.4.2. Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй болсон эсхүл нэг ч гишүүн үлдээгүй
   12.4.3. Хуульд заагдсан бусад үндэслэлүүдээр
12.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгах комиссыг томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
12.6. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.
12.7. Татан буулгах комисс нь “Компанийн тухай” хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.
12.8. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэг хохирол учруулсан бол хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.
12.9. Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

## АРВАН ГУРАВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

13.1. Компанийн дүрэмд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хуулийг удирдлага болгон шийдвэрлэнэ.
13.2. Энэхүү компанийн дүрэмтэй холбоотой маргаан гарвал маргааны эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй шүүхээр шийдвэрлүүлнэ
13.3. Энэ дүрмийг Монгол хэлээр тус бүр 2 хувь үйлдэж, нэг хувийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

1. “ТАВАН БОГД ТРЕЙД” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

   1.1 Ц.БААТАРСАЙХАН .....................

   1.2 Д.ХУЛАН .....................

   1.3 Ц.ОЮУНЦЭЦЭГ .....................

   1.4 Ц.ОЮУНЖАВ .....................

   1.5 Ц.ОЮУНСҮРЭН .....................

6648436 MonBeef LLC МонБийф ХХ компани УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.06сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2. Ж.БАРСБОЛД ..........................................

3. Ц.ЦЭЦЭНХҮҮ ..........................................

4. Э.ПҮРЭВЛХАМ ..........................................

5. И.БАТТУЯА ..........................................

6. Ж.ОЮУНЧИМЭГ ..........................................

УЛСЫН
БҮРТГЭГЧ
11/123

249

... он ...сар ... өдөр Бүртгэлийн № 1400
[illegible] Нийслэлийн Хан-Уул дүүргийн
[illegible] тойргийн нотариатч Д.Ундрах би [illegible]
энэ хуулбарын үнэн зөвийг гэрчлэв.
Үйлчилгээний хөлсөнд [illegible] төгрөг хураав
Нотариатч ..........................................

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

2022.06.22 өдөр
БҮРТГЭВ

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000181493

2006.01.13
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011010130
/ Хувийн хэргийн дугаар /

2543303
/ Регистрийн дугаар /

Таванбогд трейд Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 1997.07.04 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 4610 | Гадаад худалдаа |

| / код / | / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 6810 | Үл хөдлөх хөрөнгийн худалдаа |
| 0413 | Бизнесийн үйл ажиллагаа |
| 4520 | Автомашины засвар үйлчилгээ |
| 4530 | Автомашины худалдаа |
| 1010 | Гурилын үйлдвэрлэл |
| 8299 | Менежментийн зөвлөгөө өгөх |
| 4669 | Хүнс, барааны бөөний болон жижиглэнгийн худалдаа |
| 4390 | Өргөх байгууламж 4.1 заалтын дагуу /2017.11.29-2022.11.29/ |

| Хугацаагүй | 5 | 3,970,859.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, 6, Стадион Оргил-1, Хаан банк цамхаг, 10-р давхар, 1001 тоот, Утас1: 75112222, Утас2: , Факс: 345223
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

МОНГОЛ УЛС

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

5296722
1118268581

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 5 сар 2 өдөр

6648436 MonBeef

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Цагаач овогтой Баатарсайхан-г Захирал-р томилсныг бүртгэв. | 2006.01.13 | Х.Дуламсүрэн |
| 2 | Дахин эрчилээ олгов.<br>8110 Автомашины зогсоолын үйлчилгээ | 2019.05.02 | Г.Алтай |
| 3 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 500000 мян.төг-р хасагдаж нийт 3470859 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2019.10.10 | Г.Санжаа |
| 4 | 2543303 тоот регистрийн дугаартай Таванбогд трейд-г тусгаарласныг бүртгэв. | 2019-10-10 | Г.Санжаа |
| 6 | 6320007 тоот регистрийн дугаартай Таван богд консалтинг-г, 6320082 тоот регистрийн дугаартай Таван богд саппорт-г, 6083242 тоот регистрийн дугаартай Эй Ти Эм сервис монголиа-г нэгтгэснийг бүртгэв. | 2019.12.16 | М.Монголжин |
| 5 | 6482236 тоот регистрийн дугаартай Богд моторс –г тусгаарлсныг бүртгэв. | 2019.10.10 | Г.Санжаа |
| 5. | 6482236 тоот регистрийн дугаартай Богд моторс –г тусгаарлсныг бүртгэв. | 2019.10.10 | Г.Санжаа |
| 7 | 6320007 тоот регистрийн дугаартай Таван богд консалтинг-г, 6320082 тоот регистрийн дугаартай Таван богд саппорт-г, 6083242 тоот регистрийн дугаартай Эй Ти Эм сервис монголиа-г нэгтгэснийг бүртгэв. | 2019.12.16 | М.Монголжин |
| 8 | Шинэчилсэн дүрэм бүртгэв. | 2019.12.18 | Г.Санжаа |
| 9 | Эцсийн өмчлөгч 1 ирсэн бүртгэв. | 2020.10.01 | Н.Энхтуяа |
| 10 | 6267416 тоот регистрийн дугаартай Глобал ложистик сервис-г нэгтгэснийг бүртгэв. | 2021.10.20 | Э.Батачир |
| 11. | Шинэчилсэн дүрэм. бүртгэв. | 2021.10.14 | Э.Бат-Очир |

*000181493*

СЗХ
2022 06. 22 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-22
БҮРТГЭВ-03

*Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 10 сарын 20-ны өдрийн ХЭ. 01/58 тоот шийдвэрийн хавсралт 1*

## "ТАВАН БОГД ТРЕЙД" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар 9011010130
2021 оны 10 сарын 28 өдөр
Бүртгэсэн: Улсын (ахлах) бүртгэгчийн гарын үсэг

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ2

1.1 Компанийн оноосон нэр (Монголоор)

а) Бүрэн нэр "**Таван Богд Трейд**" ХХК
б)Товчилсон нэр "**ТБТ** " ХХК
в) Англиар "**Tavan Bogd Trade**" LLC

1.2. Компанийн оршин байгаа хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө 6, Хаан банк цамхаг, 10-р давхар, 1001 тоот. Web: www.tavanbogd.com, утас: 345225, 345223

1.3 Компанийн үүсгэн байгуулагчид, хувьцаа эзэмшигчид

| № | Овог нэр | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|---|
| 1 | Цагаачийн Баатарсайхан. | ПБ66011274 | УБ. ХУД 11-р хороо, 2 хэсэг зайсан цогцолбор 54-2 тоот | 77112222 |
| 2 | Дашдаваагийн Хулан | ХП68082200 | УБ. ХУД 11-р хороо, 2 хэсэг зайсан цогцолбор 54-2 тоот | 77112222 |
| 3 | Цагаачийн Оюунцэцэг | ХЕ64012867 | УБ. ХУД 11-р хороо, 2 хэсэг Анома 72-11 тоот | 77112222 |
| 4 | Цагаачийн Оюунжав. | ПБ62013022 | УБ. БГД, 19-р хороо, 4-р хороолол, 55б-1 | 77112222 |
| 5 | Цагаачийн Оюунсүрэн | ПБ67112700 | УБ.БЗД, 26-р хороо, Баянмонгол 401-р байр 46 тоот | 77112222 |

1.4 "Таван Богд Трейд" ХХК нь (цаашид "компани" гэнэ) Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу зохион байгуулагдсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллана.

1.5 Компани нь орлого, ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бараа, ажил үйлчилгээг нийлүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу эрхэлж болох бөгөөд дараах үндсэн болон туслах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа,
- Бизнесийн үйл ажиллагаа
- Автомашины худалдаа

MonBeefLLC
Мон Бийф ХХ Компани
6648436 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 .08 .22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17

- Менежментийн зөвлөгөө өгөх
- Гурилын үйлдвэрлэл
- Хүнс, барааны болон жижиглэнгийн худалдаа
- Өргөх байгууламж 4.1 заалтын дагуу
- Автомашины зогсоолын үйлчилгээ
- ....................................................

1.6 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ

1.7 Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

1.8 Компани нь улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ

2.1 Компани нь өөрийн нэрийн өмнөөс эрх, эдлэн үүрэг хүлээх, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж түүнийг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдана.

2.2 Компани нь өөртөө барааны тэмдэг болон бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг (тамга) хэрэглэнэ.

2.3 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар болон бусадтай хамтран өөрийн эсвэл салбар эсвэл төлөөлөгчийн газрыг гадаадад болон бусад аймаг, хот, дүүрэг, хороонд ажиллуулна. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ. Компанийн салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд, компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

2.4 Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрт болон гадаадад салбар төлөөлөгчийн газар, охин компанийг байгуулан ажиллуулах эрхтэй.

2.5 Компанийн үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

2.6 Компани нь төрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллага түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлүүлэх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.

2.7 Компани өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцална.

2.8 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэнэ.

## ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ

3.1. Компани нь энэхүү дүрмийн 1.5-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
Мон Бийф ХХК
MonBeef LLC
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022.06.22 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

3.2. Компани нь Монгол улсын "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулна.
3.3. Компани нь дотоод хяналтын /аудит/ албатай байх ба компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэл нь хууль тогтоомж, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт нийцэж байгааг хангаж ажиллана.
3.4. Дотоод хяналтын алба нь үүссэн зөрчил дутагдлыг засаж залруулах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зөвлөмж, шаардлагыг хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагад танилцуулж мэдээлэх үүрэгтэй.
3.5. Компани нь Монгол улсын татварын хуулиудыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлнө.
3.6. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
3.7. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргийг биелүүлнэ.
3.8. Компани нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ХАРИУЦЛАГА

4.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
4.3. Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.
4.4. Компанийн Хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх удирдлага болон түүний багын гишүүн, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг эрх бүхий албан тушаалтанд тооцно.
4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд "Компанийн тухай" хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-д заасан үүрэг хүлээж, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

## ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

5.1. Хувьцаа эзэмшигч нь Компанийн дүрэмд заасан журмын дагуу компанийн үйл ажиллагааг удирдахад оролцоно.
5.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
5.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах. Ногдол ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.
5.4. Хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах.
5.5. Компани татан буугдах үед өр төлбөр барагдуулсны дараагаар компанийн үндсэн хөрөнгө худалдан борлуулсан орлогоос эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувь хүртэх.

СЭХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

5.6. Компанийн үйл ажиллагааны байдал, санхүүгийн байдал, бусад бичиг баримт мэдээ тайлантай танилцах.
5.7. Компанийн эрх барих болон захиргааны байгууллагад санал оруулах, хэлэлцүүлэх,
5.8. Компанийн болон түүний шууд харьяа үйлдвэрийн бүтээгдэхүүн, гадаад дотоод зах зээлээс худалдан авч байгаа зүйлс, үзүүлж буй үйлчилгээг тэргүүн ээлжид авах эрхтэй.
5.9. Хувьцаа эзэмшигч нь нас барсан тохиолдолд түүний өв залгамжлагч нь компанийн гишүүнээр элсэх эрхтэй.
5.10. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсны дагуу Ерөнхий захирал, гүйцэтгэх захирлаар ажиллаж болно.

## ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

6.1 Хувьцаа эзэмшигч нь компанийн дүрэм, гэрээний заалтыг чанд сахиж компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх.
6.2 Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлэх
6.3 Компанийн нууцыг чандлан хадгалах.
6.4 Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаанд чин шударгаар хандах.
6.5 Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээгээр биелүүлэх.
6.6 Хувьцаа эзэмшигч нь өөрийн буруугаас компанид учруулсан хохирлыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаарснаас хойш 12 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.
6.7 Хувьцаа эзэмшигч нь төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ноогдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасаж болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.
6.8 Хувьцаа эзэмшигч нь энгийн хувьцаа, ноогдол хувь эзэмших эрхээ бүгдийг буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх саналтай бол энэ тухайгаа бусад хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдэгдэнэ. Бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг давуу эрхийн дагуу тэргүүн ээлжид худалдан авах эсэхээ 30 хоногийн дотор мэдэгдэнэ. Энэ хугацаанд хариу мэдэгдээгүй бол мэдэгдэлд дурдсан хугацаанд шилжүүлэх, худалдахыг зөвшөөрсөн гэж үзнэ.
6.9 Хувьцаа эзэмшигч нь компанийн гишүүнээс гарах тухай өргөдлөө хувь эзэмшигчдийн хуралд 1 сараас доошгүй хугацааны өмнө гаргана. Хувьцаа эзэмшигчийг компаниас гаргах тухай шийдвэр, дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хувьцаа эзэмшигчийг компаниас гарсанд тооцно.
6.10 Хувьцаа эзэмшигч компаниас гарсан тохиолдолд дор дурдсан хөрөнгө олгоно.
  6.10.1 Хувь нийлүүлсэн хөрөнгийнх нь үнэ. /өртөг/
  6.10.2 Уг гишүүнд ногдох ноогдол ашиг.
6.11 Хувьцаа эзэмшигчид дараах зүйлийг хориглоно.
  6.11.1 Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолдоо ашиглахыг хориглоно.
  6.11.2 Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөнд гэм хор учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхийг хориглоно.

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№01

## ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

7.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
7.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
7.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг дийлэнх олонхын саналаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
7.3.1 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
7.3.2 Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
7.3.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
7.3.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
7.3.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
7.3.6 Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
7.3.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
7.3.8 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
7.3.9 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
7.3.10 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
7.3.11 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
7.3.12 Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
7.3.13 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
7.3.14 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг батлах
7.3.15 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
7.3.16 Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

## НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

8.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.
8.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь 3 (гурван) гишүүнтэй байна.
8.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь түүний хурал байна.
8.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:
8.4.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
8.4.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
8.4.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

СЭХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

8.4.4 Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах
8.4.5 Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
8.4.6 Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
8.4.7 Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
8.4.8 Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
8.4.9 Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
8.4.10 Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
8.4.11 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
8.4.12 Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
8.4.13 Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
8.4.14 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
8.4.15 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
8.4.16 Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
8.4.17 Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
8.4.18 Энэхүү дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхээс бусад бүх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;
8.4.19 Компанийн тухай хуульд заасан бусад асуудал;

8.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг улирал нэг удаа хуралдуулна.

8.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх буюу гуравны хоёр (2/3) оролцсоноор хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонх буюу гуравны хоёр (2/3)-ын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

8.7 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос Төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж, чөлөөлнө.

8.8 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, түүнд хяналт тавих үүргийг хүлээнэ.

8.9 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас томилно.

8.10 Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно.

8.11 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь 3 (гурван) жил байх ба бүрэн эрхийн хугацаандаа 1 (нэг)-ээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

8.12 Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудал хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, төлөөлөн удирдах

зөвлөлийн гишүүдийг сонгох, тавигдах шалгуур, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын эрх, үүрэг, тэдгээрийн болон гишүүдийн цалин, урамшуулалтай, Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

## ЕС. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

9.1 Компани нь нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэ бүхий 3,470,859 (гурван сая дөрвөн зуун далан мянга найман зуун тавин есөн) ширхэг энгийн хувьцаатай 3,470,859,000 (гурван тэрбум дөрвөн зуун далан сая, найман зуун тавин есөн мянга) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Хувьцаа эзэмшигчид дараах байдлаар эзэмшинэ. Үүнд:

| № | Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр | Эзэмших хувьцаа | | | Хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо ширхэг | Нэгж үнэ | Бүгд үнэ | |
| 1. | Ц.Баатарсайхан | 2,082,515 | 1 000 | 2,082,515,000 | 60% |
| 2 | Д. Хулан | 694,172 | 1 000 | 694,172,000 | 20% |
| 3 | Ц.Оюунцэцэг | 347,086 | 1 000 | 347,086,000 | 10% |
| 4 | Ц.Оюунжав | 173,543 | 1 000 | 173,543,000 | 5% |
| 5 | Ц.Оюунсүрэн | 173,543 | 1 000 | 173,543,000 | 5% |
| | НИЙТ | 3,470,859 | | 3,470,859,000 | 100% |

9.2 Хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, алдагдал хариуцах үүргийн хэмжээ болон компанийг татан булгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг гэрчилнэ.

9.3 Компанийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байх бөгөөд энгийн хэлбэртэй байна. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.

9.4 Шаардлагатай тохиолдолд хувь эзэмшигчдийн санаачилга, хамтын шийдвэрээр дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.

9.5 Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан хувь нийлүүлсэн хөрөнгөө тэр хэмжээгээр хорогдуулж болно.

9.6 Компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.

9.7 Энэхүү хөрөнгө нь тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний тайланг хавсаргаж баталгаажуулна.

## АРАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА ТҮҮНИЙ ЭРХ, ХЭМЖЭЭ

10.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

СЭХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

10.2 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн заасан журмын дагуу зарлан хуралдуулна.
10.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
10.4 Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт удирдлагыг хэрэгжүүлэх Төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд компанийн тухай хуульд заасан ТУЗ-ийн эрх, үүргийг Хувьцаа эзэмшигчдийн хурал хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тус хурлын дарга удирдах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нь Ерөнхий захирал байна.
10.5 Компанийн удирдлагын бүтэц, эрх бүхий албан тушаалтан, түүний орон тоог компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр баталж болно.
10.6 Тус компанийн Ерөнхий захирал нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд компанийн үйл ажиллагаатай холбогдсон дараах асуудлыг шийдвэрлэх эрхтэй.
10.6.1 Эрх бүхий харилцаанд компанийг төлөөлөх
10.6.2 Компанийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл байгуулах
10.6.3 Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулах цуцлах, тэдгээрийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох.
10.6.4 Бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргах
10.6.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон эрх хэмжээний хүрээнд компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах.

## АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН БҮРЭН ЭРХ, ХАРИУЦЛАГА.

11.1 Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилсон гүйцэтгэх захирлаар удирдуулж болно.
11.2 Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр томилж, чөлөөлөх ба түүний эрх, үүрэг, хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, урамшуулал зэргийг менежментийн гэрээгээр тохирно. Энэхүү гэрээнд Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн заалтуудыг агуулгын хувьд багтаана. Гүйцэтгэх захирлын ажиллах хугацааг хатуу тогтооно.
11.3 Гүйцэтгэх удирдлага нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон, түүнтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна. гэрээгээр тогтоосон эрхийн хүрээнд эрх бүхий асуудлаар шийдвэр гаргах, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна компанийг төлөөлөх,.
11.4 Гүйцэтгэх захирал нь компанийн үйл ажиллагааны үр дүн, гэрээний биелэлтийг жилд нэгээс доошгүй удаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнан дүгнүүлж байна.
11.5 Гүйцэтгэх удирдлага нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан хохирлыг хариуцна.

## АРВАН ХОЁР. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

12.1 Компани нь санхүүгийн тайлангаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Аудитын тухай” хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц

УЛСЫН БҮРТГЭГЧ 11/123
MonBeefLLC Мон Бийф УЛААНБААТАР

хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.

12.2 Компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах бөгөөд толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.

12.3 Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна

- Баланс
- Орлого үр дүнгийн тайлан
- Мөнгө гүйлгээний тайлан
- Хуримтлагдсан ашгийн тайлан
- Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн удирдлагад олгосон цалин урамшуулал, тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас.

12.4 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх удирдлага хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

12.5 Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, ня-бо бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.

12.6 Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.

- Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Компанийн дотоод бичиг, баримт, материалууд
- Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд
- Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
- Компанийн гүйцэтгэх удирдлагын тушаал шийдвэр, хурал зөвлөгөөний тэмдэглэл
- Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд
- Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд

## АРВАН ГУРАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ. ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

13.1 Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

13.2 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компанийн тухай" хуулийн 18-23 дугаар зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

13.3 Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр, иргэний хууль болон компанийн тухай хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

13.4 Шүүх Компанийг дараах үндэслэлээр татан буулгана.

- Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан
- Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй болсон, эсхүл нэг ч гишүүн үлдээгүй

СЭХ
2022.08.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17

- Хуульд заагдсан бусад үндэслэлүүдээр

13.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгах комиссыг томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

13.6 Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

13.7 Татан буулгах комисс нь "Компанийн тухай" хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.

13.8 Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэг хохирол учруулсан бол уул хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

13.9 Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

## АРВАН ДӨРӨВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

14.1 Компанийн дүрэмд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол улсын Компанийн тухай хууль болон холбогдох бусад хуулийг удирдлага болгон шийдвэрлэнэ.

14.2 Энэхүү компанийн дүрэмтэй холбоотой маргаан гарвал маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд хүрч чадаагүй шүүхээр шийдвэрлүүлнэ.

14.3 Энэ дүрмийг Монгол хэлээр тус бүр 2 хувь үйлдэж, нэг хувийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.

14.4 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД:

1. Ц.БААТАРСАЙХАН ..............................
2. Д.ХУЛАН ..............................
3. Ц.ОЮУНЦЭЦЭГ ..............................
4. Ц.ОЮУНСҮРЭН ..............................
5. Ц.ОЮУНЖАВ: ..............................

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

MonBeef LLC
Мон Бийф ХХ КОМПАНИ
6648436
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022.06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-05-17
БҮРТГЭВ-03

**“МОН БИЙФ” ХХК-ИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 4 сарын 01 өдөр    Дугаар 40/ТУЗ-04    Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан
хуралдуулах, санал оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, 76.1.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь хэсэг, “Мон Бийф” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.2 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон Бийф” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 5 сарын 16-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, стадион оргил, Хаан банк цамхаг, 10-р давхар, Хурлын зааланд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн өдрийг 2022 он 5 дугаар сарын 16-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2022 оны 4 дугаар сарын 4-ны өдөр байхаар тогтоож, бичгээр мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Солонго)-д даалгасугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Ц.Баатарсайхан даргалахыг дурдсугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Түмэнжаргал овогтой Солонго /РД: ХВ83101062/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА    И.БАТТУЯА

Мон Бийф ХХ компани, MonBeefLLC, Улаанбаатар, 6648436

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ

*"МОН БИЙФ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн*
*2022 оны .4. сарын 1...-ны өдрийн хурлын*
*40/ТУЗ-04 тоот тогтоолын Хавсралт 1*

## "МОН БИЙФ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. "Мон Бийф" ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах замаар хувьцаат компани болгох тухай;
2. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан нэмж хувьцаа гаргах тухай;
3. Компанийн одоогийн нийт хувьцааны 30 (гуч) –иас доошгүй хувийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох тухай;
4. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан Үнэлгээний компанийн үнэлгээг танилцуулах, түүнд үндэслэн хувьцааны нэгж үнэлгээг ТУЗ-өөс тогтоох эрх олгох тухай;
5. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан одоогийн хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх эсэх;
6. "Мон Бийф" ХХК-ийн нэмж гаргасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс олон нийтэд санал болгон, хувьцааг нээлттэй арилжаалахыг зөвшөөрсний дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хувьцаат компани хэлбэртэй компанийн "Дүрмийн төсөл"-ийг батлах тухай;
7. Компани анх удаа олон нийтэд хувьцаа санал болгохтой холбоотой бусад асуудлууд.

**"МОН БИЙФ" ХХК**

СЗХ
2022 .06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-СЗ

**"МОН БИЙФ" ХХК-ИЙН**

**ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 01-ний өдөр Дугаар ТУЗ-04 Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **Хурлын ирц:** | Хурлын ирц 100% |
| **Хурал болсон газар:** | Компанийн хурлын танхим, |
| **Хурал эхэлсэн, дууссан:** | 2022 оны ... сарын ....., ...:.... цагт эхэлж .....:..... цагт дуусав. |
| **Хурлаар хэлэлцсэн асуудал:** | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах, оруулах санал хэлэлцэх тухай |

Хурлыг ТУЗ-ийн дарга И.Баттуяа даргалав.

**Хэлэлцсэн нь**:

**Хурлын дарга:** "Мон Бийф" ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, хувьцааг олон нийтэд анх удаа санал болгохтой холбогдуулан дараах асуудлыг өнөөдрийн хурлаар хэлэлцэхээр энэхүү хурлыг зарласан болно. Хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан та бүхэнд цахимаар ТУЗ-ийн нарын бичгийн даргаас хүргүүлсэн байгаа болно.

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах хурлын тов тогтоох
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:** Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасны дагуу 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулахаар заасан байдаг тул энэ хугацааг тооцох шаардлагатай мөн хурлаар нийт 7 асуудал хэлэлцээр байгаа тул хэлэлцэх асуудалтай та бүхэн нэг бүрчлэн танилцан санал өгнө үү.

**Гишүүн Ц.Оюунцэцэг**: Хувьцаа эзэмшигчдийн хурал тэгэхээр хэзээ хуралдуулах боломжтой байна вэ?

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:** 40-өөс доошгүй хоног гэхээр 5 дугаар сарын 15-17-ний өдрүүд байх боломжтой байна.

**Хурлын дарга:** Гишүүдэд асуух асуулт байна уу?

**Гишүүд:** Байхгүй гэв.

**Хурлын дарга:** Нэмэлт асуулт байхгүй бол ТУЗ-ын тогтоолыг батлахыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэв.

**Шийдвэрлэсэн нь:**

1. "Мон Бийф" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 11:00 цагт Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, стадион оргил, Хаан банк цамхаг, 10-р давхар, Хурлын зааланд зарлан хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлын хэлэлцэх асуудлыг жагсаалтыг ТУЗ-ийн хурлын тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2022 оны 05 сарын 16-ны өдөр байхаар тогтоосугай.

Mon Beef LLC
6648436
Мон Бийф ХХК
Улаанбаатар хот

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

4. Хувьцаа эзэмшигчийн ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр байхаар тогтоож, бичгээр мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Солонго)-д даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуулийн дагуу зохион байгуулахыг ТУЗ-ийн нарын бичгийн дарга /Т.Солонго/-д үүрэг болгосугай.

**Хурлын тэмдэглэл хөтөлсөн:**

ТУЗ-ийн нарын бичгийн дарга Т.СОЛОНГО

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

ТУЗ-ийн дарга И.БАТТУЯА

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-05-17
БҮРТГЭГДСЭН

**“МОН БИЙФ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР**

2022 оны ..5... сарын ..16.. өдөр Дугаар 40/14 Улаанбаатар хот

Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон олон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.4 62.1.16 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. дэх хэсэг,“Мон Бийф” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 5.2 дахь хэсэг болон ТУЗ-ийн 2022 оны .... дүгээр сарын .... -ны өдрийн тогтоолыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Мон Бийф” ХХК-ийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулсугай.
2. Компанийн одоо байгаа нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 150,000,000 (нэг зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаа дээр 64,285,700 (Жаран дөрвөн сая хоёр зуун наян таван мянга долоон зуу) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, компани нийт 214,285,700(Хоёр зуун арван дөрвөн сая хоёр зуун наян таван мянга долоон зуу) ширхэг энгийн хувьцаатай байхаар нэмэгдүүлсүгэй.
3. Компанийн нэмж гаргасан хувьцаа болох 64,285,700 (Жаран дөрвөн сая хоёр зуун наян таван мянга долоон зуу) ширхэг энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-иар дамжуулан анхдагч зах зээлийн арилжаагаар анх удаа олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсүгэй.
4. Хараат бус үнэлгээний компани болох “Итгэлт эстимэйт” ХХК-ийн гаргасан бизнесийн үнэлгээ болон Үндсэн Андеррайтер “Апекс капитал ҮЦК” ХХК-ийн саналыг харгалзан олон нийтэд санал болгох нэгж хувьцааны зах зээлийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоохыг зөвшөөрсүгэй.
5. Компанийн хувьцаа эзэмшигчид нь нийтэд санал болгохоор нэмж гаргасан энгийн хувьцаанаас Компанийн тухай хуульд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэхгүй, татгалзсан болохыг дурдсугай.
6. Энэхүү шийдвэрийн биелэлтийг хангах, хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр хангаж шаардлагатай арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажиллах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд болон Гүйцэтгэх удирдлагад олгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

1. “ТАВАН БОГД ТРЕЙД” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ,

   1.1. Ц.БААТАРСАЙХАН ..........

   1.2. Д.ХУЛАН ..........

   1.3. Ц.ОЮУНЦЭЦЭГ ..........

   1.4. Ц.ОЮУНЖАВ ..........

Tavan Bogd Trade Co., Ltd
Таван Богд Трейд ХХ компани
2543303
Улаанбаатар хот

Mon Beef LLC
Мон Бийф ХХ компани
Улаанбаатар хот

СӨХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 03

2022-06-17
БҮРТГЭВ-03

1.5. Ц.ОЮУНСҮРЭН ..............................

2. Ж.БАРСБОЛД ..............................

3. Ц.ЦЭЦЭНХҮҮ ..............................

4. Э.ПҮРЭВЛХАМ ..............................

5. Ж.ОЮУНЧИМЭГ ..............................

6. И.БАТТУЯА ..............................

MonBeefLLC
Мон Бийф
ХХ компани
6648436
УЛААНБААТАР ХОТ

ӨЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ [illegible]

2022-06-17
БҮРТГЭВ

**Итгэмжлэл олгох тухай**

2022 оны 05 сарын 13 -ний өдөр Улаанбаатар хот

Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3, 63 дугаар зүйлийн 63.1, 64 дүгээр зүйлийн 64.2 дах хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улаанбаатар хот, Хан Уул дүүрэг, 15-р хороо, Цэнгэлдэх хотхон, 204 дүгээр байр, 801 тоот-д оршин суух Жавзандолгор овогтой Оюунчимэг /РД: ХН73031868/ би хуулийн этгээдийн 9011823614 бүртгэлийн дугаартай, 6648436 регистрийн дугаартай “Мон Бийф” ХХК-ийн нэг бүр нь 10 төгрөгийн 3,000,000 ширхэг нийт 30,000,000 сая төгрөгийн 2 хувийн хувьцаа эзэмшдэг болно. Энэхүү итгэмжлэлийн дагуу “Мон Бийф” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, хурлаар хэлэлцүүлэгдсэн асуудлаар санал өгөх болон хурлаас гарсан баримт бичгүүд, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт гарын үсэг зурах эрхийг Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 11-р хороо, Дүнжингарав гудамж, 51-р байр 1-р орц 82 тоотод оршин суугч Энхтөр овогтой Пүрэвлхам /РД: ПЮ86082877/-т олгож байна.

Энэхүү итгэмжлэл нь итгэмжлэл олгосон өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд хүчинтэй байна.

ТӨЛӨӨЛҮҮЛЭГЧ: ............................................................ Ж.ОЮУНЧИМЭГ

ТӨЛӨӨЛӨГЧ: ............................................................ Э.ПҮРЭВЛХАМ

2022.05.13 Бүртгэлийн № 1049
Нийслэлийн ... нотариатч
Ц.Бэлрээ би энэхүү гарын үсэг зурсан хүмүүсийн
үнэн зөвийг гэрчлэв
Нотариатч ....................................

МонБийф ХХК
Мон Бийф XX компани
6648436
УЛААНБААТАР

СЭХ
2022 06 22
он сар өдөр
БҮРТГЭ...
№ 01



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA

Овог Family name
Боржигон
Borjigon
Эцэг/эх/-ийн нэр Surname
Жавзандолгор
Javzandolgor
Нэр Given name
ОЮУНЧИМЭГ
OYUNCHIMEG
Хүйс Sex
Эмэгтэй / Female
Төрсөн он, сар, өдөр Date of birth
1973/03/18
Регистрийн дугаар Registration number
ХН73031868 / KhN73031868

Олгосон байгууллага Issuing authority
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration
Олгосон он, сар, өдөр Date of issue
2018/04/11
Хүчинтэй хугацаа Date of expiry
0000/00/00
Хаяг Address
УБ, Хан-Уул, 15-р хороо
рапид харш, 24 байр
69 тоот
MNG



МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA

Овог Family name
Анчин
Anchin
Эцэг/эх/-ийн нэр Surname
Энхтөр
Enkhtur
Нэр Given name
ПҮРЭВЛХАМ
PUREVLKHAM
Хүйс Sex
Эрэгтэй / Male
Төрсөн он, сар, өдөр Date of birth
1986/08/28
Регистрийн дугаар Registration number
ПЮ86082877 / PYu86082877

Олгосон байгууллага Issuing authority
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration
Олгосон он, сар, өдөр Date of issue
2012/08/30
Хүчинтэй хугацаа Date of expiry
2031/08/28
Хаяг Address
УБ, Сүхбаатар, 12-р хороо
хангайн 6 гудамж
195 тоот
MNG

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

MonBest LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№

2022-06-17
БҮРТГЭВ-03

**“МОН БИЙФ” ХХК-ИЙН**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**

**ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 5... сарын ...16... өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **Хурлын ирц:** | Хурлын ирц 100% |
| **Хурал болсон газар:** | Компанийн хурлын танхим, |
| **Хурал эхэлсэн, дууссан:** | 2022 оны .... сарын ....., ...:.... цагт эхэлж ...:.... цагт дуусав. |
| **Хурлаар хэлэлцсэн асуудал:** | “Мон Бийф” ХХК-ийн компанийн хэлбэрийг өөрчлөх, олон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай |

Хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ц.Баатарсайхан нээв.

**Хэлэлцсэн нь**:

**Хурлын дарга:** Дараах 7 асуудлыг өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх байна. Үүнд:

1. “Мон Бийф” ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах замаар хувьцаат компани болгох тухай;
2. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан нэмж хувьцаа гаргах тухай;
3. Компанийн одоогийн нийт хувьцааны 30 (гуч) –иас доошгүй хувийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох тухай;
4. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан Үнэлгээний компанийн үнэлгээг танилцуулах, түүнд үндэслэн хувьцааны нэгж үнэлгээг ТУЗ-өөс тогтоох эрх олгох тухай;
5. Олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбогдуулан одоогийн хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх эсэх;
6. “Мон Бийф” ХХК-ийн нэмж гаргасан хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс олон нийтэд санал болгон, хувьцааг нээлттэй арилжаалахыг зөвшөөрсний дараа зохион байгуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хувьцаат компани хэлбэртэй компанийн “Дүрмийн төсөл”-ийг батлах тухай;
7. Компани анх удаа олон нийтэд хувьцаа санал болгохтой холбоотой бусад асуудлууд.

**ТУЗ:** Холбогдох Хууль зүйн дүгнэлт, аудитын дүгнэлт, андеррайтерын компанийн санал болон үнэлгээний байгууллагаас хийсэн дүгнэлтүүдийг танилцуулав.

- Энэ хүрээнд Үндсэн андеррайтер “Апекс капитал ҮЦК” ХХК;
- Туслах андеррайтер “Таван Богд Капитал ҮЦК” ХХК;
- Бизнесийн үнэлгээ Итгэлт Эстимэйт” ХХК
- Санхүүгийн тайланг “Эс Жи Эм Ди Аудит” ХХК;
- Хууль зүйн дүгнэлтийг “ХаанЛекс партнерс” ХХН болон “Эм Жэй Эл Атторнейс” ХХН нартай тус тус хамтран ажиллаа;

**Хурлын дарга:** Гишүүдэд асуух асуулт байна уу?

**Гишүүд:** Байхгүй гэв.

Мон Бийф ХХК
6648436
Улаанбаатар хот

СЗХ
2022 .08 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17
БҮРТГЭВ-03

**Хурлын дарга:** Нэмэлт асуулт байхгүй бол ХЭХ-ийн шийдвэрийг батлах уу

Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэв.

**Шийдвэрлэсэн нь:**

1. "Мон Бийф" ХХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙГ САНАЛ НЭГТЭЙГЭЭР БАТЛАХААР ШИЙДВЭРЛЭВ.

2. Шийдвэрийн биелэлтийг хангах, хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр хангаж шаардлагатай арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажиллах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд болон Гүйцэтгэх удирдлагад олгосугай.

**Хурлын тэмдэглэл хөтөлсөн:** **ТУЗ-ийн нарын бичгийн дарга Т.Солонго**

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

Хувьцаа эзэмшигч хурлын дарга Ц.БААТАРСАЙХАН

СЗХ
2022 .06. 22 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

**"МОН БИЙФ" ХХК-ИЙН**
**ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 06 сарын 20-ний өдөр    Дугаар 40/ТУЗ-08    Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **Хурлын ирц:** | Хурлын ирц 100% |
| **Хурал болсон газар:** | Компанийн хурлын танхим, |
| **Хурал эхэлсэн, дууссан:** | 2022 оны 06 сарын 20, 16:00 цагт эхэлж 17:00 цагт дуусав. |
| **Хурлаар хэлэлцсэн асуудал:** | Нийтэд санал болгох үнэ тогтоох тухай |

Хурлыг ТУЗ-ийн дарга И.Баттуяа даргалав.

**Хэлэлцсэн нь**:

**Хурлын дарга:** Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн 40/14 тоот шийдвэрээр компанийн хэлбэрийг өөрчилж, олон нийтэд хувьцаагаа санал болгохтой холбоотой хувьцааны зах зээлийн үнийг дараах зарчмаар тогтоох саналтай байна. Үүнд:

1.3. Хараат бус үнэлгээний компани болох "Итгэлт эстимэйт" ХХК-ийн гаргасан компанийн бизнес үнэлгээ болох 12,861,800,000 *(Арван хоёр тэрбум найман зуун жаран нэгэн төгрөг, найман зуун мянган)* төгрөгөөр үнэлсэн.

1.4. Үндсэн андеррайтер "Апекс капитал ҮЦК" ХХК-ийн санал болгосон хямдруулалтын хувийг дахин нэмэгдүүлэн 25 хувь болгох буюу 9,642,856,500 *(Есөн тэрбум зургаан зуун дөчин хоёр сая найман зуун тавин зургаан мянга таван зуу)* төгрөг болгон хямдруулсан үнэлгээгээр компанийн хувьцааг олон нийтэд санал болгохоор шинэчлэн тогтоох саналтай байна.

1.5. Компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувь болох 64,285,700 ширхэг хувьцааны нэгж үнийг 45 төгрөгөөр тогтоож, олон нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгох саналтай байна.

Иймд ТУЗ-ийн гишүүд та бүгд дээрх саналууд дээр санал өгнө үү.

**Гишүүн Ж.Барсболд**: Олон нийтээс нийт татан төвлөрүүлэх дүн хэд болж өөрчлөгдөхөөр байна вэ?

**ТУЗ-ийн дарга:** 2,892,856,500 (хоёр тэрбум найман зуун ерэн хоёр мянга найман зуун тавин зургаан мянга таван зуу) төгрөг байхаар тооцож байна.

**Хурлын дарга:** Гишүүдэд асуух асуулт байна уу?

**Гишүүд:** Байхгүй гэв.

**Хурлын дарга:** Нэмэлт асуулт байхгүй бол ТУЗ-ын тогтоолыг батлахыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгнө үү.

Гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэв.

**Шийдвэрлэсэн нь:**

- Компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувь болох 64,285,700 ширхэг хувьцааны нэгж үнийг 45 төгрөгөөр тогтоож, олон нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгосугай.
- Анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 2,892,856,500 (хоёр тэрбум найман зуун ерэн хоёр мянга найман зуун тавин зургаан

СЗХ
2022 .06 р 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

мянга таван зуу) төгрөг байхаар тогтоож, уг хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй.

- Нийтэд санал болгож байгаа энгийн хувьцааг "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Ариунбаатар)-д үүрэг болгосугай.

**Хурлын тэмдэглэл хөтөлсөн:**

ТУЗ-ийн нарын бичгийн дарга Т.СОЛОНГО

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

ТУЗ-ийн дарга И.БАТТУЯА

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 21
БҮРТГЭВ-03

TAVAN BOGD

**“МОН БИЙФ” ХХК-НИЙ**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 20 өдөр | Дугаар 40/ТУЗ-08 | Улаанбаатар хот

Нийтэд санал болгох
үнэ тогтоох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл болон 55 дугаар зүйл, “МОН БИЙФ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9 дугаар зүйлийн 9.1.8 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 05 сарын 16.-ны өдрийн хурлын 40/14 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн хэлбэрийг өөрчилж, олон нийтэд хувьцаагаа санал болгохтой холбоотой хувьцааны зах зээлийн үнийг дараах зарчмаар тогтоосугай. Үүнд:
   1.1. Хараат бус үнэлгээний компани болох “Итгэлт эстимэйт” ХХК-ийн гаргасан компанийн бизнес үнэлгээ болох 12,861,600,000 *(Арван хоёр тэрбум найман зуун жаран нэгэн сая зургаан зуун мянга)* төгрөгийн үнэлгээнд дахин хямдруулан 9,642,856,500 *(Есөн тэрбум зургаан зуун дөчин хоёр сая найман зуун тавин зургаан мянга таван зуу)* төгрөг болгон хямдруулсан үнэлгээгээр компанийн хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэв.
   1.2. Компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувь болох 64,285,700 ширхэг хувьцааны нэгж үнийг 45 төгрөгөөр тогтоож, олон нийтэд тогтоосон үнийн аргаар санал болгосугай.
2. Анхдагч зах зээлийн арилжаагаар нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 2,892,856,500 (хоёр тэрбум найман зуун ерэн хоёр мянга найман зуун тавин зургаан мянга таван зуу) төгрөг байхаар шинэчлэн тогтоож, уг хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад тусгасан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй
3. Энэхүү тогтоолын хавсралтаар Үнэт цаасны танилцуулгыг баталсугай.
4. Нийтэд санал болгож байгаа энгийн хувьцааг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Ариунбаатар)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ын дарга (И.Баттуяа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА　　　　И.БАТТУЯА

6648436 MonBeefLLC УЛААНБААТАР ХОТ

АПЕКС КАПИТАЛ

6648436 MonBeefLLC УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№

2022-06-17
БҮРТГЭВ

# "МОН БИЙФ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 "Мон Бийф" компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид "компани" гэх/ мөн.

1.2. Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Компанийн оноосон албан ёсны нэрийг

-монголоор: **"Мон Бийф"ХК компани**

-англиар: **Mon Beef Joint stock Company** гэнэ.

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 15-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Стадион Оргил 1, Хаан Банк Цамхаг, 10 давхар

1.5. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.6. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.7. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн "Мон Бийф" ХК эдэлнэ.

1.8. Компани нь үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.

1.9. Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

1.10. Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

## ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, компанийн логотой байх ба Компани нь банканд төгрөгийн, гадаад валютын болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

2.3. Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

2.4. Хувьцаа эзэмшигчид Компанийн хариуцлагыг хүлээхгүй ба Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

2.5. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

Мон Бийф ХХ компани
Mon Beef LLC
УЛААНБААТАР

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

## ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

3.2. Компанийн эрхэм зорилго нь: Үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, олон улсын стандартад нийцсэн эрүүл, чанартай, шимтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар бэлтгэж, хэрэглэгчдэдээ хүргэн салбартаа тэргүүлнэ.

3.3. Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:

3.3.1. Үхэр, ордос үхэр өсгөн үржүүлэх

3.3.2. Мах боловсруулах, консервлох

3.3.3. Малын тэжээл үйлдвэрлэл

3.3.4. Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа

3.3.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа;

3.4. Монгол улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

3.5. Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 214,285,700 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.

4.2. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.

4.3. Компанийн энгийн хувьцаа тус бүр Нэг саналын эрхтэй байна.

4.4. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.

4.5. Компанийн нийт хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрд өөрчлөгдөнө.

4.6. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласнаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.7. Шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

4.8. Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.

4.9. Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

4.10. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.

4.11. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах байдлаар нэмэгдүүлж хорогдуулж болно:

4.10.1. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
4.10.2. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл нэгтгэх;
4.10.3. хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.

## ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

5.2. Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1. хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

5.2.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах;

5.2.3. компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

5.2.4. нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;

5.2.5. хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах;

5.2.5.1. нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;

5.2.5.2. хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

5.2.5.3. хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

5.2.5.4. нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй;

5.2.6. энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;

5.2.7. компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;

5.2.8. энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;

5.2.9. энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;

5.2.10. компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон энэ дүрмийн 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

5.2.11. хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

5.3. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

5.3.1. хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

5.3.2. нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;

5.3.3. нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх;

5.4. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

5.5. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт заасан байна.

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ЗУРГАА.КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ ГАРГАХ ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

6.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болно.

6.2. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

6.3.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.4.Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

6.5.Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ тогтооно.

6.6. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

6.7. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.

6.8. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна[10].

6.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

6.10. Гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно.

6.11.Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

## ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх журам" болон Компанийн ТУЗ-өөс баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам[13]"-аар зохицуулна.

6648436 MonBeefLLC Мон Бийф ХХ компани УЛААНБААТАР ХОТ

7.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

7.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хурал даргалагчийг сонгоно.

7.6. Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй.

7.7. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ:

- 7.7.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
- 7.7.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
- 7.7.3. компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
- 7.7.4. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 7.7.5. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

7.8. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ:

- 7.8.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
- 7.8.2. компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
- 7.8.3. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;
- 7.8.4. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэх;
- 7.8.5. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 7.8.6. компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;
- 7.8.7. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

7.8.8. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.9. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

2022-06-17

7.10. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар дүрэмдээ засан бол энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

7.11. Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

7.12. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

7.13. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.

7.14. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.

7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн тус бүр нэг хувийг гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.

7.17. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

7.18. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

7.19. Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.

7.20. ТУЗ нь энэхүү дүрмийн 7.18-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.

MonBeef LLC
Мон Бийф ХХ компани
6648436
Улаанбаатар хот

СЭХ 2022 .06 сар 22 өдөр БҮРТГЭВ № 01

**Төлөөлөн удирдах зөвлөл**

7.21. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

7.22. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь энэ дүрмийн 7.25-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.

7.23. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь ... жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.

7.24. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжид эрхэмлэдэг этгээд байвал зохино.

7.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна:

7.25.1. дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

7.25.2. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй;

7.25.3. төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;

7.25.4. өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй;

7.25.5. компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

7.25.6. компани болон түүний хараат, охин компани, компанид нэгдэлд хамаарах компанийн нэгдэлд сүүлийн ... жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;

7.25.7. компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш.

7.26. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

7.27. Компанийн ТУЗ- гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах мэдээллийг үнэн зөвөөр тайлагнах үүрэгтэй:

7.27.1. нэр дэвшүүлсэн этгээдийг нэр;

7.27.2. нэр дэвшигчийн нас, боловсролын байдал, ажилласан туршлага болон

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК

Мон Бийф ХХК компани

СЭХ 2022.06.22
БҮРТГЭВ №01

бусад дэлгэрэнгүй мэдээлэл;

7.27.3. нэр дэвшигчийн сүүлийн 5 (тав) жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал;

7.27.4. нэр дэвшүүлэх үед түүний эрхэлж байгаа ажил, ажил тушаал, сонгуульт ажлууд;

7.27.5. нэр дэвшигч нь компанийн хоорондын харилцан хамаарал байгаа эсэх;

7.27.6. нэр дэвшигч нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэг хамааралтай эсэх;

7.27.7. компанийн томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэг хамааралтай

эсэх;

7.27.8. нэр дэвшигчийн орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

7.28. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалын хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ:

7.28.1. компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

7.28.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;

7.28.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;

7.28.4. хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;

7.28.5. өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.

7.29. ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно[22].

7.30. ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.

7.31. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

7.32. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.32.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;

7.32.2. компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;

MonBeef LLC Мон Бийф ХХ компани

СЭХ 2022.06.22 он сар өдөр БҮРТГЭВ № 01

7.32.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;

7.32.4. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

7.32.5. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах,

7.32.6. компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

7.32.7. компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

7.32.8. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

7.32.9. компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;

7.32.10. ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;

7.32.11. ТУЗ-ийн үйл ажиллагааны болон компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан бусад дотоод журмуудыг батлах;

7.32.12. зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах;

7.32.13. өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах;

7.32.14. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох;

7.32.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

7.32.16. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.32.17. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.32.18. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

7.32.19. гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах;

7.32.20. компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;

7.32.21. хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

7.33. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.

7.34. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

7.35. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын алба, хараат бус аудитын байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

7.36. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж, тэмдэглэл хөтөлнө. Мөн хурлын тухай зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичиг, гарах шийдвэрийн төслийг ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гишүүдэд хүргэнэ.

7.37. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хуралд оролцож байгаа хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана. ТУЗ-өөс тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-ийн дэргэдэх аль нэг Хороонд олгож болно.

7.38. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ний гишүүд санал нэгтэй гаргана.

7.39. Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

7.40. ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.

7.41. ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

7.42. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо түр томилно. Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 7.25-т заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжид дэвшүүлж болно.

7.43. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

7.44. ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.44.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах;

7.44.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийн

хэрэгжилтэд хяналт тавих;

7.44.3. хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцах ёстой;

7.44.4. ТУЗ-өөс олгосон бусад эрх хэмжээ.

7.45. ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

7.46. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын

Мон Бийф ХХ компани

СЗХ 2022.06.22 он сар өдөр БҮРТГЭВ № 01

хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.

2022-06-17 БҮРТГЭВ

**Аудитын хороо**

7.47. ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

7.48. ТУЗ-ийн аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байна:

7.48.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

7.48.2. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

7.48.3. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;

7.48.4. хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;

7.48.5. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

7.48.6. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

**Нэр дэвшүүлэх хороо**

7.49. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй:

7.49.1. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

7.49.2. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

7.49.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;

7.49.4 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.49.5.гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;

7.49.6.ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

7.49.7. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.50. ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй:

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

7.50.1. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;

7.50.2. жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх;

7.50.3. өмнө компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;

7.50.4. компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх;

7.51. Дор дурдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно:

7.51.1. эрх зүйн чадамжгүй;

7.51.2. урьд нь эдийн засаг, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн бөгөөд ялтай байх хугацаа нь дуусаагүй байгаа;

7.51.3. өмнө нь дампуурсан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан;

7.51.4. Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан хугацаа өнгөрөөгүй байгаа;

7.51.5. Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас 2 болон түүнээс дээш удаа захиргааны хариуцлага хүлээж байсан.

**Цалин урамшууллын хороо**

7.52. Цалин урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй:

7.52.1.эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

7.52.2. эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;

7.52.3. компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

7.52.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

7.53. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

7.54. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно:

7.54.1. компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;

7.54.2. бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;

СЗХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

7.54.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.54.4. компанийн ТУЗ нь гүйцэтгэх албаны хэлтэс газрууд үр дүнтэй мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;

7.54.5. мэдээллийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

7.54.6. хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, компани доторх маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах;

7.54.7. хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээд Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;

7.54.8. компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачилгыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

7.55. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.55.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;

7.55.2. компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

7.55.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;

7.55.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.56. Төрийн болон орон нутгийн өмчит болон давамгайлсан /50-аас дээш хувийн оролцоотой/ компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн энэ дүрмийн 7.55-д зааснаас гадна дараах нэмэлт эрх үүрэгтэй байна:

7.56.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа ажил үйлчилгээг худалдан авч байх талаар санал боловсруулах;

7.56.2. бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг дээр хуулиар тогтоосон зарчим, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн боловсруулсан саналын дагуу худалдан авч байгаа эсэхэд хяналт тавих;

**Гүйцэтгэх удирдлага**

7.57. Компанийн гүйцэтгэх удирдлага /цаашид “гүйцэтгэх захирал” гэх/ нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
Улаанбаатар хот

7.58. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.

7.59. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ.

7.60. ТУЗ компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийн төлөөлөн дарга гарын үсэг зурна.

7.61. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байх эсхүл өөр компанийн гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.

7.62. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. Үүнд:

7.62.1. компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

7.62.2. хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;

7.62.3. компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;

7.62.4. компанийн дотоод журмыг батална;

7.62.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;

7.62.6. компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;

7.62.7. компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;

7.62.8. компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

7.62.9. Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна.

7.62.10. компанийн түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан,ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;

7.62.11. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;

7.62.12. хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

7.62.13. компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.

СЗХ БҮРТГЭВ № 01

7.63. Компанийн ТУЗ нь гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь хэдийд ч чөлөөлөх эрхтэй. Түүнийг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

7.64. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.

## НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦЛАГА

8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

8.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

8.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гурав дахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

8.2.3. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

8.2.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

8.2.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

8.2.6. эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

8.3. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 8.2.2-т заасан үүргийг хүлээнэ.

8.4. Албан тушаалтан энэ дүрмийн 8.2 болон 8.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

8.4.1. компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

8.4.2. хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

8.4.3. эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

8.4.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

8.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид

СЗХ
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

2022-08-17

8.5. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## ЕС. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

**Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан**

9.1. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

9.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

9.3. Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.

9.4. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно:

9.4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг, эзэмшиж буй үнэт цаасан төрөл, тоо зэрэг мэдээллийг тусгана. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагатай гэрээ байгуулан хөтлүүлнэ;

9.4.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон хурлын шийдвэр, хуралд зориулан хувьцаа эзэмшигчдэд тараасан материал, хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлын талаар ирүүлсэн саналын бүртгэл. Хурал, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он,сар,өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

9.4.3.ТУЗ-ийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл;

9.4.4. компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтийн бүртгэл.

9.4.5. компанийн болон эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;

9.4.6. компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн бүртгэл;

9.4.7.төрийн эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлангийн бүртгэл;

9.4.8. хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн засаглалын, хөдөлмөрийн, цалин урамшууллын, хөдөлмөр хамгаалалын гэх мэт дотоод журам, заавын бүртгэл;

6648436 MonBeefLLC Мон Бийф ХХК Улаанбаатар

9.4.9. компанийн санхүүгийн тайланд болон ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр хийсэн аудитын шалгалтын тайлангийн бүртгэл;

9.4.10. компанийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн бүртгэл;

9.4.11. ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон бусад бүртгэл;

9.5. Энэхүү дүрмийн 9.4-т заасан бүртгэлтэй холбогдох үндсэн бичиг баримт болон дор заасан бичиг баримтыг хадгална:

9.5.1. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлүүд, лиценз;

9.5.2. компанийн өмчлөл болон эзэмшилд байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт;

9.5.3. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;

9.5.4. салбар төлөөлөгчийн газрын дүрэм;

9.5.5 гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр;

9.5.6. ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт;

9.6. Энэ дүрмийн 9.4 болон 9.5-д заасан бичиг баримтыг 5 жил хадгалаад архивд шилжүүлнэ. Харин компанийн дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг байнга хадгална.

9.7. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

9.8. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна.

9.8.1. баланс;

9.8.2. орлогын, үр дүнгийн тайлан;

9.8.3. мөнгөн гүйлгээний тайлан;

9.8.4. хуримтлагдсан ашгийн тайлан;

9.8.5. нэмэлт, тайлбар, тодруулга;

9.8.6. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

9.8.7. эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр;

9.8.8. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга.

9.9. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

9.10. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулна.

9.11. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хэлэлцүүлнэ.

9.12. Компани Монгол улсын аль нэгэн болон хэд хэдэн банканд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани нь гадаадын банканд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон Татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

9.13. Компанийн ТУЗ нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитын болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ:

9.13.1. компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт;

9.13.2. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн;

9.13.3. компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт.

9.14. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 9.13-т заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

## АРАВ. НОГДОЛ АШИГ

10.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.

10.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

10.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

10.3.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

10.3.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

10.3.3. компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

10.4. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэдээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.5. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

10.6. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

10.7. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

10.8. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.

10.9. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

## АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

**Дотоод хяналт**

11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

11.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

11.3. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

11.4. Дотоод хяналтын албаны ажилтнууд нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

11.5. Дор дурдсан этгээдийг дотоод хяналтын албанд ажиллуулахыг хориглоно:

11.5.1. эрх зүйн чадамжгүй;

11.5.2. урьд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан;

11.5.3. компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд эсвэл ямар нэг шалтгаанаар тэдний нөлөөнд автах боломжтой/ найз нөхрийн болон өмнө хамт ажиллаж байсан зэргээр холбоо харилцаатай/;

11.5.4. толгой компани болон хараат буюу салбар компанид ажилладаг;

11.5.5.өмнө нь авлигын хэрэгт шийтгэгдэж байсан.

11.6. Дотоод хяналтын албанаас хийх шалгалт нь ээлжит болон тусгай гэсэн хэлбэртэй байна. Ээлжит шалгалтын хуваарийг өмнөх жилийн 12 дугаар сард албаны дарга боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллана. Харин ТУЗ болон гүйцэтгэх захирлын даалгавраар, тэдний баталсан удирдамжийн дагуу тодорхой асуудлаар хийх шалгалтыг тусгай шалгалт гэнэ.

11.7. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээ авч байна.

**Аудиторын /хөндлөнгийн/ хяналт**

11.8. Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.

11.9. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

11.10. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

11.11. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитын хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.

11.12. Компанийн ТУЗ-ийн аудитын хороо аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх үүрэг, хариуцлага, аудитын үйлчилгээний хөлсний хэмжээг заана. Аудитын дүгнэлтийн шинж чанараас хамааруулан аудитын хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

11.13. Аудитын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

11.14. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

11.15. Эрх бүхий албан тушаалтан энэ дүрмийн 9.17-д заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай албан тушаалтан хариуцан төлнө. Энэ тухай шийдвэрийг аудитын компаниас ирүүлсэн албан ёсны хүсэлтийг үндэслэн ТУЗ гаргана. Харин дээрх шалтгаанаар аудиторын ажил зогссон тухайд аудитын компани ТУЗ-ийн аудитын хорооны даргад албан ёсоор мэдэгдсэн байна.

11.16. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

11.17. Дараах этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:

11.17.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

11.17.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

11.17.3. компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

11.18. Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг заавал тусгасан байна:

11.18.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

11.18.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрсэн бол зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлсон;

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

11.18.3. шалгалтын хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг КТХ-д заасан журмын дагуу хийсэн эсэх тухай дүгнэлт;

11.18.4. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл;

11.18.5. ТУЗ-ин аудитын хорооны саналаар аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлт;

## АРВАН ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

12.1. Компанийн үйл ажиллагаанд гарч болох компани түүний бизнесийн түншүүд /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч г.м/, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байх асуудал болно.

12.2. Аливаа зөрчил, маргаан үүссэн үед компанийн эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны удирдлагад танилцуулна.

12.3. Энэ дүрмийн 12.2-т заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.

12.4. Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцохгүй.

12.5. Компани нь Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална:

12.5.1. компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон аудитын хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;

12.5.2. хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;

12.5.3. хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид хохирол учруулсан бол эрх бүхий алан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

12.5.4. Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

## АРВАН ГУРАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

13.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

13.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

13.2.1. компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

13.2.2. хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн;

13.2.3. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр;

## АРВАН ДӨРӨВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

14.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

14.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 14.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

--ooOoo--

СЭХ
он 2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

# ГЭРЧИЛГЭЭ

CGDC CORPORATE GOVERNANCE DEVELOPMENT CENTER

БҮРТГЭВ-03

Дугаар 0131850

Ичинноров овогтой Батбуяа нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын богино хугацаат сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Т.ЦЭНД-АЮУШ

Компанийн Засаглалын Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх Захирал

2022 оны 02-р сарын 25 өдөр

МонБийф ХХК
Мон Бийф ХХ компани
Улаанбаатар хот

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

КЗҮЗ

# CERTIFICATE
# ГЭРЧИЛГЭЭ

МУЦАЭХ

Дугаар 0430861

Жанцанхорлоо ............ овогтой ............ Барсболд ............ нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Д.ГАНБАЯР
Компанийн засаглалын
Үндэсний зөвлөлийн дарга

Ц.ХУЯГ
Монголын үнэт цаасны
арилжаа эрхлэгчдийн холбоо
Гүйцэтгэх захирал

20*21* оны *11*-р сарын *11* өдөр

СЭХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

КЗУЗ

# CERTIFICATE
# ГЭРЧИЛГЭЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ХОЛБОО

Дугаар 0520481

........Цагаан........................ овогтой ........Оюунцэцэг.................... нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Д.ГАНБАЯР
Компанийн засаглалын
Үндэсний зөвлөлийн дарга

Г.НАНДИНЦЭЦЭГ
Захирал

201*6*. оны *12*. р сарын *04* өдөр

СЗХ
2022 .08р 22 өдөр
БҮРТГЭВ

БҮРТГЭВ

Мон Бийф ХХ компани
Mon Beef LLC
УЛААНБААТАР

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION OF MONGOLIA

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ХОЛБОО

# CERTIFICATE
# ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 0520513

Түмэнжаргал овогтой Солонго нь

Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтыг үндэслэн

"Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан

Компанийн засаглалын 36 цагийн сургалтанд хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Д.ГАНБАЯР
Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийн дарга

Г.НАНДИНЦЭЦЭГ
Захирал

201.7. оны 2. р сарын 5. өдөр

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

Мон Бизнес ХХ компани
Улаанбаатар

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000162477

2011.03.02
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011274085
/ Хувийн хэргийн дугаар /

5453283
/ Регистрийн дугаар /

Апекс капитал ҮЦК Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2011.02.21 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

4610 Худалдааны зуучлал
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6611 Брокер, дилерийн үйл ажиллагаа

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 1 | 1,350,000.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Цэнтрал тауэр, 9 давхар 903 тоот, Утас1: 99111561, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 5 сар 18 өдөр

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -06- 17

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Мөнхбаяр овогтой Амар-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2018.04.23 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2018.05.18 | О.Шижиртуяа |
| 1 | Буяндэлгэр овогтой Лхамдолгор -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2018.08.22 | Ч.Батдэлгэр |
| 2 | 6499 Андеррайтерийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2018.11.02 | Ж.Нямдорж |
| 6 | 66300 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2019.09.24 | С.Мөнхсанчир |
| 7 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2020.04.14 | Д.Чулуунтуяа |
| 8 | 64300 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.04.14 | Д.Чулуунтуяа |
| 9 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1700000 мян.төг-р нэмэгдэж нийт 3050000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2020.05.07 | О.Өлзийбат |
| 9 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.05.07 | О.Өлзийбат |
| 10 | Эцсийн өмчлөгч 1 нэмэгдэж 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.05.07 | О.Өлзийбат |
| 11 | 66110 Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.05.07 | О.Өлзийбат |
| 12 | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 4, Нью Хоризонс оффис, 901 тоот Утас1: 99111561, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.09.28 | Г.Сарнаа |

УЛСЫН БҮРТГЭГЧ

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0016247 7*

6648436 MonBeefLLC Мон Бийф ХХК УЛААНБААТАР ХОТ

5453283 УЛААНБААТАР ХОТ 1118265142

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/62

2011 оны 03 сарын 28 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 03 сарын 28 өдрийн 75 дугаар тогтоолоор

"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК -д

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА
"тамга"

Д.БАЯРСАЙХАН

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЗХ 2022.06.22 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

2022-06-17
БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/62 ТООТ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Брокер | 2011.03.28 | №75 тогтоол | |
| 2. | Дилер | 2011.03.28 | №75 тогтоол | |
| 3. | Андеррайтер | 2018.10.17 | №329 тогтоол | |
| 4. | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах | 2019.09.11 | №256 тогтоол | |
| 5. | Номинал дансаар дамжуулах | 2020.04.08 | №153 тогтоол | |
| 6. | Хөрөнгө оруулалтын зөвлөх | 2020.04.22 | №187 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

МонБийф ХХК
УЛААНБААТАР

СЗХ
2022 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-09-17
БҮРТГЭВ

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп 5, Аюуд тауэр, 702 тоот | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | | | 1,350,000,000 |
| 2. | 1,700,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2020.04.22 | №188 | 3,050,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, төрөл |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | О.Дамжин | | 1,350,000,000 | 100% | | |
| 1. | О.Дамжин | ОО72080875 | 1,550,000,000 | 50.82% | 2020.04.22 | №188 тушаал |
| 2. | О.Сайнжаргал | ХД68111714 | 1,500,000,000 | 49,18% | 2020.04.22 | №188 тушаал |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
5453283 УЛААНБААТАР ХОТ

MonBeef LLC
Мон Бийф ХХК компани
6648436 УЛААНБААТАР ХОТ

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

СЗХ 2022.08.22 БҮРТГЭВ №31

2022-08-17

Мон Бийф ХХК MonBeef LLC Улаанбаатар

СЭХ
2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛ УЛС

# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000238888

2011.04.15
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011286006
/ Хувийн хэргийн дугаар /

5469112
/ Регистрийн дугаар /

Таван богд капитал ҮЦК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2011.04.11 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 66120 | Брокерын үйл ажиллагаа эрхлэх /2011.06.30-/ |
|---|---|
| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 3 | 1,330,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Их эзэн Чингис хаанч нэрэмжит талбай - 16, Галлериа Улаанбаатар тэвийн 1 давхарт, Утас1: 72727282, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ О.ӨЛЗИЙБАТ
/тамга/ /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон 2021 он 09 сар 16 өдөр*

2022-06-17 БҮРТГЭВ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Гочоо овогтой Мөнхэрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.06.29 | Г.Санжаа |
| 2 | Дахин өөрчлөлт олгов. | 2021.09.16 | О.Өлзийбат |
| 3 | 66300 Үнэт цаасны дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.10.18 | Г.Санжаа |
| 4 | 64190 Мөнгөн хөрөнгийн орлого,зарлагын номинал данс эзэмших /-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>32110 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах,худалдан авахад зуучлах үйл ажиллагаа /-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.11.02 | Н.Энхцэцэг |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

СЗХ
20.. оны ..10.. сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/84

2011 оны 06 сарын 30 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 06 сарын 30 өдрийн 207 дугаар тогтоолоор **"ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК" ХХК** -д

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН
"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЗХ 2022.06.22 БҮРТГЭВ № 01

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

2022-06-17

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/84 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Брокер | 2011.06.30 | №207тогтоол | |
| 2. | Дилер | 2011.06.30 | №207 тогтоол | 2019.08.28 №250 тогтоол |
| 1. | Дилер | 2021.10.13 | №433 тогтоол | |
| 2. | Хөрөнгө оруулалтын зөвлөх | 2021.10.13 | №433 тогтоол | |
| 3. | Андеррайтер | 2021.10.13 | №433 тогтоол | |
| 1. | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах,худалдан авахад зуучлах | 2021.10.28 | №476 тогтоол | |
| 2. | Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал данс эзэмших | 2021.10.28 | №476 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК УЛААНБААТАР ХОТ 5453283

Мон Бийф ХХ компани Mon Beef LLC 6648436 УЛААНБААТАР ХОТ

"Зэт Жи Би ҮЦК" ХХК -ийн оноосон нэрийг "Таван Богд Капитал ҮЦК" ХХК болгон өөрчлөхийг зөвшө
2021.06.28 №158 тушаал

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Түшиг оффис төвийн байр, 408 тоот. | | |
| 2. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа-Улаанбаатар худалдаа үйлчилгээний төв, 1 давхарт | 72727282 | 2021.08.02 №5/2629 албан тоот |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2011.06.30 | №207 | 51,000,000 |
| 2. | 50,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.05.28 | №136 | 101,000,000 |
| 3. | 1,229,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2021.09.14 | №239 | 1,330,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

эөв.

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Г.Болормаа | ХГ69102564 | 51,000,000 | 100% | 2011.06.30 | №207 тогтоол |
| 2. | Г.Болормаа | ХГ69102564 | 101,000,000 | 100% | 2021.05.28 | №136 тушаал |
| 1. | Ж.Барсболд | СЮ76100216 | 101,000,000 | 100% | 2021.06.28 | №158 тушаал |
| 1. | Ж.Барсболд | СЮ76100216 | 66,500,000 | 5% | 2021.09.14 | №239 тушаал |
| 2. | "Таванбогд трейд" ХХК | 2543303 | 1,130,500,000 | 85% | 2021.09.14 | №239 тушаал |
| 3. | Г.Мөнх-Эрдэнэ | УМ90082417 | 133,000,000 | 10% | 2021.09.14 | №239 тушаал |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

СЗХ
20?? он ?? сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 тоот тушаалаар батлав

МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000157255

2007.03.21
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011085084
/ Хувийн хэргийн дугаар /

2866641
/ Регистрийн дугаар /

Итгэлт-Эстимэйт Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2005.01.07 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6820 Хөрөнгийн үнэлгээ / 2017.01.11-2020.01.11 /
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

8299 Бизнес зөвлөгөө
6629 Даатгалын хохирол үнэлгчийн үйл ажиллагаа

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 2 | 10,000.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянзүрх, 26-р хороо, хүнну, Олимп плаза 401 тоот, Утас1: 99995638, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 2 сар 5 өдөр

СЭХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Эрдэнэбаяр овогтой Ганчимэг-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2018.02.05 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин эрчилгээ олгов. | 2018.02.05 | Э.Эрдэнэбилэг |
| 3 | 6820 Хөрөнгийн үнэлгээ / 2017.01.11-2020.01.11 / үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 68200 Хөрөнгийн үнэлгээ /2017.07.18-2020.07.18/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.02.03 | Г.Санжаа |
| 4 | 68200 Хөрөнгийн үнэлгээ үйл ажиллагааны чиглэлийн хугацааг 2020.06.26-2023.06.26 болгож сунгав. | 2020.09.25 | Б.Алтансүх |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
0 0 0 1 5 7 2 5 5
Мон Бийф ХХК компани УЛААНБААТАР

СЭХ
2022 оны 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Эрдэнэбаяр овогтой Ганчимэг-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2018.02.05 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин эрчилээ олгов. | 2018.02.05 | Э.Эрдэнэбилэг |
| 3 | 6820 Хөрөнгийн үнэлгээ / 2017.01.11-2020.01.11 / үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 68200 Хөрөнгийн үнэлгээ /2017.07.18-2020.07.18/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.02.03 | Г.Санжаа |
| 4 | 68200 Хөрөнгийн үнэлгээ үйл ажиллагааны чиглэлийн хугацааг 2020.06.26-2023.06.26 болгож сунгав. | 2020.09.25 | Б.Алтансүх |

Мон Бийф ХХ компани
MonBeefLLC
6648436
УЛААНБААТАР

*0001 57255*

СЗХ
2022 оны 08 сарын 22 өдөр
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-17

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр
тушаалын 3 дугаар хавсралт

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар *071200075*

Иргэний ургийн овог: *Боржгон*

Иргэний овог,нэр: *Гунгаадаш овогтой Оюунчимэг*

Иргэний үнэмлэхний дугаар: *УБ1158834*

Иргэний бүртгэлийн дугаар: *ЗЛ:64111901*

Үнэлгээчний гэрчилгээний дугаар: ........

Иргэний хаяг: *УБ Чингэлтэй, 16-р хороо согоот 27-353 тоот*

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: *Сангийн сайдын 2010/12/20-ны өдрийн 280 тоот тушаал*

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ........ / **С.БАЯРЦОГТ** /

УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ... ХХК

СЭХ
2022 .08.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2013. оны 286 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2013. оны 12..-р сарын 20..-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.УЛААН /

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.17. оны .7.... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.17. оны .1..-р сарын 11..-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Б.ЧОЙЖИЛСҮРЭН

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2019.... оны 262.... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.19 оны .12-р сарын 17..-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР/

0000013

2022-06-17
БҮРТГЭВ-03

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
6648436
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2022 сар 06 . 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2017.. оны 250 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2017.. оны .07.-р сарын 18...-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.ЧОЙЖИЛСҮРЭН /

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 20.. оны 130 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..20 оны 06-р сарын 26-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

0000226

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

MonBeefLLC
УЛААНБААТАР
МонБийф

СЗХ
2022 оны 06 сарын 22 өдөр
БҮРТГЭВ

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MICA
Mongolian Institute of Certified Appraisers

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН
ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТ

# ГЭРЧИЛГЭЭ

№ 14/27

Эрдэнэбаяр овогтой Ганбаатар нь

Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдэд зориулсан "Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт" сэдэвт 34 цагийн сургалтад хамрагдаж төгссөн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

Сургалтад хамрагдсан сэдвүүд:

- Санхүүгийн зах зээлийн зохицуулалт
- Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт
- Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын асуудлууд
- Бизнесийн үнэлгээний асуудлууд

СЗХорооны ажлын албаны дарга

Х.Бум-Эрдэнэ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.Үхэртар

Улаанбаатар хот
2014 оны 12 сарын 17 өдөр

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MICA
Mongolian Institute of Certified Appraisers
МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТ

# ГЭРЧИЛГЭЭ

№ 2019036

**Эрдэнэбаяр овогтой Ганбаатар нь**

Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээчдэд зориулсан

*"Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт"*

сэдэвт 30 цагийн сургалтад хамрагдаж амжилттай төгссөн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

| САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА | МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ |
|---|---|
| Б.АРИУНГАА | Б.ЭНХБОЛД |

Улаанбаатар хот

2019 оны 11 дүгээр сарын 04 өдөр

Мон Бийф ХХК компани MonBeefLLC 6648436

ҮХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ

2022 -06- 17
БҮРТГЭВ-03

АНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр
тушаалын 3 дугаар хавсралт

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар *140600038*

Иргэний ургийн овог: *Батаагийнхан*

Иргэний овог,нэр: *Эрдэнэбаяр овогтой Ганбаатар*

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: *УХ 88103012*

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: *УБ, Баянзүрх, 18-хороо,13-р хороолол, 10 байр, 62 тоот*

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: *Сангийн сайдын 2014 оны 06-р сарын 23-ны өдрийн 139 дүгээр тушаал*

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ........................ / Ч.УЛААН /

**УЛААНБААТАР ХОТ**

6648436 MonBeefLLC УЛААНБААТАР

2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

2022-06-17
БҮРТГЭВ-03

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000178048

2018.09.21
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9022003026
/ Хувийн хэргийн дугаар /

6351034
/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн хаан лекс партнерс ХХН — Нөхөрлөл /ХХН/
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2018.09.18 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6910 — Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
/ код / — / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 3 | 200.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянгол, 6-р хороо, 10-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, к103, 1 тоот, Утас1: 99001070, Утас2: 89099106, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2019 он 1 сар 23 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Идэрхангай овогтой Учралбаяр-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.* | *2018.09.21* | *Д.Гангамөрөн* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2019.01.23* | *В.Хандсүрэн* |
| 3 | *Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимпийн, 5 аюуд тауэр, 14 давхар 1404 тоот Утас1: 99001070, Утас2: 89099106, Факс: хаягийг шинээр бүртгэв.* | *2021.02.10* | *Л.Бархасбадь* |
| 4 | *Эцсийн өмчлөгч 3 иргэн бүртгэв.* | *2021.02.10* | *Л.Бархасбадь* |

Гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

* 0 0 0 1 7 8 0 4 8 *

СЭХ
он 2022 сар 06, 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО**

# *ГЭРЧИЛГЭЭ*

**БҮРТГЭЛИЙН ДУГААР: 203**

**ӨМГӨӨЛЛИЙН "ХААНЛЕКС ПАРТНЕРС" ХХН**

*Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журмын 8.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Өмгөөллийн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж НОТЛОМЖ олгов.*

MONGOLIAN BAR ASSOCIATION

**ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА** **Ц.ГАНБОЛД**

**УЛААНБААТАР ХОТ**

2019.05.16

СЗХ
он 2022 сар 06, 22 өдөр
БҮРТГЭВ
№ ...

2022-06-17
БҮРТГЭВ

# МОНГОЛ УЛС
# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
# ТОГТООЛ

2020 оны 06 сарын 10 өдөр Дугаар 338 Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид
хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн
этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, 63 дугаар зүйлийн 63.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өмгөөллийн хаан лекс партнерс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Өмгөөллийн хаан лекс партнерс" ХХН /И.Учралбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

ТУ32072 9020030255 5043239

MonBeefLLC
Мон Бийф ХХК
УЛААНБААТАР
6648436

СЭХ
он сар өдөр
2022.06.22
№ 01

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000098400

2012.11.30
/ Бүртгэсэн он сар өдөр /

9022001140
/ Улсын бүртгэлийн дугаар /

5653576
/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн Эм Жэи Эл атторнейс ХХН — Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
/ Хуулийн этгээдийн нэр хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2012.11.29 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6910 — Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 2 | 200.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / хувьцааны тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, самбуугийн, Глобал бизнес центр, 405 , Утас1: 70129556, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн оршин буй хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2015 он 4 сар 13 өдөр

СЗХ
2022 06. 22
БҮРТГЭВ
№ 01

## Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| Голомт банк | Валютын | 1170010796 | Э.Ганцэцэг |
| Голомт банк | Төгрөгийн | 1170003358 | Н.Энхбат |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Мөнхбат овогтой Мөнхжаргал-г Захирал-р томилсныг бүртгэв | 2012.11.30 | Н.Энхбат |
| 2 | Дахин гэрчилгээ олгов | 2015.04.13 | Э.Ганцэцэг |
| 2 | Хувь нийлүүлэгчээс 2 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2016.05.23 | М.Монголжин |
| 3 | Хувь нийлүүлэгчээс 0 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2017.06.08 | О.Шижиртуяа |
| 4 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2017.11.17 | Б.Гэрэлзул |
| 5 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 0 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2017.12.21 | Б.Гэрэлзул |
| 6 | Хувьцаа эзэмшигч 1хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.04.24 | М.Монголжин |
| 7 | Эцсийн өмчлөгч 4 ирсэн бүртгэв. | 2020.04.24 | М.Монголжин |
| 8 | Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, самбуугийн, 13/2 байр, Глобал бизнес центр, 503 тоот Утас1: 70129556, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.10.15 | Н.Долгоржав |
| 9 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 5 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.10.15 | Н.Долгоржав |
| 10 | [illegible] бүртгэв. | 2021.10.15 | Н.Долгоржав |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0000098400*

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 34

2022-06-17

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр Дугаар 429 Улаанбаатар хот

"Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс" ХХН /М.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА Д.БАТБОЛД

001172
МонБийф ХХК
MonBeef LLC
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MICA
Mongolian Institute of Certified Appraisers

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТ

# ГЭРЧИЛГЭЭ

№. 15/35

**Мөнхбат** овогтой **Мөнхжаргал** нь

**Үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдэд зориулсан "Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт" сэдэвт 34 цагийн сургалтад хамрагдаж төгссөн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.**

Сургалтад хамрагдсан сэдвүүд:

- Санхүүгийн зах зээлийн зохицуулалт
- Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт
- Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын асуудлууд
- Бизнесийн үнэлгээний асуудлууд

СЗХорооны ажлын албаны дарга

Б.Батсэлэнгэ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.Үхэртар

УЛААНБААТАР ХОТ

Улаанбаатар хот

2015 оны 11 сарын 18 өдөр

MonBeefLLC

СЗХ
2022 оны 06 сарын 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

MICA
Mongolian Institute of Certified Appraisers
МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТ

# ГЭРЧИЛГЭЭ

№ 17025

**Отгонбаяр** овогтой **Мөнхболд** нь

Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуульчдад зориулсан

*"Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалт"*

сэдэвт 32 цагийн сургалтад хамрагдаж амжилттай төгссөн тул ГЭРЧИЛГЭЭ олгов.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ҮНЭЛГЭЭЧДИЙН ИНСТИТУТИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БАЯРЖАРГАЛ

Улаанбаатар хот

2017 оны 06 дугаар сарын 12 өдөр

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

# ГЭРЧИЛГЭЭ

БҮРТГЭЛИЙН ДУГААР: 047

## ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ЖЭЙ ЭЛ АТТОРНЕЙС" ХХН

*Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5, Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журмын 8.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Өмгөөллийн хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж НӨТЛӨМЖ олгов.*

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ЦАГАНБОЛД

MONGOLIAN BAR ASSOCIATION

УЛААНБААТАР ХОТ

2015.10.01

УБ СЭХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Монгол Улсын Засгийн газрын
2022-06-17
БҮРТГЭВ
Зөвлөөрөв ЦЕГ 01

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2006.03.20
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9018001042
/Улсын бүртгэлийн дугаар/

5050286
/Регистрийн дугаар/

Эс Жи Эм Ди Аудит ХХК - Аудит
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

| Тушаал | 266 | 2009.11.30 |
|---|---|---|
| /шийдвэрийн нэр/ | /дугаар/ | он, сар, өдөр |

741200 /код/ — Аудитын үйл ажиллагаа
/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

749900 — Бизнесийн зөвлөгөө өгөх

/код/ /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

| 3 | 3 | 1.000,0 |
|---|---|---|
| хугацаа | /гишүүдийн тоо/ | /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/ |

Баянгол, 1-р хороо, Хатан баатар Магсаржавын гудамж, 3А - 11, утас1:99188451, утас2:, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/бүртгэсэн байгууллагын нэр/

Гэрчилгээг дахин олгосон: 2010 он 01 сар 05 өдөр УХА0463

Мон Бэйф ХХК компани

СЭХ
2022 ,06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17

### Харилцах банкны бүртгэл:

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн | |
|---|---|---|---|---|
| | | | Огноо | Ажилтан, тэмдэг |
| Худалдаа хөгжлийн банк | Төгрөгийн | 404138566 | 2006.03.20 | Г.Мягмар |
| Худалдаа хөгжлийн банк | Валютын | 404138577 | 2006.03.20 | Г.Мягмар |

### Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тэмдэг |
| | Энэ хуулийн этгээдэд 2006.03.20 өдөр олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, гэрчилгээг дахин олгосон болно. | 2010.01.05 | Б.Аюурмэд |
| 2 | Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, , оюутны, 14/2и, 9 тоот, Утас1 70006948, Утас2 , Факс хаягийг шинээр бүртгэв. | 2014.09.22 | У.Даваасүрэн |
| 3 | Хувь нийлүүлэгчээс 0 нэмэгдэж, 2 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2014.09.22 | У.Даваасүрэн |
| 4 | 'Салбар 1' Өмнөговь, Даланзадгад, 1-р баг, Баруунсайхан, , 12, , 12 байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2014.09.22 | У.Даваасүрэн |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК

Мон Бийф ХХ компани

СЭХ
2022 оны 06 сарын 22 өдөр
БҮРТГЭЭ №

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр
тушаалын 4 дүгээр хавсралт

## АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 078-2009

Аж ахуйн нэгжийн нэр: "Эс Жи Эм Ди Аудит" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 5050286

Аж ахуйн нэгжийн хаяг: СБД, 6-р хороо, 15-р байр, 01 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2009.11.30-ны өдрийн 266 дугаар тушаал

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ................ / С.БАЯРЦОГТ /

УЛААНБААТАР ХОТ

2022-06-
БҮРТГЭЭ

6648430 Мон Бийф ХХ компани УЛААНБААТАР

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2012 оны 227 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2012 оны 11-р сарын 30-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.УЛААН /

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2015 оны 310 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2015 оны 11-р сарын 30-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.БОЛОР /

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2018 оны 278 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2018 оны 11-р сарын 29-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

СЭХ 2022.06 сар 22 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

0000011

СЗХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 13 өдөр | Дугаар 278 | Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.2 дахь заалт, Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хуульд заасан шаардлагыг хангасан "Эс Жи Эм Ди Аудит" ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн, "Аккурэйт финанс Аудит" ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2018 оны 11 сарын 13-ний өдрөөс эхлэн, "БДО Аудит" ХХК-ийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2018 оны 12 дугаар сарын 26-ний өдрөөс эхлэн тус тус 3 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь сунгагдсан компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т даалгасугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

MonBeefLLC
Мон Бийф ХХК компани
УЛААНБААТАР
6648436

СЗХ
2022.06.22 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# МОНГОЛ УЛСЫН
# САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 25 өдөр | Дугаар 209 | Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа
сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.4.2, Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх дараах хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Сунгах хугацаа |
|---|---|---|
| 1 | "Аккурэйт финанс Аудит" ХХК | 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс |
| 2 | "Баян сагсай Аудит" ХХК | 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс |
| 3 | "Есөнхангай Аудит" ХХК | 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс |
| 4 | "Эс Жи Эм Ди Аудит" ХХК | 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс |

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь сунгагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

Б.ЖАВХЛАН

9767001336

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
6648436
Улаанбаатар хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2021.12.13 № 9/4322

танай ________ -ны № ________ -т

"ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ" ХХК

Хороонд танай компанийн 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1/110 тоот бичгээр ирүүлсэн Үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр шинэчлэн бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлтэй танилцлаа.

Танай компани нь Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.7-д заасан үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх компанийн нөхцөл шаардлагыг хангасан байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЗОЛГОРСҮРЭН

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ №

2022-06-

151630001734

Мон Бийф ХХ компани MonBeefLLC 6648436 УЛААНБААТАР

СЗХ
он 2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

MJL attorneys
Монгол Улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Глобал бизнес центр, 503 тоот
И-мэйл: info@mjlattorneys.mn
Утас: (976)7012-9665

KhanLexPartners
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Олимпын гудамж-5, Аюуд Тауэр;
И-мэйл: info@khanlex.mn
Утас: (976)7747-1122

"МОНБИЙФ" ХХК-ИАС НИЙТЭД АНХ УДАА САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААТАЙ ХОЛБООТОЙ

# ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

**БЭЛТГЭСЭН:**

ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ЖЭЙ ЭЛ АТТОРНЕЙС" ХХН

ӨМГӨӨЛЛИЙН "ХААНЛЕКС ПАРТНЕРС" ХХН

**ХАЯГ:**

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 4-Р ХОРОО, ГЛОБАЛ БИЗНЕС ЦЕНТР, 503 ТООТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СҮХБААТАР ДҮҮРЭГ, ОЛИМПЫН ГУДАМЖ 5, АЮУД ТАУЭР, 1404 ТООТ

**УТАС/ФАКС**:

(976) 7012-9665

(976) 7747-1122

MonBeef LLC
Мон Бийф ХХ Компани
Улаанбаатар хот
6648436

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -06- 17
БҮРТГЭВ-03

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ....1

**1.1 Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл**....1

**1.2 Ажлын даалгавар, хамрах хүрээ**....1

**1.3 Дүгнэлт хийсэн арга, аргачлал**....2

**1.4 Хуулийн фирмийн үнэт цаас гаргагчтай сонирхлын зөрчилгүй болох тухай мэдэгдэл**....2

**1.5 Хангагдсанд тооцох нөхцөл**....2

**1.6 Хариуцлага хязгаарлах тухай мэдэгдэл**....3

**1.7 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг, хууль тогтоомж**....4

2. НЭР ТОМЬЁО БА ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР....6

3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ....7

**3.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаар**....7

**3.2. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-д заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын тухай**....10

**3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж буй эсэх талаар**....12

**3.4. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх тухай дүгнэлт**....31

**3.5. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаар**....40

**3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх тухай**....45

**3.7. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх тухай**....46

**3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх тухай**....49



MonBeef LLC
Мон Бийф ХХ компани
Улаанбаатар

СЭХ
2022 08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 21

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -08- 17

**3.9. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох нь**...50

**3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай**...53

**3.11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх тухай**...54

ХАВСРАЛТ № 1 - КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ...56

ХАВСРАЛТ № 2 - "МОН БИЙФ" ХХК-ААС ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ НЬ ҮНЭН ЗӨВ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ, ДҮГНЭЛТ...68

ХАВСРАЛТ № 3 -ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР ТӨРИЙН БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГААС АВСАН ЛАВЛАГАА, БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ...124

ХАВСРАЛТ №4 - ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙГООР "МОН БИЙФ" ХХК-ИАС ХҮЛЭЭН АВСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ...126



MonBeefLLC
Мон Бийф ХХ компани
6648436
УЛААНБААТАР

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

# 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

## 1.1 Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН болон Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН (цаашид хамтад нь "**Бид**" эсхүл "**Хуулийн фирм**") нар нь "Мон Бийф" ХХК (цаашид "**Үнэт цаас гаргагч**" эсхүл "Компани" гэх)-тай 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 540 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (цаашид "**Гэрээ**" гэх)-ний дагуу Үнэт цаас гаргагч анх удаа олон нийтэд хувьцаа санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "**СЗХ**" гэх)-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11.1 дэх хэсэгт, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.6 дахь хэсэгт заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хууль зүйн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухай энэхүү хуулийн дүгнэлтийг (цаашид "**Дүгнэлт**" гэх) бэлтгэн хүргүүлж байна.

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН нь 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн СЗХ-ны 429 тоот тогтоолын дагуу, Өмгөөллийн "ХаанЛекс Партнерс" ХХН нь СЗХ-ны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн СЗХ-ны 338 тоот тогтоолын дагуу тус тус үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх этгээдээр бүртгэгдсэн болно.

## 1.2 Ажлын даалгавар, хамрах хүрээ

Үнэт цаас гаргагчтай байгуулсан Гэрээний дагуу СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйл болон МХБ-ийн журмын 2.6 дахь хэсэгт тус тус заасанчлан дараах агуулгын хүрээнд энэхүү Дүгнэлтийг бэлтгэсэн болно. Үүнд:

1.2.1 Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;

1.2.2 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл;

1.2.3 Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;

1.2.4 Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

1.2.5 Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

1.2.6 Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах,

Мон Бийф ХХ компани

цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

1.2.7 Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;

1.2.8 Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

1.2.9 Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;

1.2.10 Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;

1.2.11 Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх;

**1.3 Дүгнэлт хийсэн арга, аргачлал**

Хуулийн фирмийн зүгээс энэхүү Дүгнэлтийг Үнэт цаас гаргагчтай Гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн болно.

Дүгнэлтийг бэлтгэхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд ашиглах эх сурвалжийг сонгохдоо хавсралт № 3 болон № 4-т дурдсан Үнэт цаас гаргагчийн зүгээс Бидэнд ирүүлсэн албан ёсоор баталгаажсан баримт болон гуравдагч этгээдээс олгож тодорхойлсон лавлагаа, тодорхойлолт, баримт бичгийг удирдлага болгож ажилласан.

Түүнчлэн, хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо үгийн хэл зүйн шууд утгаар болон Монгол Улсын дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, Иргэний хуулийн тайлбарт тусгагдсаны дагуу ойлгосон бөгөөд утгыг тодорхойлох боломжгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухааны түгээмэл тогтоосон зарчим, онолын дагуу агуулгыг ойлгож Дүгнэлт бэлтгэсэн болно.

**1.4 Хуулийн фирмийн үнэт цаас гаргагчтай сонирхлын зөрчилгүй болох тухай мэдэгдэл**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас нийтэд анх удаа санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд оролцож буй Үнэт цаас гаргагч, андеррайтерийн компани болох "Апекс ҮЦК" ХХК, дэд андеррайтер "Таван Богд Капитал ҮЦК" ХХК, үнэлгээний компани болох "Итгэлт Эстимэйт" ХХК, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй бөгөөд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх болохоо 2022 оны 05 дугаар сарын 17-ний өдөр у/22/237 тоот албан бичгээр мэдэгдсэн болно.

**1.5 Хангагдсанд тооцох нөхцөл**

Бид энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа дараах нөхцөлүүдийг хангагдсанд тооцсон болно. Үүнд:

СЗХ
2022.06.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

1.5.1 Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээдүүд, бусад эрх бүхий байгууллага болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн баримт, мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр.

1.5.2 Баримт бичгүүд (энэхүү Дүгнэлтийн хавсралт №4-т тодорхойлсон) дэх огноо, гарын үсэг, тамга, тэмдэг нь үнэн зөв, хүчин төгөлдөр, тийнхүү гарын үсэг зурах, батлах бүрэн эрх олгогдсон;

1.5.3 Баримт бичгийн хуулбарыг хүлээн авсан бол тэр нь эх хувийн үнэн зөв, бүрэн хуулбар мөн;

1.5.4 Хэрвээ Бид Баримт бичгийн төслийг хүлээн авсан бол уг баримт бичиг нь тус төслийн дагуу үйлдэгдэнэ;

1.5.5 Бидэнд ирүүлсэн Баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт ороогүй, эсхүл тэдгээр нь хүчингүй болоогүй;

1.5.6 Үнэт цаас гаргагч болон бусад оролцогч талууд нь Баримт бичгийг үйлдэх бүрэн эрхтэй бөгөөд түүнийг зохих журмын дагуу үйлдсэн буюу байгуулсан ба түүгээр хүлээсэн үүргээ биелүүлнэ;

1.5.7 Аливаа этгээд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээрээ төөрөгдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаанд оролцоогүй. Аливаа этгээд нь энэхүү тайлангийн аливаа хэсгийг буруу болгох ямарваа үйл ажиллагаанд оролцоогүй буюу оролцохгүй;

1.5.8 Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан болон хавсаргагдсан андеррайтер, аудитор болон мэргэжлийн бусад оролцогчдын гаргасан судалгаа, дүгнэлт, тайлан, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;

1.5.9 Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үйл баримт, мэдээлэл нь ирээдүйд хэрэгжих тохиолдолд тус үйл баримт, мэдээлэл нь хуулийн дагуу зохих ёсоор биелэгдэнэ.

## 1.6 Хариуцлага хязгаарлах тухай мэдэгдэл

Энэхүү Дүгнэлтэд дор дурдсан хязгаарлалт хамаарна. Үүнд:

Дүгнэлтийг зөвхөн энд дурдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь Хуулийн фирмээс зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Бид Дүгнэлт бэлтгэх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд энэхүү Дүгнэлтийг бэлтгэсэн бөгөөд Хуулийн фирм нь бусад аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд аливаа үйл явдлын талаар саналаа илэрхийлэхгүй болно.

Дүгнэлтийг энд дурдсан хүрээ хязгаарын дотор зөвхөн хууль зүйн асуудлаар бэлтгэсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зах зээлийн мэдээ, бизнес, эдийн засаг, санхүү, технологи гэх мэт хуульчаас өөр тусгай мэргэжил, мэргэшил шаардагдах асуудлаар дүгнэлт гаргах эрхгүй буюу хариуцлага хүлээхгүй болно.

Эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн бэлтгэсэн Дүгнэлтийн хамаарах хугацаа нь лавлагаа, тодорхойлолтын огноогоор хязгаарлагдана. Тухайн лавлагаа, тодорхойлолтын огнооноос хойших үйл явдалд Хуулийн фирм нь



Мон Бийф ХХК компани
Mon Beef LLC
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

Дүгнэлт хийгээгүй бөгөөд түүнд Хуулийн фирмийн зүгээс ямар нэгэн баталгаа гаргахгүй болно.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд анх удаа санал болгон худалдах гэж байгаатай холбогдуулан гаргасан энэхүү Дүгнэлтийг СЗХ болон МХБ-д хүргүүлж зохих зөвшөөрлийг авсан өдрөөс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон зэрэг бусад үйл ажиллагаатай холбогдуулан Бид нэмэлт хууль зүйн Дүгнэлт гаргах үүрэг хүлээхгүй болно.

Дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт тусгагдсан мэдээлэлд Дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хууль тогтоомжоор МХБ, СЗХ зэрэг төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамааруулсан болон эдгээр байгууллагаас зохих зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийж, Дүгнэлт гаргаагүй болно.

Дүгнэлт гаргах явцад Үнэт цаас гаргагч болон бусад холбогдох этгээд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, худал мэдээлсэн зэрэг нөхцөлд үүсэх үр дагаврыг Хуулийн фирм хариуцахгүй.

***Жич: Энэхүү Дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.***

### 1.7 Дүгнэлт гаргахад ашигласан баримт бичиг, хууль тогтоомж

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн дараах баримт бичиг, мэдээлэл (цаашид "Баримт бичиг" гэх)-д үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

Энэ Дүгнэлтийг гаргахтай холбоотойгоор төрийн холбогдох байгууллагаас авсан бөгөөд тус Дүгнэлтийн Хавсралт №3-д жагсаасан лавлагаа, тодорхойлолтууд;

Хуулийн фирмийн хүсэлтийн дагуу Компаниас гаргаж өгсөн, энэ Дүгнэлтийн Хавсралт № 4-д жагсаасан баримт бичгүүд.

Дүгнэлтийг дараах Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан болно. Үүнд:

#### *1.7.1 <u>Судалсан хууль тогтоомжууд:</u>*

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 он;
- Компанийн тухай хууль, 2011 он;
- Иргэний хууль, 2002 он;
- Зохиогчийн эрхийн тухай хууль, 2021 он;
- Оюуны өмчийн тухай хууль, 2020 он;
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, 2009 он
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, 2015 он;
- Газрын тухай хууль, 2002 он;

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018 он;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001 он;
- Зээлийн мэдээллийн тухай хууль, 2011 он;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021 он;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, 2003 он;
- Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, 2017 он;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015 он;
- Байгууллагын нууцын тухай хууль, 1995 он;
- Эрүүл ахуйн тухай хууль, 2016 он;
- Хөдөлмөрийн аюулгүй байдаль, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2002 он;
- Бусад хууль тогтоомж.

### *1.7.2 <u>Судалсан дүрэм журмууд:</u>*

- СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам, 2021 он;
- МХБ-ээс Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам, 2018 он;
- СЗХ-ны баталсан "Компанийн засаглалын кодекс", 2022 он;
- Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн А/07 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан "Оюуны өмчийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн санг үүсгэх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журам;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам", 2021 он;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам", 2021 он;
- MNS 4969: 2000 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалт зохион байгуулалт. Үндсэн дүрэм", 2000 он;
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам", 2017 он;
- Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам", 2013 он;
- Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", 2020 он.

СЗХ
2022.08.22 өдөр
БҮРТГЭВ
№01

2022-08-17

## 2. НЭР ТОМЬЁО БА ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Дүгнэлтэд хаалтад тодорхойлсноос гадна дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

**"Компанийн дүрэм"** гэж Компанийн хувьцаа эзэмшигчийн 2022 оны 5 дугаар сарын 02-ний өдрийн 40/12 тоот шийдвэрийн хавсралтаар батлагдсан Компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг;

"**Компанийн засаглалын кодекс**" гэж СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийг;

"**МХБ**" гэж "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг;

"**СЗХ**" гэж Санхүүгийн зохицуулах хороог;

"**Тасалбар болгосон өдөр**" гэж 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг;

"**ТУЗ**" гэж Төлөөлөн удирдах зөвлөлийг;

"**УБЕГ**" гэж Улсын бүртгэлийн ерөнхий газрыг;

"**ХАБЭА**" гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг;

"**ХК**" гэж хувьцаат компанийг;

"**ХХК**" гэж хязгаарлагдмал хариуцлагатай компанийг;

"**ХХН**" гэж хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг;

"**ХЭУБГ**" гэж УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрыг;

"**ХЭХ**" гэж хувьцаа эзэмшигчдийн хурлыг.



6648436 MonBeefLLC УЛААНБААТАР
Мон Бийф ХХК компани

СЗХ
2022 оны 06 сарын 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -06- 17

## 3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

### 3.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаар

#### 3.1.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх тухай

**3.1.1.1. Компанийг үүсгэн байгуулсан талаар:**

Компани нь Монгол Улсын Иргэний хуулийн 25.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд болохынхоо хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар улсын бүртгэлд бүртгүүлснээр эрх зүйн чадвар үүснэ.

Үнэт цаас гаргагч (улсын бүртгэлийн дугаар: 9011823614, регистрийн дугаар: 6648436) нь 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн үүсгэн байгуулагчийн 01 тоот тогтоолын дагуу "Ти Би Жи Эстэйтс" ХХК гэх нэрээр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд зохих ёсоор бүртгэгдсэн байна. Тус тогтоолоор Үнэт цаас гаргагч нь 10,000,000 (арван сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үүсгэн байгуулагдаж, 100 хувийн хувьцаа эзэмшигч нь Ц.Баатарсайхан байсан бөгөөд гүйцэтгэх захирлаар Ринчинсамбуу овогтой Баттулгыг томилж байсан байх ба хувьцаа эзэмшигчийн хурлын 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 40/2 тоот шийдвэрээр Компанийн оноосон нэрийг "Мон Бийф" ХХК болгон өөрчилсөн байна.

Үнэт цаас гаргагч нь хуульд заасны дагуу зохих ёсоор үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн болох нь Үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг (үүсгэн байгуулах шийдвэр, дүрэм)-үүд, ХЭУБГ-аас 000222836 тоот гэрчилгээ, ХЭУБГ-аас ирүүлсэн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 22260002002026 тоот дугаартай дэлгэрэнгүй лавлагаагаар тус тус тогтоогдож байна.

**3.1.1.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа:**

Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдэн, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн дүрэм болон ХЭУБГ-ын 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 22260002002026 дугаар бүхий лавлагаанд тусгагдсанаар ***Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн*** **үнэ бүхий 150,000,000 (нэг зуун тавин сая) ширхэг хувьцаа гаргасан байх ба нийт 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна**. Үнэт цаас гаргагчийн хувьцааг дараах байдлаар хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт №1. Компанийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл*

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Нийт үнэ | Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь |
|---|---|---|---|---|

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд ХХК | 112,500,000 | 1,125,000,000 | 75% |
| 2 | Ж.Барсболд | 15,000,000 | 150,000,000 | 10% |
| 3 | Ц.Цэцэнхүү | 7,500,000 | 75,000,000 | 5% |
| 4 | Э.Пүрэвлхам | 7,500,000 | 75,000,000 | 5% |
| 5 | Ж.Оюунчимэг | 3,000,000 | 30,000,000 | 2% |
| 6 | И.Баттуяа | 4,500,000 | 45,000,000 | 3% |
| | **Нийт** | **150,000,000** | **1,500,000,000** | **100%** |

Түүнчлэн, ХЭУБГ-ын лавлагаагаар Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд буюу гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Намхайдорж овогтой Ариунбаатар бүртгэлтэй байна. Түүнийг гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэл нь ХЭУБГ-аас олгосон Компанийн гэрчилгээнд 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хийгдсэн байх бөгөөд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс 2022 оны 02 дугаар сарын 8-ны өдөр 40/01 дугаартай тогтоол гаргаж, Н.Ариунбаатарыг гүйцэтгэх захирлаар томилсон байна.

### 3.1.1.2. Компанийн үйл ажиллагааны чиглэл, хугацаа

Үнэт цаас гаргагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 000222836 дугаартай хулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Компанийн дүрэм болон ХЭУБГ-ын лавлагаанд дурдсаныг үзвэл Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь (i) менежментийн зөвлөгөө өгөх, (ii) барилгын материалын худалдаа, (iii) үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх, (iv) мах боловсруулах, консервлох, (v) малын тэжээл үйлдвэрлэл, (vi) мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн байна. Эдгээр үйл ажиллагааны чиглэлүүд нь Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагааны төрөлд хамаарахгүй бөгөөд эдгээр үйл ажиллагааг Компанийн дүрмийн 1.8-д заасны дагуу хугацаагүй эрхэлдэг байна.

### 3.1.1.3. Компанийн хаяг:

Компанийн оршин байгаа газрын хувьд Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт тусгасны дагуу түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх зохицуулалттай. Үнэт цаас гаргагчийн одоогийн оршин байгаа газар буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаяг нь Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 15-р хороо, ХААН банк цамхаг, 10-р давхар хаягт 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн, энэ хугацаанаас хойш тухайн хаягт өөрчлөлт оруулаагүй байна.

**Дээрхийг нэгтгэн дүгнэвэл**, Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж эрх бүхий байгууллагад зохих ёсоор бүртгэгдсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс дүгнэлээ.

### 3.1.1.4. Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх тухай

СЗХ
2022 06. 22
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

Компанийн тухай хуулийн 62.1.3, 62.1.4 дэх хэсэгт заасны дагуу компанийн хувьцаа гаргах, компанийн хэлбэрийг өөрчлөх шийдвэр гаргах нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал учир Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс Компанийн тухай хуулийн 61.1.5, 76.1.2, 76.1.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах бүрэн эрхтэй. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт Компанийн тухай хуулийн 60.2 дахь хэсэгт заасан зүйлсийг тусгах шаардлагатай.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр ***"Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах санал оруулах тухай"*** 40/ТУЗ-04 тоот тогтоол гаргаж компанийн хэлбэрийг өөрчлөн хувьцаат компани болгох, компанийн нийт энгийн хувьцаан дээр нэмж хувьцаа гарган МХБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох, үнэлгээний компанийн үнэлгээг танилцуулж, нэгж хувьцааны үнийг ТУЗ-өөс тогтоох эрх олгох, хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх эсэх, олон нийтэд анх удаа хувьцаа санал болгохтой холбоотой бусад асуудлыг шийдвэрлүүлэх саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлэхээр тогтсон байна.

Энэ хүрээнд Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр "***Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар өөрчлөн байгуулах болон олон нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах тухай***" 40/14 тоот шийдвэр гаргасан байна. Энэхүү шийдвэрээр Компанийн хэлбэрийг хувьцаат компани хэлбэртэй болгон өөрчлөхийг зөвшөөрч, Компанийн нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150,000,000 (нэг зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаан дээр 64,285,700 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар дамжуулан олон нийтэд санал болгон арилжих, санал болгох, Компанийн тухай хуульд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхгүй байх, нийтэд санал болгох нэгж хувьцааны зах зээлийн үнийг үнэлгээний компани болон андеррайтерийн компанийн саналыг харгалзан ТУЗ-өөс тогтоох асуудлыг тус тус шийдвэрлэсэн байна.

Энэхүү шийдвэрт үндэслэн Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл, 55 дугаар зүйлийг үндэслэн **"Нийтэд санал болгох үнэ тогтоох тухай"** 40/ТУЗ-08 тоот тогтоол гаргаж, нийтэд санал болгох 64,285,700 ширхэг энгийн хувьцааны үнийг 45 төгрөг байхаар шийдвэрлэсэн байна.

Дээрх ТУЗ болон ХЭХ-ын шийдвэрүүд нь Компанийн тухай хуулийн 38.8, 43.1, 55.2, 62.1.2, 62.1.3, 62.1.4 дэх заалтуудад нийцсэн байхаас гадна ХЭХ-аас шийдвэр гаргахдаа хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн нь Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэг, Компанийн дүрмийн 9.10 дахь хэсэг тус тус нийцсэн байна.

Иймд Компанийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгохтой холбоотой Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцсэн байна гэж Хуулийн фирм дүгнэлээ.

СЗХ
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

### 3.2. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-д заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын тухай

Компанийн тухай хуулийн 84.2-т заасны дагуу Компани нь эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг дүрэмдээ тухайлан заах шаардлагатай байдаг. Энэхүү шаардлагын дагуу Компанийн дүрмийн 4.4 дэх хэсэгт ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэхудирдлага, түүний баг ("Менежментийн баг")-ийн гишүүд, санхүүгийн менежер, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдүүдийг эрх бүхий албан тушаалтнуудад хамааруулахаар заасан байна. Энд заасан менежментийн багийн бүтцийг Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 40/А-17 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан байх бөгөөд үүнд гүйцэтгэх удирдлага, үйлдвэрийн дарга, фермийн дарга, ерөнхий нягтлан бодогч, санхүүгийн менежер, хүний нөөцийн менежер гэсэн нийт 6 албан тушаалтныг хамруулсан байна. Иймд Компанийн эрх бүхий албан тушаалтны бүтцийг Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж байна гэж дүгнэлээ.

Компани нь 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 40/А-56 тоот албан бичиг, 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 40/А-122 тоот албан бичгийн дагуу Хуулийн фирмд Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалтыг ирүүлсэн ба дараах албан тушаалтнуудыг эрх бүхий албан тушаалтанд хамруулсан байна. Үүнд:

*Хүснэгт №2 Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын жагсаалт*

| № | Овог нэр | Албан тушаал | Томилогдсон огноо |
|---|---|---|---|
| 1 | Намхайдорж овогтой Ариунбаатар | Гүйцэтгэх захирал | 2022.02.08 |
| 2 | Ганболдын Оюундэлгэр | Санхүүгийн менежер | 2022.01.03 |
| 3 | Должинсүрэн овогтой Марал-Эрдэнэ | Ерөнхий нягтлан бодогч | 2021.12.13 |
| 4 | Ганхуяг овогтой Дөлгөөн | Хүний нөөцийн менежер | 2022.01.10 |
| 5 | Жаргалсайхан овогтой Байгальмаа | Үйлдвэрийн дарга | 2022.05.02 |
| 6 | Вандангэсэр овогтой Санчир | Бордох үйл ажиллагааны фермийн дарга | 2022.04.01 |
| 7 | Ичинноров овогтой Баттуяа | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга | 2022.02.25 |
| 8 | Цагаач овогтой Оюунцэцэг | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | 2022.02.25 |
| 9 | Жанцанхорлоо овогтой Барсболд | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн | 2022.02.25 |

Мон Бийф ХХ компани

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Түмэнжаргал овогтой Солонго | Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга | 2022.02.25 |

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84.3, СЗХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан "Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 2.1.2-т тус тус заасан шаардлагыг нэгэн зэрэг хангасан байх ёстой бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал зэрэг тодорхой албан тушаалтнуудын хувьд эдгээр нийтлэг шаардлагаас гадна Компанийн тухай хуульд заасан нэмэлт шаардлагыг мөн хангасан байх ёстой.

Бид эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага нь хуульд нийцэж байгаа эсэх тухай дүгнэлтийг дээр заасан шалгууруудын дагуу нэг бүрчлэн шалгахад эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага нь хуульд заасан шаардлагыг бүрэн хангаж байсан болно.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх тухай дүгнэлтийн дэлгэрэнгүйг Хавсралт № 1-ээс үзнэ үү.

СЭХ
2022 .06. 22 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

### 3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж буй эсэх талаар

Үнэт цаас гаргагчийн зүгээс Хуулийн фирмд ирүүлсэн Хүснэгт №3-т буй Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөн, хэрэгжиж буй дүрэм, журам, Үнэт цаас гаргагч нь ХК болохтой холбоотой дагаж мөрдөх зарим дүрэм, журмын төсөлд тус тус дүн шинжилгээ хийсэн болно.

***Хүснэгт №3. Компанийн дотоодод мөрдөгдөж буй дүрэм, журмын мэдээлэл***

| № | Журмын төрөл | Тоо |
|---|---|---|
| 1 | "Мон Бийф" ХХК-ийн дүрэм | 1 |
| 2 | "Мон Бийф"ХК-ийн дүрмийн төсөл | 1 |
| 3 | "Мон Бийф" ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төсөл | 1 |
| 4 | "Мон Бийф" ХК-ийн ТУЗ-ийн хороодын дүрэм | 3 |
| 5 | Ёс зүйн дүрмийн төсөл | 1 |
| 6 | Ногдол ашгийн журмын төсөл | 1 |
| 7 | Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмын төсөл | 1 |
| 8 | Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам | 1 |
| 9 | Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам | 1 |
| 10 | Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журмын төсөл | 1 |
| 12 | Хэрэглэгч, харилцагчийн санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам | 1 |
| 13 | Мэдээллийн үйл ажиллагааны журам | 1 |
| 14 | Нууцын тухай журам | 1 |
| 15 | Хөдөлмөрийн дотоод журам | 1 |
| 16 | Гүйцэтгэлийн удирдлагын журам | 1 |
| 17 | ХАБЭА-н мэдлэг ур чадвар олгох журам | 1 |
| 18 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам | 1 |
| 19 | Хөдөлмөрийн эрүүл ахуйн журам | 1 |
| 20 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам | 1 |
| 21 | Компанийн дотоод хяналтын бодлогын баримт бичгийн төсөл | 1 |
| 22 | Мөшгөлтийн журам | 1 |
| 23 | Бордох үйл ажиллагааны журам | 1 |
| 24 | Борлуулалт худалдан авалттай холбоотой журам | 3 |
| Нийт | | 27 |

#### 3.3.1. Үнэт цаас гаргагчийн дүрэм

Компанийн дүрэмд Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 40/04 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралт, 2022 оны 03 дугаар сарын 21-

СЗХ 2022.06.22 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

ний өдрийн 40/10 тоот шийдвэрийн нэгдүгээр хавсралтаар тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байх ба энэ нь Компанийн тухай хуулийн 17.1 дэх хэсэг, 62.1.1 дэх хэсэгт тус тус заасан шаардлагад нийцэж байна.

Компанийн дүрэм нь компанийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хориглох зүйл, компанийн удирдлага түүний эрх хэмжээ, ТУЗ-ийн эрх хэмжээ, гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан нийт 13 зүйлээс бүрдэх бөгөөд эдгээр нь дээрх хуулийн заалтууд болон Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан нийтлэг шаардлагад нийцсэн байна. Тодруулбал:

- Агуулгын хувьд түүнд заавал тусгавал зохих Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэг хэсэгт заасан зүйлсийг бүрэн тусгасан байна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 62.1 дэх хэсэгт нийцсэн байна.
- Хувьцаа эзэмшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх эрх нь Компанийн тухай хуулийн 66.1 дэх хэсэгт нийцсэн байна.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам нь Компанийн тухай хуулийн 59.4, 61.1, 60-74 дүгээр зүйлд заасан зохицуулалтад тус тус нийцсэн байна.
- ТУЗ-ийн бүрэн эрхийн зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 76.1 дэх хэсэгт нийцсэн байна.

### 3.3.2. Хувьцаат компанийн дүрмийн төсөл

Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд “ХХК” хэлбэртэй компани болон “ХК” хэлбэртэй компани нар нь харилцан адилгүй эрх зүйн зохицуулалттай байх тул Компани өөрчлөн байгуулагдсанаас хойш Компанийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжих дүрмийн төслийг Үнэт цаас гаргагчаас боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн байна. Компанийн дүрмийн төсөл нь нийт 14 зүйлтэй бөгөөд зүйл тус бүр нь дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- Нэгдүгээр зүйл. Дүрмийн зорилго, хүрээ, нэр томьёоны тайлбар;
- Хоёрдугаар зүйл. Компанийн эрх зүйн байдал;
- Гуравдугаар зүйл. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл;
- Дөрөвдүгээр зүйл. Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө;
- Тавдугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг;
- Зургадугаар зүйл. Компанийн үнэт цаасыг гаргах худалдах, худалдан авах;
- Долдугаар зүйл. Компанийн удирдлага;
- Наймдугаар зүйл. Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн хариуцлага;
- Есдүгээр зүйл. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан;
- Аравдугаар зүйл. Ногдол ашиг;
- Арван нэгдүгээр зүйл. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт;
- Арван хоёрдугаар зүйл. Сонирхлын зөрчлийг зохицуулах;
- Арван гуравдугаар зүйл. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;
- Арван дөрөвдүгээр зүйл. Компанийн дүрэм хүчин төгөлдөр болох.

СЗХ
2022 .08сар22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан СЗХ-ний 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаартай тогтоолд нээлттэй хувьцаат компани нь үйл ажиллагаандаа Компанийн засаглалыг кодексийг дагаж мөрдөхийг үүрэг болгосон байдаг учир дээрх дүрмийн төсөл нь Компанийн засаглалын кодекс, холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж дүгнэсэн болно.

Тухайлбал, ТУЗ-ийн хороод нь үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий гурваас доошгүй гишүүдтэй байна гэж заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.5 дахь хэсэгт нийцсэн, ТУЗ-ийн хороодын бүтэц, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, эрх үүргийн зохицуулалт нь Компанийн засаглалын кодексийн хоёрдугаар зарчим, 5.2 дахь хэсэгт тус тус нийцэж байна.

Иймд, бид уг дүрмийн төслийн заалтууд нь хөрөнгө оруулагч, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн байдлыг хуульд зааснаас дордуулсан эсэх болон хууль тогтоомжид заасан нийтлэг шалгуурыг хангаж байгаа эсэхийг нэг бүрчлэн шалгаад, Компанийн засаглалын кодекст заасан нийтлэг зарчмуудад болон болон Компанийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.3.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төсөл

Үнэт цаас гаргагч нь хувьцаат компани хэлбэртэй болох үед батлагдах Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам (шинэчилсэн найруулга)-ын төслийг Хуулийн фирмд ирүүлсэн бөгөөд хувьцаат компанийн хувьд Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй. Уг кодекст Компанийн засаглалын хэрэгжилтийг хариуцах гол субъект нь ТУЗ гэж заасан учир Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын төслийг Компанийн засаглалын кодекс болон бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэсэн болно.

Энэхүү журмаар ТУЗ-ийн бүрэн эрх, чиг үүрэг, ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрх, чиг үүрэг, бүрэн эрх дуусгавар болох үндэслэл, чөлөөлөх зохицуулалт, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн эрх үүрэг, нэр дэвшүүлэх зохицуулалт, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, ТУЗ-ийн даргын бүрэн эрх, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг, ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, ТУЗ-ийн хурал, түүнийг хуралдуулахтай холбоотой зохицуулалт зэрэг харилцааг зохицуулсан байна.

Журмаар ТУЗ-ийн чиг үүрэг болон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан байгаа нь Компанийн засаглалын кодексийн 1.1 дэх хэсэгт: *"төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна"* гэсэнтэй нийцэж байхаас гадна ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын эрх, үүрэг нь Компанийн засаглалын кодексийн 1.6 дахь хэсгийн Тайлбар 1, Тайлбар 2, 1.1 дэх хэсгийн Тайлбар 2 хэсэгтэй тус тус нийцэж байна.

Журмын төслийн удиртгал хэсэгт ТУЗ нь Компанийн ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байх бөгөөд Компанийн үйл

ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах байдалд хяналт тавих, Компанийн хувьцаа эзэмшигчид, удирдлага болон бусад оролцогч талуудын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд зуучлагчийн үүрэг гүйцэтгэн Компанийн эрх ашиг болон сайн засаглалын зарчимд нийцүүлэн оновчтой зохицуулалт хийх гэж заасан нь Компанийн засаглалын кодекст заасан компанийн засаглалын зарчмуудтай нийцэж байна. Түүнчлэн, ТУЗ-ийн гишүүний чиг үүрэгт шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, Компанийн үр дүнг дээшлүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийн тэнцвэрийг хангах, хууль, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ зохих төвшинд хариуцлагатай гүйцэтгэхийн тулд уг ажилдаа хангалттай цаг зарцуулан ажиллах зэргээр зохицуулсан байгаа нь Компанийн засаглалын кодексийн 1.2 дахь хэсгийн Тайлбар 4, есдүгээр зарчим буюу хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандах, долдугаар зарчим буюу Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндлэх зохицуулалттай нийцэж байна.

Түүнчлэн, ТУЗ-ийн хороодтой холбоотой зохицуулалт нь Компанийн засаглалын кодексийн 2.2 дахь хэсгийн Тайлбар 4-тэй, ТУЗ-ийн хараат бус гишүүний эрх, үүрэгт тавигдах шаардлагын зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 79.1, 79.3 дахь хэсэгтэй тус тус нийцсэн байна. Үүнээс гадна журамд ТУЗ-ийн үйл ажиллагааг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос боловсруулсан ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулгад үндэслэн жилд нэг удаа үнэлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 1.3 дахь хэсгийн Тайлбар 1-т нийцэж байна.

### 3.3.4. ТУЗ-ийн цалин, урамшууллын хорооны дүрмийн төсөл

Үнэт цаас гаргагчаас хувьцаат компани болохтой холбогдуулан шинэчлэн батлагдах ТУЗ-ийн Цалин, урамшууллын хорооны дүрмийн төслийг бидэнд ирүүлсэн бөгөөд Хуулийн фирмийн зүгээс уг төслийг холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодекст нийцсэн эсэхийг дүгнэсэн.

Компанийн тухай хуулийн 81.6 дахь хэсэгт ТУЗ-ийн Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах талаар заасан байдаг. Тухайлбал, (i) компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих; (ii) ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх; (iii) компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтооно гэж заасан байна.

Тус хорооны чиг үүрэг нь хорооны дүрмийн төслийн 1.1 дэх хэсэгт: "*ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих, эдгээр эрх бүхий албан тушаалтнуудад олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах, Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх захирлын цалин урамшууллын хэмжээг тодорхойлох*" хэмээн заасан нь "Компанийн засаглалын кодекс"-ийн 2.3 дахь хэсгийн Тайлбар 1-т: "*компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг ТУЗ-ийн цалин*



СЗХ он 2022 сар 7.2 өдөр БҮРТГЭВ № 01

СЭХ 2022.06.22 он сар өдөр БҮРТГЭВ №01

*урамшууллын хорооноос боловсруулан ТУЗ-өөр батлуулна*" гэх зохицуулалт болон дээр дурдсан Компанийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байна. Үүнээс гадна дүрмийн төсөлд ТУЗ-ийн цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж батлахаар заасан нь "Компанийн засаглалын кодекс"-ийн 6.1 дэх хэсэгт заасантай нийцэж байна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн цалин, урамшууллын хорооны дүрмийн төслийн 2.1 дэх хэсэгт: "*Хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна*" гэж заасан нь Компанийн тухай хуулийн 81.2 дахь хэсэгт: "*Хувьцаат компанийн ТУЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ*" гэж заасан болон Компанийн засаглалын кодексийн 2.3 дахь хэсэгтэй тус тус нийцэж байна. Үүнээс гадна цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн байхаар заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.3 дахь хэсэгт: "*Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.*" хэмээн заасантай нийцэж байна.

### 3.3.5. Эрсдэл, аудитын хорооны дүрмийн төсөл

Компани нь эрсдлийн хорооны чиг үүргийг аудитын хорооны чиг үүрэгтэй нэгтгэн эрсдэл, аудитын хороотой байхаар тус төсөлд заасан байх бөгөөд энэ нь Компанийн засаглалын кодексийн 5.3 дахь хэсгийн Тайлбар 4-т: "*Эрсдлийн хорооны чиг үүргийг аудитын хороонд хариуцуулж болно*" гэх зохицуулалтын хүрээнд нийцэж байна.

Эрсдэл, аудитын хорооны дүрмийн төслийн 2.1-т: "*Эрсдэл, аудитын хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.*" хэмээн заасан нь Компанийн тухай хуулийн 81.2-т: "*...хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.*" гэсэн шаардлагад нийцсэн байна. Мөн хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагуудыг оролцуулахаар заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.2 дахь хэсгийн Тайлбар 5-д: "*Аудитын хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахын тулд компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг зөвхөн тус хорооны хүсэлтээр хуралдаанд оролцуулна.*" хэмээн заасантай нийцэж байна.

Тус дүрмийн төслийн 2.4-т: "*Хорооны гишүүн бүр нь санхүүгийн боловсролтой байх бөгөөд хамгийн багадаа нэг гишүүн нь санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль зүй ба зохицуулалтын хүрээнд "санхүүгийн шинжээч" байна.*" хэмээн заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.2 дахь хэсгийн тайлбар 2-т тусгагдсан: "*Аудитын хорооны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна.*" гэсэн зохицуулалтад нийцсэн байна.

Тус дүрэмд зааснаар Эрсдэл, аудитын хороо нь:

- ***Хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр:***



6648436 MonBeefLLC УЛААНБААТАР МонБийф ХХК Компани

СЭХ
2022.06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

Хөндлөнгийн аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан, ТУЗ-өөр шийдвэрлүүлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.2 дахь хэсгийн тайлбар 1 -т тусгагдсан: "*Аудитын хороо нь аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайлагналын чанарыг хангана*" болон Компанийн тухай хуулийн 81.4-д: "*аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна: .... аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах*" гэж заасан зохицуулалтын хүрээнд байна.

Хөндлөнгийн аудиторын хараат бус байдал болон бусад шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн, бие даан шууд сонгох, аудитортой байгуулах гэрээг батлах хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, гэрээг цуцлах зэрэг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 4.1.-т: "*Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.*" гэх зохицуулалтад нийцэж байгаа төдийгүй Компанийн тухай хуулийн 81.4.3, 94.3, 94.4 дахь хэсэгт тусгагдсан зохицуулалтын хүрээнд байна.

Дотоод аудиторын шалгалтын үр дүн, тайланг үндэслэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг тодорхойлж компанийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг чиглэл өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн тухай хуулийн 81.3-т: "*Төлөөлөн удирдах зөвлөлийн хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, энэ хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй*" гэх зохицуулалтад нийцсэн байна.

- ***Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, эрсдлийн удирдлагын чиглэлээр:***

Гадаад, дотоод хяналтын тогтолцоогоор дамжуулан компанийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, санхүү, нягтлан бодох бүртгэл үнэн зөв хөтөлж байгаа эсэх, хараат бус аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа байдал, санхүүгийн тайлагнал нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцэж буй эсэх, компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаа зохистой байгаа эсэх, хууль дүрэм, ёс зүйн хэм хэмжээг баримталж байгаа эсэх, мэдээллийн ил тод байдал хангагдаж байгаа эсэх, Компанийн дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тэдгээрийн хэрэгжилт зэрэгт хяналт тавьж үнэлэлт, дүгнэлт гарган гарсан зөрчил, дутагдлыг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг чиглэл өгч, хяналтын үйл ажиллагааны үр дүнг ТУЗ-д тайлагнах үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 5.2 дахь хэсгийн тайлбар 2-т заасантай нийцсэн бөгөөд Компанийн тухай хуулийн 81.4.1-т: "*аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна: компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих*" гэж заасан зохицуулалтын хүрээнд байна.

- ***Эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр:***



Мон Бийф ХХ Компани MonBeef LLC 6648436 Улаанбаатар хот

СЭХ
он 2022 сар 06 өдөр 22
БҮРТГЭВ
№ 01

Эрсдэл, аудитын хороо энэ хүрээнд эрсдлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бүтэц үйл ажиллагааны зохион байгуулалт, төлөвлөгөөг батлах, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 5.2 дэх хэсгийн Тайлбар 1-т: "*Компанийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бизнесийн онцлогоос хамаарч учирч болох эрсдэл харилцан адилгүй тул төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн зорилго, алсын хараатай уялдуулан хүлээж болох эрсдэлийн төрөл, хэмжээ хязгаарыг одорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ;*" Тайлбар 2-т: "*Эрсдэлийн хороо нь компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.*" хэмээн заасантай тус тус нийцэж байна.

Мөн тус хорооны дүрмийн төсөлд тусгагдсанаар уг хороо нь Компанийн байгуулж байгаа гэрээ, хэлцэл нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй мөн эсэх, эдгээр хэлцлийн талаар ТУЗ-д тайлагнах эрх хэмжээг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн тухай хуулийн 81.4.4 дэх хэсэгт тусгагдсан зохицуулалтын хүрээнд байна.

### 3.3.6. Нэр дэвшүүлэх хорооны дүрмийн төсөл

Уг хорооны дүрмийн төслийн 2.1 дэх хэсэгт: "*Хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна*" хэмээн заасан нь Компанийн тухай хуулийн 81.2-т: "*Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.*" хэмээн заасантай нийцсэн байна.

Мөн нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн байхаар заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.4 дэх хэсэгт: "*Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.*" хэмээн заасантай нийцэж байна.

Дээрх төсөлд дурдснаар хороо нь Компанийн ердийн болон хараат бус гишүүн, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулахад тавигдах шаардлагыг тодорхойлох, ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, хувь хүний зан чанарын болон хараат бус байдлын шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, тус шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалтыг хууль, журмын дагуу нээлттэй зарлах замаар ил тод явуулан, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг бүртгэн, урьдчилсан байдлаар үнэлж, хараат бус гишүүний хувьд Компанийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн засаглалын кодексийн 2.4 дэх хэсгийн Тайлбар 2-т: "*Нэр дэвшүүлэх хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох ба уг хороо нь тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.*" болон Компанийн тухай хуулийн 81.5.1-81.5.4, 81.5.6 дэх хэсгүүдэд заасантай тус тус нийцсэн байна.

СЗХ
2022.06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

Мөн дээрх хороо нь Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд оруулах өөрчлөлтийн төслийн боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан нь Компанийн тухай хуулийн 81.5.5-д заасантай нийцэж байна.

### 3.3.7. Компанийн Ёс зүйн дүрмийн төсөл

Үнэт цаас гаргагчаас бидэнд Компанийн дагаж мөрдөх "Ёс зүйн дүрэм"-ийн төслийг ирүүлсэн бөгөөд энэхүү дүрмийн төсөлд ТУЗ, ажилтан, удирдлагын багийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ, ажлын байранд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, оролцогч талуудтай харилцах харилцаа, ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахуулиас ангид хүрээнд ажиллах, мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангах, шударга, ил тод байдлыг хангах, аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаа, Засгийн газар, улс төр шатны харилцаа, ёс зүйн зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх, ёс зүйн хороо, хариуцлага, хувийн ашиг сонирхлын эсрэг баталгаа зэргийг зохицуулж, журмыг компанийн ТУЗ, ТУЗ-ийн гишүүд, удирдлагын багын гишүүд, нийт ажилтнууд болон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хэрэглэгч, харилцагч, гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгч зэрэг бүхий л оролцогч талууд өдөр тутамдаа мөрдлөг болгохоор заасан байна.

Ийнхүү ТУЗ-өөс заавал дагаж мөрдөхөөр заасан нь Компанийн засаглалын кодексийн 1.2 дахь хэсгийн Тайлбар 6 дахь хэсэг, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, зөрчигдөж байгааг мэдсэн тохиолдолд энэ талаар Ёс зүйн хороонд нэн даруй мэдэгдэж, шийдвэрлүүлэх бөгөөд хэрэв зөрчил гаргасан бол холбогдох хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байгаа нь Компанийн засаглалын кодексийн 8.2 дахь хэсгийн Тайлбар 1 дэх хэсэгт, Компанийн оролцогч талуудын эрхийг дээдлэн, ашиг сонирхлыг тэгш хангах ажиллахыг зорьж, тэдний гомдол саналыг тухайлсан журмын дагуу шийдвэрлэхээр зохицуулсан нь Компанийн засаглалын кодексийн долдугаар зарчим болох компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндлэх зарчмын зохицуулттай тус тус нийцэж байна.

### 3.3.8. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмын төсөл

Үнэт цаас гаргагч нь ХХК болохын хувьд одоогоор батлагдсан "Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам" байхгүй бөгөөд ХК болсон нөхцөлд дагаж мөрдөх "Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын төслийг бидэнд ирүүлсэн. Энэхүү журмын төсөлд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудыг хувийн ашиг сонирхлын зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил бий болсон тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь тухайн албан тушаалд томилогдохдоо ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг гаргаж, хэрэв ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн бичгээр тайлбар гаргаж, уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байхаар зохицуулсан байна.

Журмын төслийн уг зохицуулалт нь Компанийн тухай хуулийн 84.4 дэх хэсэгт: "*компанийн эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх*", 91.2 дахь хэсэгт: "*Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй*" гэх зохицуулалтуудад тус тус нийцэж байна.

СЗХ
он 2022 он 06. 22 өдөр
БҮРТГЭВ

2022-06-17

Иймд энэхүү "Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын төсөл нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжитой нийцэж байна.

**3.3.9. Ногдол ашгийн журмын төсөл**

Үнэт цаас гаргагчид одоогоор батлагдсан "Ногдол ашгийн журам" байхгүй бөгөөд хувьцаат компани болох нөхцөлд дагаж мөрдөх "Ногдол ашгийн журам"-ын төслийг бидэнд ирүүлсэн ба журмын төсөл нь дараах байдлаар хуулийн шаардлага хангаж байна.

Тус журмын төсөлд зааснаар уг журмаар ногдол ашгийн бодлого, түүнийг хуваарилах шийдвэр гаргах журам, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг мэдээлэх, хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Тухайлбал, журмын төслийн 2.2 дахь хэсэгт: "*Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой төвшинд байлгах бодлоготой ажиллана*" хэмээн заасан нь "Компанийн засаглалын кодекс"-ийн 9-р зарчимд тусгасан "хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, эрхээ хэрэгжүүлэх боломжоор бүрэн хангах зарчим"-д нийцэж байна. Түүнчлэн, ногдол ашгийг ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэхээр тусгасан, ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгохоор тусгасан, тухайн жил нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах, тогтоосон ногдол ашиг хуваарилах шийдвэрт тусгагдах зүйлс, ногдол ашиг хуваарилах шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг бүрэн олгож дуусгах, ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд холбогдох хууль, журамд заасны дагуу хариуцлага хүлээхээр тусгасан байгаа нь Компанийн тухай хуулийн 46.6, 46.1, 46.7, 46.5, 46.10, 46.11 дэх хэсгүүдэд нийцэж байна.

Иймд Ногдол ашгийн журмын төсөл нь энэхүү боловсруулсан найруулгаараа батлагдана гэж үзвэл "Компанийн засаглалын кодекс", Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс дүгнэлээ.

**3.3.10. Бордох үйл ажиллагааны журам**

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 40\А-09 дугаартай тушаалаар "Бордох үйл ажиллагааны журам"-ыг баталж, уг журмаар Бордох үйл ажиллагааны албаны өдөр тутмын ажилбарыг зохион байгуулах, үхэр хүлээн авах, технологийн дагуу бордох, тэжээл бэлтгэх, нядалгаанд үхэр бэлтгэх болон бусад холбогдох гарах үйл ажиллагааг зохицуулсан байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-234 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам"-ын 8.3 дахь хэсэгт: "*Мах бэлтгэлийн зориулалтаар тууварлах, тээвэрлэх малд тухайн орон нутгийн үзлэг, шинжилгээ хийлгэж эрүүл мэндийн тодорхойлолт авч, мал эмнэлгийн тасагт шилжилт хөдөлгөөн хийх бүртгэлд оруулж, мал эмнэлгийн гэрчилгээ авна*", 8.4 дэх хэсэгт: "*мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, бэлтгэлд тэнцсэн, мал эмнэлгийн гэрчилгээтэй, малыг тууварлаж, тээвэрлэнэ*" гэж заасан байна. Түүнчлэн, мөн журмын 8.6 дахь хэсэгт: "*тээвэрлэлт, тууварлалтын явцад малд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, олон мал адил шинж тэмдэгтэй гэнэт олноор өвчилсөн, хорогдсон тохиолдолд тээвэрлэх,*



Мон Бийф ХХК компани MonBeef LLC Улаанбаатар

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

*шууварлах үйл ажиллагаа даруй зогсоож, мал эмнэлгийн тасагт 12 цагийн дотор мэдээлнэ*", 9.4 дэх хэсэгт: "*мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын хүрээнд үйлдвэрт мал хүлээн авах үеийн болон нядлахын өмнөх үзлэг хийнэ*" гэж зохицуулсан байна.

Үүнийг үнэт цаас гаргагчийн Бордох үйл ажиллагааны журам хангасан байгаа эсэхийг шалгавал 6.1.3 дахь хэсэгт: "*харьяа газрын малын эмчээс эрүүл гэсэн гарал үүслийн гэрчилгээтэй, хянан баталгаажуулсан мал эмнэлгийн байцаагчийн баталгаажуулалттай байна*", 6.1.11 дэх хэсэгт: "*тээвэрлэгдэж ирсэн үхрийг мал хүлээн авах хэсэгт буулгаж, амрааж тээвэрлэлтийн стресс, хөлийг оршоог гаргаж, 12-24 цагийн дараагаар бүртгэх ажилбарыг хийх*"-ээр зохицуулсан нь дээрх хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна.

Түүнчлэн "Бордох үйл ажиллагааны журам"-ын 7.7.1 дэх хэсэгт: "*галын аюулгүй байдлыг хангаж, ажлын байранд тамхи татах, зориулалтын бус газар цахилгаан хэрэгсэл, ил гал гарах тоног төхөөрөмж ажиллуулахыг хориглоно*" гэж заасан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт: "*галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ*" гэх заалттай нийцэж байна.

Иймд "Бордох үйл ажиллагааны журам" нь эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд үхрийг хүлээн авч, сайтар шалгаж, хэрэв эрүүл мэндийн асуудал нэн даруй эмчлэх, үхрийг эрүүл, аюулгүй тэжээж мал нядалгаанд бэлтгэх шаардлагыг нарийвчилсан сайтар тусгасан Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны чиглэлд ихээхэн ач холбогдол бүхий журам байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс дүгнэлээ.

**3.3.11. Борлуулалт, худалдан авалттай холбоотой журам**

Үнэт цаас гаргагч нь дотоод үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа борлуулалт, худалдан авалттай холбоотой нийт 3 журам Хуулийн фирмд ирүүлсэн байна. Үүнд:

- Зээлийн борлуулалтын журам;
- Борлуулалтын албаны үйл ажиллагаанд мөрдөх журам;
- Үхэр худалдан авах журам.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 40/А-16 тоот тушаалаар батлагдсан "Зээлийн борлуулалтын журам", Гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 40\А-17 тоот тушаалаар батлагдсан "Борлуулалтын албаны үйл ажиллагаанд мөрдөх журам", Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 40\А-17 тоот тушаалаар батлагдсан "Үхэр худалдан авах журам" тус тус холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг бид дүгнэсэн болно.

Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн хувьд бие даасан хууль тогтоомж болох 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар өмч, хөрөнгөө үр ашигтай захиран зарцуулахад баримтлах харилцааг зохицуулдаг бол хувийн өмчид хуулийн



Мон Бииф ХХК

СЗХ
2022-06. 22
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

этгээдүүдийн хувьд өөрсдийн гэсэн бодлого, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах боломжтой байдаг.

- **Зээлийн борлуулалтын журам**

Тус журам нь харилцагчдад бараа бүтээгдэхүүнээ зээлээр борлуулах, борлуулалтын лимитийг тогтоох, авлага цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд Компанийн ажилтнууд зээлээр борлуулалт хийх, авлага цуглуулах үедээ мөрдөж ажиллах зорилгоор энэхүү журмыг баталсан байна. Тус журмын 3.3.7 дахь хэсэгт: "*зээлээр худалдах, худалдан авах гэрээ байгуулж, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарагдсаны дараа бараа бүтээгдэхүүнийг зээлээр нийлүүлэх бөгөөд зээлээр худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй тохиолдолд төлбөрийг бэлнээр төлнө*" хэмээн заасан, 3.3.4 дэх хэсэгт зээлээр олгох төлбөрийн нөхцөл буюу төлбөр төлөх хуваарийг зохицуулсан байгаагаас үзвэл Иргэний хуулийн 262.1 дэх хэсэгт заасан "зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-ний агуулгыг илэрхийлж байх ба Иргэний хуулийн 263.1 дахь хэсэгт заасны дагуу энэхүү гэрээг бичгээр байгуулах шаардлагад нийцсэн байна. Өөрөөр хэлбэл, худалдагч нь үнийг бүрэн төлөхөөс өмнө худалдан авагчийн өмчлөлд эд хөрөнгийг шилжүүлэх үүрэг хүлээх, худалдан авагч нь үнийг гэрээнд заасны дагуу тодорхой хугацааны турш хэсэгчлэн төлөх үүргийг хүлээдэг зээлээр худалдах, худалдан авах гэрээний зохицуулалттай нийцэж байна.

- **Борлуулалтын албаны үйл ажиллагаанд мөрдөх журам**

Компанийн борлуулалтын өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө, төсөв, болон борлуулалтын ажилтнуудын хүлээх үүрэг хариуцлага, цалин урамшуулал, борлуулалтын албанаас бусадтай гэрээ хэлцэл хийх журам зэргийн талаар зохицуулсан байна. Энэхүү журмын 5 дугаар зүйлд: "*ажилтнуудын нийт цалинг үндсэн цалин болон нэмэгдэл цалин гэж хуваан авч үзнэ, нэмэгдэл цалин нь борлуулалтын төлөвлөгөөний биелэлтээс шууд хамаарна*" гэх зэргээр зохицуулсан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх хэсэгт заасан: "*цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ*", 108.1 дэх хэсэгт заасан: "*нэмэгдэл цалин нь ажилтны ур чадвараас хамааран холбогдох гэрээ болон дотоод журмаар тогтооно*" гэсэн зохицуулалтуудтай нийцэж байна. Түүнчлэн, тус журмын 6 дугаар зүйлд борлуулалтын менежер нь байгууллагуудтай утсаар болон имэйлээр харилцан холбоо тогтоож, хэлцэл хийхдээ бүтээгдэхүүний дээжийг өгч танилцуулга хийхээр тусгасан, харилцагчийн зүгээс тавигдах шаардлага, хэрэглээний төвшинг тодорхойлж үндсэн үнийн санал өгнө гэх зэргээр тусгаж, хэлцэл, хэлэлцээр хийх журмыг тодорхой тусгасан байгаа нь Иргэний хуулийн 39.2 дахь хэсэг, 42.8 дахь хэсэг, 195.1 дэх хэсэгт заасан хэлцэл хийх хүсэл зоригоо хангалттай тодорхой илэрхийлэх заалтуудтай нийцсэн байна.

- **Үхэр худалдан авах журам**

Уг журмаар үхрийн фермийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад зориулагдсан эрүүл, гарал үүсэл сайтай бяруу болон шүдлэн үхрийг худалдан авах, бэлтгэн нийлүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байх бөгөөд үүнд худалдан авах



Мон Бийф ХХ компани

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

үхэрт тавих шалгуур, төлбөр тооцоо хийхдээ шаардах баримт бичиг, үнийг тооцох журам, амьдын жингээр жинлэх үед баримтлах үнэ, толгойлон худалдан авахад баримтлах үнэ зэргийг тусгасан байгаа нь Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт заасан: *"талууд биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгийг холбогдох баримт бичгийн хамт худалдан авах"*, 244.1 дэх хэсэгт заасан: *"талууд худалдах худалдан авах гэрээнд үнийг шууд заагаагүй бол талууд үнэ тодорхойлох арга хэрэгслийн тухай хэлэлцэн тохиролцож болно"* гэх заалтуудад нийцсэн байна.

Иймд Үнэт цаас гаргагчаас баталсан дээрх журмууд нь холбогдох хууль тогтоомжид бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.3.12. Хэрэглэгч, харилцагчийн санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам**

Монгол Улсын 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар бараа, бүтээгдэхүүн /цаашид "**бараа**" гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд уг хуулийн 11.2 дахь хэсэгт: *"хэрэглэгчтэй байгуулсан гэрээний нөхцөл нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай энэ хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон нөхцөлөөс дордуулсан бол хүчин төгөлдөр бус байна"* гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар тодорхойлсон эрхийг ямар ч тохиолдолд хязгаарласан агуулгаар хэлцэл, гэрээ байгуулахыг хуулиар хориглосон байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 сарын 10-ны өдрийн 40/А-05 тоот тушаалаар "Хэрэглэгч харилцагчийн санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам"-ыг баталсан бөгөөд тус журмаар хэрэглэгч, харилцагчийн хүлээлт, сэтгэл ханамжинд нийцээгүй үл тохирсон бүтээгдэхүүний талаарх гомдол, саналыг бүртгэх, залруулах, сэргийлэх, шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна. Ингэхдээ журмын 5.1 дэх хэсэгт: *"гомдол хүлээн авах, бүртгэх журмыг зааж, гомдлыг бүтээгдэхүүний сав, баглаа, боодол дээрх байгууллагын утас, цахим хаягаар болон хэрэглэгч, харилцагч өөрийн биеэр компанийн байранд ирж аман байдлаар мэдээллэх, мөн бичгээр, борлуулагчаар гэсэн бүхий л сувгаар хүлээн авч бүртгэх"* тухай зааж, хэрэглэгчийн гомдол гаргах эрхийг баталгаажуулсан байна.

Түүнчлэн, тус журмын 5.1.3 дэх хэсэгт: *"мастер технологич бүртгэгдсэн гомдлыг 1 цагийн дотор нэгжийн удирдлагууд болон дээд удирдлагад мэдээлж, ба "Хэрэглэгч харилцагчийн гомдол мэдээллэх" тиймс (teats) группд оруулна"* хэмээн шуурхай арга хэмжээ авах талаар зохицуулсан байгаа нь онцлог байх бөгөөд энэ нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтад нийцсэн байна.

Аливаа үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн хувьд ашигтай ажиллахад хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэн чухал байдаг тул Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1, 12.3 дахь хэсэгт заасны дагуу хэрэглэгчийн гомдлын дагуу хохирлыг бүрэн барагдуулах нь чухал байдаг. Энэ хүрээнд дээрх журмын 5.3.6 дэх хэсэгт: *"гомдол нь компаниас хамаарсан болох нь мөшгөлтөөр тогтоогдсон тохиолдолд нотлох баримтыг үндэслэн хэрэглэгч харилцагчийн хохирлыг бүрэн барагдуулна"*, 5.3.7 дэх хэсэгт: *"бүтээгдэхүүнээс хамаарч хөдөлмөрийн бүтээмжээ алдсан нь эрх бүхий байгууллагаар батлагдсан тохиолдолд нотлох баримтыг үндэслэн компани барагдуулна"* гэх зэргээр хэрэглэгчийн

хохирлыг барагдуулах талаар зохицуулсан байгаа нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн байна.

Иймд энэхүү журам нь хэрэглэгч, цаашлаад Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.3.13. Нууцын тухай журам**

Байгууллагын нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 40/А-13 дугаар тушаалын хавсралтаар "Нууцын тухай журам"-ыг баталсан байна. Дээрх журам нь нууц мэдээлэлтэй ажиллах дараалал, нууц мэдээллийн зэрэглэлийг бууруулах, нууц мэдээлэлтэй харьцах эрх бүхий албан тушаалтнуудын эрх, үүрэг, хариуцлагын талаар зохицуулсан байна.

Мөн Нууцын журмын нэгдүгээр хавсралтаар байгууллагын нууцад хамаарах мэдээлэл, түүний зэрэглэлийг, хоёрдугаар хавсралтаар нууц хадгалах гэрээний загварыг тус тус баталсан байна. Ийнхүү хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд байгууллагын нууцад хамааруулсан мэдээлэл нь Байгууллагын нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан нууцлахыг хориглосон мэдээлэлд хамаарахгүй байгаагийн дээр бусад зохицуулалтууд нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

**3.3.14. Хөдөлмөрийн дотоод журам**

Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 40/А-16 дугаар тушаалын хавсралтаар Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх "Хөдөлмөрийн дотоод журам"-ын шинэчилсэн найруулгыг баталсан байна.

Тус журамд зааснаар ажилтныг дагалдангаар ажиллуулах, туршилтын хугацаагаар ажиллуулах, улирлын шинжтэй ажил гүйцэтгүүлэх, ажлын байрны хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах, түр ажлын байранд ажиллуулах зэрэг тохиолдлуудад хөдөлмөрийн гэрээг хугацаатай, дээрхээс бусад байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүйгээр байгуулна хэмээн заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1 дэх хэсэгт тусгагдсан зохицуулалтад нийцсэн байна.

Мөн хугацаатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусмагц талууд түүнийг дуусгавар болгох тухай сануулаагүй бөгөөд ажилтан ажил үүргээ гүйцэтгэсээр байгаа тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцохоор заасан нь Хөдөлмөрийн хуулийн 50.3 дахь хэсэгт заасантай нийцэж байна.

Ажилтныг өөр ажлын байранд түр шилжүүлэх үндэслэл, шилжүүлсэн хугацаа дуусмагц өмнөх ажилд эргүүлэн авах талаарх журмын зохицуулалтууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 58.1, 58.2 дахь хэсгүүдэд тус тус нийцсэн байна.

Тус журмын 4.4.4 дэх хэсэгт: "*ажлын ачааллыг тэнцүүлэх, тодорхой ажлын байранд ажиллуулахаар бэлтгэх, мэргэшүүлэх, хэд хэдэн ажлын байранд ажиллах чадвар эзэмшүүлэх, нэг ажлын байран дээр удаан ажилласнаас үүсэж болох зүй бус гадны нөлөөллөөс урьдчилан сэргийлэх үүднээс ажил олгогч болох Компани нь ажилтантай*

СЗХ 2022.06.22 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-06-17 БҮРТГЭВ-03

*харилцан тохиролцсоны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллага дотроо, харьяа компани, хэлтэс, нэгж, салбарын хооронд ажилтныг гурван жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.*" хэмээн заасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд нийцсэн байна.

Мөн дээрх журмаар шинээр ажилд орсон ажилтан 6 сар ажилласны дараа ээлжийн амралт биеэр эдлэх эрх үүсэх бөгөөд ээлжийн амралтын үндсэн болон нэмэлт амралтын хугацаа, ээлжийн амралтын цалингийн талаар холбогдох зохицуулалтууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.1, 2.13, 3.1, 3.3 болон холбогдох бусад зохицуулалтуудад нийцсэн байна.

Мөн ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, хариуцлага, илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амраах, эсвэл илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ажилтанд хувийн чөлөө олгох үндэслэл, түүний хугацаа, цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болгох үндэслэл, журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, журам, сахилгын арга хэмжээ, шийтгэлийн төрөл, түүнийг ногдуулах журам болон хөдөлмөрийн дотоод журмын бусад зохицуулалтууд нь Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зохицуулалтуудад нийцсэн бөгөөд тус хууль, түүнд нийцүүлэн гарсан бусад эрх зүйн актаар ажилтанд олгосон эрхийг хязгаарласан, явцууруулсан, хориглосон шинжтэй аливаа зохицуулалт дотоод журамд тусгагдаагүй байна.

**3.3.15. ХАБЭА-н мэдлэг, ур чадвар олгох журам**

Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 40/А-12 дугаар тушаалаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, ур чадвар олгох журам"-ыг баталсан байна.

Тус журам нь Компанийн ажилтнуудад аливаа эрүүл мэнд, амь насны осол гэмтэлд хүргэж болзошгүй аюулыг таних, урьдчилан сэргийлэх, ажлын байрны эрсдэлийг шийдвэрлэхэд шаардлагатай мэдлэг ба ур чадварыг эзэмшүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг байна. Энэ хүрээнд ажилтнуудын ХАБЭА-н мэдлэг ба ур чадварын хэрэгцээг тодорхойлох, сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх тайлагнахтай холбоотой зохицуулалтууд тусгагдсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам"-ыг баталсан бөгөөд тус журмын 1.4 дэх хэсэгт: "*Ажил олгогч нь ажилтны сургалтыг ХАБЭА-н асуудал хариуцсан нэгж, ажилтан, зөвлөлөөр гүйцэтгүүлж, хяналт тавих ба бүртгэлийн гэрчилгээ авсан байгууллагатай гэрээ байгуулан явуулж болно.*" хэмээн заасны дагуу Компани нь сургалтын байгууллагатай сургалтын гэрээ байгуулан ажиллахаар заасан байна.

Тус журамд заасанаар ХАБЭА-н сургалт нь (i) Ажил олгогчийн сургалт; (ii) Нийт ажилтны сургалт; (iii) Эрсдэлтэй ажлын байрны сургалт; (iv) ХАБЭА-н тусгай сургалт гэсэн төрөлтэй байхаар заасан бөгөөд энэ нь MNS 4969:2000 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалт зохион байгуулалт. Үндсэн дүрэм" стандарт ("Стандарт")-ийн 2.8-д заасантай нийцэж байна.

Дээрх сургалтын төрлүүдийн агуулгад хамаарах мэдээллээс үзвэл Стандартад заасан сургалтын агуулгад тусгах зохицуулалтууд бүрэн тусгагдсан байна. Мөн журамд заасан сургалт хоорондын хугацаа нь Стандартын 2.9 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн байна.

**3.3.16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам**

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 27.2. дахь хэсэгт: "*Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.*" хэмээн заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 40/А-15 дугаар тушаалын хавсралтаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам"-ыг баталсан байна.

Тус журам нь байгууллагын төвшинд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой харилцааг зохицуулдаг байна.

Дээрх журмын 3 дугаар зүйлд зааснаар ХАБЭА-н зөвлөлийн ажлын чиглэл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3-т тусгагдсан зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**3.3.17. Хөдөлмөрийн эрүүл ахуйн журам**

Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 40/А-10 дугаар тушаалын хавсралтаар "Хөдөлмөрийн эрүүл ахуйн журам"-ыг баталсан байна.

Тус журмын 4.1.2-т Эрүүл мэндийн хугацаат үзлэг, мэргэжлээс шалтгаалах өвчний судалгаа шинжилгээг хүний нөөцийн алба болон нэгжийн удирдлагуудтай хамтран жилд 1 удаа зохион байгуулахаар заасан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ын 2.1, 4.1 дэх хэсгүүдэд тус тус нийцэж байна.

Мөн журмын 4.2 дахь хэсэгт ажил олгогчийн зүгээс ажилтны эрүүл мэндийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлсон бөгөөд тус хэсгийн 4.2.2-т: "*Ажил олгогч эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр нийт ажилтныг жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамруулна.*" хэмээн заасан нь Эрүүл ахуйн тухай хуулийн 15.4 дэх хэсэгт: "*Байгууллага, аж ахуйн нэгж, ажил олгогч нь эрүүл мэндийн байгууллага болон холбогдох мэргэжлийн төрийн бус байгууллагатай хамтран эрүүл ахуйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, сургалтын байр болон сургалтад шаардагдах бусад зардалд дэмжлэг үзүүлнэ.*" хэмээн заасантай нийцэж байна.

**<u>Нэгтгэн дүгнэвэл,</u>** Үнэт цаас гаргагчийн дотоодод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцаатай холбоотой дээрх журмууд нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалын нэгдүгээр

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

хавсралтаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам", MNS 4969: 2000 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалт зохион байгуулалт. Үндсэн дүрэм" стандартад тус тус нийцэж байна.

**3.3.18. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам**

Компани нь гүйцэтгэх захирлын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 40/А-14 тоот тушаалын хавсралтаар "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөх журам"-ыг баталсан байх бөгөөд энэ нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2.1.2-т "*Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон албан хэрэг хөтлөлтийн журмыг баталж мөрдөнө*" гэсэн шаардлагад нийцэж байна. Тус журамд дурдсаны дагуу Компани нь албан хэрэг хөтлөлтийг боловсронгуй болгох, арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, Компанийн үйл ажиллагааг баримтжуулах чиг үүрэг бүхий захиргаа, бичиг хэргийн ажилтантай байх бөгөөд энэ нь "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2.1.3-т заасан шаардлагад нийцэж байна. Түүнчлэн тус журмаар захиргаа, бичиг хэгийн ажилтны эрх, үүрэг, Компанийн үйл ажиллагаанд явцад боловсруулан, хөтлөгдөж буй албан баримт бичгийн агуулга, бүтэц, албан хэрэг хөтлөлтийн шатанд баримт бичгийн бүрдэл, хадгалалт, ашиглалт зэрэгтэй холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь хууль тогтоомжид заасан шаардлагад харшлаагүй байх тул хуульд нийцсэн гэж дүгнэлээ.

**3.3.19. Гүйцэтгэлийн удирдлагын журам**

Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн эрхэм зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн байгууллагын зорилгыг ажилтан бүрийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, гүйцэтгэл биелэлтийг хянах, үнэлэх замаар бизнесийн үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 40/А-08 тоот тушаалаар Гүйцэтгэлийн удирдлагын журмыг баталсан байна. Гүйцэтгэлийн удирдлагын журмаар түүний зорилго, журмыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, мастер төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, сайжруулах, гүйцэтгэлийг үнэлэх, уг үнэлгээний дагуу авах арга хэмжээ болон хариуцлага зэрэг цогц харилцааг зохицуулсан байх бөгөөд энэхүү журмын заалт болон агуулга нь Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексд нийцсэн гэж дүгнэлээ.

**3.3.20. Мөшгөлтийн журам**

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч (буюу Үнэт цаас гаргагч) нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох үүрэгтэй байх бөгөөд энэхүү харилцааг зохицуулах зорилгоор Үнэт цаас гаргагч нь 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 40/А-07 тоот гүйцэтгэх захирлын тушаалаар Компанийн мөшгөлтийн журмыг баталсан байна. Тус журам нь ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх болон хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хөдөлгөөнийг хянах үйл ажиллагааг зохицуулсан нийт 11 бүлгээс бүрдэж байх бөгөөд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцсэн байна.

**3.3.21. Компанийн дотоод хяналтын бодлогын баримт бичгийн төсөл**

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
УЛААНБААТАР ХОТ

Компанийн засаглалын кодексийн 4 дүгээр зарчимд дурдсаны дагуу ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангах үүрэгтэй байдаг. Энэхүү шаардлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь хувьцаат компани болсоноос хойш хэрэгжих "Дотоод хяналтын бодлогын баримт бичиг"-ийн төслийг боловсруулан Хуулийн фирмд ирүүлсэн байна. Дотоод хяналтын бодлогын баримт бичгийн төслөөр Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу үр ашигтайгаар удирдан явуулах, Компанийн эд хөрөнгийг хамгаалах, найдвартай байдлыг хангах, ашиглан, залилангийн үйлдэл болон алдаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, засах, нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бодитоор бэлтгэн гаргах, эрсдэлийг тогтмол хянах, удирдахтай холбоотой харилцааг зохицуулж байх бөгөөд үүнд дараах онцлох зохицуулалтууд тусгагджээ. Тодруулбал:

- Компанийн ТУЗ нь дэргэдээ Эрсдэл, аудитын хороотой байх бөгөөд уг хороо нь дотоод хяналтын бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хянаж, дотоод хяналтын үнэлгээг жил бүр хийж, ТУЗ-д тайлагнах үүрэгтэй байх тул энэ нь Компанийн засаглалын кодексын 4 болон 5 дугаар зарчимд нийцэж байна.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо нь шүгэл үлээгчдийн мэдээллийг зохих журмын дагуу хүлээн авч, шалгалтыг хараат бусаар гүйцэтгэж шийдвэрлэдэг байх бөгөөд энэ нь Компанийн засаглалын кодексийн 8.2 дахь хэсэгт: "*аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсхүл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна*" хэмээн заасантай нийцэж байна.
- Үнэт цаас гаргагч нь Компанийн бүхий л түвшинг хамарсан хяналт шалгалт явуулах чиг үүрэг бүхий гүйцэтгэх удирдлагаас хараат бус, бие даасан дотоод аудитын газартай байх бөгөөд тус газар болон дотоод хяналтын үйл ажиллагаанд оролцох этгээдүүдийн эрх хэмжээг Дотоод хяналтын бодлогоор тус тус тодорхойлсон байх тул Компанийн засаглалын кодексийн 4 дүгээр зарчимд нийцэж байна гэж үзэх боломжтой байна.

Түүнчлэн, Дотоод хяналтын бодлогын баримт бичийн төсөлд заасны дагуу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах бүрэн эрхийг ТУЗ-д олгосон нь Компанийн тухай хуулийн 76.1.13 болон Компанийн засаглалын кодексийн 8.1.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэж байна. Иймд дээрхийг нэгтгэн дүгнэвэл уг баримт бичгийн төсөл нь энэ хэвээрээ батлагдвал Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байна.

**3.3.22. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмын төсөл**

Компанийн гүйцэтгэх захиралтай холбоотой харилцааг Компанийн тухай хуулийн 83, 84 болон 85 дугаар зүйлээр тус тус зохицуулдаг бөгөөд бид эдгээр шаардлагын хүрээнд гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг дараах байдлаар нэг бүрчлэн хянасан болно.

Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмын төсөлд дурдсаны дагуу тус журмыг Компанийн ТУЗ-өөс батлахаар байх бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 76.1.13-т заасан шаардлагад нийцэж байна.

Тус журмын төсөлд дурдсаны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн эрхэд шууд харьяалагдахаас бусад Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, зохион байгуулах эрхтэй байх бөгөөд Компанийн ТУЗ-д үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй байх тул Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт нийцсэн байна.

Энэхүү журмын төслөөр гүйцэтгэх захирлын эрх хэмжээ, хариуцлага, түүний цалин, урамшуулал, түүнийг томилох болон бүрэн эрхийг цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд эдгээр нь Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтууд болон Компанийн засаглалын кодексд заасан зарчимд нийцэж байна.

**3.3.23. Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журмын төсөл**

Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны бодлогын журмын төслөөр гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөлт, бодлогыг хэрэгжүүлэх этгээдийн үүрэг хариуцлага, сул орон тоонд залгамжлан ажиллах хүнийг олж томилох, сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байх бөгөөд журмыг нэр дэвшүүлэх хорооны саналд үндэслэн ТУЗ-өөс батлахаар байх тул энэ нь Компанийн засаглалын кодексийн 2.4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж байна.

Тухайлбал, гүйцэтгэх удирдлага ажил үүргээ түр хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүний бүрэн эрхийг тэргүүн дэд захирал хэрэгжүүлэх бөгөөд гүйцэтгэх захирал ажлаас чөлөөлөгдсөн буюу ажил үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал бий болсон бол ТУЗ-өөс Компанийн ажилтнууд, харилцагч, олон нийтэд мэдээлэл хүргэх зэргээр шат дараалласан цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна.

Хуулийн фирм нь энэхүү журмын зохицуулалтыг нэг бүрчлэн шалгахад тус журам нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн засаглалын кодекст болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

**3.3.24. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын төсөл**

Компанийн засаглалын кодексийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг тогтоох, хурлын зар хүргүүлэх, хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох баримт, мэдээлэлтэй урьдчилан судалж, танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, хурлыг удирдан явуулах санал хураах, хурлын шийдвэрийг баримтжуулах, хадгалах, тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэр болон тэмдэглэлтэй танилцах боломжийг олгох зэрэг асуудлыг зохицуулсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тусгайлсан журмыг батлан мөрдөх шаардлагатай байх бөгөөд Компани нь энэхүү шаардлагыг хангах зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын төслийг боловсруулан, Хуулийн фирмд ирүүлсэн болно. Тус төсөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар хүргэх, мэдээлэх, хурлаас шийдвэр гаргах, хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг харилцааг зохицуулсан нийт 8 бүлгээс бүрдэж байх бөгөөд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, СЗХ-ны хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журамд тус тус нийцсэн байх тул журмын төсөл энэ хэвээрээ батлагдах нөхцөлд Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

СЗХ
2022.08.22
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-17
БҮРТГЭВ-03

**3.3.25. Мэдээллийн ил тод байдлын журмын төсөл**

СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.4, Компанийн засаглалын кодексийн 3 дугаар хэсэгт тус тус заасны дагуу хувьцаат компани нь мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай бөгөөд Үнэт цаас гаргагч нь энэхүү шаардлагыг хангах зорилгоор Мэдээллийн ил тод байдлын журмын төслийг Хуулийн фирмд ирүүлсэн.

Хувьцаат компани хэлбэртэй компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 56 дугаар зүйл, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10 дугаар бүлэг, Компанийн засаглалын кодексийн 7.3 дугаар зүйл, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 21 дүгээр зүйл, МХБ-ийн Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх зааварт тус тус заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах ёстой. Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журмаар Үнэт цаас гаргагчаас тухай бүр болон тогтмол мэдээлэх мэдээлэл, түүнийг боловсруулах, түгээх журам, мэдээллийг нийтэд хүргэхэд тавигдах хязгаарлалттай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байх бөгөөд журам нь дээр дурдсан хууль тогтоомж, СЗХ болон МХБ-ийн журамд нийцэж байна.



Мон Бийф ХХ КОМПАНИ
MonBeefLLC

### 3.4 Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх тухай дүгнэлт

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Тасалбар болгосон өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг хянаж дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалаас үзвэл нийт 98 гэрээ байгуулагдсанаас Тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 52 гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

***Хүснэгт №4. Компанийн сүүлийн 3 (гурван) жилийн байдлаар бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээний тоон үзүүлэлт.***

| № | Төлөв | 2021 он | 2022 он |
|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа | 16 | 36 |
| 2. | Дуусгавар болсон | 38 | 8 |

***Хүснэгт №5. Компаниас сүүлийн 3 (гурван) жилийн байдлаар бусадтай байгуулсан Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний төрлийн тоон үзүүлэлт.***

| № | Гэрээний төрөл | Байгуулсан гэрээний тоон мэдээлэл |
|---|---|---|
| | | 2022.03.31-ний өдрийн байдлаар |
| 1 | Худалдах, худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ | 19 |
| 2 | Зээлийн гэрээ | 2 |
| 3 | Үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ | 31 |
| Нийт | | 52 |

Хуулийн фирм нь эдгээр гэрээг дүгнэхдээ гэрээний хүчин төгөлдөр байдал, хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгсөн ба зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд дүгнэсэн болно.

Ийнхүү дүгнэхдээ Компанийн нууцын журмын дагуу харилцагчидтай байгуулсан гэрээний мэдээлэл нь Компанийн нууц мэдээлэлд хамаарах бөгөөд Үнэт цаас гаргагчтай зөвшилцсөний үндсэн дээр гэрээний талын мэдээллийг ил болгохгүйгээр дүгнэсэн бөгөөд гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд дүгнэлт өгөөгүй болохыг анхаарна уу.

**3.4.1. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан худалдах худалдан авах гэрээ болон бэлтгэн нийлүүлэх гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх:**

**3.4.1.1 Үйлдвэрлэлд шаардлагатай машин механизм худалдах худалдан авах гэрээ:**

Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан үйлдвэрлэлд шаардлагатай худалдах, худалдан авах гэрээнүүд дундаас машин механизм худалдах худалдан авахтай холбоотой ач холбогдол бүхий 4 гэрээг авч хянасан бөгөөд үүнд: (i) "****" ХХК-тай байгуулсан, нийт 85,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий трактор, тоног төхөөрөмж Худалдах худалдан авах тухай 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 21/41 тоот гэрээ, (ii) 36,300,000 төгрөгийн үнийн дүн бүхий 40 тонны хөргүүртэй чингэлэг Худалдах, худалдан тухай 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2021/40/31 дугаартай гэрээ, (iii) Үхрийн мах түгээх зорилгоор 19,425,000 төгрөгийн үнийн дүн бүхий Nissan Vanette автомашин Худалдах, худалдан авах тухай 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн гэрээ болон (iv) "****" ХХК-тай байгуулсан, 3,800,000 төгрөгийн үнийн дүн бүхий үхэр усалгааны онгоц Худалдах худалдан авах тухай 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн гэрээ зэрэг болно.

Эдгээр гэрээнүүдийг нэгтгэн дүгнэвэл нэг тал нь нөгөө талаас тодорхой бэлэн байгаа биет болон эрхийн доголдолгүй машин механизм, эд зүйлийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, үүний хариуд гэрээнд заасан төлбөр төлөхөөр заасан байгаа нь Монгол Улсын Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт худалдах худалдан авах гэрээний шинжийг хангаж байна.

Гэрээнүүдийн хувьд Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгт заасны дагуу худалдах худалдан авах гэрээний гол нөхцөлүүд болох гэрээний үнэ болон гэрээний зүйлийг тусгасан байна. Түүнчлэн, талуудын эрх бүхий төлөөлөгч болох Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирал болон түүнээс олгосон итгэмжлэлийн дагуу Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэг болон 56.1.8 дахь хэсэгт нийцсэн байна. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын хувьд аль нэг тал нь гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-ийн алданги, тооцохоор тусгасан нь Иргэний хуулийн 232.4 дэх хэсэгт заасан анзын хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

СЗХ
2022 06. 22
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

Түүнчлэн, эдгээр гэрээнүүдэд авилгын эсрэг заалт нийтлэг байдлаар тусгагдаж, худалдан авагч нь гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэхдээ удирдлагын баг болон ажилтан холбогдох албан тушаалтанд мэдэгдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг, шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг хориглоно гэж тусгасан нь ач холбогдолтой байна.

Үнэт цаас гаргагчийн эдгээр гэрээнүүд нь гэрээний нөхцөлийг нэг талаас урьдчилан тогтоосон нөхцөлөөр байгуулагдсан тохиолдолд Иргэний хуулийн 200.1 стандарт нөхцөл гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 202.1, 202.2 дахь хэсэгт заасны дагуу харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байх шаардлага тавигдах бөгөөд үүнийг шалгавал эдгээр гэрээнүүд нь нэг талд хэт хохиролтой буюу шударга ёс, тэгш эрхийн зарчимд харш нөхцөл тусгагдаагүй байгаагаас гадна гэрээний талууд нь хуулийн этгээдүүд байх тул эрх тэгш байдлын үндсэн дээр гэрээг байгуулах боломжоор хангагдсан байна. Дээрх худалдах, худалдан авах төрлийн гэрээнүүдэд Иргэний хуулийн 56-60 дахь зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөл тусгагдаагүй, ийм нөхцөл байдал үүсээгүй байх учир Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байна.

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан чухал ач холбогдол бүхий худалдах, худалдан авах гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсэхээргүй байна гэж дүгнэсэн болно.

### 3.4.1.2 Үхрийн мах, малын тэжээл бэлтгэн нийлүүлэх гэрээ:

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бэлтгэн нийлүүлэх гэрээнээс ач холбогдол бүхий 3 гэрээг сонгон авч хянасан бөгөөд үүнд: (i) "******" ХХК-д чанарын шаардлага хангасан үхрийн мах тогтмол бэлтгэн нийлүүлэх үүрэг хүлээсэн 2022 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 2022-04/24 тоот гэрээ, (ii) "******" ХХК-аас тогтмол хугацаанд малын тэжээлийн зориулалтаар ашиглагдах, 50 тонн, нийт 37,500,000 төгрөгийн үнэ бүхий малын багсармал тэжээлийг гэрээгээр тохиролцсон хугацаанд Үнэт цаас гаргагчид нийлүүлэх үүрэг хүлээсэн 2021 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн ТХХАГ 21/09 дугаартай гэрээ, (iii) нийлүүлэгч буюу "******" ХХК-тай байгуулсан, жилийн хугацаанд нийт 111,995,400 төгрөгийн үнийн дүн бүхий ногоон тэжээл авах үүрэг хүлээсэн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн гэрээ.

Дээрх гэрээнүүдэд талуудыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тамгаар баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 40.1 дэх хэсэг, 62.1 дэх хэсэг, 196.1.2 дахь хэсэг болон 56.1.8 дахь заалтад нийцсэн байна. Талууд гэрээнд бэлтгэн нийлүүлэх гэрээнд тусгах шаардлагатай гэрээний гол нөхцөл болох нийлүүлэх барааны нэр, үнэ, тоо ширхэгийг тусгасан байгаа нь Иргэний хуулийн 195.3 дахь хэсэгт заасантай нийцэж байна. Түүнчлэн, энэхүү гэрээг заавал бичгээр байгуулахаар хуульд тусгагдаагүй боловч талууд бичгээр байгуулсан нь нотолгооны ач холбогдолтой гэж үзнэ.

СЗХ
2022 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

Гэрээнд заасан талуудын үндсэн үүргийг нэгтгэн дүгнэвэл нийлүүлэгч талаас эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг захиалгын тоо хэмжээний дагуу холбогдох эрүүл ахуйн шинжилгээний бичгийн хамт хүлээлгэх өгөх, Үнэт цаас гаргагч нь хүлээн авсан бүтээгдэхүүний төлбөрийг гэрээнд заасны дагуу цаг тухайд нь төлөх үүрэг хүлээсэн байна. Түүнчлэн, үхрийн мах бэлтгэх нийлүүлэх гэрээнд талууд шаардлагатай тохиолдолд нөгөө талын төлөөллийг байлцуулан мэргэжлийн байгууллагаар, эсхүл талуудын дотоод хяналтын албаар хяналт шалгалт гүйцэтгүүлж, гүйцэтгэж болохоор тусгасан байгаа нь онцлог, ач холбогдол бүхий заалт байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын хувьд үхрийн мах бэлтгэх нийлүүлэх гэрээнд Үнэт цаас гаргагч нь гэрээнд заасан төлбөр төлөх үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%-ийн алданги төлөхөөр, харин нийлүүлэгч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3%-тай тэнцэх хэмжээний алданги төлөхөөр тус тус зохицуулсан нь Иргэний хуулийн 232.4 дэх хэсэгт заасан анзын хэмжээ болон ногдуулах журамтай нийцсэн байна. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан гэрээ нь гэрээний нөхцөлийг нэг талаас урьдчилан тогтоосон нөхцөлөөр байгуулагдсан тохиолдолд Иргэний хуулийн 200.1 стандарт нөхцөл гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 202.1, 202.2 дахь хэсэгт заасны дагуу харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байх шаардлага тавигдах бөгөөд үүнийг шалгавал эдгээр гэрээнүүд нь нэг талд хэт хохиролтой буюу шударга ёс, тэгш эрхийн зарчимд харш нөхцөл тусгагдаагүй байгаагаас гадна Иргэний хуулийн 56-60 дахь хэсэгт заасан хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох нөхцөл тусгагдаагүй байх учир Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байна. Түүнчлэн, гэрээнд заасан бусад талуудын эрх, үүрэг болон хариуцлагатай холбогдолтой заалтууд нь Иргэний хуулийн 205, 225, 254, 256 дахь хэсгүүдтэй бүрэн нийцэж байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан чухал ач холбогдол бүхий бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх гэрээ нь хүчин төгөлдөр, Иргэний хуульд нийцсэн, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсэхээргүй байна гэж дүгнэсэн болно.

### 3.4.2. Үнэт цаас гарагчийн бусадтай байгуулсан зээлийн гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх:

#### 3.4.2.1. Зээлийн шугамын гэрээ

Үнэт цаас гаргагчийн зүгээс хүчин төгөлдөр хэрэгжиж буй дараах зээлийн гэрээнүүдийг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Үүнд:

- Компани нь өөрийн толгой компани болох **** ХХК-тай 2021 оны 9 дүгээр сарын 02-ний өдөр №21/01 тоот зээлийн шугамын гэрээг байгуулсан байна. Дээрх гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ

Мон Бийф ХХ компани MonBeef LLC Улаанбаатар хот

СЗХ
2022 .06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17

(2,000,000,000 төгрөг, 1,000,000 ам доллар/ 2,849,230,000 төгрөг[1] / буюу нийт 4,849,230,000 төгрөг/)-нд багтаан мөнгөн хөрөнгийг 2023 оны 7-р сарын 05-ны өдрийг дуустал хүртэлх хугацаагаар жилийн 11.1 хувь, ам долларыг жилийн 5.6 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна.

- Компани нь 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өөрийн зэргэлдээ компани болох **** ХХК-тай 22-05/45 тоот зээлийн шугамын гэрээг байгуулсан байна. Тус гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ болох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгөнд багтаан мөнгөн хөрөнгийг 1 жилийн хугацаатайгаар, жилийн 11 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл, түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагчаас бусадтай байгуулсан дээрх зээлийн гэрээнүүдэд Иргэний хуулийн 281.1 дэх хэсэгт тусгагдсан зээлийн гэрээнд тусгавал зохих гол нөхцөлүүд тусгагдсан бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга, тэмдэг даран баталгаажуулсан байна. Дээрх хэлцэл нь Компанийн тухай хуулийн 87.1 болон 89.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бөгөөд Компанийн тухай хуулийн 88.1-т заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн *"Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай"* 40/04-4 тоот шийдвэр, ТУЗ-ийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 40/ТУЗ-02 тоот *"Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай"* тогтоолын дагуу уг хэлцлийг байгуулсан байх тул зохих этгээдийн зөвшөөрөлтэйгөөр хийсэн хэлцэл байна.

Иймд дээрх зээлийн шугамын гэрээнүүд нь Иргэний хууль, Компанийн тухай хуульд нийцсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсгэхээргүй байна.

### 3.4.3. Үнэт цаас гаргагчийн бусадтай байгуулсан чухал ач холбогдол бүхий гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх:

Хуулийн фирмийн зүгээс үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой бусад гэрээ гэдэгт тухайн гэрээнд заасан нөхцөл хэрэгжээгүйгээс Компанийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэхүйц, ач холбогдол бүхий гэрээнүүдийг сонгон авч хянасан болно.

#### 3.4.3.1. Ажил гүйцэтгэх гэрээ

Компаниас Тасалбар болгосон өдрийн байдлаар хуулийн фирмд дараах ажил гүйцэтгэх гэрээнүүдийг ирүүлсэн байна. Үүнд:

[1] Гэрээ байгуулах өдрийн байдлаар ам долларын төгрөгтэй харьцах ханш 1 ам доллар=2,849.23 төгрөг.

СЗХ
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17
БҮРТГЭВ-03

- 2021 оны 09 дүгээр сарын 28-ний өдөр "***" ХХК-тай Автомат усалгааны системийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Дээрх гэрээний дагуу гүйцэтгэгч нь барилга угсралтын ажлыг барилгын зураг төсөл, норм, стандартад нийцүүлэн, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, гарал үүсэл чанар нь лабораториор баталгаажсан материалаар гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж, хүлээлгэн өгөх, захиалагч буюу Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон хөлс төлөхөөр тохиролцсоноос үзвэл талууд Иргэний хуулийн 189.1 дэх хэсгийн хүрээнд гэрээний агуулгыг өөрсдөө тодорхойлсон бөгөөд энэ Иргэний хуулийн 343-359 дүгээр зүйлд нийцсэн бөгөөд тус гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байна.

- Компани нь Төв аймгийн Сэргэлэн сумын урд байрлах үхрийн аж ахуй байгуулах 9.8 га талбайд инженер геологи, геотехнологийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгүүлэхээр 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр "***" ХХК-тай Барилгын инженер геологийн судалгааны ажил гүйцэтгүүлэх тухай гэрээ байгуулсан байна.

- Компани нь Төв аймгийн Сэргэлэн суманд байрлах өөрийн бордооны үхрийн цогцолбор аж ахуйн үхрийн тэжээлийн бааз төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, аж ахуйн үйл ажиллагааг тогтворжуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр *****-тай хөдөө аж ахуйн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна. Тус гэрээний дагуу гүйцэтгэгч тал нь Бордооны үхрийн аж ахуйн үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөгөө өгөх, зохион байгуулалт хийх, тэжээллэг баазыг төлөвлөх, тэжээлийн жор боловсруулах, аж ахуйн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, чадавхжуулах зэрэг зөвлөх үйлчилгээ үзүүлэх, захиалагч нь зөвлөхийн ажлыг хүлээн авч хөлс төлөхөөр харилцан тохиролцсон байна.

Дээрх гэрээнүүдээс гадна Тасалбар болгосон өдрийн байдлаар дараах хоёр Ажил гүйцэтгэх гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

- Компани нь 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдөр "******" ХХК-тай Зураг төсөл боловсруулах гэрээ байгуулсан байна. Тус гэрээний дагуу гүйцэтгэгч болох Сивил дизайн ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт баригдах фермийн ерөнхий төлөвлөгөө, ажилчдын байр, уурын зуухны барилгын ажлын зураг төслийг боловсруулах, захиалагч буюу Үнэт цаас гаргагч нь харилцан тохиролцсон хөлс төлөхөөр тус тус тохиролцсон байна.

- 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр "*******" ХХК-тай Барилгын зургийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Уг гэрээгээр Гүйцэтгэгч "*******" ХХК нь захиалагч буюу Компанийн заасан байршилд баригдах махны үйлдвэрийн болон ажилтнуудын байрны барилгын зураг төслийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартад заасны дагуу боловсруулах, төрийн эрх бүхий байгууллагатай зөвшилцөн баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийлгэх, захиалагч буюу Үнэт

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

цаас гаргагч нь ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөхөөр тохиролцсон байна.

Компаниас ирүүлсэн дээрх ажил гүйцэтгэх гэрээнүүдийн дагуу ажил, үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд гэрээнд заасан үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдүүд бөгөөд гэрээг бичгээр үйлдэж, талуудыг төлөөлж эрх бүхий албан тушаалтнууд гарыг үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байх ба Иргэний хуулийн 56-60 дугаар зүйлд тодорхойлсон хэлцэл хүчин төгөлдөр бус байх, хэлцлийг хүчин төгөлдөр буст тооцох үндэслэл тогтоогдохгүй байна. Тус гэрээнүүд нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

### 3.4.4. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн эсэх:

ХЭУБГ-ийн лавлагаагаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) тогрог байх ба Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн нь 75,000,000 (далан таван сая) төгрөг ба түүнээс дээш мөнгөн дүн байна.

Тасалбар болгох өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээ (буюу 75,000,000 төгрөг ба түүнээс дээш хэмжээ)-ний үүрэг хүлээсэн дараах гэрээг байгуулсан байна. Үүнд:

***Хүснэгт №6 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээний жагсаалт***

| № | Гэрээний нэр | Үнэ | Гэрээ байгуулсан огноо | Хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Sales Contract | 47,350 ам.доллар (134,936,609 төгрөг [2]) | 2021.05.24 | Үгүй |
| 2 | Ажил гүйцэтгэх ерөнхий гэрээ | 235,000,000 | 2021.05.28 | Үгүй |
| 3 | Үхрийн хашаа угсралтын ажил гүйцэтгэх гэрээ | 157,000,000 | 2021.09.28 | Үгүй |
| 4 | Гражийн барилгын угсралтын ажил гүйцэтгэх гэрээ | 300,000,000 | 2021.09.03 | Үгүй |

[2] Гэрээ байгуулсан өдрийн байдлаарх Монголбанкны төгрөгийн ам доллартай харьцах ханш 1 ам доллар = 2.849.41 төгрөг.

СЗХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Ногоон тэжээл худалдах, худалдан авах гэрээ | 108,000,000 | 2021.12.13 | Үгүй |
| 6 | Ногоон тэжээл худалдах, худалдан авах гэрээ | 102,130,100 | 2021.11.23 | Үгүй |
| 7 | Хамтран ажиллах гэрээ | 100,000,000 | 2021.11.02 | Тийм |
| 8 | Худалдах, худалдан авах гэрээ | 85,000,000 | 2021.06.02 | Үгүй |
| 9 | Зээлийн шугамын гэрээ | 4,849,230,000 | 2021.09.02 | Тийм |
| 10 | Зээлийн шугамын гэрээ | 10,000,000,000 | 2022.03.25 | Тийм |

Дүгнэлт гарах өдрийн байдлаар Компаниас бусадтай байгуулсан Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээг дүгнэвэл:

- Хөлсөөр ажиллах гэрээ

Компани нь 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр ***** ХХК-тай 21/15 тоот хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Талууд тус гэрээг хамтран ажиллах гэрээ хэмээн нэрлэсэн хэдий ч гэрээнд тусгагдсан талуудын эрх, үүргээс үзвэл дээрх гэрээ нь Иргэний хуулийн 359.1 дэх хэсэгт тусгагдсан хөлсөөр ажиллах гэрээнд хамаарахаар байна. Тус гэрээний дагуу гүйцэтгэгч ***** ХХК нь гэрээ байгуулснаас хойш 1 жил хүртэлх хугацаанд захиалагч талын (буюу Компанийн) өмчлөлийн үхрийг өөрийн үйлдвэртээ төхөөрч, сэврээх, шулж ангилах, дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж, савлах болон гүн хөлдөөх, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэх, захиалагч нь харилцан тохиролцсон хөлс болох 100,000,000 төгрөгийг төлөхөөр тус тус тохиролцсон байна. Талуудын хооронд байгуулагдсан дээрх гэрээ нь хөлсөөр ажиллах гэрээнд тусгавал зохих гол нөхцөлийг тусгасан, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байх тул хуульд заасан агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Түүнчлэн, Иргэний хуулийн 56 дугаар зүйлээс 60 дугаар зүйлд заасан хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцогдох аливаа нөхцөл болон гэрээний аль нэг талын үүргийн зөрчил байхгүй тул хууль зүйн хувьд Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар тогтоогдохгүй байна.

- Зээлийн шугамын гэрээ

Компани нь өөрийн толгой компани болох **** ХХК-тай 2021 оны 9 дүгээр сарын 02-ний өдөр №21/01 тоот зээлийн шугамын гэрээг байгуулсан байна. Дээрх гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ (2,000,000,000 төгрөг, 1,000,000 ам доллар/ 2,849,230,000 төгрөг / буюу нийт 4,849,230,000 төгрөг/)-нд багтаан мөнгөн хөрөнгийг 2023 оны 7-р сарын 05-ны өдрийг дуустал хүртэлх хугацаагаар жилийн 11.1 хувь, ам долларыг жилийн 5.6 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна



Мон Бийф ХХК компани

СЗХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17

Компани нь 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр өөрийн зэргэлдээ компани болох **** ХХК-тай 22-05/45 тоот зээлийн шугамын гэрээг байгуулсан байна. Тус гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ болох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгөнд багтаан мөнгөн хөрөнгийг 1 жилийн хугацаатайгаар, жилийн 11 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл, түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна.

Үнэт цаас гаргагчийн зүгээс бусадтай байгуулсан дээрх зээлийн гэрээнүүдэд Иргэний хуулийн 281.1 дэх хэсэгт тусгагдсан зээлийн гэрээнд тусгавал зохих гол нөхцөлүүд тусгагдсан бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга, тэмдэг даран баталгаажуулсан байна. Дээрх хэлцэл нь Компанийн тухай хуулийн 87.1 болон 89.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бөгөөд Компанийн тухай хуулийн 88.1-т заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн *"Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай"* 40/04-4 тоот шийдвэр, ТУЗ-ийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 40/ТУЗ-02 тоот *"Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай"* шийдвэрийн дагуу уг хэлцлийг байгуулсан байх тул зохих этгээдийн зөвшөөрөлтэйгөөр хийсэн хэлцэл байна

Иймд Компанийн зүгээс өөрийн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүсээгүй байна.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ



6648436
MonBeefLLC
МОН БИФ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

### 3.5. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаар

Үнэт цаас гаргагч нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдсан учир 2021 оны 1 дүгээр сараас 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд бусадтай бичгээр байгуулсан их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулсан эсэхийг судалж үзлээ.

#### 3.5.1. Их хэмжээний хэлцэл:

Их хэмжээний хэлцлийг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд зохицуулсан бөгөөд 87.1.1 дэх хэсэгт: "*хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/*"; мөн хуулийн 87.1.2 дахь хэсэгт: "*компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг*" гэж тус тус тодорхойлсон байдаг.

Түүнчлэн, тус хуулийн 88.1 дэх хэсэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтэйгээр гаргах бөгөөд 88.2 дахь хэсэгт заасны дагуу хэрэв ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэхээр тусгасан байдаг.

Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна.

***Хүснэгт №8. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн балансын активын 25%-ын тоон үзүүлэлт.***

| № | Хугацаа | Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр) | Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1 | 2021 оны нэгдүгээр улирал | 199,899,010.00 | 49,974,752.50 |
| 2 | 2021 оны хоёрдугаар улирал | 670,412,743.10 | 167,603,185.78 |
| 3 | 2021 оны гуравдугаар улирал | 1,776,718,637.48 | 444,179,659.37 |
| 4 | 2021 оны дөрөвдүгээр улирал | 3,718,709,091.09 | 929,677,272.98 |
| 5 | 2022 оны нэгдүгээр улирал | 3,810,244,226.26 | 952,561,056.57 |

Дээрх тоон үзүүлэлтийн дагуу Үнэт цаас гаргагч нь энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэгт тодорхойлсон их

хэмжээний хэлцэлд хамаарах зээлийн шугамын гэрээг 2021 оны 9 дүгээр сарын 02-ний өдөр "***" ХХК-тай байгуулсан байна. Тус гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ ( 2,000,000,000 төгрөг, 1,000,000 ам доллар/ 2,849,230,000 төгрөг / нийт 4,849,230,000 төгрөг/)-нд багтаан мөнгөн хөрөнгийг 2023 оны 7-р сарын 05-ны өдрийг дуустал хүртэлх хугацаагаар жилийн 11.1 хувь, ам долларыг жилийн 5.6 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна.

2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр "****"ХХК-тай байгуулсан байна. Тус гэрээний дагуу зээлдүүлэгч нь зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ болох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгөнд багтаан мөнгөн хөрөнгийг 1 жилийн хугацаатайгаар, жилийн 11 хувийн хүүтэйгээр зээлдэгч (буюу Компани)-ид шилжүүлэх, зээлдэгч нь зээл, түүний хүүг гэрээнд заасан хугацаанд төлөх үүргийг тус тус хүлээсэн байна.

Эдгээр хэлцлүүд нь Компанийн тухай хуулийн 87.1 болон 89.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бөгөөд Компанийн тухай хуулийн 88.1-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн "*Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай*" 40/04-4 тоот шийдвэр, ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн "*Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах тухай*" 40/ТУЗ-02 тоот шийдвэрийн дагуу уг хэлцлийг байгуулсан байх тул зохих этгээдийн зөвшөөрөлтэйгөөр хийсэн хэлцэл байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилд байгуулагдсан их хэмжээний хэлцлийг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн зохих журмын дагуу олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хуульд заасан журмын дагуу байгуулсан гэж дүгнэлээ.

### 3.5.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт: "*Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно*" гэж тодорхой заасан байдаг бөгөөд дээрх хуулийн 91.2 дахь хэсэгт тусгаснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй байхаар заасан байдаг.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах журмын талаар Компанийн тухай хуулийн 92.1 дэх хэсэгт: "*Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай*

СЭХ
2022 08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

*шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргана*", мөн хуулийн 76.1.17 дахь хэсэгт: "*компанийн ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох*"-оор тус тус зохицуулсан байдаг.

Үнэт цаас гаргагчаас Бидэнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн хугацаанаас тасалбар болгох өдөр хүртэлх хугацаанд нийт 6 сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан бөгөөд эдгээр хэлцэлтэй холбоотой аливаа маргаан үүсээгүй талаар 2022 оны 05 дугаар сарын 16 -ны өдрийн 40/А-125 тоот батламжийг мэдэгдлийг ирүүлсэн болно.

***Хүснэгт №7 сүүлийн гурван жилийн байдлаар Компанийн байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл***

| № | Гэрээний нэр | Гэрээ байгуулагч, түүний сонирхлын зөрчлийн хамаарал | Гэрээний агуулга | Гэрээ байгуулсан огноо | Хувьцаа эзэмшигч, ТУЗ баталсан эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Худалдах худалдан авах гэрээ | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани болох "Таван Богд Сольюшнс" ХХК-тай байгуулсан хэлцэл | Камер, холбогдох хэрэгслийг нийт 4,481,100 төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээ. | 2021.11.12 | ХЭХ-ын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 40/25-3 тоот шийдвэр |
| 2 | Үйлдвэрийн бүтээгдэхүүн худалдах худалдан авах гэрээ | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани болох "Улаанбаатар гурил" ХХК-тай байгуулсан хэлцэл | Тодорхой хугацаанд зах зээлийн үнээр хивэг худалдах, худалдан авах гэрээ | 2021.10.22 | ХЭХ-ын 2021 оны 10 дугаар сарын 21-нпа өдрийн 40/05-2 тоот шийдвэр |
| 3 | Автомашин худалдах худалдан авах гэрээ | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани болох "Жуулчин Дюти Фрий" ХХК-тай байгуулсан хэлцэл | Компанийн үйлчилгээнд зориулж 55,000,000 төгрөгийн автомашин худалдах, худалдан авах гэрээ | 2021.08.03 | ХЭХ-ын 2021 оны 08 дугаар сарын 2-ны өдрийн 40/04-02 тоот шийдвэр |
| | | "Таван Богд Трейд" ХХК-ийн охин | Үйл ажиллагааныхаа зорилгоор эзэмшүүлж, | | ХЭХ-ийн 2021 оны |

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Түрээсийн гэрээ | компани болох “Таван Богд Проперти” ХХК-тай байгуулсан хэлцэл | ашиглуулах зорилгоор 40 тн багтаамжтай 3 ширхэг контэйнер нэг сарын 880,000 төгрөгөөр түрээслэх гэрээ | 2021.08.25 | 08 дугаар сарын 24-ны өдрийн 40/24-03 тоот шийдвэр |
| 5 | Зээлийн шугамын гэрээ | “Таван Богд Трейд” ХХК | Зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ ( 2,000,000,000 төгрөг, 1,000,000 ам доллар/ 2,849,230,000 төгрөг[3]/ нийт 4,849,230,000 төгрөг)-нд багтаан төгрөгийн жилийн 11.1 хувь, ам долларын жилийн 5.6 хувийн хүүтэйгээр 2023 оны 7-р сарын 05-ны өдрийг дуустал хүртэлх хугацаагаар байгуулсан зээлийн гэрээ | 2021.09.02 | ХЭХ-ийн 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 40/04-4 тоот шийдвэр |
| 6 | Зээлийн шугамын гэрээ | “Таван Богд Трейд” ХХК-ийн охин компани болох “Таван Богд” ХХК-тай байгуулсан хэлцэл | Зээлийн шугамын эрхийн дээд хэмжээ (10,000,000,000 төгрөг)-нд багтаан жилийн 11 хувийн хүүтэйгээр, 1жилийн | 2022.03.25 | ТУЗ-ийн 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 40/ТУЗ-02 тоот тогтоол |

[3] Гэрээ байгуулах өдрийн байдлаар ам долларын төгрөгтэй харьцах ханш 1 ам доллар=2,849.23 төгрөг.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хугацаатай байгуулсан зээлийн гэрээ | | |

Дээрх хэлцлийн талууд нь Компанийн тухай хуулийн 6.15 дахь хэсэгт заасан нэг толгой компанийн охин компаниуд буюу зэргэлдээ компаниуд хоорондоо болон толгой компанитай хийгдсэн хэлцэл байх тул Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарч байна. Түүнчлэн, эдгээр хэлцлүүдээс 5 хэлцэл нь нь Үнэт цаас гаргагчийг 2022 оны 02 дугаар сард ТУЗ-тэй болохоос өмнө батлагдсан хэлцлүүд учир Компанийн тухай хуулийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах, 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан хэлцлийн хувьд ТУЗ-өөр батлуулах шаардлага тавигдана.

Үнэт цаас гаргагчийн дээрх хэлцлүүдийг хийх тухай зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрүүд болон ТУЗ-ийн тогтоолоос үзвэл Компанийн тухай хуулийн 92.1, 91.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар хэлцлийг батлах эсэх талаар зөвшөөрөл олгох шийдвэр гаргах ёстой боловч Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь “Таван Богд Трейд” ХХК-тай нэгдмэл сонирхолтой этгээд буюу тухайн хэлцэлд сонирхлын зөрчилтэй байх тул шийдвэрүүдийг бүх хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтэйгээр гаргаж, хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид эсхүл ТУЗ-ийн гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурсан байна.

Түүнчлэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай зөвшөөрөл олгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг үзвэл хэлцэл тус бүрийн гэрээний нөхцөл, гэрээ байгуулах үнэ зэргийг урьдчилан танилцуулж, хэлэлцүүлсний дүнд хувьцаа эзэмшигчдийн саналыг авч, хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлаар аливаа эсрэг санал тэмдэглэгдээгүй байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн хугацаанд байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухай бүрт ТУЗ /байхгүй үед ХЭХ-аас/-өөс зохих журмын дагуу олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хуульд заасан журмын дагуу байгуулсан гэж дүгнэлээ.

### 3.6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх тухай

**3.6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байгаа эсэх тухай**

ХЭУБГ-т бүртгүүлсэн Компанийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрмийн 1.6-д зааснаар, мөн ХЭУБГ-ын лавлагаанд дурдсанаар Компани нь дараах чиглэлд үйл ажиллагааг хугацаагүйгээр явуулдаг байна. Үүнд:

- Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
- Барилгын материалын худалдаа;
- Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх;
- Мах боловсруулах, консервлох;
- Малын тэжээл үйлдвэрлэл;
- Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа.

Компанийн эрхэлж буй дээрх үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгагдсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааны төрөлд хамаарахгүйн дээр Компани тусгай зөвшөөрөл авахаар хуулиар тусгайлан шаардсан үйл ажиллагаа эрхэлдэггүй буюу үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байхгүй байна.

**3.6.2. Үнэт цаас гаргагчийн зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмших эрх нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх тухай**

Оюуны өмчийн газрын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 4/130 тоот болон 3/132 тоот лавлагаанууд тус тус зааснаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр аливаа зохиогчийн эрх, аж үйлдвэрийн өмч (шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг)-ийн эрх бүртгэгдээгүй байна.

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

3.7. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх тухай

**3.7.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг үүссэн эсэх**

Компанийн дүрэм болон ХЭУБГ-ын2022 оны 5 дугаар сарын 10-ний өдрийн 22260002002026 дугаар лавлагаанд дурдсанаар Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 150,000,000 ( нэг зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаа гаргасан байна. Үнэт цаас гаргагчийн хувьцааг энэхүү Дүгнэлтийн Хүснэгт №1-д тусгагдсаны дагуу 6 (зургаан) хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад барьцаалсан тухай ямар нэгэн мэдээлэл хөдлөх хөрөнгийн барьцааны www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой аливаа санхүүгийн хэрэгсэл эзэмшдэггүй ба ямар нэгэн үл хөдлөх эд хөрөнгө өмчилдөггүй талаар Хуулийн фирмд 2022 оны 05 дугаар сарын 16 -ны өдөр ирүүлсэн 40/А-125 тоот батламжаар мэдэгдсэн болно.

**3.7.2. Үнэт цаас гаргагчийн газрын эрх, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг үүссэн эсэх**

***3.7.2.1. Газар эзэмших эрх***

Үнэт цаас гаргагч нь Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р багт байрлах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборын зориулалттай, 4109060940 тоот нэгж талбарын дугаартай, эрхийн улсын бүртгэлийн Э-1419004402 дугаар бүхий 9.9 га газрыг эзэмших эрхтэй болно.

Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн 2022 оны 5-р сарын 4-ний өдрийн нэгж талбарын тодорхойлолтоос үзвэл Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу холбогдох төрийн байгууллагад бүртгэгдсэн байна. Газар эзэмших гэрээнд заасан газрын төлбөрийг хуульд заасан хугацаанд төлсөн бөгөөд төлбөрийн үлдэгдэлгүй болох нь Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай 2022 оны 5-р сарын 5-ны өдөр үйлдсэн Газрын төлбөрийн тооцоо нийлсэн актаар тогтоогдож байна. Мөн Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу газар эзэмших, эрх нь дуусгавар болоогүй, газрын эрх нь хүчин төгөлдөр, хуульд заасан шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангасан байна.

Газрын тухай хуулийн 35.1.7 дахь хэсэгт заасны дагуу газар эзэмшигч нь газар эзэмших эрхээ газрын тухай хуульд заасны дагуу барьцаалж болох ба энэ тохиолдолд Газрын тухай хуулийн 35.3.6-д заасны дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай. Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн 2022 оны 5-р сарын 22-ны өдрийн нэгж талбарын тодорхойлолтын дагуу Компанийн эзэмшиж



Мон Бийф ХХ компани
УЛААНБААТАР ХОТ

буй 9.9 га газар эзэмших эрхийг аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан тухай мэдэгдэл байхгүй байна.

Иймд дээрх газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд хугацаа нь дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсээгүй байна.

### *3.7.2.2. Авто тээврийн хэрэгсэл болон бусад хөдлөх хөрөнгө*

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл болон Авто тээврийн үндэсний төвийн 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн тодорхойлолтоос үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр дараах авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. Үүнд:

***Хүснэгт №9. Компанийн өмчлөл дэх авто тээврийн хэрэгслийн мэдээлэл***

| № | Тээврийн хэрэгслийн улсын дугаар | Марк/ модель | Үүрэг ногдуулсан хэлцэл бий эсэх |
|---|---|---|---|
| 1. | 74 63 УБҮ | Toyota Land Cruiser Prado | Үгүй |
| 2. | 94 60 УАН | Toyota Succeed | Үгүй |
| 3. | 39 50 УБР | Isuzu Giga | Үгүй |
| 4. | 86 74 УАН | Nissan Vanette | Үгүй |
| 5. | 88 90 УР | Shandong Lugong L938 | Үгүй |
| 6. | 39 50 УР | Yto LY1104 | Үгүй |
| 7. | 39 50 МЧ | Qingdao QQV9405 | Үгүй |

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1[4] дэх хэсэгт заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгүүлдэг ба уг бүртгэлд хийсэн судалгаанаас үзвэл 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй дээрх тээврийн хэрэгслүүдийг аливаа үүргийн гүйцэтгэлийг хангахаар барьцаалсан мэдэгдэл тус цахим санд бүртгэгдээгүй байна.

Үнэт цаас гаргагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх аудитлагдсан санхүүгийн тайлан болон 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Бидэнд ирүүлсэн 40/А-125 тоот батламжаас үзвэл 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Компани нь дээр дурдсан авто тээврийн хэрэгслийг оролцуулан нийт 1,413,011,000 (нэг тэрбум дөрвөн зуун арван гурван сая арван нэгэн мянга) төгрөгийн үнэ бүхий хөдлөх бусад эд хөрөнгө (машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгсэл гэх мэт) бүртгэлтэй байна. Үнэт цаас цаас гаргагчийн санхүүгийн тайланд тусгагдсан дээр дурдсанаас бусад хөдлөх эд хөрөнгө (тухайлбал, оффисийн хэрэглээ, ахуйн хэрэглээ, тоног төхөөрөмж гэх мэт)-ийн өмчлөх эрхийг

[4] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг: *"Цахим мэдээллийн санд бүртгэгдсэн барьцааны мэдэгдэл нийтэд нээлттэй болсон үеэс хүчин төгөлдөр болно."*

хөндлөнгийн байр суурьнаас баталгаажуулах боломжгүй тул эдгээр хөрөнгөтэй холбоотой мэдээллийг Үнэт цаас гаргагчаас тодруулна уу.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд хийсэн судалгаагаар 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй дээрх хөдлөх эд хөрөнгөнд үүрэг ногдуулсан аливаа барьцааны мэдэгдэл бүртгэгдээгүй байна. Түүнчлэн, Компанийн аливаа хөрөнгийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүднээс бусдад барьцаалсан, үүрэг хүлээсэн зүйл байхгүй болохыг Үнэт цаас гаргагч 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 40/А-125 тоот батламжаараа тодорхойлсон байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн эд (үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө)-ийн болон эдийн бус хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр байгаа бөгөөд тэдгээртэй холбоотой аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн, барьцаалсан зүйл байхгүй байна.

СЭХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

### 3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх тухай

Үнэт цаасны танилцуулга нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.5, Биржийн журмын 4 дүгээр зүйлд заасан шаардлагыг тус тус хангасан байх ёстой.

Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны танилцуулга нь нийт үндсэн 4 бүлгээс бүрдэх бөгөөд үнэт цаасны танилцуулгад заавал тусгах суурь мэдээллийг бүрэн багтаасан байх тул холбогдох хууль, журамд нийцэж байна гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг оролцогч этгээдүүдийн үүсгэн байгуулах болон бусад баримт бичиг, мөн холбогдох хууль тогтоомж, журамтай тулган шалгах, оролцогч этгээдүүд болон төрийн эрх бүхий байгууллагаас тодруулга, лавлагаа авах замаар шалгахад түүнд тусгагдсан хууль зүйн мэдээллүүд нь тухайн баримт бичигтэй нийцэж байх тул үнэт цаасны танилцуулга, түүнд тусгагдсан хууль зүйн мэдээллийг үнэн зөв, хүчин төгөлдөр гэж дүгнэж байна. Үнэт цаасны танилцуулгатай холбоотой дэлгэрэнгүй хууль зүйн шинжилгээ, дүгнэлтийг Хавсралт №2-аас үзнэ үү.



Мон Бийф ХХ компани
MonBeef LLC

## 3.9. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох нь

### 3.9.1. Үнэт цаас гаргагчийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэл

Компанийн тухай хуулийн 6.1 дэх хэсэгт: "*Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ*", 6.3 дахь хэсэгт: "*Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ*", 6.15 дахь хэсэгт: "*Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэрэгэлдээ компани гэнэ*" хэмээн тус тус зохицуулсан байдаг.

Үнэт цаас гаргагчийн нийт хувьцааны 75%-ийг "Таван Богд Трейд" ХХК эзэмшдэг учир Үнэт цаас гаргагч нь "Таван Богд Трейд" ХХК-ийн охин компани байх бөгөөд доороо охин болон хараат компанигүй байна. Бидэнд ирүүлсэн мэдээллээр үнэт цаас гаргагч нь дараах 36 зэргэлдээ компанитай байна. Үүнд:

- Улаанбаатар гурил ХХК;
- Таван Богд Проперти ХХК;
- Таван Богд ХХК;
- Улаанбаатар Принт ХХК;
- Жуулчин ХХК;
- Хаан Палас ХХК;
- Таван Богд Вашёкү ХХК;
- Таван Богд Хот Пот ХХК;
- Таван Богд Смарт Электроникс ХХК;
- Монгол Машин Концерн ХХК;
- Таван Богд Резиденс ХХК;
- Таван Богд Хаус ХХК;
- Сэргэлэн Ресорт ХХК
- Таван Богд Солюшнс ХХК;
- Таван Богд Интернэйшнл ХХК;
- Таван Богд Финанс ХХК;
- Таван Богд Билдинг Саплай ХХК;
- Таван Богд Мон Мийт ХХК;
- Таван Богд Капитал ХХК;
- Таван Богд Фүүдс ХХК;
- Эйрлинк Монголиа ХХК;
- Говь ХК;
- Жуулчин Дюти Фрий ХК;

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

- Говь Монголиан Кашмир Ю Эс Эй Корп;
- Говь Кашмир Иннер Монголиа ХХК;
- Говь Кашмир Европ ХХК;
- Гоёо ХХК;
- Таван Богд Фүүдс Пицца ХХК;
- Фүүд Сервис Солюшн ХХК;
- Жуулчин Ворлд ХХК;
- Файв старс ин Хархорин ХХК;
- Таван Богд Тайер ХХК;
- Ти Би Юу Би Эф ХХК;
- Таван Богд Кубикс ХХК;
- Таван Богд дистрибьюшн ХХК.
- Наран кредит ХХК

### 3.9.2. Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч:

Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлохдоо Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн хурлаар шийдэгдэж байгаа аливаа асуудлаар саналын давуу эрхтэй буюу эцсийн шийдвэрийг гаргахад саналын олонхоороо шууд нөлөөлөх боломжтой, аливаа шийдвэр гарахад хамгийн нөлөөлөл бүхий хувьцаа эзэмшигчийг компанийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гэж үзэн тогтоосон болно.

*Үнэт цаас гаргагчаас бидэнд ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, эзэмшиж буй хувьцааны тоо хэмжээ*

| № | Хувьцаа эзэмшигч | Тоо ширхэг | Нийт үнэ | Дүрмийн санд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Таван Богд Трейд ХХК | 112,500,000 | 1,125,000,000 | 75% |
| 2 | Ж.Барсболд | 15,000,000 | 150,000,000 | 10% |
| 3 | Ц.Цэцэнхүү | 7,500,000 | 75,000,000 | 5% |
| 4 | Э.Пүрэвлхам | 7,500,000 | 75,000,000 | 5% |
| 5 | Ж.Оюунчимэг | 3,000,000 | 30,000,000 | 2% |
| 6 | И.Баттуяа | 4,500,000 | 45,000,000 | 3% |
| | **Нийт** | **150,000,000** | **1,500,000,000** | **100%** |

Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт: "*Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна*", 62.3 дахь хэсэгт: "*Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна*", 63.5 дахь хэсэгт: "*Энэ хууль болон компанийн дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно*" гэж заасан байдаг боловч Компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн саналын хувийг тодорхой зааж өгөөгүй байгаа тул

хуульд илүү дээгүүр хувь тогтоосноос бусад асуудлаарх хувьцаа эзэмшигчдийн хурлын аливаа шийдвэр нь олонхийн саналаар гарахаар байна.

Иймд Үнэт цаас гаргагчид хамгийн их саналын эрхтэй хувьцаа эзэмшигч болох "Таван Богд Трейд" ХХК (75% хувийн 112,500,000 ширхэг хувьцаа эзэмшигч) нь Компанийн хяналтын багцыг хэрэгжүүлэгч байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

### 3.9.3. Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулийн 3.1.6 дахь хэсэгт: **"эцсийн өмчлөгч"** гэдэгт "*харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг*" ойлгохоор тусгасан. Мөн уг хуулийн $4^1$ хэсэгт компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох дарааллыг зохицуулсан байх бөгөөд $4^1$.1.1 дэх хэсэгт: "*хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг*", $4^1$.1.2 дахь хэсэгт: "*энэ хуулийн $4^1$.1.1-д заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг*", $4^1$.1.3 дахь хэсэгт: "*энэ хуулийн $4^1$.1.1, $4^1$.1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг*" хэлэхээр заасан.

ХЭУБГ-ын лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 75%-ийг эзэмшигч "Таван Богд Трейд" ХХК нь эцсийн өмчлөгч хуулийн этгээдээр, "Таван Богд Трейд" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ц.Баатарсайхан нь эцсийн өмчлөгч иргэнээр бүртгэгдсэн байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь "Таван Богд Трейд" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ц.Баатарсайхан байна гэж дүгнэлээ.

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх тухай

2022 -06- 17
БҮРТГЭВ-03

**3.10.1. Арбитрын маргаан**

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитраас 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдөр ирүүлсэн 4/312 тоот лавлагаанаас үзвэл тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх арбитрын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн № GS-2022- 607 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь тус арбитрт сүүлийн гурван жилийн хугацаанд хянан шийдвэрлэгдсэн хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна

**3.10.2. Захиргааны хэргийн маргаан**

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 1/808 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн хугацаанд тус шүүхэд хянан шийдвэрлэгдсэн захиргааны хэрэгт нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр оролцож байгаагүй байна.

**3.10.3. Эрүүгийн хэргийн маргаан**

Цагдаагийн ерөнхий газрын харьяа цагдаагийн байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжээс 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдөр гаргаж өгсөн Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай болон эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь аливаа гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүйн дээр тодорхойлолт гарах өдрийн байдлаар эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байна.

Иймд Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт оролцогчоор татагдаж байгаагүй байх ба арбитр, иргэн, захиргааны хэргийн оролцогч байгаагүй байна.

**3.10.4. Иргэний хэргийн маргаан**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхийн тусгай архивын 2022 оны 03-р сарын 07-ний өдрийн 1/568 тоот лавлагаанд дурдснаар Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн байдлаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй байна.

## 3.1. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх тухай

Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн тодорхойлолт, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 161 тоот албан бичиг, Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 4/343 тоот албан бичигт дурдсанаар Компани нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна.

Түүнчлэн Компани нь улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой аливаа зөрчилтэй эсэхийг тодруулах зорилгоор бид төрийн эрх бүхий байгууллагуудаас тодруулга хүсэхэд тус байгууллагуудаас дараах агуулга бүхий лавлагаа, мэдээллийг гарган өгсөн болно. Тодруулбал:

- Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 4/343 тоот албан бичигт: "*Компани нь үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн тайлангаар ногдуулсан татваруудаа цаг тухайд нь төлж, татварын алданги торгууль болон татварын өргүй, урьд онуудад татварын хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй болно ...*";
- Нийслэлийн Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 161 тоот албан бичигт ".. *Тус компани нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой ямар нэгэн зөрчил одоогоор үүсгээгүй байгаа болно.*";
- Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 5/3030 тоот албан бичигт: "*... Компанийн хувийн хэрэгт Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан баримт байхгүй байна*".

Дээрх лавлагаа, мэдээллээс дүгнэвэл Компани нь улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой аливаа зөрчилгүй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-21
БҮРТГЭВ-03

2022.06.22
БҮРТГЭВ
№ 01

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

| ӨМГӨӨЛЛИЙН "ЭМ ЖЭЙ ЭЛ АТТОРНЕЙС" ХХН | ӨМГӨӨЛЛИЙН "ХААНЛЕКС ПАРТНЕРС" ХХН |
|---|---|
| НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН: | НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН: |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| Нэр: М.Мөнхжаргал | Нэр: Г.Батжаргал |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| Нэр: О.Мөнхболд | Нэр: И.Учралбаяр |

2022 оны 6 дугаар сарын 21-ны өдөр

# ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

# МОН БИЙФ

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

---

2021 оны 12 дугаар сарын 31-ний
өдрөөр дуусвар болсон жилийн
Санхүүгийн Тайлан болон хараат
бус аудиторын дүгнэлт

Улаанбаатар хот, 2022 он

СЭХ
2022 06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

# МОН БИЙФ

**Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн
Санхүүгийн Тайлан

**"Эс Жи Эм Ди-Аудит" ХХК**
Монгол улс, Улаанбаатар-46,
Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Оюутны гудамж-44,
14/ 2 и байр, 9 тоот
Утас: 976-11-70006948
Факс: 976-11-70006948
e-mail: info@sgmd-audit.mn

СЗХ
2022.08.22
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17
БҮРТГЭВ-03

# "МОН БИЙФ" ХХК

## Байгууллагын талаарх мэдээлэл

**Байгуулах шийдвэр**

"Мон Бийф" ХХК нь 2020 оны 12 сард үүсгэн байгуулагдсан.

2020 оны 12 сарын 31-ний өдөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 6648436 тоот регистрийн дугаар бүхий 9011823614 тоот гэрчилгээ авсан.

**Үндсэн үйл ажиллагаа**

Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
Барилгын материалын худалдаа
Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх
Мах боловсруулах, консервлох
Малын тэжээл үйлдвэрлэл
Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа

**Хувьцаа эзэмшигчид**

| | |
|---|---|
| Таванбогд Трейд | 61% |
| Ц. Цэцэнхүү | 10% |
| Ж. Барсболд | 5% |
| Ж. Оюунчимэг | 8% |
| Ч. Ванчин-Эрдэнэ | 8% |
| Э. Пүрэвлхам | 5% |
| И. Баттуяа | 3% |

**Гүйцэтгэх Захирал**

Н. Ариунбаатар

**Байнгын хаяг**

Улаанбаатар, Хан-Уул, 15 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Стадион Оргил,
Хаан Банк Цамхаг, 10 давхар

**Аудитор**

**Эс Жи Эм Ди-Аудит ХХК**
Монгол улс, Улаанбаатар-46,
Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Оюутны гудамж-44,
14/2 и байр, 9 тоот
Утас: 976-11-70006948
Факс: 976-11-70006948
e-mail:ekhbayar@sgmd-audit.mn

СЭХ
2022.06.22 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

| ГАРЧИГ | ХУУДАС |
|---|---|
| ЗАХИРЛУУДЫН МЭДЭГДЭЛ | 3 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 4-5 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН | 7 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 8 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 9 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10-27 |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн Санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 4-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Мон Бийф" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн ("Компани" гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг Сангийн Яамнаас баталсан аж Ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг өөдрөг ажиллагааны төсөөлөлд үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэлгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Мон Бийф" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

| | |
|---|---|
| Н. АРИУНБААТАР | Д. МАРАЛ-ЭРДЭНЭ |
| *Гүйцэтгэх захирал* | *Ерөнхий нягтлан бодогч* |

Огноо: 2022.04.01



6648436 MonBeefLLC УЛААНБААТАР
Мон Бийф ХХ компани

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

SGMD АУДИТ

# ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Огноо 2022.04.01 № 1/040 Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
## "МОН БИЙФ" ХХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

### Аудиторын дүгнэлт

**"Мон Бийф" ХХК** ("Компани" гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний цуглуулсан аудитын нотолгоо нь гаргасан аудиторын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж иттэж байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрдэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан орлоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл бидний аудитын явцад олж мэдсэн ойлголттой материаллагаар үл нийцэж байгаа эсэх эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Бид гүйцэтгэсэн ажиллаа үндэслэн бусад мэдээллийг материаллагаар буруу илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн тохиолдолд энэ талаар тайлагнах шаардлагатай байдаг. Бидэнд үүнтэй холбоотой тайлагнах зүйлс байхгүй болно.

### Санхүүгийн Тайланд Удирдлага ба Засаглах Удирдлагын Хүлээх Үүрэг Хариуцлага

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулахаас гадна алдаа эсвэл залиь мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэгтэй байдаг.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагаа нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх Компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Монгол Улс, Улаанбаатар хот
СБД, 8-р хороо, Оюутны гудамж-44
14/2и байр 9 тоот

Утас: 976 (11) 7000 6948
99__ 6948
Факс: 976 (11) 7000 6948
И-мэйл: ekhbayar@sgmd-audit.mn
info@sgmd-audit.mn

СЗХ
2022.06.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-17
БҮРТГЭВ-03

## Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх тухай ул үндэслэлтэй баталгаажилт цуглуулж, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин буй бүх материаллаг буруу илэрхийллийг илрүүлнэ гэсэн баталгаагаар хангахгүй.

Буруу илэрхийлэл заль мэхнээс эсвэл алдаанаас үүсч болох ба энэ нь дангаараа эсвэл эсвэл бусад буруу илэрхийллүүдийн хамтаар санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын ажил гүйцэтгэхдээ бид мэргэжлийн шийдэл гаргаж, мэргэжлийн ул итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэх нь хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг ул ойшоох зэргийг багтаадаг бөгөөд эдгээрээс үүсэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүсэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Цуглуулсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэвч ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Санхүүгийн тайлан ба түүний тодруулгын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгаас гадна санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитын ажлын явцад илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдал, аудитын томоохон илрүүлэлтүүд болон бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох **"Мон Бийф" ХХК** ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Огноо: 2022.04.01

Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн захирал Д.Эхбаяр
Монгол улс, Улаанбаатар хот
СБД 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байр 9 тоот



Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
УЛААНБААТАР ХОТ
6648436

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17

**"МОН БИЙФ"**
**Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх**
**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

| | Тэм. | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | | | |
| Өмч, Барилга, Тоног төхөөрөмж | 3 | 1,365,990 | - |
| Биет бус хөрөнгө | 4 | 18,566 | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 5 | 38,171 | - |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **1,422,727** | - |
| *Эргэлтийн хөрөнгө* | | | |
| Бараа материал | 6 | 1,905,617 | - |
| Урьдчилж төлсөн зардал | 7 | 211,838 | - |
| Худалдааны болон бусад авлага | 8 | 138,466 | - |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 9 | 40,061 | 19,999 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **2,295,982** | **19,999** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **3,718,709** | **19,999** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | | |
| *Өмч* | | | |
| Хувьцаат капитал | 10 | 200,000 | 10,000 |
| Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | | (352,431) | 9,899 |
| **Нийт өмч** | | **(152,431)** | **19,899** |
| *Өр төлбөр* | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 11 | 288,929 | - |
| Татварын өр | 12 | 1,679 | 100 |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | | **290,608** | **100** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Холбоотой талын санхүүжилтийн өр | 13 | 3,580,532 | - |
| **Нийт урт хугацаат өр төлбөр** | | **3,580,532** | - |
| **Нийт өр төлбөр** | | **3,871,140** | **100** |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **3,718,709** | **19,999** |

*10-27-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЭХ
он 2022 сар 06 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ-03

**"МОН БИЙФ"**
**Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

**2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн**
**ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

| | Тэм | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 14 | 226,697 | 10,000 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 15 | (206,540) | - |
| **Нийт ашиг** | | **20,156** | **10,000** |
| Хүүгийн орлого | | | - |
| Бусад орлого | 16 | 3,032 | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | 17 | (95,832) | (1) |
| Ерөнхий удирдлагын зардал | 18 | (258,626) | - |
| Санхүүгийн цэвэр зардал | 19 | (62,153) | - |
| Бусад зардал | 20 | (6,653) | - |
| Ханшийн зөрүүгийн ашиг алдагдал | 21 | (425) | - |
| Бусад ашиг (алдагдал) | | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | | (400,501) | 9,999 |
| Татварын зардал | 22 | 38,171 | (100) |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | (362,330) | 9,899 |

*10-27-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

Мон Бийф ХХ компани
УЛААНБААТАР ХОТ

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| | Өмч мян.төг | Хуримтлагдсан ашиг мян.төг | Нийт дүн мян.төг |
|---|---|---|---|
| Эхлэлтийн үлдэгдэл | 10,000 | - | 10,000 |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | 9,899 | 9,899 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | 10,000 | 9,899 | 19,899 |
| Тайлант үеийн цэвэр алдагдал | - | (362,330) | (362,330) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 190,000 | - | 190,000 |
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | 200,000 | (352,431) | (152,431) |

*10-27-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЗХ
он 2022 сар 06 . 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -03- 17
БҮРТГЭВ-03

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Үзүүлэлт | 2021 MNT'000 | 2020 MNT'000 |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **107,137** | **10,000** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 107,027 | 10,000 |
| Бусад мөнгөн орлого | 110 | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(2,635,657)** | **(1)** |
| Ажиллагчдад төлсөн | (102,792) | - |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (76,485) | - |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (2,176,187) | - |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (8,080) | - |
| Хүүгийн төлбөрт төлсөн | (55,329) | - |
| Татварын байгууллагад төлсөн | (20,547) | - |
| Даатгалын төлбөрт төлсөн | (578) | - |
| Бусад мөнгөн зарлага | (195,659) | (1) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(2,528,520)** | **9,999** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **2,548** | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 2,548 | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(1,207,963)** | - |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (1,207,963) | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,205,415)** | - |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **7,890,382** | - |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 7,700,382 | - |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 190,000 | |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(4,135,579)** | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | (4,135,579) | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **3,754,803** | - |
| Валютын ханшийн зөрүү | (806) | - |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **20,063** | **9,999** |
| **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **19,999** | **10,000** |
| **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **40,062** | **19,999** |

*10-27-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022-03-17

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

## 1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

"Мон Бийф" ХХК нь 2020 оны 12 сард үүсгэн байгуулагдсан. 2020 оны 12 сарын 31-ний өдөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 6648436 тоот регистрийн дугаар бүхий 9011823614 тоот гэрчилгээ авсан.

Компанийн хүчин төгөлдөр дүрмийн дагуу дараах үндсэн үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан:

- Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
- Барилгын материалын худалдаа
- Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх
- Мах боловсруулах, консервлох
- Малын тэжээл үйлдвэрлэл
- Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа

Мон Бийф ХХК нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж зах зээлд чанартай, гарал үүсэл нь тодорхой үхрийн мах нийлүүлэх, хөдөө аж ахуйн кластер системийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт эрчимжсэн үхрийн фермийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.
Компани нь 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр 54 ажиллагсадтай байсан.

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримталдаг.

### a) Тайлан бэлтгэсэн үндэслэл

#### *i. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий суурь*

Санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьд үндэслэн, компанийн тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

#### *ii. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим*

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

### b) Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагын гүйлгээнүүдийг гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.
Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

СЭХ
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01

2022-06-17
БҮРТГЭВ



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### c) Санхүүгийн хэрэглүүр

**Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт**
Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.
Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дахь гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт*
Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй Дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэгддэгээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:
- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд компанид БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна.

Ангиллыг тодорхойлохдоо:
- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин Дансны авлагын үнэ цэнийн бууралт нь бусад зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

*Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт*

*(а) Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө*
Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):
- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулга болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Мон Бийф ХХК
MonBeef LLC
УЛААНБААТАР ХОТ
ШАЛГАВ

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### (c) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

*(b) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)*

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно. Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

*(c) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)*

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо илүү ирээдүйд чиглэсэн мэдээлэлд суурилах болсон ба үүнийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргачлал гэж нэрлэдэг. Энэ нь НББОУС 39-ийн зээлийн алдагдлыг бодитоор бий болсон үед хүлээн зөвшөөрөх аргыг орлоно.

Энэхүү шинэ шаардлагын дагуу хорогдуулсан өртгөөр болон БҮЦБДО-оор хэмжигдэх зээл, бусад өрийн төрлийн санхүүгийн хөрөнгүүд, дансны авлага, СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөн, хэмжигдсэн гэрээний хөрөнгө, зээлийн үүрэг болон БҮЦАА-аар хэмжигддэггүй зарим санхүүгийн баталгааны гэрээг хамруулна.

Зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхөд компани нь зээлийн алдагдал үүсэх нөхцөл бий болохыг хүлээх шаардлагагүй болсон. Үүний оронд компани нь зээлийн эрсдэлийг үнэлэх болон хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал, хэрэгслийн ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй цуглуулгад нөлөөлөх үндэслэлтэй дэмжигдэхүйц таамаглал зэрэг мэдээллийг харгалзан үздэг.

СЗХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№



2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### (c) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Тус аргачлалыг ашиглахад дараах зүйлсийг ялгаж харах шаардлагатай. Үүнд:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрснөөс хойш түүний зээлийн эрсдэл их хэмжээгээр нэмэгдээгүй, тайлант хугацааны үеэр бага эрсдэлтэй байгаа бол (Шатлал 1)
- Анхны хүлээн зөвшөөрөлтөө хойш зээлийн чанар мэдэгдэхүйц муудсан, зээлийн эрсдэл бага биш байгаа санхүүгийн хэрэгслүүд (Шатлал 2)

Шатлал 3 нь тайлагналын өдөр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо олдсон санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна. Дараагийн 12 сард хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 1-д, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 2-д хүлээн зөвшөөрнө.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд зээлийн алдагдлын магадлалын жингийн тооцооллоор тодорхойлно.

**Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгө**
Компани нь Дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицийг ашиглан хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо Компани нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Компани нь Дансны зээлийн авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо хугацаа хэтэрсэн өдрүүдээр нь бүлэглэн зээлийн эрсдэлийн шинж чанарт ангилан үнэлнэ.

**Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт**
Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл, Дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

СЗХ
2022.08.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-03-17



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### d) Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

*i) Хүлээн зөвшөөролт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн тоног төхөөрөмжүүдийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарсан бусад зардал зэргээс бүрдэнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулснаас хойш гарсан зарцуулалтууд болох урсгал болон их засварын зардлыг зардал гарсан үеийн орлогоос суутган тооцдог.

Зарцуулалт нь тухайн өмч барилга, тоног төхөөрөмжийг ашигласнаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа тохиолдолд уг зарцуулалтыг өмч, барилга, тоног төхөөрөмжийн нэмэлт өртөг болгон капиталжуулдаг.

*i) Элэгдэл*

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

| | |
|---|---|
| ▪ Тоног төхөөрөмж | 10 жил |
| ▪ Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| ▪ Компьютер | 2 жил |

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

### e) Бараа материал

Бараа материалууд нь түүхэн өртгөөрөө илэрхийлэгддэг. Хуучирсан барааны техникийн болон биет хуучралын талаар байгууллагын удирдлага ямар нэгэн тооцоолол хийдэггүй. Бараа материалын өртөгт бараа материалыг худалдан авсан үнэд ноогдох гаалийн болон бусад төрлийн татвар, хураамж, одоогийн байршил, нөхцөлд авчрахад гаргасан бүхий л зардлууд (тээвэрлэлтийн зардал орохгүй)-ыг тооцоолж бараа материал дансанд бүртгэдэг. Бараа материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

### f) Үнийн бууралт

Үнийн бууралтыг илэрхийлсэн ямарваа нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бараа материалаас бусад хөрөнгийн дансны үнийг тайлант үеийн эцэс бүрт шалгадаг. Хөрөнгийн дансны үнэ эсвэл хөрөнгийн ашиг авчрах эсэх нь эргэн төлөгдөх дүнгээсээ давсан эсэхийг хянадаг ба үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрч орлогын тайланд тусгадаг.

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР
Мон Бийф ХХ Компани
ШАЛГАВ

СЗХ
он сар ... өдөр
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01



MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-03-17
БҮРТГЭВ-03

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### g) Урьдчилж төлсөн зардал

Үйл ажиллагааны зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хүртэл урьдчилж төлсөн зардлаар тайлагнадаг. Урьдчилж төлсөн зардлыг төлсөн хэмжээгээр буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

### h) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

### i) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

### j) Дансны болон бусад өглөг

Дансны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

### k) Хувьцаат капитал

*i) Энгийн хувьцаа*

Энгийн хувьцааг эзэмшигчийн өмчид ангилдаг. Энгийн хувьцаа ба хувьцааны опционыг гаргахад шууд хуваарилагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан цэвэр дүнгээр нь өмчийг бууруулан хүлээн зөвшөөрнө.

### l) Орлого хүлээн зөвшөөрөлт

*i) Борлуулсан бүтээгдэхүүн*

Орлого хүлээн зөвшөөрөхдөө компани нь дараах 5-н алхмыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хуваарилах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх



Мон Бийф ХХ компани
Улаанбаатар хот
6648436

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 17
БҮРТГЭВ-03

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Компани нь бараа, ажил үйлчилгээтэй холбоотойгоор олон төрлийн ажил гүйлгээ хийдэг. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрт тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.
Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.
Борлуулсан бүтээгдэхүүнээс олсон орлогыг буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмждэг.

### m) Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

*i) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг*
Борлуулалтын өртгийг бараа материалыг борлуулах үед буюу бараа, бүтээгдэхүүний өмчлөлийн эрхийг бусдад шилжүүлж орлого олсон тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

*ii) Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал*
Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### n) Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана. Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардлыг хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

СЗХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -06- 17
БҮРТГЭЛД

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Барьж босгоход хугацаа шаардлагатай хөрөнгийн өртөгт багтаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах үйл ажиллагаанаас гарч буй зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг.

### о) Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

### р) Түрээс

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгууруудыг хангасан гэрээ юм:

(а) Тодорхойлсон хөрөнгөтэй;
(б) Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг хүртдэг; ба
(в) Компани хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжит бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтчилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол Компанийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түрээсийн өр төлбөрийн дансны үнэд дараах зүйлс багтана:

- үлдэх өртгийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- худалдан авах сонголтоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ;

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

- түрээсийг цуцлах сонголтоо хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

Компани аливаа түрээсийн хугацааны тооцоололд өөрчлөлт оруулсан бол (жишээ нь, сунгах эсвэл цуцлах сонголтыг түрээслэгч хэрэгжүүлэх магадлалыг дахин үнэлсэн гэх мэт шалтгаанаар) шинэчлэгдсэн хугацааны турш хийх төлбөрийг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх бөгөөд үүнийг түрээсийн эхлэлд мөрдөж байсантай ижил дискаунтын хувь ашиглан дискаунтчилна. Хувь хэмжээ эсвэл индексээс хамааралтай ирээдүйн түрээсийн төлбөрийн хувьсах элементүүдийг шинэчилсэн бол түрээсийн өр төлбөрийн дансны үнийг ч мөн шинэчилнэ. Аль ч тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэд зохих тохируулгыг хийх бөгөөд шинэчилсэн дансны үнийг түрээсийн үлдсэн (шинэчилсэн) хугацааны турш хорогдуулна.

### q) Ажиллагсдын тэтгэмж

#### *i) Тур хугацааны ажиллагсдын тэтгэмж*

Богино хугацаат ажиллагсдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажиллагсдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

#### *ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал*

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ 2022.06.22
№ 01

“МОН БИЙФ”
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

## 3. Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

| | Машин, тоног төхөөромж | Тээврийн хэрэгсэл | Тавилга эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | - | - | - | - | - |
| Нэмэгдсэн | 67,676 | 439,436 | 838,257 | 67,643 | 1,413,011 |
| Хасагдсан | - | - | - | - | - |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **67,676** | **439,436** | **838,257** | **67,643** | **1,413,011** |
| *Хуримтлагдсан элэгдэл:* | | | | | |
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | - | - | - | - | - |
| Байгуулсан элэгдэл | 2,717 | 15,750 | 19,494 | 9,061 | 47,022 |
| Данснаас хассан хөрөнгийн элэгдэл | - | - | - | - | - |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,717** | **15,750** | **19,494** | **9,061** | **47,022** |
| *Дансны үнэ:* | | | | | |
| **2020 оны 12-р сарын 31** | - | - | - | - | - |
| **2021 оны 12-р сарын 31** | 64,960 | 423,686 | 818,763 | 58,581 | 1,365,990 |

MonBeef LLC 6648436 УЛААНБААТАР

## 4. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь программ хангамжийн өртгийг илэрхийлэх бөгөөд тайлант жилд гарсан хөдөлгөөн нь дараах байдалтай байна. Үүнд:

| | Программ хангамж мян.төг |
|---|---|
| **ӨРТӨГ** | |
| **2020 оны 12-р сарын 31** | - |
| Нэмэгдсэн | 20,919 |
| Хасагдсан дүн | |
| **2021 оны 12-р сарын 31** | **20,919** |
| **ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ** | |
| **2020 оны 12-р сарын 31** | - |
| Байгуулсан | 2,353 |
| Хасагдсан | |
| **2021 оны 12-р сарын 31** | **2,353** |
| *Дансны үнэ:* | |
| **2020 оны 12-р сарын 31** | - |
| **2021 оны 12-р сарын 31** | **18,566** |

## 5. Хойшлогдсон татварын хөрөнгө

Энэхүү дүн нь татварын алдагдлыг дараагийн тайлант үед шилжүүлэхтэй холбоотойгоор үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийн 2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл дүнг илэрхийлнэ.

## 6. Бараа материал

| | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Түүхий эд материал | 1,502,107 | - |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 103 | - |
| Бэлэн бүтээгдэхүүн | 308,030 | - |
| Хангамжийн материал | 95,377 | - |
| | **1,905,617** | - |

СЗХ
он 2022 сар 06 сар 30
БҮРТГЭВ
№ 01



2022-03-17
БҮРТГЭВ-03

## 7. Урьдчилж төлсөн тооцоо ба зардал

| | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 31,782 | - |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр | 180,056 | - |
| | **211,838** | - |

## 8. Худалдааны болон бусад авлага

| | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Дансны авлага | 6,784 | |
| Үнэ цэнийн бууралтын нөөц | - | - |
| **Цэвэр худалдааны авлага** | **6,784** | - |
| Ажилчидаас авах авлага | 4,855 | - |
| Гүйцэтгэлийн баталгаа, Гэрээний барьцаа | 18,150 | - |
| Холбоотой талаас авах авлага | 101,890 | - |
| Гаалийн албан татварын авлага | 2,863 | - |
| НДШ-ийн авлага | 3,924 | |
| **Бусад авлага** | **131,682** | - |
| **Нийт худалдааны ба бусад авлага** | **138,466** | - |

## 9. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Касс дахь мөнгө-төгрөг | - | - |
| Харилцах данс дахь мөнгө-төгрөг | 38,113 | 19,999 |
| Харилцах данс дахь мөнгө-гадаад валют | 1,948 | - |
| **Нийт мөнгөн хөрөнгө** | **40,061** | **19,999** |



ЖЭМ ДИ АУДИТ ХХК ШАЛГАВ 01
Мон Бийф ХХК
Мон Бийф ХХ компани
УЛААНБААТАР

“МОН БИЙФ”
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

## 10. Хувьцаа эзэмшигчдийн өмч

| | 2021 он | | 2020 он | |
|---|---|---|---|---|
| | Дүн Мян.төг | Хувьцааны тоо | Дүн Төгрөг | Хувьцааны тоо |
| *Оруулсан хөрөнгө оруулалт* | | | | |
| **01 сарын 01-нээр** | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 |
| Шинээр гаргасан | 190,000 | 190,000 | - | - |
| **12 сарын 31-нээр** | **200,000** | **200,000** | **10,000** | **10,000** |

Компанийн хувьцаа эзэмшигчдийн өмч нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байгаа бөгөөд дараах байдлаар эзэмшдэг.

| Хувьцаа эзэмшигчид | хувьцааны тоо | нэгжийн үнэ төгрөг | Дүн мян.төг |
|---|---|---|---|
| Таванбогд Трейд | 122,000 | 1,000 | 122,000 |
| Ц. Цэцэнхүү | 20,000 | 1,000 | 20,000 |
| Ж. Барсболд | 10,000 | 1,000 | 10,000 |
| Ж. Оюунчимэг | 16,000 | 1,000 | 16,000 |
| Ч. Ванчин-Эрдэнэ | 16,000 | 1,000 | 16,000 |
| Э. Пүрэвлхам | 10,000 | 1,000 | 10,000 |
| И. Баттуяа | 6,000 | 1,000 | 6,000 |
| | **200,000** | | **200,000** |

## 11. Худалдааны болон бусад өглөг

| | 2021 оны 12 сарын 31 мян.төг | 2020 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Худалдааны өглөг | 200,947 | - |
| Цалингийн өглөг | 40,532 | - |
| НӨАТ-ын өглөг | 188 | - |
| ХХОАТ-ын өглөг | 6,486 | - |
| Бусад өглөг | 40,777 | - |
| | **288,929** | - |

## 12. Татварын өр

Энэхүү дүн нь ААНОАТатварын өглөгийн дүнг илэрхийлнэ.

СЗХ
2022 .08. 12
БҮРТГЭВ
№ 01

## 13. Санхүүжилтийн өр

Энэхүү дүн нь холбоотой тал болох Таван богд трейд ХХК-аас авсан санхүүжилтийн өрийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийг илэрхийлнэ. .

## 14. Борлуулалтын орлого

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Бараа борлуулалтын орлого | 216,360 | 10,000 |
| Бараа борлуулалтын орлого-онлайн | 10,337 | - |
| **Нийт борлуулалтыг орлого** | **226,697** | **10,000** |
| Борлуулалтын буцаалт ба хөнгөлөлт | - | |
| | **226,697** | **10,000** |

## 15. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Бараа борлуулсны өртөг | (200,590) | - |
| Бараа борлуулсны өртөг-онлайн | (5,950) | - |
| | **(206,540)** | - |

## 16. Бусад орлого

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Алданги, торгуулийн орлого | 77 | |
| Үнэ төлбөргүй бусдаас авсан ажил үйлчилгээ | 94 | |
| Бусад орлого | 2,861 | |
| | **3,032** | - |

СЭХ 2022.08.22 өдөр БҮРТГЭВ №
2022-08-17

## 17. Борлуулалт, маркетингийн зардал

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | (28,588) | - |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | (3,894) | - |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | (2,427) | - |
| Томилолтын зардал | (114) | - |
| Бичиг хэргийн зардал | (1,201) | - |
| Шуудан холбооны зардал | (1,090) | - |
| Сургалтын зардал | (100) | - |
| Даатгалын зардал | (25) | - |
| Засварын зардал | (512) | - |
| Элэгдэл, хорогдлын зардал | (1,554) | - |
| Түрээсийн зардал | (1,254) | - |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | (57) | - |
| Тээврийн зардал | (120) | - |
| Шатахууны зардал | (2,203) | - |
| Бусад | (52,692) | (1) |
| | **(95,832)** | (1) |

## 18. Ерөнхий удирдлагын зардал

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | (144,890) | - |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | (19,022) | - |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | (4,241) | - |
| Томилолтын зардал | (5,751) | - |
| Бичиг хэргийн зардал | (8,989) | - |
| Шуудан холбооны зардал | (3,171) | - |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | (125) | - |
| Сургалтын зардал | (1,590) | - |
| Даатгалын зардал | (553) | - |
| Засварын зардал | (2,749) | - |
| Элэгдэл, хорогдлын зардал | (10,962) | - |
| Түрээсийн зардал | (36,480) | - |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | (2,943) | - |
| Тээврийн зардал | (200) | - |
| Шатахууны зардал | (5,557) | - |
| Зар сурталчилгааны зардал | (909) | - |
| Бусад | (10,494) | |
| | **(258,626)** | - |

АПЕКС КАПИТАЛ УЦК ХХК УЛААНБААТАР ХОТ
Мон Бийф ХХК УЛААНБААТАР

## 19. Санхүүгийн цэвэр зардал

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Санхүүжилт авахтай холбоотой гарах зардал | (3,849) | - |
| Зээлийн шугамын хүүгийн зардал | (30,673) | - |
| Компани хоорондын зээлийн хүүгийн зардал | (27,631) | - |
| | **(62,153)** | - |

## 20. Бусад зардал

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Алданги, торгуулийн зардал | (1,020) | - |
| Хандивын зардал | (200) | - |
| Үнэ цэнийн бууралтын гарз | (1,838) | - |
| Бусад зардал | (3,595) | - |
| | (6,653) | - |

## 21. Ханшийн зөрүүгийн ашиг/(алдагдал)

| | 2021 он мян.төг | 2020 он мян.төг |
|---|---|---|
| Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн | - | - |
| Авлагын үлдэгдлийн | - | - |
| Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн | (425) | - |
| | (425) | - |

## 22. Орлогын татварын зардал

Компани нь Монгол Улсын Татварын хуулийн дагуу татварын зорилгоор татвар ногдуулахгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлуудын нөлөөг тооцсоны үндсэн дээр орлогын татвараа мэдүүлдэг ба 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж ААН-ийн Орлогын татвар төлөх үүрэгтэй. Компани 2021 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон жилд алдагдалтай ажилласан бөгөөд алдагдлыг шилжүүлэн бүртгэж, хойшлогдсон татварын хөрөнгө, орлогын татварын өгөөж хүлээн зөвшөөрч тайлагнасан.

## 23. Холбоотой талууд

*(i) Холбоотой талуудыг тодорхойлох*

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно. Тус компани нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:

| **Холбоотой талуудын нэр** | **Хамаарал** |
|---|---|
| Таван Богд Трейд ХХК | Хувьцаа эзэмшигч |

*(ii) Холбоотой талуудын ажил гүйлгээ*

2021 болон 2020 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилд холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна:

| | 2021 он<br>мян.төг | 2020 он<br>мян.төг |
|---|---|---|
| Хүлээн авсан санхүүжилт | 3,602,122 | - |

*(iii) Холбоотой талуудын ажил гүйлгээний үлдэгдэл*

2021 оны 12 дугаар сарын 31-нээрх тасалбар болсон жилд холбоотой талуудтай хийгдсэн ажил гүйлгээний үлдэгдэл дараах байдалтай байна:

| | 2021 он<br>мян.төг | 2020 он<br>мян.төг |
|---|---|---|
| **Холбоотой талд төлөх өр** | | |
| Таван Богд Трейд ХХК | 3,580,532 | - |

СЗХ
2022.06.22
БҮРТГЭВ
№ 01



2022-03-17
БҮРТГЭВ-03

## 24. Балансын дараах үйл явдал

Балансын дараа буюу 2020 оны 1 дүгээр сараас эхэлсэн Ковид-19 буюу короно вирусийн халдвар дэлхий даяар тархаж, нийтдээ 200 гаруй улсад тохиолдол бүртгэгдэж, дэлхий нийтийн эрүүл мэндээс гадна бизнес, эдийн засгийн нөхцөлд сөрөг нөлөө үзүүлж байна. Олон улсын эдийн засагчид энэхүү халдварт овчноос хамаарсан эдийн засгийн хямрал цаашид үргэлжлэх төлөвтэй байгааг мэдээлж байна. Компанийн санхүү эдийн засгийн чадварт энэхүү хямрал хэрхэн нөлөөлж болохыг урьдчилан таамаглах боломжгүй байна.

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, үйлчлүүлэгчийн ажлын байранд ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт горим, сорил хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Мон Бийф ХХ компани
Улаанбаатар
6648436

СЗХ
2022 он 06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

2022-08-17
БҮРТГЭВ

# МОН БИЙФ

Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон завсар үеийн Санхүүгийн Мэдээлэл болон хараат бус аудиторын дүгнэлт

Улаанбаатар хот, 2022 он

СЭХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17
БҮРТГЭВ-03

# МОН БИЙФ

**Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон завсар үеийн
Хураангуй Санхүүгийн Мэдээлэл


**"Эс Жи Эм Ди-Аудит" ХХК**
Монгол улс, Улаанбаатар-46,
Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Оюутны гудамж-44,
14/ 2 и байр, 9 тоот
Утас: 976-11-70006948
Факс: 976-11-70006948
e-mail: info@sgmd-audit.mn


АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК
ШАЛГАВ
01
MonBeef LLC
Мон Бийф ХХ компани

СЭХ
2022 .06. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 21

2022-03-17
БҮРТГЭВ-33

**"МОН БИЙФ" ХХК**

**Байгууллагын талаарх мэдээлэл**

**Байгуулах шийдвэр**

"Мон Бийф" ХХК нь 2020 оны 12 сард үүсгэн байгуулагдсан.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 6648436 тоот регистрийн дугаар бүхий 9011823614 тоот гэрчилгээ авсан.

**Үндсэн үйл ажиллагаа**

Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
Барилгын материалын худалдаа
Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх
Мах боловсруулах, консервлох
Малын тэжээл үйлдвэрлэл
Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа

**Хувьцаа эзэмшигчид**

| | |
|---|---|
| Таванбогд Трейд | 75% |
| Ц. Цэцэнхүү | 5% |
| Ж. Барсболд | 10% |
| Ж. Оюунчимэг | 2% |
| Э. Пүрэвлхам | 5% |
| И. Баттуяа | 3% |

**Гүйцэтгэх захирал**

Н. Ариунбаатар

**Байнгын хаяг**

Улаанбаатар, Хан-Уул, 15 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Стадион Оргил,
Хаан Банк Цамхаг, 10 давхар

**Аудитор**

**Эс Жи Эм Ди-Аудит ХХК**
Монгол улс, Улаанбаатар-46,
Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Оюутны гудамж-44,
14/ 2 и байр, 9 тоот
Утас: 976-11-70006948
Факс: 976-11-70006948
e-mail:ekhbayar@sgmd-audit.mn

СЗХ
2022 .08 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01


| ГАРЧИГ | ХУУДАС |
|---|---|
| ЗАХИРЛУУДЫН МЭДЭГДЭЛ | 3 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 4-5 |
| САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН | 7 |
| ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 8 |
| МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 9 |
| САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 10-25 |

СЗХ
2022.08.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-17

**2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон завсар үеийн Санхүүгийн мэдээлэл бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 4-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Мон Бийф" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн ("Компани" гэх) 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон завсар үеийн хураангуй санхүүгийн мэдээлэлтэй холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгахад чиглэгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг НББОУС 34, *Завсар үеийн санхүүгийн тайлан* болон Сангийн Яамнаас баталсан аж Ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2022 оны 03 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, 2022 оны 1-р улирлын санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг өөдрөг ажиллагааны төсөөлөлд үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Компанийн санхүүгийн байдлыг үнэн зөвөөр, аливаа хугацаанд харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн заавар журмын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Мон Бийф" ХХК-ийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон завсар үеийн санхүүгийн мэдээллийг гаргахыг зөвшөөрч батлав.

| | |
|---|---|
| Н. АРИУНБААТАР | Д. МАРАЛ-ЭРДЭНЭ |
| *Гүйцэтгэх захирал* | *Ерөнхий нягтлан бодогч* |

Огноо: 2022.04.13

СЗХ
2022 .06. 22
БҮРТГЭВ
№ 01



Огноо 2022.04.13 № 1/052 Улаанбаатар хот

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
# "МОН БИЙФ" ХХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## Аудиторын дүгнэлт

**"Мон Бийф" ХХК** ("Компани" гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн завсар үеийн хураангуй санхүүгийн мэдээллүүдэд аудит хийлээ:

- 2022 оны 3 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан:
- Энэ өдрөөр тасалбар болсон 2022 оны 1-р улирлын ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд: болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр хавсаргасан хураангуй санхүүгийн мэдээллүүд нь Компанийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон 2022 оны 1-р улирлын санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 34, *Завсар үеийн санхүүгийн тайлан* ("НББОУС 34")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЁЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаардаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний цуглуулсан аудитын нотолгоо нь гаргасан аудиторын дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

## Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь завсар үеийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл бидний аудитын явцад олж мэдсэн ойлголттой материаллагаар үл нийцэж байгаа эсэх эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Бид гүйцэтгэсэн ажилдаа үндэслэн бусад мэдээллийг материаллагаар буруу илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн тохиолдолд энэ талаар тайлагнах шаардлагатай байдаг. Бидэнд үүнтэй холбоотой тайлагнах зүйлс байхгүй болно.

## Санхүүгийн Тайланд Удирдлага ба Засаглах Удирдлагын Хүлээх Үүрэг Хариуцлага

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулахаас гадна алдаа эсвэл заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэгтэй байдаг.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх Компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

4

Монгол Улс, Улаанбаатар хот
СБД, 8-р хороо, Оюутны гудамж-44
14/2н байр 9 тоот

Утас: 976 (11) 7000 6948
9911 6948
Факс: 976 (11) 7000 6948
И-мэйл: ekhbayar@sgmd-audit.mn
info@sgmd-audit.mn

СЗХ
2022 06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх тухай ул үндэслэлтэй баталгаажилт цуглуулж, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин буй бүх материаллаг буруу илэрхийллийг илрүүлнэ гэсэн баталгаагаар хангахгүй.

Буруу илэрхийлэл заль мэхнээс эсвэл алдаанаас үүсч болох ба энэ нь дангаараа эсвэл эсвэл бусад буруу илэрхийллүүдийн хамтаар санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын ажил гүйцэтгэхдээ бид мэргэжлийн шийдэл гаргаж, мэргэжлийн ул итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэх нь хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг ул өйшоох зэргийг багтаадаг бөгөөд эдгээрээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Цуглуулсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадварт томоохон эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэвч ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсоохоод хүргэх нөлөө үзүүлж болно.
- Санхүүгийн тайлан ба түүний тодруулгын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгаас гадна санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитын ажлын явцад илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдал, аудитын томоохон илрүүлэлтүүд болон бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох **"Мон Бийф" ХХК** ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК

Огноо: 2022.04.13

Захирал Д.Эхбаяр
Эс Жи Эм Ди Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
СБД 8-р хороо, Оюутны гудамж 14/2и байр 9 тоот



УЛААНБААТАР
MonBeefLLC
Мон Бийф ХХК

СЗХ
2022 ,06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөрх
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Тэм. | 2022 оны 03 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | | | |
| Өмч, Барилга, Тоног төхөөрөмж | 3 | 1,418,016 | 1,365,990 |
| Биет бус хөрөнгө | 4 | 23,755 | 18,566 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 5 | 38,171 | 38,171 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **1,479,942** | **1,422,727** |
| *Эргэлтийн хөрөнгө* | | | |
| Бараа материал | 6 | 1,907,665 | 1,905,617 |
| Урьдчилж төлсөн зардал | 7 | 256,670 | 211,838 |
| Худалдааны болон бусад авлага | 8 | 155,788 | 138,466 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 9 | 10,179 | 40,061 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **2,330,302** | **2,295,982** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **3,810,244** | **3,718,709** |
| **ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | | |
| *Өмч* | | | |
| Хувьцаат капитал | 10 | 1,500,000 | 200,000 |
| Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | | (873,319) | (352,431) |
| **Нийт өмч** | | **626,681** | **(152,431)** |
| *Өр төлбөр* | | | |
| Худалдааны болон бусад өглөг | 11 | 158,919 | 288,929 |
| Татварын өр | 12 | 3,644 | 1,679 |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | | **162,563** | **290,608** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Холбоотой талын санхүүжилтийн өр | 13 | 3,021,000 | 3,580,532 |
| **Нийт урт хугацаат өр төлбөр** | | **3,021,000** | **3,580,532** |
| **Нийт өр төлбөр** | | **3,183,563** | **3,871,140** |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **3,810,244** | **3,718,709** |

*10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЗХ
2022 .06. 22
БҮРТГЭВ

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022-09-17
БҮРТГЭВ-03

**2022 оны 1 дүгээр улирлын**
**АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

| | Тэм | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал* мян.төг |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 14 | 509,165 | |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 15 | (624,232) | |
| **Нийт ашиг** | | **(115,067)** | - |
| Хүүгийн орлого | | | |
| Бусад орлого | 16 | 1,146 | - |
| Борлуулалт, маркетингийн зардал | 17 | (109,978) | - |
| Ерөнхий удирдлагын зардал | 18 | (198,604) | |
| Санхүүгийн цэвэр зардал | 19 | (75,259) | |
| Бусад зардал | 20 | (7,164) | - |
| Ханшийн зөрүүгийн ашиг алдагдал | | (15,962) | - |
| Бусад ашиг (алдагдал) | | | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | | **(520,888)** | |
| Татварын зардал | 21 | - | - |
| **Тайлант жилийн цэвэр ашиг** | | **(520,888)** | - |

* Компани нь 2021 оны 1-р улиралд үйл ажиллагаа явуулаагүй учраас зэрэгцүүлэх боломжгүй байсан.

*10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЗХ
2022.08.22 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022 оны 1 дүгээр улирлын
**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

| | Өмч мян.төг | Хуримтлагдсан ашиг мян.төг | Нийт дүн мян.төг |
|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **10,000** | **9,899** | **19,899** |
| Тайлант үеийн цэвэр алдагдал | - | (362,330) | (362,330) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 190,000 | - | 190,000 |
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **200,000** | **(352,431)** | **(152,431)** |
| Завсар үеийн цэвэр алдагдал | - | (520,888) | (520,888) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 1,300,000 | - | 1,300,000 |
| **2022 оны 3-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,500,000** | **(873,319)** | **626,681** |

*10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЗХ
2022 .06 сар 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022-06-17
БҮРТГЭВ

## 2022 оны 1 дүгээр улирлын
## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Үзүүлэлт | 2022 оны 1-р улирал MNT'000 | 2021 он MNT'000 |
|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **449,399** | **107,137** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 448,580 | 107,027 |
| Бусад мөнгөн орлого | 819 | 110 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(1,079,950)** | **(2,635,657)** |
| Ажиллагчдад төлсөн | (107,119) | (102,792) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (61,451) | (76,485) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (673,061) | (2,176,187) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | - | (8,080) |
| Хүүний төлбөрт төлсөн | (68,944) | (55,329) |
| Татварын байгууллагад төлсөн | (28,613) | (20,547) |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | (578) |
| Бусад мөнгөн зарлага | (140,762) | (195,659) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(630,551)** | **(2,528,520)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | - | **2,548** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 2,548 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(133,701)** | **(1,207,963)** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (133,701) | (1,207,963) |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(133,701)** | **(1,205,415)** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **9,352,825** | **7,890,382** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 8,042,825 | 7,700,382 |
| Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 1,310,000 | 190,000 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(8,602,494)** | **(4,135,579)** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | (8,602,494) | (4,135,579) |
| | - | |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **750,331** | **3,754,803** |
| Валютын ханшийн зөрүү | (15,962) | (806) |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(29,883)** | **20,063** |
| **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ** | **40,062** | **19,999** |
| **МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **10,179** | **40,062** |

*10-25-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*

СЭХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022 оны 1 дүгээр улирлын
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

## 1. Үндсэн үйл ажиллагаа ба зохион байгуулалт

"Мон Бийф" ХХК нь 2020 оны 12 сард үүсгэн байгуулагдсан. 2020 оны 12 сарын 31-ний өдөр улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 6648436 тоот регистрийн дугаар бүхий 9011823614 тоот гэрчилгээ авсан.
Компанийн хүчин төгөлдөр дүрмийн дагуу дараах үндсэн үйл ажиллагаа эрхлэхээр үүсгэн байгуулагдсан:

- Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
- Барилгын материалын худалдаа
- Үхэр, одос үхэр өсгөн үржүүлэх
- Мах боловсруулах, консервлох
- Малын тэжээл үйлдвэрлэл
- Мал аж ахуйн салбарын туслах үйл ажиллагаа

Мон Бийф ХХК нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж зах зээлд чанартай, гарал үүсэл нь тодорхой үхрийн мах нийлүүлэх, хөдөө аж ахуйн кластер системийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт эрчимжсэн үхрийн фермийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани нь 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр 58 ажиллагсадтай байсан.

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримталдаг.

### а) Тайлан бэлтгэсэн үндэслэл

*i. Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий суурь*

Завсар үеийн санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртгийн суурьд үндэслэн, компанийн тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

*ii. Завсар үеийн санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл*

2022 оны 3 дугаар сарын 31-нээр тасалбар болсон эхний улирлын санхүүгийн тайлангуудыг НББОУС 34 Завсрын санхүүгийн тайлагнал болон бусад холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Энэхүү тайлан нь бүтэн тайлант хугацааны санхүүгийн тайланд тусгагддаг бүх тодруулгыг агуулаагүй тул 2021 оны санхүүгийн тайлантай хамт уншина уу. 2021 оны жилийн санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Завсар үеийн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ ашигласан.

*iii. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим*

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

СЗХ
он 2022 сар 06 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

“МОН БИЙФ”
**Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани**

2022-03-17
БҮРТГЭВ



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### b) Санхүүгийн хэрэглүүр

**Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт**
Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.
Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дахь гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт*
Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй Дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэгддэгээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:
- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд компанид БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна.

Ангиллыг тодорхойлохдоо:
- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин Дансны авлагын үнэ цэнийн бууралт нь бусад зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

*Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт*

***(a) Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө***
Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):
- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал “цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг” бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулга болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ЭРЖЭМ ДИ АУДИТ ХХК
ШАЛГАВ 01
Мон Бийф
MonBeefLLC

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### (с) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

***(b) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)***

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.
Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно. Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

***(c) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)***

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

**Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

СТОУС 9-ийн дагуу хүлээгдэж буй зээлийн алдагдлын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо илүү ирээдүйд чиглэсэн мэдээлэлд суурилах болсон ба үүнийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргачлал гэж нэрлэдэг. Энэ нь НББОУС 39-ийн зээлийн алдагдлыг бодитоор бий болсон үед хүлээн зөвшөөрөх аргыг орлоно.
Энэхүү шинэ шаардлагын дагуу хорогдуулсан өртгөөр болон БҮЦБДО-оор хэмжигдэх зээл, бусад өрийн төрлийн санхүүгийн хөрөнгүүд, дансны авлага, СТОУС 15-ын дагуу хүлээн зөвшөөрөгдөн, хэмжигдсэн гэрээний хөрөнгө, зээлийн үүрэг болон БҮЦАА-аар хэмжигддэггүй зарим санхүүгийн баталгааны гэрээг хамруулна.

Зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөхөд компани нь зээлийн алдагдал үүсэх нөхцөл бий болохыг хүлээх шаардлагагүй болсон. Үүний оронд компани нь зээлийн эрсдэлийг үнэлэх болон хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал, хэрэгслийн ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй цуглуулгад нөлөөлөх үндэслэлтэй дэмжигдэхүйц таамаглал зэрэг мэдээллийг харгалзан үздэг.

СЗХ
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### (с) Санхүүгийн хэрэглүүр (үргэлжлэл)

Тус аргачлалыг ашиглахад дараах зүйлсийг ялгаж харах шаардлагатай. Үүнд:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрснөөс хойш түүний зээлийн эрсдэл их хэмжээгээр нэмэгдээгүй, тайлант хугацааны үеэр бага эрсдэлтэй байгаа бол (Шатлал 1)
- Анхны хүлээн зөвшөөрөлтөө хойш зээлийн чанар мэдэгдэхүйц муудсан, зээлийн эрсдэл бага биш байгаа санхүүгийн хэрэгслүүд (Шатлал 2)

Шатлал 3 нь тайлагналын өдөр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо олдсон санхүүгийн хөрөнгүүдийг хамруулна. Дараагийн 12 сард хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 1-д, нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг Шатлал 2-д хүлээн зөвшөөрнө.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд зээлийн алдагдлын магадлалын жингийн тооцооллоор тодорхойлно.

**Дансны болон бусад авлага, гэрээний хөрөнгө**
Компани нь Дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй зээлийн алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэглүүрийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицийг ашиглан хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохдоо Компани нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Компани нь Дансны зээлийн авлагын үнэ цэнийн бууралтыг тооцохдоо хугацаа хэтэрсэн өдрүүдээр нь бүлэглэн зээлийн эрсдэлийн шинж чанарт ангилан үнэлнэ.

**Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт**
Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл, Дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнийн олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ЭМ ДИ АУДИТ ХХК
ШАЛГАВ 01
Мон Бийф ХХК

СЗХ
2022 .06. 22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### c) Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

*i) Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн тоног төхөөрөмжүүдийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарсан бусад зардал зэргээс бүрдэнэ.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулснаас хойш гарсан зарцуулалтууд болох урсгал болон их засварын зардлыг зардал гарсан үеийн орлогоос суутган тооцдог.

Зарцуулалт нь тухайн өмч барилга, тоног төхөөрөмжийг ашигласнаас бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа тохиолдолд уг зарцуулалтыг өмч, барилга, тоног төхөөрөмжийн нэмэлт өртөг болгон капиталжуулдаг.

*i) Элэгдэл*

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж, орлогын тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна:

- Тоног төхөөрөмж — 10 жил
- Тээврийн хэрэгсэл — 10 жил
- Компьютер — 2 жил

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

### d) Бараа материал

Бараа материалууд нь түүхэн өртгөөрөө илэрхийлэгддэг. Хуучирсан барааны техникийн болон биет хуучралын талаар байгууллагын удирдлага ямар нэгэн тооцоолол хийдэггүй. Бараа материалын өртөгт бараа материалыг худалдан авсан үнэд ноогдох гаалийн болон бусад төрлийн татвар, хураамж, одоогийн байршил, нөхцөлд авчрахад гаргасан бүхий л зардлууд (тээвэрлэлтийн зардал орохгүй)-ыг тооцоолж бараа материал дансанд бүртгэдэг. Бараа материалыг зарлага болгохдоо дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

### e) Үнийн бууралт

Үнийн бууралтыг илэрхийлсэн ямарваа нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бараа материалаас бусад хөрөнгийн дансны үнийг тайлант үеийн эцэс бүрт шалгадаг. Хөрөнгийн дансны үнэ эсвэл хөрөнгийн ашиг авчрах эсэх нь эргэн төлөгдөх дүнгээсээ давсан эсэхийг хянадаг ба үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрч орлогын тайланд тусгадаг.

СЗХ
2022 оны 06 сарын 22 өдөр
БҮРТГЭВ
№



2022-06-17
БҮРТГЭВ

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### f) Урьдчилж төлсөн зардал

Үйл ажиллагааны зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хүртэл урьдчилж төлсөн зардлаар тайлагнадаг. Урьдчилж төлсөн зардлыг төлсөн хэмжээгээр буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

### g) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

### h) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

### i) Дансны болон бусад өглөг

Дансны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

### j) Хувьцаат капитал

*i) Энгийн хувьцаа*

Энгийн хувьцааг эзэмшигчийн өмчид ангилдаг. Энгийн хувьцаа ба хувьцааны опционыг гаргахад шууд хуваарилагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан цэвэр дүнгээр нь өмчийг бууруулан хүлээн зөвшөөрнө.

### k) Орлого хүлээн зөвшөөрөлт

*i) Борлуулсан бүтээгдэхүүн*

Орлого хүлээн зөвшөөрөхдөө компани нь дараах 5-н алхмыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хуваарилах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Мон Бийф ХХК
Эскимо Ди Аудит ХХК

СЗХ
2022 06 22
БҮРТГЭВ
№ 01



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Компани нь бараа, ажил үйлчилгээтэй холбоотойгоор олон төрлийн ажил гүйлгээ хийдэг. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрт тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.
Орлогыг тохиролцсон барааг шилжүүлсэн болон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.
Борлуулсан бүтээгдэхүүнээс олсон орлогыг буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмждэг.

### l) Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

*i) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг*
Борлуулалтын өртгийг бараа материалыг борлуулах үед буюу бараа, бүтээгдэхүүний өмчлөлийн эрхийг бусдад шилжүүлж орлого олсон тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

*ii) Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал*
Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### m) Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана. Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардлыг хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Барьж босгоход хугацаа шаардлагатай хөрөнгийн өртөгт багтаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах үйл ажиллагаанаас гарч буй зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг.

СЗХ
2022.06.22
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

"МОН БИЙФ"
Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани

2022-06-17
БҮРТГЭВ



## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

### п) Татварын зардал

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татвар хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг юм.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй.

Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

### о) Түрээс

Гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг нь төлбөрийн хариуд хөрөнгийг ашиглах эрхийг тодорхой хугацааны турш олгодог бол түүнийг Компани түрээс гэж үздэг. Түрээс гэдэг нь дараах шалгуурыудыг хангасан гэрээ юм:

(а) Тодорхойлсон хөрөнгөтэй;
(б) Хөрөнгийн ашиглалтаас үүсэх эдийн засгийн бараг бүх үр өгөөжийг хүртдэг; ба
(в) Компани хөрөнгийг ашиглалтыг удирдан чиглүүлэх эрхтэй.

Түрээслүүлэгчид төлөх гэрээний төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хэмжинэ. Түрээсийн нуугдмал хүүгийн түвшнийг шууд тодорхойлох боломжит бол уг түвшнийг ашигласнаар түрээсийн төлбөрийг дискаунтчилна. Хэрэв тэрхүү түвшнийг шууд тодорхойлох боломжгүй бол Компанийн зээлийн өсөн нэмэгдэх хүүгийн түвшнийг ашиглана.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түрээсийн өр төлбөрийн дансны үнэд дараах зүйлс багтана:

- үлдэх өртгийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй дүн;
- худалдан авах сонголтоо Компани хэрэгжүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол тэрхүү сонголтыг хэрэгжүүлэх үнэ;
- түрээсийг цуцлах сонголтоо хэрэгжүүлэх талаар тухайн түрээсийн нөхцөлд тусгадаг бол түрээсийг цуцалсны улмаас төлөх торгуулийн дүн.

МонБиифLLC УЛААНБААТАР 5646436
ЭЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК ШАЛГАВ 01

## 2. Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Компани аливаа түрээсийн хугацааны тооцоололд өөрчлөлт оруулсан бол (жишээ нь, сунгах эсвэл цуцлах сонголтыг түрээслэгч хэрэгжүүлэх магадлалыг дахин үнэлсэн гэх мэт шалтгаанаар) шинэчлэгдсэн хугацааны турш хийх төлбөрийг илтгэхийн тулд түрээсийн өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийх бөгөөд үүнийг түрээсийн эхлэлд мөрдөж байсантай ижил дискаунтын хувь ашиглан дискаунтчилна. Хувь хэмжээ эсвэл индексээс хамааралтай ирээдүйн түрээсийн төлбөрийн хувьсах элементүүдийг шинэчилсэн бол түрээсийн өр төлбөрийн дансны үнийг ч мөн шинэчилнэ. Аль ч тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэд зохих тохируулгыг хийх бөгөөд шинэчилсэн дансны үнийг түрээсийн үлдсэн (шинэчилсэн) хугацааны турш хорогдуулна.

### р) Ажиллагсдын тэтгэмж

*i) Түр хугацааны ажиллагсдын тэтгэмж*

Богино хугацаат ажиллагсдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажиллагсдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг. Хэрэв ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

*ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал*

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

## 3. Өмч, Барилга, Тоног төхөөрөмж

| | Машин, тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **67,676** | **439,436** | **838,257** | **67,643** | 1,413,011 |
| Нэмэгдсэн | 4,420 | 107,540 | 67,661 | 76,258 | 255,879 |
| Хасагдсан | | (100,035) | (3,375) | (58,783) | (162,193) |
| **2022 оны 3-р сарын 31-ний үлдэгдэл** | **72,096** | **446,941** | **902,543** | **85,118** | **1,506,698** |
| *Хуримтлагдсан элэгдэл:* | | | | | |
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **2,717** | **15,750** | **19,494** | **9,061** | **47,022** |
| Байгуулсан элэгдэл | 2,201 | 15,036 | 20,482 | 17,367 | **55,086** |
| Данснаас хассан хөрөнгийн элэгдэл | | (4,188) | (82) | (9,155) | (13,425) |
| **2022 оны 3-р сарын 31-ний үлдэгдэл** | **4,918** | **26,598** | **39,893** | **17,273** | **88,682** |
| *Дансны үнэ:* | | | | | |
| **2021 оны 12-р сарын 31** | **64,960** | **423,686** | **818,763** | **58,581** | **1,365,990** |
| **2022 оны 3-р сарын 31** | **67,179** | **420,343** | **862,649** | **67,845** | **1,418,016** |

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

СЭЗ 2022 оны 08 сар 22 өдөр БҮРТГЭВ № 01

2022-08-17 БҮРТГЭВ

## 4. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө нь программ хангамжийн өртгийг илэрхийлэх бөгөөд тайлант жилд гарсан хөдөлгөөн нь дараах байдалтай байна. Үүнд:

| | Программ хангамж мян.төг |
|---|---|
| **ӨРТӨГ** | |
| **2021 оны 12-р сарын 31** | **20,919** |
| Нэмэгдсэн | 6,415 |
| Хасагдсан дүн | |
| **2022 оны 03-р сарын 31** | **27,334** |
| **ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ** | |
| **2021 оны 12-р сарын 31** | **2,353** |
| Байгуулсан | 1,226 |
| Хасагдсан | |
| **2022 оны 3-р сарын 31** | **3,579** |
| *Дансны үнэ:* | |
| **2021 оны 12-р сарын 31** | **18,566** |
| **2022 оны 3-р сарын 31** | **23,755** |

## 5. Хойшлогдсон татварын хөрөнгө

Энэхүү дүн нь татварын алдагдлыг дараагийн тайлант үед шилжүүлэхтэй холбоотойгоор үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл дүнг илэрхийлнэ.

## 6. Бараа материал

| | 2022 оны 3 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Түүхий эд материал | 1,276,190 | 1,502,107 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 87 | 103 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 539,418 | 308,030 |
| Хангамжийн материал | 91,970 | 95,377 |
| | **1,907,665** | **1,905,617** |

АПЕКС КАПИТАЛ ҮЦК ХХК, УЛААНБААТАР ХОТ

МОН БИЙФ ХХК, УЛААНБААТАР ХОТ

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК, ШАЛГАВ 01

20

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн түүхий эд материалын үлдэгдэлд 841,618 мянган төгрөгийн дансны үнэтэй 360 толгой үхэр (2021 оны 12 сарын 31-нээр: 1,088,475 мянган төгрөгийн дансны үнэтэй 722 толгой үхэр) багтаж байгаа болно.

## 7. Урьдчилж төлсөн тооцоо ба зардал

| | 2022 оны 3 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 58,204 | 31,782 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр | 198,466 | 180,056 |
| | **256,670** | **211,838** |

## 8. Худалдааны болон бусад авлага

| | 2022 оны 3 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Дансны авлага | 20,563 | 6,784 |
| Үнэ цэнийн бууралтын нөөц | - | - |
| **Цэвэр худалдааны авлага** | **20,563** | **6,784** |
| Ажилчидаас авах авлага | 494 | 4,855 |
| Гүйцэтгэлийн баталгаа, Гэрээний барьцаа | 18,660 | 18,150 |
| Холбоотой талаас авах авлага | 114,683 | 101,890 |
| Гаалийн албан татварын авлага | - | 2,863 |
| НДШ-ийн авлага | 16 | 3,924 |
| Бусад авлага | 1,372 | - |
| **Бусад авлага** | **135,225** | **131,682** |
| **Нийт худалдааны ба бусад авлага** | **155,788** | **138,466** |

## 9. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| | 2022 оны 3 сарын 31 мян.төг | 2021 оны 12 сарын 31 мян.төг |
|---|---|---|
| Замд яваа мөнгө | 1,498 | - |
| Харилцах данс дахь мөнгө-төгрөг | 6,777 | 38,113 |

СЗХ 2022 оны 06 сарын 22 өдөр БҮРТГЭВ № 01

| | | |
|---|---|---|
| Харилцах данс дахь мөнгө-гадаад валют | 1,904 | 1,948 |
| **Нийт мөнгөн хөрөнгө** | **10,179** | **40,061** |

## 10. Хувьцаа эзэмшигчдийн өмч

| | 2022 он | | 2021 он | |
|---|---|---|---|---|
| | Дүн Мян.төг | Хувьцааны тоо | Дүн Төгрөг | Хувьцааны тоо |
| *Оруулсан хөрөнгө оруулалт* | | | | |
| **1 сарын 01-нээр** | **200,000** | **200,000** | **10,000** | **10,000** |
| Шинээр гаргасан | 1,300,000 | 1,300,000 | 190,000 | 190,000 |
| **12 сарын 31-нээр/3 сарын 31** | **1,500,000** | **1,500,000** | **200,000** | **200,000** |

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн өмч нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,500,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байгаа бөгөөд дараах байдлаар эзэмшдэг.

| **Хувьцаа эзэмшигчид** | **хувьцааны тоо** | **нэгжийн үнэ төгрөг** | **Дүн мян.төг** |
|---|---|---|---|
| Таванбогд Трейд | 1,101,000 | 1,000 | 1,125,000 |
| Ц. Цэцэнхүү | 75,000 | 1,000 | 75,000 |
| Ж. Барсболд | 150,000 | 1,000 | 150,000 |
| Ж. Оюунчимэг | 30,000 | 1,000 | 30,000 |
| Э. Пүрэвлхам | 75,000 | 1,000 | 75,000 |
| И. Баттуяа | 45,000 | 1,000 | 45,000 |
| | **1,500,000** | | **1,500,000** |

## 11. Худалдааны болон бусад өглөг

| | **2022 оны 03 сарын 31 мян.төг** | **2021 оны 12 сарын 31 мян.төг** |
|---|---|---|
| Худалдааны өглөг | 61,488 | 200,947 |
| Цалингийн өглөг | 44,084 | 40,532 |
| НӨАТ-ын өглөг | 194 | 188 |
| ХХОАТ-ын өглөг | 7,005 | 6,486 |
| Бусад өглөг | 46,147 | 40,777 |
| | **158,919** | **288,929** |

СЭХ
2022 .06. 21
БҮРТГЭВ
№ 01



2022 -06- 17
БҮРТГЭГДЭВ

## 12. Татварын өр

Энэхүү дүн нь ААНОООСА Татварын өглөгийн дүнг илэрхийлнэ.

## 13. Санхүүжилтийн өр

Энэхүү дүн нь холбоотой тал болох Таван богд трейд ХХК-аас авсан санхүүжилтийн өрийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийг илэрхийлнэ. .

## 14. Борлуулалтын орлого

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Бараа борлуулалтын орлого | 512,468 | - |
| Бараа борлуулалтын орлого-онлайн | 563 | - |
| **Нийт борлуулалтыг орлого** | **513,032** | - |
| Борлуулалтын буцаалт ба хөнгөлөлт | (3,867) | |
| | **509,165** | - |

## 15. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Бараа борлуулсны өртөг | (623,583) | - |
| Бараа борлуулсны өртөг-онлайн | (649) | - |
| | **(624,232)** | - |

## 16. Бусад орлого

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Алданги, торгуулийн орлого | | - |
| Үнэ төлбөргүй бусдаас авсан ажил үйлчилгаа | 60 | - |
| Бусад орлого | 1,085 | - |

СЗХ
2022 . 06 . 22
БҮРТГЭВ
№ 01



| | | |
|---|---|---|
| | 1,146 | - |

## 17. Борлуулалт, маркетингийн зардал

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | (50,682) | - |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | (7,003) | - |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | (14,372) | - |
| Томилолтын зардал | (1,596) | - |
| Бичиг хэргийн зардал | (21) | - |
| Шуудан холбооны зардал | (2,626) | - |
| Даатгалын зардал | (6) | - |
| Ашиглалтын зардал | (226) | |
| Засварын зардал | (440) | - |
| Элэгдэл, хорогдлын зардал | (2,474) | - |
| Түрээсийн зардал | (4,550) | - |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | (15) | - |
| Тээврийн зардал | (45) | - |
| Шатахууны зардал | (5,147) | - |
| Бусад | (20,774) | - |
| | **(109,978)** | - |

## 18. Ерөнхий удирдлагын зардал

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | (104,329) | - |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | (12,357) | - |
| Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | (7,452) | - |
| Томилолтын зардал | (1,068) | - |
| Бичиг хэргийн зардал | (1,871) | - |
| Шуудан холбооны зардал | (2,101) | - |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | (1,650) | - |
| Сургалтын зардал | (2,317) | - |
| Даатгалын зардал | (428) | - |
| Засварын зардал | (1,011) | - |
| Элэгдэл, хорогдлын зардал | (9,421) | - |
| Түрээсийн зардал | (18,340) | - |
| Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | (3,244) | - |
| Шатахууны зардал | (5,832) | - |
| Зар сурталчилгааны зардал | (30) | - |

СЗХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-06-17

| | | |
|---|---|---|
| Бусад | (27,154) | |
| | **(198,604)** | **-** |

## 19. Санхүүгийн цэвэр зардал

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Санхүүжилт авахтай холбоотой гарах зардал | - | - |
| Зээлийн шугамын хүүгийн зардал | (1) | - |
| Компани хоорондын зээлийн хүүгийн зардал | (75,258) | - |
| | **(75,259)** | **-** |

## 20. Бусад зардал

| | 2022 оны 1-р улирал мян.төг | 2021 оны 1-р улирал мян.төг |
|---|---|---|
| Үнэ цэнийн бууралтын гарз | (325) | - |
| Бусад зардал | (6,838) | - |
| | **(7,164)** | **-** |

## 21. Орлогын татварын зардал

Компани нь Монгол Улсын Татварын хуулийн дагуу татварын зорилгоор татвар ногдуулахгүй орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлуудын нөлөөг тооцсоны үндсэн дээр орлогын татвараа мэдүүлдэг ба 6 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж ААН-ийн Орлогын татвар төлөх үүрэгтэй. Компани 2021 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон жилд алдагдалтай ажилласан бөгөөд алдагдлыг шилжүүлэн бүртгэж, хойшлогдсон татварын хөрөнгө, орлогын татварын өгөөж хүлээн зөвшөөрч тайлагнасан.

ШАЛГАВ 01

СЗХ
2022 .08. 22 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ИТГЭЛТ
ЭСТИМЭЙТ

**БИЗНЕС ҮНЭЛГЭЭ**
**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ**
**ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ**

2022-08-17

# БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| | |
|---|---|
| **Захиалагч:** | **"Мон Бийф" ХХК** |
| **Захиалагчийг төлөөлж:** | **Н.Ариунбаатар /Гүйцэтгэх захирал/** |
| **Үнэлсэн хөрөнгийн нэр:** | **"Мон Бийф" ХХК-ийн бизнесийн үнэ цэнэ** |
| **Үнэлсэн хөрөнгийн байршил:** | **Төв аймаг, Сэргэлэн сум** |
| **Үнэлгээний дүн:** | **12,861,800,000 /Арван хоёр тэрбум найман зуун жаран нэгэн сая найман зуун мянга/-н төгрөг** |
| **Огноо:** | **2022.05.09** |

**Улаанбаатар хот**

СЭХ
2022.06.22 өдөр
БҮРТГЭВ
№

## АГУУЛГА

1. **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ** 5
2. **БИЗНЕСИЙН ОРЧИН БА ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ** 6
2.1 Инфляци 7
2.1.1 Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс 7
2.1.2 Эдийн засгийн өсөлт 8
2.2 Дотоод эдийн засгийн орчин 9
2.2.1 Хөдөлмөрийн зах зээл 9
2.2.2 Ажил эрхлэлт, нийгмийн даатгал 9
2.2.3 Мөнгө, зээлийн үзүүлэлт 10
2.2.4 Валютын ханш 10
2.3 Хөрөнгийн зах зээл 11
2.3.1 Хөрөнгийн зах зээл 11
2.3.2 Нэгдсэн төлөв болон Засгийн газрын өр 11
2.4 ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН 11
2.4.1 Гадаад эрэлт 11
2.4.2 Худалдааны нөхцөл 11
2.4.3 Төлбөрийн тэнцэл 11
2.4.4 Мөнгөний бодлого 13
2.5 БИЗНЕСИЙН ТҮҮХ, МӨН ЧАНАР ӨНӨӨГИЙН БАЙДАЛ 14
2.5.1 Эрүүл чанартай, гарал үүсэл тодорхой мах, махан бүтээгдэхүүн 14
2.5.2 Бэлчээрийн даац 14
2.5.3 Сум орон нутагт ажлын байрыг бий болгох 15
2.5.4 Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөж, орлогыг нэмэгдүүлэх 15
2.5.5 Мал аж ахуйн салбарын шинэчлэл 27
2.5.6 Санхүүгийн тайлан, санхүүгийн шинжилгээ 41
2.5.7 Хөрөнгийн үнэлгээ 45
**3. БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ** 46
3.1 Бизнес үнэлгээ хийсэн тухай 46
3.1.1 Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргаар хийсэн тухай 53
3.2 Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргаар хийсэн үнэлгээ 54
3.3 Цэвэр активын аргаар хийсэн үнэлгээ 55
3.4 Зах зээлийн аргаар хийсэн үнэлгээ 55

Мон Бийф ХХ компани

3.5 Үнэлгээний дүгнэлт 56
**4. НИЙЦЭЛТИЙН ТУХАЙ МЭДЭГДЭЛ** 57
**5. ҮНЭЛГЭЭГ АШИГЛАЖ БОЛОХ НӨХЦӨЛ** 58

СЭХ
он 2022 сар 06. 22 өдөр
БҮРТГЭВ

# “ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ” ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## БИЗНЕС ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(Хураангуйлал)*

| | |
|---|---|
| Захиалагчийн нэр: | “Мон Бийф” ХХК |
| Захиалагчийг төлөөлж: | Н.Ариунбаатар (Гүйцэтгэх захирал) |
| Компанийн регистрийн дугаар: | 6648436 |
| УБ-ийн гэрчилгээний дугаар: | 9011823614 |
| Үнэлсэн хөрөнгийн нэр: | “Мон Бийф” ХХК-ийн бизнесийн үнэ цэнэ |
| Хөрөнгийн байршил: | Төв аймаг Сэргэлэн сум |
| Үнэлгээний дүн: | **12,861,800,000 /Арван хоёр тэрбум найман зуун жаран нэгэн сая найман зуун мянга/-н төгрөг** |
| Гүйцэтгэгч: | Итгэлт-Эстимэйт ХХК<br>Регистр 2866641<br>Улсын бүртгэлийн дугаар 24/4539<br>Утас: 76005638, 99115638<br>E-mail: itgelt_estimate@itgeltgroup.mn<br>Web: www.itgeltgroup.mn |
| Ерөнхий захирал: | Э.Ганбаатар нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 140600038 тоот тусгай зөвшөөрөлтэй<br>М.Эрхэмбаяр нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 140600035 тоот тусгай зөвшөөрөлтэй<br>Г.Оюунчимэг нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 071200075 тоот тусгай зөвшөөрөлтэй<br>Д.Гантулга нь СЯ-ны хөрөнгийн үнэлгээ хийх эрхийн 15012092 тоот тусгай зөвшөөрөлтэй |
| Тайлан бичсэн огноо: | 2022 оны 05 дугээр сарын 09-ний өдөр |

Мон Бийф ХХ КОМПАНИ

**БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022-05-09 №98/01 Улаанбаатар хот

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Бид “Мон Бийф” ХХК-ийн бизнесийн үнэлгээ хийлгэх хүсэлтийн дагуу 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр үнэлгээний ажлын 2022/08 тоот гэрээг байгуулж “Мон Бийф” ХХК-ийн 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх бизнесийн зах зээлийн үнэ цэнийг Монгол улсын хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Үнэлгээний Олон Улсын Стандарт болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бие даасан хараат бус байдлаар тогтоох зорилгоор энэхүү үнэлгээг хийсэн болно.

**Зах зээлийн үнэ цэнэ:** гэдэг нь зохих маркетинг сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулалгчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн юм.

**Бизнесийг үргэлжлүүлэн ашиглах** гэдэгт үндсэндээ дараах тохиолдлууд орно. Үүнд:

- ✓ Тухайн бизнес нь үзүүлж буй үйлчилгээнийхээ эдийн засгийн шаардлагыг хангасан байх;
- ✓ Бизнес нь цаашид урт хугацаанд тасралтгүй үргэлжлэх боломжтой байх;
- ✓ Хариуцлагатай өмчийн эзэн, чадварлаг менежменттэй байх;
- ✓ Өөр зорилгоор ашиглах нь эдийн засгийн хувьд тохиромжгүй, хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй байх;
- ✓ Одоогийн, эсвэл түүнтэй төстэй хэрэглэгчид өнөөгийн ашиглалтыг цааш нь үргэлжлүүлэх;

Бид бодит байдлыг шинжилж үзээд компанийн ирээдүйд олох боломжит орлогод тулгуурлан бизнесийн үнэ цэнийг тогтоосон болно.

**Нийт хөрөнгө** гэдэг нь бүхий л биет хөрөнгө (барилга, байгууламж, тоног төхөөрөмж, ажлын капитал) болон үргэлжлүүлэн ашиглах биет бус хөрөнгийн нийлбэр юм.

**Цэвэр өөрийн хөрөнгө** нь нийт хөрөнгөөс бусдад төлөх өр төлбөрийг хассан зөрүүгээр тодорхойлогдсон.

Бид “Мон Бийф” ХХК-ийн бизнесийн үнэлгээг 5 жилийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд үндэслэн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тогтоосон болно.

СЭХ
ом 2022 са 06. 22 өдөр
БҮРТГЭВ



## ХОЁРДУГААР БҮЛЭГ. БИЗНЕСИЙН ОРЧИН БА ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

**Монгол банкны инфляцийн 3-р сарын тайлан ба үзүүлэлт, график холбогдох мэдээлэл**
*Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхий дахинд тодорхой бус байдал эрс нэмэгдэн, түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, байгалийн хийн үнэ огцом өсөж, богино хугацаанд дэлхий нийтээр инфляц даамжрах, эдийн засгийн өсөлт удаашрах эрсдэлийг бий болгож байна. Манай орны хувьд ч энэхүү нөхцөл байдал нь гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, шатахуун болон бусад импортын үнийн шууд болон дам нөлөөгөөр инфляцыг эрчимжүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлийн зардлыг өсгөж, эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна. Цаашид урд болон хойд хилийн нөхцөл байдал, түүнтэй холбогдон эдийн засгийн идэвхжил төсөөллөөс саарах, зардлын болон нийлүүлэлтийн гаралтай инфляц илүү нэмэгдэх эрсдэлтэй байна.*

**Олон улсын харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор инфляцын төсөөлөл нэмэгдсэн** ба инфляц 2022 оны 2-р сард улсын хэмжээнд жилийн 14.2 хувь, Улаанбаатар хотод 15.5 хувийн өсөлттэй гарав. Үүнд, гадаад талаас олон улсын зах зээл дээрх нефтийн үнийн өсөлт, тээвэр логистикийн саатал, түүнээс улбаатай тээврийн нэмэлт зардал, нийлүүлэлтийн доголдол, гадаад инфляц зэрэг нь нөлөөлөв. Дотоод талаас тээврийн болон үйлдвэрлэлийн зардал өссөн, малын гоц халдварт өвчин дэгдсэн нь нөлөөлсөн.

**Нэгдсэн төсвийн 2022 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 32 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй гарсан.** Үүнд, төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52 хувиар буюу 841 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний дийлэнх хэсэг нь өмнөх жилүүдэд Ирээдүй өв санд бүртгэдэг байсан ашигт малтмалын нөөц Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар 5 ашигласны төлбөрийг тэнцвэржүүлсэн орлогод бүртгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн суурь нөлөө үргэлжилж байгаатай холбоотой байна. Харин төсвийн нийт зардал энэ оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 40.0 хувиар буюу 696 тэрбум төгрөгөөр өсөж 2.4 их наяд төгрөгт хүрэв.

**Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, банкуудын зээлийн өсөлт алгуур нэмэгдсэн хэвээр байна**. Сүүлийн саруудад гадаад валютын цэвэр урсгал сөрөг байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад голлон нөлөөлөв.
Төмрийн хүдрээс бусад түүхий эдийн үнийн төлөв өмнөхөөс сайжирсан ч импортын үнэ өссөнөөр худалдааны нөхцөл муудахаар байна. Эрэлт өндөр, нийлүүлэлт хязгаарлагдмал байгаагаас газрын тос, зэс, нүүрсний үнэ өмнөх төсөөллөөс өслөө. Ялангуяа, олон улсын харилцаанд үүссэн нөхцөл байдлаас үүдэн газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт буурч, үнэ огцом өсөөд байгаа бөгөөд цаашдын түүхий эдийн үнийн төлөв үүсээд буй нөхцөл байдлаас хүчтэй хамаарахаар байна.

MonBeef LLC
Мон Бийф ХХ компани
6648436
УЛААНБААТАР

**Төлбөрийн тэнцлийн 2021 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэлийг авч үзвэл 358.6 сая ам.долларын ашигтай гарсан.** Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант улиралд урсгал дансны алдагдал тэлж, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг буурснаар төлбөрийн тэнцлийн ашиг цэвэр дүнгээр буурчээ.

**I ИНФЛЯЦИ**

**1. Инфляцид нөлөөлж буй хүчин зүйлс**

-Тээвэр логистикийн саатал бий болсноор тээврийн зардал өсөх, нийлүүлэлт тасалдах зэрэг чингэлгийн бөөгнөрөл

-Мөн урд хөрштэй холбоотой бараа, бүтээгдэхүүний хомсдол, эрэлт өссөнөөр

-Геополитикийн асуудлаас үүдэн дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ, үйлдвэрлэлийн зардлын өсөлт /ОХУ-Украйны геополитикийн хүндрэл/ зэрэг.

**Инфляцын цаашдын төлөв**




Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад инфляцын төсөөлөл нэмэгдлээ. Олон улсын харилцаанд шинээр үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор тодорхой бус байдал ихээхэн нэмэгдээд байгаа бөгөөд дэлхийн зах зээл дэх газрын тос болоод ХАА-н түүхий эдийн үнийн өсөлт эрчимжиж, гадаад инфляц нэмэгдэх эрсдэл бий болсон нь инфляцын төсөөллийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

**2. Эдийн засгийн өсөлт**

Эдийн засгийн өсөлт сүүлийн гурван улирал дараалан саарсан хэдий ч бодит ДНБ жилийн дүнгээр 1.4 хувиар тэлэв. Үүний дийлэнх хэсгийг I улирлын огцом өсөлт бүрдүүлсэн бол IV улиралд эдийн засаг 3.8 хувиар агшсан байна. Түүнчлэн, ДНБ 2019 онтой харьцуулахад 2021 онд 3.2 хувиар бага байгаа нь эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргээгүй байгааг илтгэж байна.







**Нийт эрэлт**

Нийт эрэлт 2021 онд 1.4 хувиар өсөхөд нийт хөрөнгийн хуримтлал голлон тэтгэсэн бол цар тахлаас сэргийлэх хязгаарлалтын арга хэмжээ, гадаад худалдааны тээвэр, логистикийн хүндрэл нь эцсийн хэрэглээ, цэвэр экспортод хүчтэй сөрөг нөлөө үзүүлэв.

**Нийт нийлүүлэлт**

Эдийн засгийн өсөлтийг нийлүүлэлт9 талаас авч үзвэл 2021 оны нийт дүнгээр уул уурхай 1.7 хувь, уул уурхайн бус салбарууд 1.4 хувиар тус тус өсжээ. Мөн цар тахлын өмнөх үе буюу

СЗХ
2022.06.22 он сар өдөр
БҮРТГЭВ
№



2019 онтой харьцуулахад уул уурхай салбар 8.3 хувь, уул уурхайн бус салбарууд 2.3 хувиар тус тус бага байна

## II ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

### 1. Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын өнөөгийн байдлыг тоймлон авч үзвэл сүүлийн улирлуудад алгуур сэргэж байгаа хэдий ч цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хараахан хүрээгүй хэвээр байна. Хөдөлмөрийн зах зээлийн төлөвийг тодорхойлдог үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл тайлант улиралд ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувьд, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.6 хувьд тус тус хүрч сайжирлаа. Түүнчлэн, хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин12 өмнөх улирлаас 0.1 нэгж хувь, өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурсан нь мөн эерэг үзүүлэлт боллоо. Харин ажилгүйдлийн түвшин (8.1%) өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өндөр байсан байна.

### 2. Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

**Нийт ажил эрхлэлт IV улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.2%-иар нэмэгджээ.** Үүнд уул уурхай, барилга, ХАА, зочлох үйл ажиллагаа, мэдээлэл холбоо, төрийн удирдлагын салбарт ажиллагчдын өсөлт голлон нөлөөлжээ. Нөгөөтэйгүүр, боловсруулах, худалдаа, санхүү даатгал, эрүүл мэнд, урлаг үзвэрийн салбарт албан хаагчид өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна




ХЭТ- Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

АТ- Ажилгүйдлийн түвшин

АХОТ- Ажиллах хүчний оролцооны түвшин

**Ажилгүйдэл**

Энэ оны эхний 2 сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 10.5 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 4.2 мянган хүнд олгоод байна. Хэдийгээр олгосон тэтгэмжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.9%-иар өндөр байгаа ч тэтгэмж авсан иргэдийн тоо 9.2%-иар

буурчээ. Ингэснээр нэг иргэнд ногдож буй сарын дундаж ажилгүйдлийн тэтгэмж өмнөх оны мөн үеэс 30%-иар нэмэгдэж, 2.5 сая төгрөгт хүрлээ

**Цалин, өрхийн орлого**

Улсын дундаж цалин тайлант IV улиралд 1438.2 мянган төгрөг, медиан цалин 1068.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 7-8 хувиар нэмэгдсэн үзүүлэлт болж байна. Үүнтэй уялдаатайгаар өрхийн сарын дундаж нийт орлого өмнөх оны мөн үеэс 15.3%-иар өсөж, 1642.9 мянган төгрөгт хүрчээ. Хэдийгээр нэрлэсэн орлого ийнхүү өссөн ч иргэдийн худалдан авах чадварыг илэрхийлэх үнийн нөлөөллийг арилгасан бодит орлогын үзүүлэлтүүд бууралттай байна. Тухайлбал, улсын дундаж бодит цалингийн индекс өмнөх оны мөн үеэс 4.4%- иар буурсан байна

**3. Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд**

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, харин банкуудын зээлийн өсөлт алгуур нэмэгдэв. Банкны системийн хадгаламжийн долларжилт сүүлийн саруудад тогтвортой, зээлийн долларжилт буурлаа. Банкуудын зээлийн шалгуур, нөхцөл суларч, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрэлт нэмэгдсэн байна.

**4. Валютын ханш**

Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ам.долларын ханш 2850 төгрөгийн орчимд тогтвортой байсан. Гэвч 2022 оны 2 дугаар сараас эхлэн төгрөгийн ам.доллартой харьцах ханш сулрах хандлага ажиглагдаж байна. Тайлант улиралд импорт өссөн хэдий ч экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдэн худалдааны тэнцэл ашигтай гарсан нь ханш харьцангуй тогтвортой хадгалагдахад нөлөөлөв. Харин 2022 оны 1-р улиралд ОХУ-Украины нөхцөл байдал нь төгрөг төдийгүй бусад валютуудын ханш ам.долларын эсрэг сулрахад нөлөөлөв. Энэ нь экспортын хэмжээ бага байгаатай давхцсан нь зах зээлд оролцогчдын итгэлд сөргөөр нөлөөллөө.

Төгрөг доллартай харьцах ханш 2021 оны 4 сараас 2022 оны 3 сар хүртэлх



## III ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 1.Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн захын идэвх 2021 оны туршид эрчимжиж 12 дугаар сарын дунджаар ТОП-20 индекс 41,668.8 нэгжид хүрсэн нь оны эхнээс 2 дахин өссөн үзүүлэлт боллоо. Мөн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд хэмжээ буюу 5.98 их наяд төгрөгт хүрэв. Харин он гарснаар хөрөнгийн захын идэвхжил харьцангуй тогтворжсон бөгөөд 2022 оны 1-р сарын дунджаар ТОП-20 индекс 42,447.6 нэгжид хүрч өмнөх сарын дунджаас 1.9 хувиар өсчээ

### 2.Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2021 онд батлагдсан дүнгээс 600 21 “ЭТТ бонд”-ын арилжааны дүнг хасч дүрслэв. орчим тэрбум төгрөгөөр давж, зардал бүрэн зарцуулагдсанаар нэгдсэн төсөв 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлого төлөвлөгөөнөөс давсан нь 1/ Оюу толгой компаниас 1 их наяд төгрөгийн орлого нэмж бүрдсэн, 2/ НДШ 2021 оны 7 дугаар сараас эхлэн хөнгөлөлтгүй хувь хэмжээгээр төлөгдөж эхэлсэн, 3/ НӨАТ-ын орлого төлөвлөгөөнөөс өндрөөр биелсэнтэй холбоотой байв.

## IV ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

### 1.Гадаад эрэлт:

БНХАУ, АНУ, Евро бүсийн 2022 оны өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс муудаж, глобал эдийн засгийн өсөлтийн төлөв муудлаа. Үүнд цар тахлын нөхцөл байдал, БНХАУ-ын өсөлт саарах төлөв, ОХУ-Украины нөхцөл байдал, хүлээлтээс давсан инфляц, мөнгөний бодлого хурдтай нормалчлагдах зэрэг нь голлон нөлөөлж байна. Түүхий эдийн үнэ Түүхий эдийн үнийн төлөв ОХУ-Украины нөхцөл байдлаас хүчтэй хамаарахаар байна.

### 2.Худалдааны нөхцөл

ҮСХ-ны тооцоогоор манай худалдааны нөхцөл 2021 оны 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.6 хувиар сайжирав. Нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ жилийн 76.5 хувиар өссөнөөс голлон шалтгаалж нийт импортын үнийн индекс 24.9 хувиар нэмэгдсэн байна. Харин нүүрсний хилийн үнэ 252 хувиар өссөнөөс шалтгаалж экспортын үнэ илүү хурдтай буюу 60.7 хувиар нэмэгдсэн нь худалдааны нөхцөл сайжрахад нөлөөлөв. Дэлхийн улс орнуудад инфляц эрчимжсэн, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, хүнсний үнэ өссөн, тээврийн зардал нэмэгдсэн нь манай улсын импортын үнэ өсөх суурь шалтгаан болов.

### 3.Төлбөрийн тэнцэл

Урсгал тэнцлийн алдагдал тэлснээр 2021 онд Монгол улсын төлбөрийн тэнцэл 221.6 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Тодруулбал, 2021 оны туршид импорт экспортоос хурдтай тэлж, гадаад худалдааны ашиг буурсан, ААН-үүдийн дахин хөрөнгө оруулалт нэмэгдэж, орлогын дансны алдагдал тэлснээр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оноос 2.9 дахин тэлж, ДНБий 13 хувьд хүрсэн байна (Зураг IV.3.2). Урсгал тэнцлийн алдагдлыг ГШХО, гадаад зээлээр голлон санхүүжүүлжээ. Гадаад валютын албан нөөцийн хувьд 2021 оны эцэст 4366.1 сая ам.долларт хүрсэн нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 8.0 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

## МӨНГӨНИЙ БОДЛОГО

Мөнгөний бодлогын хорооны гишүүд нь улиралд нэг буюу жилд 4 ээлжит хурал зохион байгуулдаг ба мөн шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зарлан тухайн цаг үеэсээ хамааран нэмэлтээр хурлын тов гарган мөнгөний бодлогын мэдэгдэл гаргадаг.

2022 оны 3 сард

Бодлогын хүүг өсгөх тухай Дугаар: 2022/02

Огноо: 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар сарын 23, 24-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөвийг **хэлэлцэн бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 9.0 хувьд хүргэх шийдвэр гаргалаа.** Олон улсын харилцаанд хурцадмал байдал шинээр үүсэж, гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдлын нэмэлт эх сурвалж болж байна. Ийнхүү тодорхой бус байдал огцом нэмэгдэж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, хүнсний үнэ огцом өсөж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэхээр байгаагаас энэ онд инфляц өмнө нь төсөөлж байснаас нэмэгдэх, эдийн засгийн өсөлт саарах эрсдэл олон улс оронд бий болоод байна. Жилийн инфляц 2022 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 14.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.5 хувьтай гарав. Инфляцад олон улсын зах зээл дээрх хүнсний болон шатахууны үнэ өссөн, тээвэр логистикийн саатал, түүнээс улбаатай тээврийн нэмэлт зардал, нийлүүлэлтийн доголдол зэрэг хүчин зүйлс нь голлон нөлөөлж байна. Инфляц 2 дугаар сараас алгуур саарч эхэлсэн нь өмнөх төсөөлөлтэй нийцтэй байсан хэдий ч олон улсад шинээр үүсээд буй хурцадмал байдалтай холбоотойгоор инфляцын төсөөлөл нэмэгдэж байна. Цар тахлаас үүдэлтэй хязгаарлалт суларч худалдаа, үйлчилгээний салбар эдийн засгийн идэвхжлийг дэмжсэн хэдий ч хилийн хязгаарлалттай холбоотойгоор уул уурхай, тээвэр, барилгын үйлдвэрлэл буурснаас эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд хүлээлтээс бага гарлаа. Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсөж, үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлэх, БНХАУ-ын ковидын эсрэг бодлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт хязгаарлагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөг 2022 онд үзүүлэхээр байна. Үйлдвэрлэлийн зардлын өсөлтөөр дамжин зардлын инфляц бий болох, инфляцын хүлээлт өсөх, төлбөрийн тэнцэлийн алдагдал нэмэгдэхийн зэрэгцээ гадаад суурь хүү илүү хурдтай өсөх нөхцөл үүсэж байгаа нь мөнгөний бодлогын төлөвийг илүү хурдтай чангаруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна.

**Цаашид гадаад, дотоод эдийн засгийн идэвхжил, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн хязгаарлалт, олон улсын харилцааны нөхцөл байдалтай уялдуулан мөнгөний бодлогын дараагийн алхмуудыг тухай бүр авч хэрэгжүүлэх болно.** Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

**Товчхондоо,**

*Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхий дахинд тодорхой бус байдал эрс нэмэгдэн, түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, байгалийн хийн үнэ огцом өсөж, богино хугацаанд дэлхий нийтээр инфляц даамжрах, эдийн засгийн өсөлт удаашрах эрсдэлийг бий болгож байна. Манай орны хувьд ч энэхүү нөхцөл байдал нь гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, шатахуун болон бусад импортын үнийн шууд болон дам нөлөөгөөр инфляцыг эрчимжүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлийн зардлыг өсгөж, эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна. Цаашид урд болон хойд хилийн нөхцөл байдал, түүнтэй холбогдон эдийн засгийн идэвхжил төсөөллөөс саарах, зардлын болон нийлүүлэлтийн гаралтай инфляц илүү нэмэгдэх эрсдэлтэй байна.*

Олон улсын харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор инфляцын төсөөлөл нэмэгдсэн ба инфляц 2022 оны 2-р сард улсын хэмжээнд жилийн 14.2 хувь, Улаанбаатар хотод 15.5 хувийн өсөлттэй гарав.

Мон Бийф ХХ компани
MonBeef LLC
Улаанбаатар хот
6648436

## 2.1 БИЗНЕСИЙН ТҮҮХ, МӨН ЧАНАР ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Grass Fed Eco Product

MON BEEF

шимтэй, зөөлөн, шүүслэг

**ТАВАН БОГД ГРУПП** нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж зах зээлд эрүүл, чанартай, гарал үүсэл тодорхой мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, хөдөө аж ахуйн кластерын системийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор махны чиглэлийн үүлдрийн үхрийн фермийн аж ахуйг **Төв аймгийн Сэргэлэн суманд** байгуулан үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Бид хөдөө аж ахуй, тэр дундаа эрчимжсэн мал аж ахуйн салбарт ажиллахаар зорьж буй нь дараах үндсэн 5 шалтгаануудтай. Үүнд:

### 1. ЭРҮҮЛ, ЧАНАРТАЙ, ГАРАЛ ҮҮСЭЛ ТОДОРХОЙ МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН

Махны үйлдвэрлэлийн 90 гаруй хувь нь үйлдвэрийн бус аргаар боловсруулагдаж зах зээлд нийлүүлэгдэж байгаа ба худалдааны дийлэнхийг ченж буюу өртөг бүтээгч бус дундын зуучлагч нар бүрдүүлдэг. Энэ нь эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангаж чадахгүй, хүнсний аюулгүй байдлын тогтолцоог алдагдуулж байна. Иймээс эрүүл, чанартай, гарал үүсэл тодорхой мах махан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх эрэлт хэрэгцээ байна.

### 2. БЭЛЧЭЭРИЙН ДААЦ

Малын тоо толгойн өсөлтийг дагаж бэлчээр доройтсоор байна. Ус цаг уур, орчны хүрээлэнгээс 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацын тухай гаргасан мэдээлэлд Монгол Улсын нийт бэлчээр нутгийн 40 гаруй хувьд бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 25 орчим хувьд 3-5 дахин хэтэрсэн, 20 орчим хувьд олон дахин хэтэрсэн байгааг онцолсон. Иймээс малыг эдийн засгийн эргэлтэнд эрт оруулж бэлчээрийн даацын хэтрэлтээс сэргийлэх, МАА-н салбарыг нийгэм, эдийн засгийн эрэлттэй нийцүүлэн хөгжүүлэх шаардлага байна

## 3. СУМ ОРОН НУТАГТ АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОХ

Аймаг, сум орон нутгийн эдийн засгийн хөгжил сул, ажлын байр хомс байна. Үүнээс шалтгаалан нийт хүн амын 60 гаруй хувь нь Улаанбаатар хотод шилжин суурьшиж, түүнийг дагаад үйлдвэрлэл, үйлчилгээнүүд нийслэлд төвлөрсөн. Иймд аймаг, сум орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийг чадавхижуулах шаардлага байна.

## 4. МАЛЧДЫН ХӨДӨЛМӨРИЙГ ХӨНГӨВЧЛӨЖ, ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Малчин өрхүүд нь малыг нас бие гүйцтэл нь маллаад эдийн засгийн эргэлтэнд оруулдаг. Ингэж маллахад малчид маш их хүч хөдөлмөр зарцуулдаг хэдий ч хангалттай үр ашиг хүртэж чаддаггүй. Иймээс эр мал буюу үржлийн бус малыг өсвөр насанд нь худалдан борлуулж эдийн засгийн өгөөжтэй байх шаардлагатай байна.

## 5. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

Монгол орон бол мал аж ахуйн орон. ХАА түүний дотроос Мал аж ахуйн салбар нь Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед манай орны эдийн засгийн гол тулгуур багана байсан ба нэгдэлжих хөдөлгөөн өрнөснөөр нүүдлийн мал аж ахуйг хагас эрчимжсэн аж ахуй болох суурийг тавьж, мал аж ахуйн салбарт урьд өмнө байгаагүй техник технологийг нэвтрүүлэн, байгаль цаг уурын хүндрэл бэрхшээлийг эрсдэл багатай даван туулах нөхцөлийг бүрдүүлж, малыг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулах, өндөр үр ашигт мал өсгөн үржүүлэхэд анхаарч байсан. Зах зээлийн нийгэмд шилжиснээр дээрх асуудлууд зогсонги байдалтай байна. Иймээс МАА салбарт шинэ инноваци нэвтрүүлж малын ашиг шим, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.




Мон Бийф ХХК компани

## SWOT ШИНЖИЛГЭЭ

### STRENGHTS

1. Тусгай жорын дагуу тэжээсэн үхрийн эрүүл махтай.
2. ТБГ-н нэр хүнд бизнесд эерэг нөлөөтэй.
3. ТБГ-н маркетингийн хүчтэй сувагтай.
4. Үйлдвэр зах зээлтэй ойр
5. Өдөр бүр шинэ махтай байна.
6. Үйлдвэрлэлийн хэмжээ ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдээс их байна.

### OPPORTUNITIES

1. Өндөр зэрэглэлийн ресторан зочид буудалд бүтээгдэхүүн нийлүүлэх боломжтой.
2. Жижиглэн болон байгууллагын бөөний борлуулалт хийх боломжтой.
3. Өөрийн аялал жуулчлал, үйлчилгээний охин компаниудад мах нийлүүлэх боломжтой.
4. E-commerce борлуулалтын сувгаар шууд борлуулалт хийх боломжтой.
5. Малчидтай урт хугацааны хамтран ажиллах гэрээ хийж чанар болон үнийг тогтворжуулах боломжтой
6. Тогтвортой бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлэх боломжтой.
7. Өөрийн стейк ресторан нээж ажиллуулах

### WEAKNESSES

1. Шинэ салбар тул туршлага бага
2. Түрээсийн үйлдвэр ашиглаж байгаа
3. Үхрийн ферм болон мал төхөөрөх, ангилах үйлдвэр орон нутагт байгаагаас мэргэжлийн хүний нөөцийн олдоц бага
4. Малын тэжээл тарьдаггүй тул өртөг өндөр гарах
5. Бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгчээс хэт хамааралтай
6. Бүтээгдэхүүний ялгаралын талаар хэрэглэгчдийн ойлголт сул
7. Сав баглаа боодлыг сайжруулах шаардлагатай

### THREATS

1. Малын гаралтай өвчин их гарч байгаа тул татан авалтанд нөлөөлдөг
2. Хэрэглэгч үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах үнэтэй байдаг гэсэн ойлголттой.
3. Хэрэглэгчид зах худалдааны төвүүдээс худалдан авалт хийж хэвшсэн.
4. Улирлын чанартай бизнес тул бяруулны тоо нөөц, чанар болон үнийн хэлбэлзэл бий.

## TOWS ШИНЖИЛГЭЭ

| SO | ST |
|---|---|
| 1. Тэжээлийн жорыг илүү сайжруулж, органик өвс тэжээл хэрэглэдэг гэдгийг нотолдог болох.<br>2. Үйлдвэрлэлийн тоо хэмжээг хэрэглэгч, зах зээлийн шаардлагад нийцүүлэх<br>3. Малын эрүүл мэндийн үзлэг шинжилгээний лабораторитой болох | 1. Малчдыг урамшуулах хөтөлбөр боловсруулж татан авалтыг тогтворжуулах<br>2. Өөрсдийн жижиг үйлдвэртэй болох<br>3. Хэрэглэгчдэд бүтээгдэхүүний ялгаралыг нөлөөллийн арга замаар хүргэх<br>4. Өндөр үнийн бодлогыг баримтлан удаан хугацаанд үнэ цэнээ хадгалах<br>5. Skin vacuum болон Shrink /агшдаг уутгай савлагаа/-ны тоног төхөөрөмж авч, сав баглаа боодлыг шинэчлэх |
| 1. Цөөн тооны өндөр зэрэглэлийн ресторануудад бүтээгдэхүүнээ нийлүүлэх замаар бүтээгдэхүүний үнэ цэнийг хадгалах<br>2. Онлайнаар гологдолгүй, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн борлуулж хэрэглэгчдийн итгэлийг олох<br>3. Группийн бусад охин компаниудтай хамтран ажиллах замаар харилцан ашиг олж, үнэ цэнээ нэмэгдүүлэх | 1. Бүтээгдэхүүний ялгаралыг нэмэгдүүлэх замаар зах зээлийн өрсөлдөөнөөс зайлсхийх<br>2. Эрчимжсэн аж ахуй болон үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны давуу талыг хэрэглэгчдэд ойлгуулах<br>3. Зорилтот хэрэглэгчдийн худалдан авалт хийдэг сувгуудад бүтээгдэхүүнээ байршуулж хэрэглэгчиддээ ойртох<br>4. Байгалийн давагдашгүй хүчин зүйлд бэлтгэлтэй байх |
| WO | WT |

СЗХ 2022 он 06 сар 22 өдөр № 01

## ХЭРЭГЛЭГЧИЙН PERSONA

| Хэрэглэгч 1: Нөөцлөгч | Хэрэглэгч 2: Хэрэглээндээ тохируулагч | Хэрэглэгч 3: Олон давтамжтай авагчид |
|---|---|---|
| **➢ Худалдан авалт:**<br>• Намар идшэндээ зориулан их хэмжээгээр нөөцлөн авч хөлдөөгчиндөө хадгалдаг.<br>**➢ Бүтээгдэхүүний төрөл:**<br>• Хөлдөөсөн задгай мах<br>**➢ Хаанаас авдаг:**<br>• Малчид болон зах, бөөний төв<br>**➢ Бүтээгдэхүүний талаарх үзэл бодол:**<br>• Ихээр авбал хэмнэлттэй гэж үздэг. Махны шинэ, нойтон байх нь тийм ч чухал биш | **➢ Худалдан авалт:**<br>• Хэрэглээндээ тохируулан 7-10 хоногт бага хэмжээгээр худалдан авдаг.<br>**➢ Бүтээгдэхүүний төрөл:**<br>• Савлагаатай мах<br>**➢ Хаанаас авдаг:**<br>• Зах болон супермаркетаас<br>**➢ Бүтээгдэхүүний талаарх үзэл бодол:**<br>• Хийх гэж буй хоол, хэрэглээндээ тохируулан өөрөө үзэж махаа авах нь тохиромжтой гэж үздэг.<br>• Төрөлжүүлсэн махыг худалдан авдаг | **➢ Худалдан авалт:**<br>• Шаардлагатай үедээ худалдан авалт хийдэг.<br>**➢ Бүтээгдэхүүний төрөл:**<br>• Төрөлжүүлсэн мах<br>**➢ Хаанаас авдаг:**<br>• Супермаркет болон өөрт ойр дэлгүүрээс<br>**➢ Бүтээгдэхүүний талаарх үзэл бодол:**<br>• Тэмдэглэлт өдрүүд болон онцгой үед нарийн хоол хийх зорилгоор жижиглэн тусгайлан бэлтгэсэн мах авдаг. |

## МАРКЕТИНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### ХЭРЭГЛЭГЧ
- Хэрэглэгчид мах авахдаа өөрийн нүдээр шиэргийг нь харж авдаг.
- Ариун цэврийг хангаж зориулалтын шаардлага орчинд бэлтгэсэн байдлыг анхаарч байна.
- Савлагаатай махыг шинэ биш удсан, хатуу, шөл гаргахад амтгүй гэж үздэг.
- Савлагаатай махыг үнэтэй гэж үздэг.
- Хэрэглэгчид үргэлж шинэ зүйлсийг туршихыг хүсдэг.

### СОЁЛ
- Махаар олон төрлийн хоол бэлтгэхийг хүсдэг болсон ба цаг зав хэмнэх үүднээс төрөлжүүлсэн махыг худалдан авч сурч байна.
- Намар идшээ урьдчилан бэлтгэдэг.
- Бөөнөөр нь авах нь илүү хэмнэлттэй гэж үздэг.

### АНГИЛАЛ
- Зах зээлд шинээр брэндүүд үүсч өрсөлдөөн бий болж байна.
- Брэндүүд махыг олон төрлөөр/стейк, бургер,котлет,шөл гэх мэт/ гаргаж байна.
- Савлагааны олон төрөл, сонголтоор гаргаж байна.

### БРЭНД
- Савлагаатай махыг худалдаална.
- Хэрэглэгчдийн сонирхолд нийцүүлэн төрөлжүүлж худалдаална.
- Найдвартай гарал үүсэл нь тодорхой махыг худалдаална.
- Ариун цэвэр, чанар стандартыг маш сайн хангана.
- Чанарт таарсан боломжийн үнэтэй байна.
- Онлайнаар гэрт нь хүргэж өгч худалдаална.

### БРЭНДИЙН ГОЛ ШАЛГУУР

Бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн аж ахуйг хослуулснаар махны амт чанар, эрүүл байдал нэмэгдэж байгааг хэрэглэгчдэд ойлгуулах

## ТУХАЙН БРЭНДИЙН НИЙГМИЙН ХӨГЖИЛ СОЁЛД ОРУУЛЖ БУЙ ҮҮРЭГ РОЛЬ

Мон Бийф брэнд нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал ахуйтай хослуулан хөдөө аж ахуй, тэр дундаа махны салбарт шинэ туршлага нэвтрүүлж байна.

### BRAND STORY

**Нийцэмж БУЮУ ХЯЛБАР БАЙДАЛ**

- 100 хоногийн турш эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, тусгайлан бэлдсэн тэжээлийн жороор бордож, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд бэлтгэн ангилж, савлан хэрэглэгчдийн гарт хүргэж байна.
- Томоохон сүлжээ дэлгүүр, өөрийн зах, их нэрд худалдааны төв, онлайн болон утсаар захиалан авах боломж олгоно.

### BRAND WORLD

**БРЭНДИЙН ЯЛГАРАЛ**

- Хамгийн найдвартай, чанартай мах
- Өөрийн ферм дээр 100 хоногийн турш тэжээдэг
- Стандартын шаардлага хангасан орчинд махыг бэлтгэдэг
- 100 хоногийн турш малын эмчийн хяналтад байдаг

Mon Beef LLC Мон Бийф ХХ компани Улаанбаатар 6648436

СЗХ
он 2022 сар 06 өдөр 22
БҮРТГЭВ
№ 01

## ХЭРЭГЛЭГЧИЙН ШИНЖИЛГЭЭ

**БИД ХҮМҮҮСТ ЮУ МЭДРҮҮЛЭХИЙГ ХҮСЧ БАЙНА ВЭ?**

- Итгэж болох, найдвартай брэнд
- Хэрэглэхэд хялбар,

**БИД ХҮМҮҮСЭЭР ЮУ ХИЙЛГЭХИЙГ ХҮСЧ БАЙНА ВЭ?**

- . Утсаар мах захиалан хүргүүлэн авахыг
- . Худалдааны цэгүүдээс худалдан авахыг
- . Бусад хэрэглэгчдэд манай махыг худалдаж авахыг санал болгодог болохыг

**БИД ХҮМҮҮСТ ЮУ БОДОГДУУЛАХЫГ ХҮСЧ БАЙНА ВЭ?**

- . Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэглэж чаддаг эсэх
- . Эрүүл мэндээ анхаарах
- . Чанартай хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх

### GOOD

**1. Бүтээгдэхүүнийг ангилж жижиглэн савлах**

**2. Хэрэглэгчид ойр байлгах үүднээс борлуулалтын сувгуудийг нэмэгдүүлэх. Үүнд:**

- wwonbeef.mn
- Monbeef - фэйсбүүк хуудас
- Ток ток хүргэлт
- Сүлжээ дэлгүүр
- Төвлөрсөн худалдааны төв

**3. Фейсбүүк, вебсайт болон бусад сувгаар борлуулалтыг автоматжуулах**

**4. Эрүүл, найдвартай үхрийн мах**

### GOOD + EASE

### EASE

- Хэрэглэгч махыг жижиглэж бэлтгэхгүй болно.
- Хэрэглэгч махыг цэвэрлэх шаардлагагүй шууд хүнсэнд хэрэглэх боломжтой болно.
- Махыг хүрч мэдэрч авахыг хүсдэг хэрэглэгчдийн хувьд сүлжээ дэлгүүр болон худалдааны төвөөс худалдан авалт хийх боломжтой болно.
- Мон Бийф брэндэд итгэдэг хэрэглэгчид утсаар болон онлайнаар захиалан авах боломжтой болно.
- Бүтээгдэхүүн худалдан авахдаа санаа зовох зүйлгүй

## PR ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

**АСУУДЛУУД**

1. Шинэ салбар тул туршлага бага
2. Үхрийн фермийн аж ахуйд ажиллаж байсан хүний нөөц бага, туршлага бага.
3. Бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгчээс хэт хамааралтай
4. Бүтээгдэхүүний ялгаралын талаар хэрэглэгчдийн ойлголт муу
5. Үнэ өндөр тул масс зах зээлд гарах боломжгүй

\+

**ХЭРЭГЛЭГЧДИЙН НИЙТЛЭГ АСУУЛТУУД**

- Үхэрнүүдээ хаанаас худалдан авдаг вэ?
- Яагаад ийм үнэтэй байгаа вэ?
- Захиалж аваад таалагдахгүй бол яах вэ?
- Өвс, тэжээлээ хаанаас авдаг вэ?
- Хаанаас худалдан авч болох вэ?
- Бусад Монгол үхрээс юугаараа ялгаатай вэ?

=

**НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД**

- Бэлчээрийн мал аж ахуйг, эрчимжүүлсэн мал аж ахуйтай хослуулснаар гарч болох дэвшилтүүдийг ойлгуулсан захиалгат нэвтрүүлэг, ПР нийтлэлүүд
- Малчид болон тариаланчдыг дэмжиж тэдэнд тасралтгүй үнэ цэн өгч байгааг илэрхийлсэн ПР ажил
- Эрүүл, аюулгүй, найдвартай байхын тулд бүтээлч өртөг шингэдэг гэсэн мессеж өгсөн сурталчилгааны компанит ажил

Мон Бийф ХХК компани
MonBeefLLC
УЛААНБААТАР
6648436

ТАВАН БОГД ГРУПП

## МАЛ МАХ БЭЛТГЭЛИЙН ПРОЦЕСС

MON BEEF

**Худалдан авалт**





**Бордох аж ахуй**




**Үйлдвэрлэл**

FOOD SAFETY



HACCP
Hazard-Analysis Critical-Control-Point

**Бэлэн бүтээгдэхүүн**

Үндсэн нэр төрлийн стейкүүд




Цул мах, бусад нэр төрлийн бүтээгдэхүүн

ТАВАН БОГД ГРУПП

## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

MON BEEF

| RIB-EYE STEAK | T-BONE STEAK | SIRLOIN STEAK | FLANK STEAK | TENDERLOIN STEAK |
|---|---|---|---|---|
|  |  |  |  |  |
| Тайлбар: Ухрийн хавирганы толгой хэсгийн стейк | Тайлбар: Нурууны махан стейк | Тайлбар: Нурууны махан стейк | Тайлбар: Цорой махан стейк | Тайлбар: Ухрийн гол махан стейк |
| MON BEEF RIB-EYE STEAK | MON BEEF T-BONE STEAK | MON BEEF SIRLOIN STEAK | MON BEEF FLANK STEAK | MON BEEF TENDERLOIN STEAK |

СЗХ
2022 .. сар 22 өдөр
БҮРТГЭВ
№



## БИЗНЕСИЙН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ




## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

1 Монгол улсын хүн амын мэдээлэл – 2020 он

| | Улаанбаатар хотод | Хөдөө орон нутагт /21 аймагт/ | Нийт |
|---|---|---|---|
| НИЙТ ӨРХИЙН ТОО | **414,292 өрх** | 494,420өрх | 908,712 өрх |
| НИЙТ ХҮН АМЫН ТОО | 1,539,800 | 1,817,700 | 3,357,500 |









# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

ТАВАН БОГД ГРУПП

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

MON BEEF

1 Улаанбаатар хотын махны зах зээлийн багтаамж




■ Идэш бэлддэг
■ Идэш бэлддэггүй

Жилд 1удаа 176.2кг мах идшэндээ авдаг бөгөөд авсан махаа 6.3 сарын турш хэрэглэдэг. Жилийн үлдсэн сар болох 5.7 сарын турш жижиглэнгээр сард дунджаар 23.4 кг мах худалдан авдаг.

= Жилд дунджаар **309.1** кг мах худалдан авдаг (176.2+23.4*5.7) x 414292 өрхийн (УБ хот) 77.8% = жилд дунджаар **99,586.15тн** мах худалдан авдаг

+

Сард дунджаар 17.7кг мах худалдан авдаг.

= Жилд дунджаар **213.1** кг мах худалдан авдаг x 414292 өрхийн (УБ хот)*22.2% = жилд дунджаар **19,617.71тн** мах худалдан авдаг

=

119.203.86 тн

---

ТАВАН БОГД ГРУПП

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

MON BEEF

**7.9***

НИЙТ ЗАХ ЗЭЭЛ 2021* он
/их наяд төг/

**691***

НИЙТ ЗАХ ЗЭЭЛ 2021* он
/мян.тн/

Мах, махан бүтээгдэхүүний төрөл /тоо хэмжээгээр.эзлэх хувь/

| | |
|---|---|
| 95.5% Малын мах | 0.7% Загас |
| 1.3% Гахай | 2.5% Тахиа |

Мах, махан бүтээгдэхүүний төрөл /мян.тн/

| | |
|---|---|
| 660 мян.тн<br>7 их наяд.төг<br>Малын мах | 5 мян.тн<br>45 тэрбум.төг<br>Загас |
| 9 мян.кг<br>50 тэрбум.төг<br>Гахай | 17 мян.кг<br>100 тэрбум.төг<br>Тахиа |

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА - УЛАМЖЛАЛТ БОЛОН ҮЙЛДВЭРИЙН АРГААР БОЛОВСРУУЛСАН МАХНЫ ХАРЬЦАА -2021* ОН




*Монгол улсын хэмжээнд 2020 оны байдлаар хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн нийт мах, махан бүтээгдэхүүний хэмжээ 647,5 мян.тн*

*Монгол улын хүн амын хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа нийт махны 5% орчим нь үйлдвэрийн аргаар боловсруулагддаг байна. Үйлдвэрийн аргаар боловсруулагддаг махны нийт хэмжээ нь 40 мян.тн, 340 тэрбум төгрөг орчим зах зээлтэй байна.*

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

1

**Та ихэвчлэн аль төрлийн мах төрлийн худалдан авдаг вэ?**




Нийт зах зээл=1,053,170,729,660₮

Зорилтот зах зээлийн эзлэмж: Нийт зах зээлийн 10% гэж үзвэл:

Зорилтот зах зээл=105,317,072,966₮

*Эх сурвалж: Үхрийн мах хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа /Таван Богд Трейд, Маркетинг судалгаа үнэлгээний баг/*

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА - ЗАХ ЗЭЭЛИЙН 5 ЖИЛИЙН ХАНДЛАГА

| | 2022 ОН | 2023 ОН | 2024 ОН | 2025 ОН | 2026 ОН |
|---|---|---|---|---|---|
| Зах зээлийн нийт багтаамж | 105.3 тэрбум | 115.8 тэрбум | 127.6 тэрбум | 140.7 тэрбум | 155.1 тэрбум |
| Мон бийф ХХК | 10.5 тэрбум | 14.5 тэрбум | 16.7 тэрбум | 19.0 тэрбум | 21.7 тэрбум |
| Зах зээлд эзлэх хувь | 10.1% | 12.5% | 13.1% | 13.5% | 14.0% |

## ТЕХНОЛОГИЙН ТАНИЛЦУУЛГА

**Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо**
Малын эмчийн хяналтанд тэжээдэг.

**Үхрийн хөдөлгөөнийг бууруулж зөөлөн, шүүслэг махтай болгоно**
Үхрийн хөдөлгөөнийг хязгаарлаж шимт чанар өндөртэй тэжээл болон тогтмол бүлээн усаар тэжээснээр өвс тэжээл хайж энерги зарцуулах шаардлагагүй болно. Ингэснээр махны ширхэг томрохгүй, биеийн шингэнээ алдахгүй илүү зөөлөн, шүүслэг махтай болно.

**Бэлчээр болон эрчимжсэн аж ахуйг хослуулсан**
Бид бэлчээрийн махны амтыг эрчимжсэн аж ахуйн зөөлөн шүүслэг байдалтай хослуулснаар үхрийн махыг илүү амттай, зөөлөн, шүүслэг болгодог.

**Grass Fed**
Монгол орны үржил шимт хөрсөнд ургасан ургаг, эрдэс бодисоор баялаг өвс, тэжээлийг тусгай жорын дагуу бэлтгэн тэжээснээр махыг илүү амт, чанартай болгодог.

**Гарал үүсэл**
Гарал үүсэл тодорхой малыг малчдаас худалдан авч тэжээдэг.

# "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК

БИЗНЕС, ҮЛ ХӨДЛӨХ, ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

СЭХ 2022 .06. 22 өдөр БҮРТГЭВ № 01

ТАВАН БОГД ГРУПП

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА - Мах Маркет

MON BEEF

**Борлуулалтын суваг:**
- Байгууллагын захиалгаар борлуулалт хийдэг.
- Цагаан сарийн баяраар тусгай багц гарган хүргэлтээр борлуулдаг.

**Уриа үг:**
Эргэлзээгүй Эрүүл Хүнс

**Стандарт:**
- HACCP
- ISO22000
- FCCS22000

**Онцлог давуу тал:**
- Мах Маркет нэрээр зах зээлд хоногшсон.

**Сошиал суваг:**
- FB : Зөвхөн Баярын мэндчилгээ болон баярын багцын мэдээлэл оруулдаг
- **Дагагч:** 13,878
- Web: www.makhmarket.mn




ТАВАН БОГД ГРУПП

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА - Мянгат

MON BEEF

**Борлуулалтын суваг:**
- Нэрийн дэлгүүр. / Монгол фарм худалдааны төв /
- Үйлдвэр. / 3, 4-р хороолол./

**Хүргэлт:**
- Ток ток апп.
- Утсаар захиалга авч хүргэдэг.



**Сошиал суваг:**
- FB : Зөвхөн үхрийн махнаас бусад хонины мах, бууз, мах чанах, өвлийн идэш бэлтгэж буй пост, бичлэг, зураг постолдог.
- **Дагагч:** 8,596

**Онцлог давуу тал:**
- Ахуйн хэрэгцээнд зориулан багц гаргаж
худалдаалдаг.
- Цөөн тооны үнэнч хэрэглэгчидтэй

**Бүтээгдэхүүн:**
- Үхрийн гуяны цул мах
- Үхрийн хааны цул мах
- Үхрийн хавирга /чанах, калби/
- Үхрийн зөрсон мах,
- Үхрийн машиндсан мах
- Хонь бүтэн, өрөөл мах
- Хонь гуяны цул мах
- Хонь сээр, нуруу, хавирга
- Хонь зөрсон мах, машиндсан мах

**Уриа үг:**
Тодорхойгүй.

**Стандарт:**
- HACCP
- ISO22000
- FCCS22000




MonBeefLLC
Мон Бийф ХХ компани
6648436
УЛААНБААТАР

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА - Гацуурт хүнс

**Борлуулалтын суваг:**
**Нэрийн дэлгүүр: 8 байршил**
1. Хан-Уул UB Town.
2. ЧД Туул ресторан.
3. БЗД КУДС эсрэг талд
4. БЗД Схрүүл хотхон 120-р байр
5. БГД Минж плаза
6. СХД Мини зах
7. СХД "Хүнс трейд" ХХК
8. БГД Гэмтлийн эмнэлгийн урд

**Хүргэлт:**
- Утсаар, 50,000₮ -с дээш
- Хүргэлтийн үнэ 3,000₮

**Онцлог давуу тал:**
- Дагалдах хүнс, ногоо, гурилан бүтээгдэхүүн.
- Нэрийн дэлгүүрээс нэг дор худалдаа хийх боломж.
- Хүнсний бүтээгдэхүүнтэй хямд багц.
- Гацуурт нэрээр зах зээлд хоногшсон.

**Сошиал суваг:**
- FB: Зөвхөн үхрийн махнаас бусад хонины мах, бууз, мах чанах, өвлийн идэш бэлтгэх пост, бичлэг, зураг постолдог.
- Ихэвчлэн үйлдвэрийн технологийг харуулсан мэдээлэл бэлтгэдэг.
  **Дагагч:** 69,511
- Web: www.gatsuurt.mn/












**•ҮХРИЙН МАХ ЦУЛ**
Үхрийн цул мах /Хавирганы
Үхрийн цул мах/ Сээр, нурууны
Үхрийн цул мах / Хааны
Үхрийн цул мах / Гуяны
Үхрийн цул мах / Богтосны
Үхрийн цул мах / Цоройны
Үхрийн цул мах / Өвчүүний
Үхрийн цул мах / Хүзүүний

**•ҮХРИЙН МАХ ЯСТАЙ**
Үхрийн ястай мах / Өвчүүний
Үхрийн ястай мах / Хавирганы
Үхрийн ястай мах / Сээр, нурууны
Үхрийн ястай мах / Богтосны

**•ҮХРИЙН ДАЙВАР**
Үхрийн элэг / Дангаарав
Үхрийн гүвээ /Цэвэрлэсэн
Үхрийн толгойн татсан мах
Шийр хуйхалсан /Том
Шийр хуйхалсан /Жижиг
Үхрийн гэдэс- Иж бүрдэл
Үхрийн гэдсэн таташ
Үхрийн мах-гургалдай
Үхрийн булууны яс
Үхрийн яс /тойгны /

**Уриа үг:**
- Монгол хүнд эрүүл хүнс.

**Стандарт:**
- HACCP
- ISO22000
- FCCS22000

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА – BB Butcher

**Борлуулалтын суваг:**
- Нэрийн дэлгүүр:
- Зайсан /сарнайх/
- Шангри-ла /Goodprice/
- Хүргэлт / Лавлах дугаараар /

**Онцлог давуу тал:**
- Махан бүтээгдэхүүнүүдийг мэргэжлийн түвшинд хагас боловсруулан худалддаг.
- Dry Aged /Загсаах/ 14-28 өдөр
- Шууд шарахад бэлэн болгон амталж бэлдсэн бүтээгдэхүүн худалдаанд гаргадаг.

**Стандарт & Боловсруулалт:**
- Dry-Aging процессоор сэврээсэн Dry-aged стейкний баялаг сонголтууд

**Уриа үг:**
- Тодорхойгүй

**Сошиал суваг:**
- FB : Голцуу хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг болгосон байдлаар зураг оруулж англи, монгол тайлбар бичдэг.
- **Дагагч: fb:** 18,037 **Insta:** 65
- **FB group:** 2,600 хэрэглэгчтэй








**BB Steak Club**
Private group · 2.6K members



СЭХ
он 2022.06.22
БҮРТГЭВ

ТАВАН БОГД ГРУПП

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА – Занаду

MON BEEF

**Сошиал суваг:**
- FB : Фермийн үйл ажиллагааг харуулсан зураг, бичлэг оруулж хэрхэн чанартай бүтээгдэхүүн гаргахаар ажиллаж байгааг харуулдаг. Мөн бүтээгдэхүүний зургийг оруулдаг. Постын тоо маш бага /Сошиалд идэвх сул/

**Дагагч:**
- FB: 14,101, Instagram: 920
- Web: https://www.xanadurazorback.com/

**Уриа үг:**
- Амт Чанартай Монгол Үхрийн Мах

**Стандарт & Боловсруулалт:**
- Dry-Aging процессоор сэвэрсэн Dry-aged стейкний баялаг сонголтууд



**Онцлог давуу тал:**
- Герман мэргэжлийн эмчтэй
- Dry aged болон энгийн 2 төрлөөр бүтээгдэхүүн гаргадаг
- Олон улсын технологиор бэлтгэдэг

**Борлуулалтын суваг:**
- Нэрийн дэлгүүр: тодорхойгүй
- Ресторан: 5 байршилд

**Хүргэлт:**
- Утсаар захиалга авч хүргэдэг
- Даваа, Мягмар, Пүрэв, Баасан
- Захиалга өгөх утас: 7777-1410

**Ресторан:**
Өөрийн нэрийн бүтээгдэхүүнийг нийлүүлдэг Ресторанууд / Нийт борлуулалтын 80% /







ТАВАН БОГД ГРУПП

## ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА – ХҮЧҮ

MON BEEF

**Борлуулалтын суваг:**
- Нэрийн дэлгүүр: тодорхойгүй
- Хүргэлт: 50,000 төгрөгөөс дээш үнэгүй хүргэлт.

**Онцлог давуу тал:**
- Dry-Aging процессоор сэвэрсэн Dry-aged стейкний баялаг сонголтууд
- Шотландын Хар Ангус & Монгол үүлдрийн үхрийн мах бэлтгэн гаргадаг

**Уриа үг:**
- Premium beef
- Огт хөлдөөгүй цоо шинэ мах

**Сошиал суваг:**
- FB : Хэрхэн мах сонгох, хэрхэн махны болцыг шалгах, Стейк шарах арга зэрэг мэдээллээр постэр бэлтгэдэг, Мөн урьдчилсан захиалга үргэлж авдаг /chatbot, Пост/

- Дагагч: 14,101
- Web: Одоогоор өөрийн Web байхгүй

**Стандарт & Боловсруулалт:**
- Гарал үүсэл тодорхой | Хүнсний аюулгүй байдал хангагдсан
- MNS 2456:2009 стандартыг хангасан
- GMO free | Генетикийн өөрчлөлтгүй
- NO Hormones | Гармоны нэмэлтгүй
- NO Antibiotics | Антибиотек тарилгагүй
- Grass-fed beef | Байгалийн хадлан, тэжээл, даршаар өсгөсөн үхрийн мах
- Үхэрт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг тогтмол хийдэг







MonBeef LLC
Мон Бийф ХХК
6648436
УЛААНБААТАР ХОТ